

# СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ


**Д.Лүндэнжанцан** /Эрхлэгч/

**О.Амархүү** /Ерөнхий редактор/

Гишүүд

**Ж.Болдбаатар**

**Ч.Энхбаатар**

**Н.Лүндэндорж**

**Б.Мандахбилэг**

**П.Түвшинтөгс**

/Нарийн бичгийн дарга/


**ПАРЛАМЕНТ БА ТӨРИЙН АЛБАНЫ СОЁЛ**

*Илтгэгч: УИХ-ын гишүүн, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Д.Лүндээжанцан*

**МОНГОЛ ТӨРИЙН АЛБАНЫ СОЁЛЫН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛД**

*Илтгэгч: Академич Ж.Болдбаатар*

**"ТӨРИЙН АЛБАНЫ СОЁЛ, ТҮҮНИЙ НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ"**

*Доктор, профессор* **Д.Зүмбэрэллхам**
*/Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн дарга/*

**ЭРДЭМТЭН, ПРОФЕССОР, БАГШ, СУДЛААЧДЫН ОЮУНЫ ХӨДӨЛМӨРИЙН ҮНЭЛЭМЖИЙН АСУУДАЛД**

МИДСК-иас зохион байгуулсан ***"Дээд боловсролын чанар-бидний оролцоо, хамтын ажиллагаа"*** сэдэвт ажил төрлийн зөвлөлгөөний *"Их, дээд сургуулиудын эрдэм шинжилгээний ажлын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх арга зам"* салбар хуралдаан дээр Шихихутуг ХЗДС-ийн Гадаад харилцаа, эрдэм шинжилгээ эрхэлсэн проректор, доктор, профессор Ч.Даваадашийн тавьсан илтгэл

**"ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЧАНАР-БИДНИЙ ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГАА" СЭДЭВТ АЖИЛ ТӨРЛИЙН УУЛЗАЛТЫГ НЭЭЖ МИДСК-ЫН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ, ШИХИХУТУГ ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭД СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ, ДЭД ПРОФЕССОР Д.ОЮУНЦЭЦЭГИЙН ХЭЛСЭН ҮГ**

**НЯЦААЛТ ХИЙХ ЭРХИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АРГА ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ**

МУИС-ийн докторант Ширчингийн Сүхбаатар

**БНХАУ-ЫН ӨВ ЗАЛГАМЖЛАЛЫН ХУУЛЬ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ**

*Т. Мөнхжаргал. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш, доктор, профессор*

**"БИЗНЕСИЙН ХУУЛИУДЫГ ХЭРЭГЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ"**

*Илтгэгч: М.Түвшинжаргал /Шихихутуг-ХЗДС-ийн Бизнесийн эрх зүйн 4-р ангийн оюутан/*

**ЭРХ ЗҮЙ БА СЭТГЭЛ ЗҮЙ**

*Э.ЭРДЭНЭБАТ*
*/Шихихутуг ХЗДС-ийн дадлагажигч багш, магистрант/*

**ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦАА ДАХЬ ЗАРААС ҮҮДЭЛТЭЙ ГЭМ ХОРЫГ АРИЛГАХ ЗАРИМ АСУУДАЛ**

***С.БАТКУЯН*** */Шихихутуг ХЗДС-ийн багш, хууль зүйн ухааны магистр/*

**ШИНЭ НОМ**


РЕДАКЦИЙН ХАЯГ:

Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо,
Их сургуулийн гудамж-1,
Шихихутуг ХЗДС-ийн хичээлийн I байр.
Web site: www.shihihutug.edu.mn
E-mail: shikhi_setguul@yahoo.com
Утас: 96687080, 91181909, 314977



# ПАРЛАМЕНТ БА ТӨРИЙН АЛБАНЫ СОЁЛ

*Илтгэгч: УИХ-ын гишүүн, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Д.Лүндээжанцан*

Соёлын тухай төсөөлөл нь ямагт хүний дотоод эрхэмлэлийн асуудалтай холбогдож байдаг. Иймд "соёл" хэмээх ойлголт нь ертөнцийг үзэх гүнзгий, нэн өргөн утга бүхий ухагдахуун. Гэсэн хэдий ч өнөөдөр бид "соёл бол хүний хүмүүнлэг чанар илрэн хэрэгжих түүхэн тасралтгүй үйл явц, түүний үр дүн мөн" хэмээн тодорхойлж, соёл, түүний илрэх хүрээ нь хүний мөн чанарын оршихуй *(үйл ажиллагаа ба үнэт зүйлсийн тогтолцоонд)*-д байдаг гэж хэлж болно.

"Соёл" хэмээх нэр томъёо бусад шинжлэх ухаан, үйлдвэрлэл, хүмүүний тодорхой үйл ажиллагааг тэмдэглэх хэл зүйн өргөн утга агуулгатай байдагт, нөгөө талаас төрийн алба, түүний соёлын талаар бусад илтгэлүүд тавигдаж байгаа болохоор энэхүү илтгэлдээ парламентын хууль тогтоох үйл ажиллагааны соёлын талаар хөндөн санал бодлоо солилцохыг хүслээ.

Хууль тогтоох үйл ажиллагааны соёл нь өөртөө хоёр элементийг агуулдаг.[1] Эхний элемент бол хууль тогтоох бодлого */gesetzgebungspolitik/*, дараагийн элемент бол хууль тогтоох техник */gesetzgebungstechnik/* юм. Аль нэг шинжийг алдвал парламент оршихуйн болон парламентын соёлын үндэс үгүй болно.

**Нэг. Хууль тогтоох бодлогын тухайд**

Монгол Улсын Их Хурлын хууль тогтоох бодлого тогтвортой, зорилготой, алсын хараатай байх ёстой. Тэгж байж Монголын эрх зүй нь Монголын бүтээгдэхүүн байх шинжээ хадгалан хөгжиж бэхжинэ. Аливаа улс үндэстний эрх зүй бол тухайн үндэстний хэл, соёл шиг өөрийн гэсэн өнгө төрхийг агуулж байдаг.

Хууль тогтоох үйл явцыг бодлогын талаас нь судалж, харж хандан болсон болоогүйг нь хэлж өгч, засаж залруулж байх хэрэгтэй юм. Тэгэхгүйгээр хууль санаачлагчид болон тогтоогчид өөрсдийнхөө хар ухаанаар дайраад, хуулийг юу ч биш болгочихож мэдэх юм. Иймэрхүү хандлага манай Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд ажиглагдах боллоо. Өөрсдийн дур зоргоор томъёолсон, санаандаа орж ирсэн "болох, болохгүй" заалт заавзрыг бус, зүй зохисыг нь нухацтай судалж үзэж, хэрэгцээ шаардлагыг тусган боловсруулсан, амьдралд бодиттойгоор хэрэгжих боломжтой хуулиудыг батлан гаргаж байх хэрэгтэй.

Хуулийн бодит чанарыг бүрэн дүүрэн хангасан байх нь төр хийгээд түүний хууль тогтоогчдоос ард түмнийхээ өмнө хүлээсэн гол үүрэг хийгээд хариуцлага мөн. Түүний гол шалгуур, алсын хязгаар нь Үндсэн хууль билээ. Парламент нь хууль тогтоохдоо Үндсэн хуулиа ягштал баримтлах ёстой.

[1] *Sigrid Emmenegger. Gesetzgebungskunst. 2006. Mohr Siebeck. 81.*

Энэ нь парламентын соёлын эрхэм зорилго байдаг. Үүнээс улбаалаад энүүнийгээ хир сахиж мөрдөж байгаагаар Улсын Их Хурлын гишүүдийн хууль зүйн болон ёс зүйн үүрэг, хариуцлагын гол шалгуур тодорхойлогдоно. Улсын Их Хурлаар баталсан хууль, түүний зүйл, заалт нь Үндсэн хуультай зөрчилдөөд, тэр нь Үндсэн хуулийн Цэцэд очин засагдаад байх нь зохистой үйлдэл биш. Гэхдээ Үндсэн хуулийн Цэцэд очсоноор Улсын Их Хурлын ажил бүхэлдээ тааруу гэж ойлгогдохоосоо илүүтэй, төрөөс "Эцэг хууль" гэгддэг Үндсэн хуулиа дээдлэн хамгаалж, хүндэтгэн сахиж байгаагийн баталгаа, хууль тогтоох үйл ажиллагааны соёлтой холбох үзэх гэж үзэх нь зүйтэй юм.

Сахилга, хариуцлага дээрээс эхэлж, доош үлгэрлэдэг, хууль журам нь дээдэст хатуу, доодост нигүүлсэнгүй байх нь төрт ёсны эрхэм чанар, нэгэн зүйл урлаг гэж үздэг тийм уламжлал ч бий.[2] Харин орчин үеийн парламентын үйл ажиллагаа нь Үндсэн хуулиар, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагынх нь хууль болон шударга ёсоор хязгаарлагдана" гэсэн суурь үзэл баримтлал парламентын соёлтой улсад хүлээн зөвшөөрөгдөж байна.

Аливаа парламентын хууль тогтоох бодлого нь улс төрийн бодлоготой зайлшгүй холбоотой байдаг. Учир нь хууль бол улс төрийн бодлогын томьёолсон илэрхийлэл, хэрэглүүр мөн. Ийнхүү хууль нь нэгэнт төрийн улс төрийн бодлогын илэрхийлэл, хэрэглүүр юм бол түүнд эрх зүйн тогтолцоо, бүлийн үүднээс хандаж хуулийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсруулж гаргахгүй бол эдийн засаг, нийгмийн хөгжлийн цэгцтэй, харилцан уялдсан төрийн нэгдсэн бодлого тодорхойлогдож чадахгүй. Эцсийн дүндээ энэ бүхэнд эрх зүйн тогтолцоо, бүлийн үүднээс хандахын учир шалтгаан оршиж байна.[3] Үүний үндэс нь хууль тогтоогчид улам бүр нарийсан хөгжиж байгаа нийгмийн харилцааг оновчтой зохицуулах гарцыг харьцуулсан эрх зүйн туршлагад тулгуурлан шийдвэрлэх өргөн гарц, боломж бий болсон байна.[4] Улсын Их Хурал нь үүнийг ашиглах, хэрэгжүүлэхийг чармайн ажиллаж байгаа хэдий ч зарим учир дутагдал байсаар байна.

**Хоёр. Хууль тогтоох техникийн тухайд**

Өнөөдөр Улсын Их Хурлаас батлагдан гарч байгаа хуулиуд нь их, бага гэлтгүй ямар нэг шүүмжлэлд өртөж байна. Энэ зүй ёсны хэрэг юм. Бүх зүйлийг урьдчилан харж, төгс төгөлдөр шийдэх боломжгүй хэдий ч түүн рүү тэмүүлэх ёстой. Үүнд ч манай Улсын Их Хурал, түүний гишүүд суралцаж чармайж байна. Нөгөө талаас энэ нь Улсын Их Хуралд эрх зүйн хийгээд хууль тогтоох үйл ажиллагааны соёл дутагдаж байна гэж хэлж болох юм. Цаад үндэс нь Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааны хууль зүйн техниктэй холбоотой.

Улсын Их Хурлаас батлагдсан хуулиуд дотор цаг үеийн шаардлагаас шалтгаалаад түргэвчилсэн, яруу сандруу шийдсэн, үүнээсээ болоод бодит амьдралд төдийлөн нийцэхгүй, хүндрэл учруулах, өөр бусад хуулиудтай зөрчилдөх, хуульчлах ёстой зарим зүйл орхигдох, түүнчлэн үг найруулгын хувьд ойлгомжгүй, хэрэгжүүлэх явцад зайлшгүй Дээд шүүхийн тайлбар, эсвэл хэрэгжүүлэх журам гаргахыг шаардсан хууль тогтоомжууд байдгийг үгүйсгэхгүй. Хуулийн төслийн шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах, тооцоо судалгаа хийх, шаардлагатай гэвэл мэргэжлийн хүмүүс, эрдэмтэн мэргэжилтний саналыг авах, тэр бүү хэл иргэний нийгэм, ард иргэд, сонгогчдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг явуулах хэрэгтэй юм. Ингэснээр аливаа хууль удаан хугацаанд тогтвортой мөрдөгдөх, улс орны эдийн нийгмийн амьдралын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чадавх сайжрах, эцсийн дүндээ хууль тогтоох байгууллага, түүний гишүүдийн нэр хүнд дээшлэнэ.

Ялангуяа хувийн буюу иргэний эрх зүйн салбар дахь хууль тогтоомжуудыг тогтвортой байлгах асуудал манай улсаас бусад улс оронд тухайн улс орны парламентын хууль тогтоох үйл ажиллагааны соёлыг нь харуулдаг нэг объектив шалгуур[5] байдаг байна. Гэтэл хувирамтгай хуультай нөхцөлд бизнесийн салбарынханд хэн итгэж хамтран ажиллах, эргээд тэд хэнд итгэж хөрөнгө оруулалт хийх вэ, яаж үйл ажиллагаагаа тогтворжуулж хөгжих вэ гэдэг асуудал урган гардгийг хэзээ ч мартаж болохгүй.

Хуулийн төсөл боловсруулах ажил адармаатай, нарийн төвөгтэй байдгийг бид бүгд мэднэ. Гэсэн хэдий ч хууль тогтоох бодлого болон эрх зүйн бүл, соёл, тогтолцооны үүднээс хандсан үзэл баримтлалгүйгээр, хууль зүйн мэргэжлийн бус байгууллагын үзэмж

[2] Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг асуудал. Нэгдүгээр дэвтэр. УБ., 2004.193 дахь тал.

[3] Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг асуудал. Нэгдүгээр дэвтэр. УБ., 2004.193 дахь тал.

[4] Цвейгерт К. Введение в сравнительное правоведение в сфере частного права. М., 1998. с.15.

[5] Кристофер Осакве. Сравнительное правоведение в схемах: Общая и Особенная части.

сонирхлоор боловсруулсан, эсвэл мэргэжлийн хийгээд тодорхой салбарын онцогийг харгалзаж үзээгүй батласан хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг манай парламент баталж ирсэн нь өнөөг хүртэл Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааны соёл төлөвшиж чадаагүй байгаатай холбоотой байна. Иймд хуульчдыг улс төрд татаж оролцуулах, улс төрчид хуульчдыг түших ийм хамтын ажиллагаа, соёл ихээхэн дутагдаж байгааг тэмдэглэн хэлж байна.

**Гурав. Хууль тогтоогчдын ёс зүйн талаар**

Парламентын соёл нь түүний гишүүдийн ёс зүй, сахилга бат, хариуцлагатай салшгүй холбоотой. Гишүүд нь хир ёс зүйтэй байна тэр хирээр парламент хүчтэй, чадвартай, эв нэгдэлтэй байж нэр хүнд нь дээшилнэ. Парламентын гишүүдийн ёс зүйгүй байдал нь нийгэмд ч сөрөг нөлөө, муу үр дагавартай.

Манай Улсын Их Хурлын гишүүдийн дунд ёс зүйн асуудал төдийлөн төлөвшиж тогтоогүй байна. Энэ нь парламентаас парламентад төлөвших биш, ухрах байдал ажиглагдаж байна. Үүнийг гишүүд өөрсдөө ч хүлээн зөвшөөрч байгаа. Түүний илрэл нь Улсын Их Хурлаар Улсын Их Хурлын гишүүдийн ёс зүйн дүрмийг 2009 оны хавар батлан гаргасан явдал юм.

Улсын Их Хурлын гишүүн нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ төрийн хуулийг дээдлэн сахих, аливаа асуудалд шударга байр сууринаас хандах, бусдын нэр төр, алдар хүнд, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, нийт иргэн, төр, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн хэнийг ч ялгаварлан гадуурхахгүй байх, албаны эрх үүргээ хувийн эрх ашгийн үүднээс ашиглахгүй байх зэрэг зарчмуудыг Ёс зүйн дүрмэнд тусгаж өгсөн.

Гагцхүү энэ дүрмийг мөрдөж ажиллах явдал чухал бөгөөд ингэж чадах аваас соёлтой парламентийг төлөвшүүлэхэд ач холбогдлоо өгнө.

Хэдийгээр Монгол Улсын Үндсэн хуульд "Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална" гэж заасан ч гэсэн Улсын Их Хурлын гишүүд нь нийт иргэдийн эрх ашгийг бодолцохын зэрэгцээ өөрийн сонгогдсон тойргийн сонгогчдын эрх ашгийг илүүд эрхэмлэх явдал байсаар байна. Үүнд Улсын Их Хурлын гишүүдийг буруутгах аргагүй юм. Энэ нь өнөөгийн сонгуулийн тогтолцоотой шууд холбоотой. Иймд сонгуулийн тогтолцоог ч эргэж харж үзэхийг шаардаж байна.

**Дөрөв Дүгнэлт, санал**

Монгол улсад парламентын соёл сонгодог утгаараа бүрэн төлөвшиж чадаагүй байна. Монгол Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааны соёл төлөвшиж чадаагүйн шалтгаан олон янз. Энэ талаар эрдэмтэн судлаачдын хийсэн дүгнэлт, үгүйсгэлээс үзэхэд харагдаж байна.

Парламентын хууль тогтоох үйл ажиллагааны гол бүтээгдэхүүн буюу үр дүн бол хууль. Тэрхүү хууль дээдлэгдэхийн үндэс нь хууль хуультай уялдсан байх, хууль нь хууль шиг байх явдал юм. Ийм хууль аяндаа дээдлэгдэнэ, хэрэгжинэ. Тийм хуулийг сайн парламент, парламентын соёл өндөр хөгжсөн төлөөлөгчдийн байгууллага л хийнэ.

Парламентын соёл өндөр хөгжсөн төлөөлөгчдийн байгууллага болохын тулд:

Хууль тогтоох үйл ажиллагааны ил тод байдлыг хангах,

- Онолын үндэс, бодитой шинжлэх ухаанд суурилсан судалгаанд тулгуурласан хууль тогтоомжийн нэгдсэн бодлого, үзэл баримталлыг бий болгосон байх;
- Хуулийн зохицуулах чадварыг тэргүүн зэрэгт тавьж, ажиллах хэрэгжих чадвар бүхий цөөн хуультай байх, өөрөөр хэлбэл тооноос илүүтэй чанарыг эрхэмлэх,
- Хууль боловсруулах, батлах ажил тодорхой төлөвлөө, үндсэн чиглэлийн дагуу явагддаг байх;
- Хуульчдыг улс төрд татаж оролцуулах, улс төрчид хуульчдад түших ийм хамтын ажиллагаа, соёлыг парламентын хүрээнд бий болгох;
- Хуулийн төсөлд хууль хэрэглэгчдийн хөндлөнгийн байр суурийг тусгах,
- Батлан гаргасан хуулийнхаа хэрэгжилтэд хяналт тавьж чаддаг байх,
- Хууль тогтоогчид нь иргэний нийгмийг сонсдог, ёс зүйтэй, сахилга баттай, хариуцлага хүлээх чадвартай байх,
- Өнөөгийн сонгуулийн тогтолцоог эргэж харж үзэх, тэгэхдээ Улсын Их Хурлын гишүүн нь Үндсэн хуульд заасан ард түмний элч байх үүргээ биелүүлэх боломжийг хангахуйц байдлаар хандах зэрэг болно.



# МОНГОЛ ТӨРИЙН АЛБАНЫ СОЁЛЫН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛД

***Илтгэгч: Академич Ж.Болдбаатар***

Манай улс төрийн утга зохиолд соёл хэмээх нийлмэл логик бүтэц бүхий үнэлэх үйлдлийн нэрийг "үнэт зүйл", "үнэт чанар" гэх мэтээр орчуулж хэрэглэн, улмаар соёл бол "...бүх үнэт зүйлсийн цогцос мөн" (1,362) гээд "эд баялаг, бүтээгдэхүүн" гэж үзэх үзэл түгээмэл байв.

Уран барилга, хөшөө дурсгал зэрэг бодит зүйл нь үнэхээр соёл мөн бөгөөд энэ нь материаллаг соёл юм. Харин соёл нь тэдгээрийг бий болгогч хүний үйл ажиллагааны зохистой арга гэдгийг орхигдуулж байсан нэгэн үе бий. Эдүгээ соёлыг цогц байдлаар үзэж, материаллаг үнэт зүйл төдийгүй хүний үйл ажиллагааны арга гэж үзэж, энэ үүднээс "улс төрийн соёл", "харилцааны соёл" гэх мэтээр ярьдаг.

Төрийн алба, түшмэл ёс хэмээх ойлголт бол хоорондоо амин шүтэлцээтэй ухагдахуун бөгөөд харилцан бие биеэ нөхцөлдүүлж байдаг. Төрийн алба нь институтжсэн шинж, бүтэц зохион байгуулалтыг, харин түшмэл ёс нь түүний мөн чанар, агуулга, төрийн албан тушаалтнуудын ерөнхий өнгө төрхийг илэрхийлж байдаг. Түшмэл ёс хэмээхүй нь төрөөс тогтоосон хэм хэмжээний дагуу засаг захиргааны ажлыг удирдах, зохион байгуулах, гүйцэтгэх эрх эрх мэдлээ албан тушаалтан хэрхэн яаж хэрэгжүүлэх арга ухаан, мэдлэг, чадвар, дадал, туршлагын цогц юм. Чухам ийм утгаараа төрийн албаны соёл гэдэг нь түшмэл ёсны соёл юм. Тэрхүү соёлыг төр, захиргааны байгууллагууд, тэдгээрийн албан тушаалтны үйл ажиллагааны арга хэмээн үзвэл тухайн албан тушаалтны оюун билгийн цараа, амьдралын туршлага, төр засах, ард иргэдийг ачлах эрдэм, төрийн бодлогын оньсыг зэрэг мултлах үзэл ухал, эрхэлсэн ажилдаа мэдлэгтэй, шуурхай дайчин, үнэнч хандах чадвар, бичиж найруулах чадал чансаа, хатамжлан захирах болон зөвэргүү зөөлөн арга барилын шүтэн барилдлага, удирдлагандаа буй алдаж, оносон хэнийг ч хайрлахын эрхээр яттан засах арга ухааны цогцлол, нийлэг нэгдэл юм.

Төрийн албаны соёл нь төрийн алба үүссэн үеэс үүдэлтэй. Монгол төрийн албаны соёл бүрэлдэн төлөвшиж ирсэн үе шатыг дараах байдлаар тоймлон үзэж болох юм. Үүнд:

1.**Хаант төрийн албаны соёлын үе.** (МЭӨ-209 оноос XX зууны эхэн үе хүртэл). Монгол нутагт оршин тогтнож байсан улсуудын хаант төр агуулга, хэлбэр ээрээ янз бүрийн өнгө төрхийг өөртөө агуулж байсан боловч, бүхэлдээ депотизмд тулгуурлаж байв. А.Тойнби Өрнөдийн судлаачид өөрийн өвөрмөц нийгмийнхээ орчин нөлөөн дор оршиж буй Өрнийн бус нийгмийг судлахдаа улс төрийн талд нь голлож анхаардаг нь Өрнөдийн талаасаа нэлээд чухал хандлага л даа. Дорно дахиныг энэ үүднээс харвал ерөөс хөдөлгөөнгүй хязгааргүй деспот дүр зураг харагдана. Гэтэл энэ нь тун ч хуурмаг өнгөц үзэгдэл болой. Өрнөдийн бус улс төрийг нухацтай судалбал өрнийн судлаач бид түүхэн үнэнийг нэлээд тодруулж болох байв.. Хэрвээ бид улс төрийн эл харанхуй манангаас ангижирч, соёлын талаас нүдээ нээвэл Дорно дахины тогтвортой амьдралыг сая зөвөөр үзэж эхлэх байв. Оршихуйн дотоод мөн чанарыг нь олж харах билгийн мэлмийг нээх байв. Чингэхлээр, нийгмийн амьдралыг тус төр лүгээ адилсган явцуурууж, соёлыг үл хайхарсан нь өрнийн мэргэдийн үнэнхүү алдаа мөн буюу" (2,84) хэмээн тэмдэглэжээ. Монголын төр ёс нь дорно дахины төр барих ухаанаас ангид биш юм. Дорнын деспотизм нь өрнийхөөс дараах хэд хэдэн онцлогтой байна.

а.Төрийг албадлагын хэрэгсэл гэж үзэхээсээ "миний эзэн", "бидний амьдралыг тэтгэгч, зам мөрийн заагч" гэж үзэж, төр шүтэх үзлийг дороос бий болгож иржээ.

б.Нийгэм-эдийн засгийн амьдралд төрийн зохицуулалт, үүрэг оролцоо хүчтэй байдгаас "Төрийн хэрэг бага ч гэсэн их, гэрийн хэрэг том ч гэсэн бага" гэж төр эрхэмсэг, төр төмбөгөр хэмээхүйг гүнээ ухамсарласан сэтгэлгээ зонхилж байдаг.

в.Төр түвшин байвал түмэн олон амгалан байна хэмээх нигүүсэл, хүн ардын их зонхийн сэтгэлийг ариусгаж байдаг.

Монголын эртний улсуудад хаант төрийн алба анх удаа биежин төлөвшиж, төрийн албаны соёлын бүрдлүүд бий болсон байна. Монголын эртний улсууд бол X-XII зууны Монголын ханлиг, аймгуудын төрийн албаны соёл нь юуны өмнө "нөхөр, турхаг"-ийн харилцаан дээр тулгуурлан төлөвшиж байжээ. Хаан, овог аймгийн толгойлогчдод шадарлан зүтгэгчид төрийн түшмэлийн үүрэг хүлээхдээ хаан эзэндээ чин үнэнч байх, харилцан итгэлцлийг чанд баримтлаж байсан юм. Тэгж ажиллаж чадаж байж, ард олны гүн итгэлийг хүлээх болжээ.

Энэ зарчим дэлхийн талыг эзэгнэсэн Их Монгол Улс, Эзэнт гүрэнд шинэ агуулга, хэлбэрээр үйлчилж байжээ. Чингис хааны байгуулсан төрийн албаны соёлын гүн ухаан нь сэтгэл зүтгэлээс улбаатай эв нэгдлийн гүн ухаан болон төлөвшчээ. Үлэмжийн их Чингис хаан "Бие бөх бөгөөс ганцыг ялъюу, сэтгэл бөх бөгөөс олныг ялъюу", (3,102) "Олон улсыг барьюу гэвэл биеийг хураахаас сэтгэлийг нь хураагтун. Сэтгэлийг хураавaас бие нь хаа одох билээ" хэмээн сургаж байсан нь үнэнч чанар, гүн итгэл хоёр бол төрийн түшмэл, эгэл ардын хоорондын хүн ёсны харилцааны соёлын хэм хэмжээ гэж үзэж байсных юм. Түшмэл ёсны соёлыг чингэж төлөвшүүлж чадсаны улмаас Хятад, Араб, Европын соёл иргэншилт орнууд болон Евро азийн үй олон хүн ардыг Эзэнт гүрний нэгэн дээвэр дор нэгтгэж, 150 жил оршин тогтносон билээ.

Монголын Юань улсын үед төрийн алба биежин цэгцэрч, нүүдэлчдийн болон суурьмал орны төрийн албаны соёл харилцан нэвчиж, дорно дахины улс орнуудын хаант төрийн албаны соёлын уламжлалт хэв маягийг бүрдүүлсэн байна. Монголын Юань улсад төрийн хоёр ёс, буюу хос ёсыг хэрэгжүүлснээр төрийн албанд зүтгэх гол шалгуур нь тухайн хүний билэг эрдэмд гийсэн байдал буюу боловсрол мэдлэг болж байв.

XIV зууны сүүлчээс XVII зууны эх хүртэл Монголд улс төрийн бутрал болж, төрийн багана хазайж эхэлсэн юм. Тэр үед төрийн албаны уламжлалт соёл бүдгэрч, улмаар алдарсан он жилүүд байв.

Манж чин улсын эрхшээлд орсон үед Эзэнт гүрний төрийн алба ажиллаж, түүнд монгол ноёд, түшмэл алба хашиж байсан бөгөөд тэрхүү алба байнгын биш, жилд хэд хэдэн сараар ээлжлэн ажиллах зарчим баримталж байв. Нэг хошууны тамгын газарт гэхэд л хошуу туслагч бол ноёны ойр торлийн тайж байх ёстой бөгөөд харин захирагч, мэйрэн, залан хэмээх албан тушаалтнууд удам гарвал харгалзахгүй төрийн жинхэнэ албан хаагч байж, төрийн түшмэлийн зиндаанд алба хашиж байсан юм. Манж чин улсын төр гол төлөв хошуу засаг нарт ван, бэйл, бэйс, гүн хэмээх хэтэрхий дөрвөн хэргэм соёрхож, төрд үнэнч бөгөөд чадмаг зүтгэсэн зарим нэг түшмэл бас дээрх хэргэмийг

алдаг оноо хүртэнэ. Төрийн мэргэн түшмэдэд "хурц", "хичээнгүй" "билэгт", "ачит" зэрэг цол олгож байсан нь тэр цагийн төрийн албаны соёлын нэг бүрдэл болж байв.

Хошуу ноён өөрийгөө залгамжлах хүүгээ хаанд мэдүүлж зарлиг гаргуулснаас хойш тусгай багш томилж, төр засах, ардыг ачлах эрдэмд элит сургуулиар сургаж байсан нь төрийн албаны соёл эрэг төлөвшихөд томоохон нөлөө үзүүлж байсан юм. Зарим хошуунд түрүүчийн ноёны үед хийж бүтээсний алдаа, оноог дэнсэлсэн шаштир бичиг хөтлөн, чандлан нууцалж хадгалаад дараагийн ноёны зэрэг шарахад (хошуу ноён залгамжлахад. Ж.Б) тусгай түшмэл уншиж, тайлбарлаж өгдөг байсан нь төрийн албаны соёлын уламжлал, шинэчлэлийн залгамж чанарыг хангахад чухал ач холбогдолтой байжээ.

**2.Бүгд Найрамдах засаг тогтсон үеийн төрийн албаны соёл.** (1921 оноос эдүгээ хүртэл) Энэ цагийн эхний жилүүдэд монгол хүн нь хамжлагт ёсны бурангуй байдлаас алхам алхмаар ангижирч, хүний наад захын эрх, эрх чөлөөг амтлан мэдэрч, нийгмийг ардчилах зоримог алхам хийж буй нөхцөлд төрийн албаны шинэ соёл төлөвшиж эхэлсэн байна. Ардын төрийн албаны анхны гараанд бичиг үсэг мэдэх төдий удирдах ажлын дор суугаагүй, туршлагагүй эгэл ард, хуучин төрийн архаг түшмэл нар хамтран зүтгэх явцад төрийн албаны шинэ маягийн соёл бүрэлдэж эхэлсэн онцлогтой.

1921 оны хувьсгалын дараа Ардын засгийн газар төрийн албыг ардчилах, төрийн албаны шинэ соёлыг төлөвшүүлэх талаар тодорхой арга хэмжээ авчээ. 1921 оны VII сарын 19-нд АЗГ-ын долоо хоногт хуралдах гариг өдрийг тогтоон, тун удалгүй АЗГ-ын хуралдаанаас хожимдох явдлыг үл гаргах, хожимдвол, хожимдсон 10 минут бүрт 5 цэн торгож байх, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх асуудлаа урьдчилан мэдэгдэж байх журам гаргаж мөрдүүлэв. Мөн оны XI сарын 1-нд яам газрын ажлын эхлэх, дуусах цагийг өглөөний 9 цагаас 16 цагаар тогтоосон байна. Түүнчлэн зарим яам албан газарт албан хаагчид ээлж халалцан суудаг ёс, хошуудын туслагчийг тогтоон томилохдоо заавал Богд хаанд биеэр бараалхаж батлалдаг ёсыг зогсоожээ. Мөн 1922-1923 онд албан хэргийг хөнгөн шуурхай зохистой явуулах зорилгоор албаны бичиг хэргийг дарагдуулсан бол торгох, албан хэргийг барагдуулах тодорхой хугацаа тогтоох нэг албан газар гэр бүлээрээ ажиллахыг хориглох, хээл хахууль, өгөхийг цаазлах зэрэг арга хэмжээ авчээ. (4,216-217)

Төрийн албаны соёл төлөвшүүлэхэд юуны өмнө, албан тушаалтныг баримтлуулж сургах явдал нэн чухал байв. Нийслэлийн иргэд, албан хаагчдыг албаны ажилд цагт баримталдаг болгохын тулд 1924 оноос эхлэн ширмэн ууранд дарь авалцуулан дуу гаргаж, үд дундын дохио өгдөг болсон түүхтэй. (5,262)

Энэ үеийн төрийн албаны соёл нь хаант төрийн албаны болон ардын эрхт шинэ төрийн албаны соёл сүлжилдсэн нийлэг шинжтэй байсан хэмээн үзэж болох юм.

XX зууны эхний хагаст төрийн томоохон албан тушаалтнууд эрдэм боловсрол, харилцааны соёл, тулх чанараараа хэн нэгнийг онцлон дагуулж сургах, залгамж халаагаа бэлтгэх болсон нь төрийн албаны соёлын бас нэг онцлог юм. Тухайлбал, чин ван М.Ханддорж, хичээнгүй сайд Б.Цэрэндоржийг, Цэрэндорж мэргэн сайд А.Амарыг, Амар сайд Довчинг өөрийгөө залгамжлан ажиллаж чадах хүн хэмээн төр засах эрдэмд дагуулан сургаж байсныг төрийн албанд олон жил зүтгэсэн ахмадуудад хуучилдаг байсан.

1928 он хүртэл Монголын үндэсний ардчилсан үзэлтнүүд төрийн албаны ардчилсан шинэ соёлыг төлөвшүүлэх талаар багагүй ажил хийсэн юм. Гэвч 1928 онд хуралдсан МАХН-ын VII их хурлаар тэднийг баруунтан хэмээн бут цохиж, Монголд зөвлөлт маягийн социализмыг туршиж эхэлснээр дөнгөж хэлбэржиж байсан төрийн албаны ардчилсан соёл төлөвших үйл явц тасалджээ.

1928-1932 онд зүүний балмад явуулга газар авснаар төрийн нүсэр алба бий болжээ. Ингэснээр эл албаны хөнгөн шуурхай, шударга дайчин чанар алдагдаж, хүн ардаа ангич, алагчлах байр сууринаас хандах болсон байна. Асуудлыг бие даан шийдвэрлэх чадвараа алдаж, зөвхөн Коминтерн, зөвлөлтийн сургагчдын ам, гар харах төдий болжээ.

Шинэ эргэлтийн бодлогын жилүүдэд 1928 он хүртэл төлөвшиж байсан төрийн албаны ардчилсан соёлын бүрдлүүд дахин сэргэж, төр, иргэдийн хоорондын итгэлцэл дахин бий болжээ.

Харин И.В.Сталин, түүний гар хөл бологчдын Монголд хийсэн улс төрийн хэлмэгдүүлэлтийн уршгаар төрийн албаны ардчилсан соёл бүрмөсөн алдагдаж, үл итгэлцэл, айдас хүйдэс бүх шатны төрийн албыг нөмөрчээ.

1940-өөд оноос Х.Чойбалсанг тахин шүтэх болсноор тоталитар дэглэм тогтож, төрийн алба ч тэрхүү дэглэмийг хэрэгжүүлэгч зэвсэг болон хувирсан байна. Х.Чойбалсанг нас барсны дараа шинэчлэлийн төлөө хөдөлгөөн түр өрнөсөн болович удалгүй дарагдаж, 1960-аад оны дунд үеэс монголын нийгэмд захиран тушаах систем ноёрхох болсон байна. Чингэснээр төрийн албанд номенклатурчид ноёрхох болов. Тухайлж хэлбэл, номенклатурчдын тоо МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны мэдлийнх 350-400 орчим, Намын Төв Хорооны мэдлийнх 300-4000 орчимд, аймаг, хот, сум дүүргийн намын байгууллагуудын мэдлийнх 33 мянга орчимд эргэлдэх болжээ. Хэдийгээр бид МАХН-ын боловсон хүчний бодлогод шүүмжлэлтэй хандлаг байгаа болович, төрийн албанд ажиллагсдыг анхан шатнаас эхлэн ажиллуулж, гүнзгий мэргэжшүүлж байсан давуу талыг үгүйсгэх аргагүй юм. Мэргэшсэн албан тушаалтнууд төрийн албыг боловсронгуй болгож, өвөрмөц соёлыг төлөвшүүлсэн юм. Тийм ч учраас хүн ардын сэтгэл зүрхэнд "Төрийн минь сүлд өршөө" хэмээх өнө эртний төр шүтэх үзэл хэвээр оршиж байсан билээ.

Хөгжлийн янз бүрийн шатанд монголчууд аливаа хүнийг төрийн албанд зүтгүүлж, улмаар томоохон албанд дэвшүүлэн, улс төрийн зүтгэлтний зиндаанд өргөмжлөхдөө нэгэн гол тулх шинжийг шалгуур болгож иржээ. Тийм шинж бол **төв эрхэмсэг шинж** юм. Эл шинж чанар нь төрийн албан тушаалтны тулх шинж бөгөөд явцуу утгаараа төрийн зүтгэлтэн, төрийн түшмэл хүн дотоод ертөнц, гүн бясалгалаа олон түмэн, хувь хүн, мөн харийнханд илэрхийлэх гадаад илрэл мөн. Өргөн утгаараа, төрийн зүтгэлтэнд төлжин шингэсэн цогц мэдлэг, чадвар, ааль авир нь нийгэм олон түмэнд ээлтэй тусах тусац, улс төрийн бодлогын давхар оньсыг улс үндэстнийхээ эрх ашигт зэрэгээр мултлах чадвар бүлгээ. Товчоор хэлбэл, төрийн зүтгэлтний эрхтэй атлаа болгоомжтой, найртай атлаа хэрсүү байх чанар, намбалаг бөгөөд сүрлэг байх гадаад илрэл юм.

Төв эрхэмсэг шинж хэн бүхэнд бурхнаас заяахгүй нь мэдээж бөгөөд хувь хүний төрөлх ухаан, боловсрол мэдлэгийн түвшин, ааш араншин, хичээл зүтгэл, өсөн төлөвшсөн нийгмийн орчин зэргээс чухам шалтгаалж байв. Төрийн зүтгэлтэн хүний мөн чанар, зэрэг бүхний хураангуй илэрхийлэл-төв эрхэмсэг шинж нь хаан хүний гучин таван эрдэмд төгс шингэсэн буй Их Чингис хаан:

Хаан хүний гучин таван эрдмээр хамгаас хандаж
Хас төрийг хууль ёсоор хүри чанга тэгшитгэж
Хамаг улсын үр ач нарыг хүмүүжүүлэн сургаж
Хань бүх улс иргэнээ амар энх болгосугай хэмээн сургаж байв.

Монголын төр ёсны түүхээс үзэхүйд, төв эрхэмсэг төлөв байдалд хүрэхийн тулд төрийн албанд зүтгэж буй хүн бүхэн төрийн албаны соёлын олон тодорхой шинжийг эзэмшихийг эрмэлзэж, төрөөс эдгээрийг хүмүүст тавих гол шаардлага, хэм хэмжээ болгож байжээ. Тухайлбал, улс орны болон, төрийн хөгжил, өрнөлтийг урьдчилан харах чадвар, улс үндэснийхээ эрх ашгийн төлөө зориг үл алдрах, өөрийгөө золиослох чанар, өөрийн биеийг ухаарахуйн шинж, чигч шударга байдал, бууръ суурь,ноён нуруу зэргийг дурьдаж болох юм.

Улс орны удирдлагын өндөрлөгт гарсан төрийн зүтгэлтнүүдэд эдгээр тулх чанар дутвааc үндэсний эрх ашигт ямар нэг хэмжээгээр хохирол учруулж байсныг түүхэн сургамж өгүүлж байна. Иймучраас номын мэргэд уг асуудлыг анхааралдаа авч, билэг сургаалаа хайрласаар ирсэн түүхтэй. Ойрмогхоноос дурьдвал: их эрдэмтэн Ч.Дэмчигдорж "Шинэ засгийн гол ёс" хэмээх номондоо: "Эрх баригчид цааз засгийг мэргэн шугамаар явуулбаас улс төр энх түвшин болму" гэсэн бол Дарив бандид "Ард түмний ариун ёс" гэдэг бүтээлдээ "Төрийг баригчдын зан авир цалгайран, цааз хууль суларваас улс ядрах, тийм болбаас төр түвшин байхад бэрх" гэжээ.

Бага буурай улс хөрөнгө чинээ, цэргийн хүчээр мөхөс ч, төрийн тулхтай зүтгэлтэн, мэргэн түшмэдийнхээ төрийн албанд зүтгэх соёл, цолх ухаан, эе эвийн ачаар тусгаар тогтнолоо хадгалж, хамгаалах боломжтойг Монголын төр ёсны хөгжлийн түүхэн туршлага харууллаа. Мөн хувь хүн төрийн өндөр зиндааны алба

хашсанаараа биш, харин үндсэний эрх ашгийг урьтал болгон, Монгол төрийн албаны соёлын уламжлал, шинэчлэлийн улбаанаас утга нээж, ухааны даацтай хүчин зүтгэснээрээ, төрийн тулхтай зүтгэлтэн, даацтай түшмэл хэмээх алдрыг хүлээж, шаштир цадиг мөнхрөн үлддэгийг түүхэн сургамж харуулж байна.

1990-ээд оноос хойш Монгол улсад эрх зүйт төрийг төлөвшүүлж байна. Энэ явцад Монгол төрийн албаны ардчилсан соёл бүрэлдэж байна гэж хэлж болох юм. Хөгжлийн шинэ сонголтын үед төр, иргэн эрх тэгш байх зарчим үйлчилж, төрийн албаны үйл ажиллагаанд иргэдээс нөлөөлөх арга, хэлбэр олон талтай, олон түмний шахалт, шаардлага хүчтэй болж байгаа нь төрийн албаны ардчилсан соёл төлөвшихөд чухал түлхэц үзүүлж байна. 2008 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан. "Төрийн албаны тухай" хууль нь монголын төрийн албаны соёл гүнзгийрэн төлөвших эрх зүйн таатай орчинг бүрдүүлж байна. Гэхдээ төрийн албаны ардчилсан соёл төлөвшихөд практик дээр олон зүйл саад тотгор болж байна. Заримаас нь дурьдвал:

-Төрийн байгууллагад анхны нэгжээс нь шат дараалан дэвшүүлж бэлтгэдэг байсан уламжлал алдагдаж, төрийн аль нэгэн албан тушаал, ялангуяа УИХ-д сонгогдох, улс төрийн албан тушаалд дэвших нь залгамж чанартай бус, тохиолдлын шинжтэй болсон,

-Төрийн удирдах албанд дэвшин ажиллагсадын мэргэжлийн чиглэл алдагдаж, биологич хүн Сангийн сайд, сэтгүүлч хүн Эрүүл мэндийн сайд, цэрэг армийн анхны мэдэгдэхүүнгүй хүн Батлан хамгаалахын сайд гэх мэтээр томилогдох нь ердийн үзэгдэл болсон,

-Төрийн албанд мэдлэг, чадвар, туршлагаараа дэвших нь нэн ховор болж, өнгө мөнгө, хахуулиар ажил албанд дэвших явдал зонхилох хандлагатай болсон,

-Төрийн албанд зүтгэгсдийг улс төрийн нам, үзэл бодлоор нь ялгаварлах явдал арилаагүйгээр барахгүй нууц байдалд орж, улам нарийн башир аргаар үргэлжлэх болсон,

-Арга башраар төрийн албанд шургалсан хүмүүс авилгал, хүнд суртлыг урган төлжүүлэх шимтэй хөрс дэвсгэр болж буй,

-Нэгэнт улс төрийн намаар дамжин парламентын гишүүд бүрдэж буй нөхцөлд төрийн үйлчилгээний албан тушаалтнуудыг улс төрийн намын харъяалалаас татгалзуулах нь цаашдын улс төрийн намын нийгмийн баазыг ядууруулж, улам чадваргүй хүмүүс сонгуулийн ажилд хүчин зүтгэсэн нэрийдлээр улс төрийн удирдах албан тушаалд, дэвшин гарч ирэх өргөн боломжийг бүрдүүлэх болсон зэргийг цохон тэмдэглэмээр байна. Ийм байдал удаан үргэлжилбэл Монголын төрийн албаны соёл улам ядуурч, зөөлөн хэлбэл тоодоггүй, хатуу хэлбэл даадаггүй, төлөвлөсөн албан бичиг, үг өгүүлбэр нь нохой амаараа ниймэн, энгийн иргэнд хандахдаа ихэмсэглэхийн хэнээ туссан, гар харж, авилгалд идэгдсэн төрийн албан тушаалтнууд олширч, эрх зүйт биш, харин эрх ямбатны ялзарсан нүсэр институт болон хувирах нь гэдгийг дахин хэлье.

Цаашид:

-Жил бүр төрийн албаны соёл сэдвийг улам нарийвчлан, бага хурал, ярилцлага зэргийг зохион байгуулах,

-Төрийн албаны зөвлөлийн шугамаар "Монгол төрийн албаны соёлын уламжлал, шинэчлэл" хэмээх сэдвээр лекц уншуулах, ярианы сэдэв тараах, ажил хэрэгч тоглоом боловсруулах, телевиз, радиогийн нэвтрүүлэг явуулах зэрэг ажил хийх

-Төрийн албаны зөвлөлөөс "Монгол төрийн албаны соёл: уламжлал, шинэчлэл" хэмээх нэгэн сэдэвт хамтын бүтээл туурвих ажлыг "Шихихутаг" хууль зүйн дээд сургууль дээр төвлөрүүлэн хийх зэрэг ажлыг шуурхай зохион байгуулах саналтай байна.

**Эшлэл, зүүлт**


1. Философийн толь, Улсын хэвлэлийн газар. Орос хэлнээс орчуулав. УБ.1990.
2. А.Тойнби. Постижение истории. М.1991.
3. Лувсандандзан. Алтан товч. УБ.1990.
4. Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ.1997.
5. Н.Багабанди. Ерөнхийлөгчийн бодлого, сэтгэл. УБ. 2000.

# “ТӨРИЙН АЛБАНЫ СОЁЛ, ТҮҮНИЙ НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ”

*Доктор, профессор* **Д.Зүмбэрэллхам**
*/Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн дарга/*



Бидний өнөөдөр хөндөн ярилцах гэж байгаа төрийн албаны соёлын тухай асуудал нь зөвхөн төрийн байгууллагынхны биш нийт нийгмийн хүрээнд хамаатай асуудал юм. Учир нь төрийн албаны соёл төрийн байгууллагуудын үйл ажиллагаагаар дамжаад нийгмийн бүхий л харилцаанд нөлөөлж, түүний хөгжил дэвшилд ихээхэн чухал үүрэг гүйцэтгэдгийг дэлхийн улс орнуудын түүхэн туршлага харуулж байна.

Чухам ийм учир шалтгааны үүднээс өнөөдрийн энэ олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах санаачлагыг гаргаж, энэ асуудалд иргэд, төрийн албан хаагчид, улс төрчид, судлаачид, хэвлэл мэдээллийнхний анхаарлыг хандуулахыг хүссэн билээ. Энэ санаачлагыг дэмжиж хурлыг хамтран зохион байгуулж байгаа УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, Шихихутаг ХЗДС, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн суурин төлөөлөгч, Шведийн олон улсын хөгжлийн агентлагийн төслийн удирдагчид гүн талархлаа илэрхийлье.

**I**

Эдүгээ Монгол улсад нийгмийн шинэ тогтолцоо, тэр дундаа улс төрийн шинэ харилцаа, тогтолцоо, түүнийг дагалдаад төрийн албаны шинэ соёл бүрэлдэн төлөвших үйл явц ээдрээ зөрчилтэй боловч бэрхшээл сорилт туулан эрчимтэй өрнөж байна. Монгол дахь улс төр, эдийн засгийн түүхэн шилжилт дууcч, нийгмийн суурь болоод давхаргад үндсэн өөрчлөлтөө хийчихээд байхад, ардчиллын замыг сонгоод хоёр арваныг туулчихаад байхад хүмүүс бид нийгмийн өөрчлөлтөөс хүсэн хүлээсэн үр дүнгээ тэр бүр хүргэж мэдрэхгүй байна вэ? Яагаад манай нийгэм хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн шинж төрхтэй болж тэр бүр чадахгүй байна вэ? Бид юуг орхигдуулав эсвэл юуг хийж чадаагүй байна вэ? гэсэн асуултад нийтээрээ хариулт хайж байна.

Тэгвэл энэ нь бид нийгмийн шинэ соёлыг төлөвшүүлж амжаагүй буюу түүнд бүрэн суралцаж чадаагүй байгаад оршино гэж хэлж болох байна. Нэг үгээр хэлбэл, өмнөх нийгмийн үеийн соёлын тогтсон хэв маягаас шинэ нийгэмд байх ёстой тэр соёлын хэв маягт шилжих шилжилт бүрэн дуусаагүй байна. Гэхдээ соёлын өөрчлөлт яагаад ийм аажим алгуур, удаан байна вэ? гэдэг шалтгааныг эрж хайхдаа “соёл” гэж юу вэ? гэдэгт анхаарал хандуулах шаардлага аяндаа урган гарч байна.

Философи, социологи, улс төр судлал, эрх зүй болон соёл судлалын ном зохиолд соёлын тухай маш олон тодорхойлолт байх боловч доорх утга агуулга нийтлэг байгааг олж харж болно. Ерөнхий утгаараа **соёл** гэдэг ойлголт нь *нэг талаас*, “хүмүүсийн нийгмийн аливаа үйлдэл, үйл ажиллагааны зохион байгуулалт, зохистой арга хэлбэрийн илэрхийлэл”, *нөгөө талаас*, “түүхэн цаг хугацааны туршид уламжлагдаж тогтсон хүмүүсийн нийтлэг итгэл үнэмшил, зан үйл, бэлгэ

тэмдэг, эрхэмлэл, үнэт зүйлс, үнэлэмж, хандлагын цогц юм"[1] гэсэн агуулгыг багтаадаг гэж судлаачид тодорхойлжээ.

Энэ ерөнхий агуулгаар авч үзвэл соёлын шинэ хэв маяг төлөвших гэдэг нь *нэг талаар*, хүмүүс бидний үйл ажиллагааны зохион байгуулалт, арга, хэлбэр, агуулга зорилго нь тухайн нийгмийн харилцаа, хэрэгцээ, шаардлагад зохицож нийцсэн зохист шинжийг олсон байх, *нөгөө талаар*, хүмүүсийн итгэл үнэмшил, зан үйл, үнэлэмж хандлагад үндсэн эргэлт, өөрчлөлт гарсан байх явдал гэдэг нь тодорхой байна. Энэ өөрчлөлт аажим алгуур явагддаг, ингэхдээ дотоод зөрчил, бэрхшээл, саадтай тулгардаг амаргүй үйл явц бөгөөд нийгмийн өөрчлөлтийн нэн бэрх, хүнд сорилт чухамдаа энд байдаг нь өмнөх цаг үеийн хүний нийгмийн бүхий л өөрчлөлтөөс илэрхий харагддаг. Ялангуяа нэн ойрын буюу өнгөрөгч XX зуунд нийгмийн хэд хэдэн шилжилт өөрчлөлтийг туулсан манай орны түүхэн сургамж ч үүнийг бэлээхэн нотолно.

Учир нь шинэ цаг үеийн шинэ зорилт, шинэ асуудлыг хуучин сэтгэлгээ, хуучин арга барил, хуучин зохион байгуулалтаар шийдэх гэж оролдох, эсвэл нийгмийн шинэ харилцаанд хуучин дадал зуршилтайгаа байх, түүнийг шингээх гэж зүтгэх нь зөрчлийг үүсгэдэг. Энэ бол чухамдаа хуучин ба шинэ соёлын хоорондын зөрчил мөн. Өнөөдөр манай нийгэмд, хүмүүс бидний үйл ажиллагаанд ардчиллын соёл, тэр тусмаа Төрийн байгууллагын үйл ажиллагаанд төрийн албаны соёл дутмаг, энэ талаар олон нийтийн үнэлэмж тааруу байгаа нь дээрх зөрчил бодит байдал дээр үргэлжилж байгаатай холбоотой.

## II

Монголчууд бид төрт ёсны өнө эртний уламжлалтай бөгөөд төрийн албаны соёлын өвөрмөц жишиг тогтолцоог төлөвшүүлж хүн төрөлхтний төр ёсны түүхэнд хувь нэмрээ оруулсан бахархам түүхтэй үндэстний нэг билээ. Үүнийг түүх гэрчилж, судлаачид нотолж байгаа төдийгүй эдүгээгийн дэлхийн олон улс орны төр, засгийн тэргүүнүүд хүлээн зөвшөөрч байгаагаа Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, Монголын ард түмэнд ирүүлсэн мэндчилгээндээ илэрхийлсэн байдаг.

Тэдгээрийг төлөөлүүлэн Бүгд Найрамдах Австри Улсын Холбооны Ерөнхийлөгч Хайнц Фишерийн илгээлтээс энд иш татья. Тэрээр илгээлтдээ дурдахдаа: "*...Миний бодлоор цэрэг дайны ололтоос ч илүү чухал зүйл бол өнөөгийн хэмжүүрээр ч шинэлэг хэмээн үзэж болох арвангуравдугаар зууны Монголын эзэнт гүрний засаглал болно. Ер нь үр өгөөжтэй, сайн зохион байгуулалт бүхий засаглал нь аливаа амжилт дагуулсан бодлого, сайн сайхан амьдрал хийгээд дэвшил хөгжлийн суурь үндэс болдог. Үүгээрээ чухал ач холбогдолтой агаад хөхүүлэн дэмжүүштэй зүйл гэдэг нь улс төрийн үндсэн сургамж болно.*

*Төрийн ийм шинэ зохион байгуулалт арвангуравдугаар зууны Монголын эзэнт гүрэнд бий болсон байна. Чингис хаан, түүнийг залгамжлагч ... дараагийн хаад ч төрийн нэгдмэл тогтолцоо, засаг төрийн албан хэргийг хөтлөн явуулах* ***дэг жаяг*** *бий болгож, тэр нь монголын төдийгүй Түрэг, Перс, Төвд, Оросын тухайн үеийн баримт бичгүүдэд ч хэрэглэгдэж байв*"[2] гэжээ. Ийм үнэлэлт дүгнэлт олныг эшлэж болно.

Энэ бол бидний өнгөрсөн түүхэнд хамаарах үнэлгээ бөгөөд, улс үндэстний түүхэн хөгжлийн залгамж чанарын үүднээс авч үзвэл монгол улсын өнөөгийн төрийн албаны соёлд өнгөрснөөс залгамжлах өв уламжлал арвин их байгааг харуулж, сануулж байгаа нэгээхэн баримт юм.

Бидний зорилго, алсын хараа бол өнгөрснөөс сургамж авч, өнөөдрийг өөрчилж, ирээдүй рүү чиглэсэн тогтвортой хөгжил дэвшлийн байр суурийг баталгаатай бэхжүүлэх явдал юм. Үүний туй чухал хүчин зүйл бол төрийн албаны шинэтгэл юм. **Төрийн албаны шинэтгэл,** түүнийг нөхцөлдүүлж буй дотоод, гадаад зайлшгүй шалтгаан, хүчин зүйлүүд, хэрэгжилтийн явц, үе шат, эцсийн үр дүнгийн тухай судлаачид ажиглагчид бишгүй ярьж, бичиж байна.[3]

Монгол улсын төрийн албаны шинэтгэл нь 1990-ээд оноос хойш манай оронд өрнөж эхэлсэн улс төрийн болон эдийн засаг, нийгмийн асар их өөрчлөлтийн тусгал болж, тодорхой үе шатуудыг дамжин хэрэгжиж ирлээ.

[1] *Философский энциклопедический словарь. М.ИНФРА.М. 1999, с.229. Социологическая энциклопедия. М.Мысль, 2003, Т.1, с. 525 Введение в философию. М. Политиздат, 1989. Часть 2, с.524-526 Улс төр судлал. Сурах бичиг. Ред. Б.Дэлгэрмаа, УБ.,2001, II дэвтэр, х.6*

[2] *Их Монгол Улс, Great Mongolian state. 2007, х.22*

[3] *Монгол улсын төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө. УБ.,2007, х.7*

Шинэтгэлийн *эхний үе шатанд* Монгол улс төрийн байгууллынхаа шинэ бүтэц, тогтолцоог бүрдүүлэх, засаглалын хуваарь, зааг хүрээг тогтоох, түүний эрх зүйн үндсийг бүрдүүлэхийг; *хоёр дахь үед* нь төрийн бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий мэргэшсэн төрийн албаны тогтолцоог бий болгох, түүний эрх зүйн орчинг бүрдүүлэхийг гол зорилт болгон түүнийгээ хэрэгжүүлж иржээ. Төрийн албаны шинэтгэлийн *гурав дахь үе шат* нь УИХ-аас батлан эдүгээ мөрдөн хэрэгжүүлж байгаа төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийн зорилтуудаар тодорхойлогдож байна. Энэхүү баримт бичигт заахдаа ***Төрийн албаны шинэтгэлийн эрхэм зорилго нь:*** Иргэдэд ойр, тэдний хэрэгцээг хангахад чиглэсэн, өөрчлөгдөж буй орчинд уян хатан зохицож чаддаг бөгөөд идэвхтэй, санаачлагатай манлайлагч менежер бүхий цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэхэд оршино гэсэн буй. Энэ нь үнэн хэрэгтээ **төрийн албаны шинэ соёлыг төлөвшүүлэх** явдал гэж үзэж болно. Иймд учраас төрийн албаны шинэтгэлийн өнөөдрийн үе шатанд бид төрийн аллбаны соёлыг төлөвшүүлэх асуудлыг бүх талаас нь судлан хэлэлцэж, хэрэгжүүлэн төлөвшүүлэх зайлшгүй шаардлага тулгамдаж байгааг зориуд тэмдэглэж байна.

## III

Төрийн албаны соёлыг төлөвшүүлэх, төгөлдөржүүлэх зорилтыг бодит үйл ажиллагаагаар хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө бид энэ талын ойлголт төсөөллөө нэгтгэх нь өнөөдрийн эрдэм шинжилгээний хурлын нэг зорилт гэж үзэж байна.

**Төрийн албаны соёл** гэдэг ойлголтын агуулга ба багтаамж нэн өргөн хүрээтэй, туи олон талтай. Төрийн албаны соёл гэж юу вэ гэсэн асуултыг соёлтой төрийн алба гэж юуг хэлэх вэ гэсэн асуултаар солиход асуудлын мөн чанар төдий л өөрчлөгдөхгүй гэж бодож байна. Тэгвэл ерөөсөө төрийн алба гэж юу вэ гэдгээс асуудлыг эхэлж хөндье.

"Төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн алба гэнэ"[4] гэсэн Төрийн албаны тухай хуулийн үзэл баримтлалын үүднээс авч үзвэл энд ямар нэг байгууллага, институци, бүтэц тогтолцоо, бүдүүвч загварыг бус харин төрийн нэрийн өмнөөс үүрэг гүйцэтгэж буй тодорхой субьектуудын үйлдэл, зан үйл буюу **үйл ажиллагааг** төрийн алба хэмээн тодотгож байгааг онцлон анзаарах хэрэгтэй. Эндээс улгуулан бодоход төрийн албаны соёл нь бүх шатны төрийн байгууллага, төрийн албан хаагчдын үйл ажиллагааны соёлоор дамжин илэрдэг, түүнээс бүрэлдэн тогтдог, түүгээр хэмжигддэг, тодорхойлогддог нь ойлгогдохоор байна.

Энэ ерөнхий агуулгаар нь авч үзвэл манай төрийн бүх байгууллага, тэдгээрийн албан хаагчдын ажил, үйлчилгээнд үндсэн хуулиар заасан ***төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмууд*** болох *"Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх ёс"*[5] хэр зэрэг хэрэгжиж байгаагаар төрийн албаны соёлын түвшин хэмжигдэнэ гэж үзэж болох юм.

**Ардчилсан ёсны** зарчмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлж чадаж байвал түүнийг өнөөдөр ардчилсан төр, соёлтой төр гэж үзэх болжээ. "Төрийн албаны соёлыг ардчилалын зарчмууд тодорхойлж байдаг" хэмээн захиргааны онолын зарим судлаачид бичиж байгаа нь үүнийг давхар нотолно. Ардчилал гэдэг нь аливаа нэгэн байгууллага биш, харин асуудлыг шийдэх арга зам бөгөөд хүмүүсийн эрхэмлэн дээдлэх зүйлс, хувь хүний эрх чөлөө, нэр төрийг хүндэтгэн дээдлэх утгыг агуулдаг гэдгийг тэд онцлон тэмдэглэжээ.[6]

Ардчилалын бас нэг гол зарчим бол *оролцооны зарчим* юм. Төрийн байгууллага нь нийтийн ашиг сонирхолыг хөндсөн аливаа асуудлаар шийдвэр гаргах, асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлоход, нийгэм соёлын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхэд иргэдийн өргөн оролцоог олон хэлбэрээр хангаж, тэдниэс дэмжлэг авч чадсанаараа ажил хэрэг нь амжилттай ,үр дүнтэй болдог байна.

**Ил тод байх** нь ардчилалын үндсэн зарчмуудын нэг мөн. Энэ зарчим нь төрийн захиргаа, түүний

[4] *Төрийн албаны тухай хууль, УБ.,2008, х.6*

[5] *Ш.Батсух. Захиргааны шинжлэх ухааны ерөнхий онолын зарим асуудлууд, УБ.,1994,*
*Я.Долгормаа. Төрийн захиргааны удирдлага, түүний эрх зүйн тойргийг өргөтгөхөд. Төрийн захиргаа сэтгүүл, УБ.,2002/2; А.Цэнжид. Төрийн захиргаа. УБ.,2009*
*Н.Болд. Төрийн захиргааны шинэтгэлийн орчин үеийн хандлага, монгол дахь хэрэгжилт*

[6] *Ханс Норгрен. Төрийн албан дахь байгууллагын соёл.*

үйл ажиллагаа нь иргэдэд нээлттэй байх, иргэдийг мэдээлэл хүртэх эрхээр хангах замаар бодит амьдрал дээр биелэлээ олдог байх учиртай. Ардчилалын энэхүү суурь зарчмын тухай бид багагүй ярьж бичиж байгаа боловч манай төрийн албаны үйл ажиллагаанд бодитой хэрэгжиж төлөвшсөн гэж хэлэхэд учир дутагдалтай байна. Төрийн байгууллага руу хандсан иргэдийн гомдол санал, шүүмжлэл, эсэргүүцлийн ихэнх нь энэ бүхэнтэй холбоотой байдаг. Энэ бол манай төрийн албаны соёлд ардчилалын соёл дутмаг байгаагийн илрэл юм. Ил тод байдал, иргэдийн оролцоог хангах, хувь хүний эрх чөлөө, нэр төрийг хүндэтгэх, хүмүүсийн эрхэмлэл, үнэт зүйлсийг дээдлэн ажиллахад суралцах нь төрийн албаны хэм хэмжээг төлөвшүүлэх, улмаар төрийн алба ардчилалын төлөө зүтгэж, түүнийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах үүргээ гүйцэтгэхэд чухал түлхэц болох учиртай.

**Шударга ёсны зарчим** ч төрийн албаны үйл ажиллагаанд дээр дооргүй нэлээд үгүйлэгдэж байгаа, иргэдийн зүгээс ихээхэн шүүмжлэл өрнүүлдэг сэдэв билээ. Шударга ёсны зарчим нь иргэдийг ямарваа шалтаг, шалтгаанаар ялгаварлахгүй хандах, танил тал, тал тохой татахгүй байх, авилга, хээл хахуульд өртөхгүй байх, ашиг сонирхолын зөрчлөөс ангид байх гээд олон шалгууртай. Харамсалтай нь энэ бүхнээс манай төрийн алба ангижирч чадаагүй байна. Шударга ёс бол төрийн албаны соёлын том шалгуур, хэмжүүр байх учиртай. Иргэддээ шударга хандаагүй төрийг хэн ч, хаана ч соёлтой төр, ардчилалтай төр гэж үнэлдэггүй. Төрийн алба, түүний үйл ажиллагааны шударга бус үйлдлийн цаана хэн нэгэн тодорхой хувь хүн буюу тодорхой албан тушаалтан, албан хаагч байгаа.Тэд л төрийн албаны болон төлөв шударга ажиллаж буй олон мянган төрийн албан хаагчдын нэр хүндийг түмний дунд унагаасаар байдаг. Нэг үхрийн эвэр доргиход мянган үхрийн эвэр доргидог гэлцдэг. Төрийн албан хаагч нэг бүрийн албаны чиг үүргээ гүйцэтгэх үйлдэл, хандлага, харилцаа болгоноос төрийн албаны шударга ёсны хувь заяа шалтгаална.

Шударга ёс нь **ёс зүйтэй байх** гэдэгтэй шууд холбоотой. Ёсзүй бол нийт хүн төрөлхтөн, аливаа улс үндэстний соёлын түвшний том хэмжүүр, тэр ч утгаараа төрийн албаны соёлын гол тулгуур багана мөн. *"Төрийн албаны мөн чанар нь ард түмэндээ үйлчилж, тэдэнд үнэнчээр зүтгэхэд оршино"*[7] хэмээн хуульд заасан бий.

Ард түмэндээ үйлчлэх ёстой хүмүүс ёс зүйгүй байж явч таарахгүй. Тэр тусмаа уламжлалаар төрийн хар хүн буюу одоогийн төрийн албан хаагчид ёс зүйгүй байх нь төрийн нэр хүндэд халтай төдийгүй төр улс, үндэсний эрх ашигт нэн хохиролтой. Төрийн ёсны тухай сургасан бүхий л мэргэдийн онол сургаалд төрийн хүний ёс зүйн тухай онцлон дурдсан байдаг.

Монголын төр ёсны уламжлалд ч энэ талаар өвлөж уламжлах олон сайхан зүйл бий бөгөөд түшмэл хүний эрхэмлэх есөн зүйлийг[8] тусгайлан тодорхойлж байсан нь чухамдаа төрийн албан хаагчийн ёс зүйн үндсэн хууль байсан гэж үзвэл зохилтой.

Төрийн албаны зөвлөл төрийн жинхэнэ албан хаагчдын ёс зүйн дүрмийг шинэчлэн боловсруулж, засгийн газарт өргөн барихад бэлэн болоод байна. Төрийн жинхэнэ албанд анх орохдоо "... *төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглая. Тангарагаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ*" хэмээн тангараг өргөсөн атлаа ажил хэрэг дээрээ ёс зүйгүй авир үйлдэл, алдаа дутагдал гаргаж байгаа хэнтэй ч болов хуулийн дагуу хариуцлага тооцох боломжийг тус дүрмэнд тусгаж байгаа.

**Хууль дээдлэх нь** төрийн үйл ажиллагаанд гуйвалтгүй баримтлах зарчим төдийгүй төрийн албаны соёлын жинхэнэ бодит хэмжүүр мөн. Өнөөгийн эрхзүйт төрийн язгуур үндсэн шинж, мөн чанар нь бүхий л үйл ажиллагаандаа хуулийг баримтлахад оршино. Гэтэл бидний эргэн

[7] *Төрийн албаны тухай хууль. УБ.,2008, х.6*

[8] *Энэ 9 зүйл аль буй хэмээвээс:*
*"Бүхдэн зөвлөнг бээд эрэмдүүлэх,*
*Буруу тэрсүүгээр хэрэмч үл явах,*
*Бүхэн хүнийг өрлөн хүндэлж хичээнгүйлэх,*
*Бодох шинжих, бодлого ухааныг нарийвчлах,*
*Бүтэц бүхлийг үзэмч үл үйлдэх,*
*Бүхэр үжимдэд солтууран үл живэх,*
*Бүгдын эдэд хомдогсон үл горилох,*
*Бүрүүлан эрэмдүүлэн ичих ичээнийг мэдэх,*
*Бүгдэрийг засахад хорыг үл шингрүүлэх эдгээр болой" гэмээ.*
*Үг хэлэх нь онолыйнхоос алдаргүй мэт боловч үгсэн утга, мөн чанар нь өрчин үеийн төрийн хүний ёс зүйд ав цав нийцэж билээ.*
*Н.Энхбаяр. Хаяжны тахиам зүгэлэх, хүний тахиам сэтгэх. (Хэлсэн үг, илтгэл, ярилцлагын эмхэтгэл). VI боть. УБ.,2008, х.26-д үз.*

тойронд болж байгаа үйл явдал, засаг төрийн ажил, алба хууль номын дагуу явж байгаа юу гэвэл тийм гэж ам бардам хэлэх хүн тэр болгон гарахгүй биз ээ. Мэдээж хууль журмын дагуу асуудлыг шийдэх гэж эрмэлздэг, ажил хэрэгтээ хууль ёсыг баримталдаг олон мянган төрийн албан хаагчид ажиллаж байгаа. Үүний хажуугаар иргэдийн итгэл сэтгэлийг хөсөрдүүлж, мянга мянган төв шударгуу төрийн албан хаагчдын зүтгэл чармайлтыг талаар болгож, хууль журмыг үл тоон, төрийн хэргийг хувийн хэрэг мэт дураар авирлагчид, албан тушаалын нэрээр түрээ баригчид төрийн албыг соёлгүй харагдуулж, хуулийг зөрчигчид, завшигчдад боломж олгож, буруу жишиг тогтоож байна.

Хууль ёсыг дээдлэх зарчмыг төрийн албаны соёлд жинхэнэ утгаар нь хэрэгжүүлж чадвал бүхэлдээ манай нийгмийн эрхзүйн соёлд ихээхэн дэвшил гарах болно. Энэ утгаараа төрийн албаны соёл нь эрхзүйн соёлын бүрэлдэхүүн хэсэг болох төдийгүй, түүний төлөвшил хөгжилд хөтөчийн үүрэг гүйцэтгэх ёстой гэж үзэж байна.

## IY

Бид төрийн албаны соёлын тухай, түүний суурь ойлголт, үндсэн зарчим, гол шинжүүдийн тухай ерөнхийд нь товч дурдлаа. Төрийн албаны соёл гэж бид ерөнхий ярьсаар ирсэн. Одоо ерөнхий ярианаас тодорхой ажил хэрэгт шилжих, тухайлбал, манай төрийн тогтолцооны бүтэц, үйл ажиллагааны ямар түвшинд нь төрийн албаны соёлын зарчим алдагдаж, хэм хэмжээ зөрчигдөж байгааг судлан тогтоож засаж залруулахад гол анхаарлаа хандуулах цаг нь болсон. Энэ үүднээс хандвал төрийн албаны соёлыг дотор нь олон янзаар ангилж, асуудлыг тус бүрт нь ярьж болно. Тухайлбал, засаглал хуваарилах онол, манай үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу байгуулагдсан Монгол улсын төрийн байгуулалын бүтэц, тогтолцоонд үндэслэж төрийн албаны соёлыг:

-Хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага ба түүний үйл ажиллагааны соёл,

-Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага ба түүний үйл ажиллагааны соёл,

-Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага ба түүний үйл ажиллагааны соёл хэмээн ангилан авч үзэж болох байна.

Асуудлыг ингэж тавих нь манай оронд засаглалын аль салаа мөчирт төрийн албаны соёлын төлөвшил, доголдол хэрхэн ямар байгааг тод томруун гаргах, асуудал шийдэх арга замыг тодорхой авч үзэх боломжийг олгоно. Дээрх ангиллыг цаашид нарийвчлан тус бүрт нь задлан ярьж болно. Жишээлбэл, шүүх засаглалын хүрээн дэх төрийн албаны соёлыг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах, ял эдлүүлэх үйл ажиллагааны соёл хэмээн задалбал асуудал улам тодорхой болж хариуцлагын тухай ярих үндэслэл бүрдэнэ.

Манай улсын хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааны соёлын одоогийн түвшингийн талаар иргэд сэтгэл нэн дундуур байгааг судалгаанаас ч, амьдралаас ч харж болохоор байна. Сонгуульд мөнгөөр санал худалдаж авдаг, улс орны нийтлэг эрх ашгаас илүү жижиг тойргийн эрх ашигт явцууран баригддаг, хууль тогтоомж батлахдаа ашиг сонирхлын зөрчилд автдаг, чуулгандаа зоргоороо оролцдог, тасалдаг, бусдыг тал талаас нь загнаж омогддог, заналхийлж дарамталдаг, өөр хоорондоо харьцахдаа элдвээр дуудалцан хэдэрлэлцэж байдаг парламентийн соёлыг монголчууд хүсээгүй нь тодорхой. Парламенттай тогтолцоог бий болгосон нь ардчиллын нэн чухал ололт мөн. Түүнийг эх орондоо зөв төлөвшүүлж энэ институцийн баталсан хууль, гишүүдийн хандлага харилцаанаас төрийн албаны соёлын үлгэр жишээг харж хүртэж байх учиртай.

Бас сонгууль болгоны дараа яам, агентлагуудын тоо албан тушаалд тавихаар тооцоолсон хүмүүсийн зарим бизнесийн ашиг сонирхлоос хамааран үндэслэлгүйгээр хэлбэлздэж байдаг, тухайн албан тушаалд хуваарилагдсан хүмүүс нь төрийн албан хаагчдыг улс төрийн итгэл үнэмшил, хандлагаар нь, эсхүл танил тал, талцалын шалтгаанаар дур мэдэн халж сольж төрийн албанд тогтворжиж мэргэших боломжоо олгодоггүй гүйцэтгэх эрх мэдлийн соёлыг бас л манай ард түмэн хүсэн хүлээгээгүй нь ойлгомжтой. Засгийн газрын бүтэц ямар ч үед тогтвортой, түүнд ажиллаж байгаа албан хаагчдын алба хаах баталгаа нь хангалттай байх явдал энэ салбарын соёлын үндсэн нөхцөл юм.

Шүүх эрх мэдлийн байгууллагын нэрийг барьж иргэдтэй ширүүн догшин харьцдаг, хэрэг маргааныг шийдвэрлэхдээ хойрго шударга бус хандлаг, чирэгдүүлж зовоодог, эцэст нь үндэслэл нь тодорхойгүй шийдвэр гаргаж олон шат дамжих

таагүй нөхцлийг бүрдүүлж иргэдийг мухардуулан дээшээ тэнгэр хол доошоо газар хатуу болгодог шүүх эрх мэдлийн соёлыг одоогийн нийгэм бас л хүсээгүй. Төрийн шударга ёсны соёлыг шүүх эрх мэдэл үлгэрлэн нийгэмд төлөвшүүлэх ёстой. Энэ салбарт хамгийн туршлагатай, хамгийн ёс зүйтэй шударга хуульчид ажиллаж шат шатандаа хараат бус бие даасан бодлоор ажиллах учиртай.

Төрийн албаны соёлыг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшингээр ангилан, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны түвшинд төрийн албаны соёл ямар байгааг ярьж, соёлын үрийг анхан шатны нэгжээс эхлүүлэн соёолуулах цаг болсон. Баг, хороо бол Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн анхан шатны нэгж. Тэнд төрийг төлөөлөн ажиллаж байгаа албан хаагчид бий. Тэдний ажил, үйлчилгээний соёл, албан хэрэг хөтлөлтийн соёл, зан авирын соёлоос л манай төрийн албаны соёл эхлэнэ, бүрдэнэ, түүгээр хэмжигдэнэ, үнэлэгдэнэ. Иймээс өөрчлөлтийг, шинэтгэлийг, шинэ соёлыг засаг захиргааны анхан шатны нэгжид хүргэх нь өнөөгийн чухал зорилт болоод байна.

Төрийн албаны соёлын нэг гол хэмжүүр буюу илэрхийлэл бол **төрийн албаны стандарт** билээ. Иймээс энэ илтгэлийн эхэнд хөндсөн соёлтой төрийн алба гэж юу вэ? гэсэн асуултынхаа хариултыг **стандартны төрийн алба** гэж маш товчоор илэрхийлж болох байна. Иим учраас төрийн байгууллага чиг үүргээ, төрийн албан хаагч албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн менежментийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагуудыг нарийвчлан тогтоосон стандартуудыг боловсруулан мөрдүүлэх нь тулгамдсан зорилтуудын нэг болоод байна.

Төрийн албаны соёлд, төрийн алба ашиг сонирхлийн зөрчлөөс ангид байх, авлигад автахгүй байх, үйл ажиллагаагаа ил тод ойлгомжтой явуулах, хууль журам ёс зүй, ёс суртахууны хэм хэмжээг сахих зэрэг бүх зүйлүүд хамаарна.

Төрийн албаны соёлыг дээшлүүлэх, шинэтгэлийг гүнзгийрүүлэх замаар төрийн захиргааны шинэ хэв маягийг бүрдүүлэх, бүхэлдээ, Монголын төрийг шинээр урлан бүтээж төлөвшүүлэх нь дан ганц төрийн албаны төв болон салбар байгууллагуудын үүрэг төдийгүй бүх нийт төрийн байгууллага, түүний удирдлага, менежерүүдийн хамтын үүрэг, хамтын хүчин чармайлтын үр дүн байх болно.

*Үүний төлөө нягт хамтран ажиллахыг та бүхэндээ хандан уриалж байна.*

*Төрийн алба цэвэр, тунгалаг байх болтугай.*

# ЭРДЭМТЭН, ПРОФЕССОР, БАГШ, СУДЛААЧДЫН ОЮУНЫ ХӨДӨЛМӨРИЙН ҮНЭЛЭМЖИЙН АСУУДАЛД

МИДСК-иас зохион байгуулсан ***"Дээд боловсролын чанар-бидний оролцоо, хамтын ажиллагаа"*** сэдэвт ажил төрлийн зөвлөлгөөний

*"Их, дээд сургуулиудын эрдэм шинжилгээний ажлын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх арга зам"* салбар хуралдаан дээр

Шихихутуг ХЗДС-ийн Гадаад харилцаа, эрдэм шинжилгээ эрхэлсэн проректор, доктор, профессор Ч.Даваадашийн тавьсан илтгэл

Тус салбар хуралдаанд өөрт оногдсон хуваарийн дагуу *"Эрдэмтэн, профессор, багш, судлаачдын оюуны хөдөлмөрийн үнэлэмжийн асуудалд"* сэдэвт илтгэлийг тавихын өмнө Шихихутуг ХЗДС-ийн эрдэм шинжилгээний ажлын талаар мэдээллийн чанартай товч хэдэн зүйл хэлье.

Шихихутуг ХЗДС-ийн зорилго бол сургалт-судалгааны хүлээн зөвшөөрөгдсөн төв болох явдал бөгөөд энэ нь манай ажлын гол чиглэлийг тодорхойлж байдаг.

Энэ хүрээнд бид дараахь ажлыг бодлого, төлөвлөгөөтэйгөөр хийж байна. Үүнд:

***Нэгд,*** манай сургууль эрдэм судлалын ажлын 15 жилийн төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа бөгөөд сүүлийн 5 жил дараалан төр, эрх зүйн орчин үеийн тулгамдсан зангилаа асуудлуудаар олон улсын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж, материалыг эмхэтгэл болгож хэвлүүлж олны хүртээл болголоо. Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойд зориулан зохион байгуулсан *"Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал, орчин үе"* сэдэвт олон улсын бага хурал нь тус ойг тэмдэглэн өнгөрүүлэх үндэсний комиссоос *"Шилдгийн шилдэг"*-ээр шалгарсан юм.

Өнгөрөгч онд бид *"Ардчилал бол хүн төрөлхтний үнэт зүйлс"* сэдэвт олон улсын оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг мөн зохион байгууллаа. Уг бага хуралд гадаад, дотоодын 10 гаруй их, дээд сургуулийн 40 гаруй оюутан илтгэл тавьж идэвхитэй оролцлоо.

Энэ 1 дүгээр сарын 22-нд бид *"Төрийн албаны соёл:Шударга ёс, Ил тод байдал, Ёс зүй "* сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулах гэж байна.

Ирэх оны хичээлийн жилд сургуулийнхаа 20 жилийн ойгоор бид *"Монгол Улсын эрх зүйн шинэчлэл, Ази, Номхон далайн орнуудын эрх зүйн хөгжлийн чиг хандлага"* сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний чуулган зохион байгуулахаар төлөвлөж байна. Энэ бүхэн нь манай сургуулийн эрдэм судлалын ажилд томоохон хувь нэмэр оруулж байна.

***Хоёрт,*** эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хүрээн дэх бидний өөр нэг томоохон ажил бол гадаадын их, дээд сургуультай хийж буй хамтын судалгаа юм. Тухайлбал, ОХУ-ын БУИС, Тува улсын их сургууль, Эрхүүгийн улсын их сургуулиудтай нэлээд хэдэн сэдвээр хамтарсан судалгаа хийж байна.

***Гуравт,*** бид сургуулиа сургалт-судалгааны төв болгох зорилгоо хэрэгжүүлэх хүрээнд сургуулийнхаа бүтцэд судалгааны төвтэй боллоо.

***Дөрөвт,*** багш нараа чадваржуулах тэдний эрдэм судлалын ажлыг хөхүүлэн дэмжих зорилгоор докторын зэрэгтэй залуу багш нарыг төлөвлөгөөтэй бэлтгэх ажлыг өрнүүлж эхлээд байна.

Энэ бүх ажилд сургууль чамгүй санхүүжилт хийж ирсэн бөгөөд энэ 5 жилд 20-иод сая төгрөг эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зориулсан болно. Цаашдаа бид улам их ажил хийхээр төлөвлөн ажиллаж байна.

** ** ** ** ** ** ** ** ** ** ** **** **

Ингээд одоо би оногдсон илтгэлийн сэдвээр гол зангилаа цөөн хэдэн асуудалд та бүхний анхаарлыг төвлөрүүлэхийг хүсч байна.

Их, дээд сургуулийн эрдэмтэн, профессор, багш, судлаачдын оюуны потенциал, түүний үнэлэмж бол энэ том салбарын асар их нөөцийг улс орны хөгжлийн эрх ашгийн тусын тулд хамгийн үр нөлөөтэй, өгөөжтэй ашиглах үндсэн гол нөхцөл юм. Энэ үнэлэмж ямар байхаас уг нөөцийг ашиглах ажлын эцсийн үр дүн шалтгаална.

Өнгөрөгч зууны 70-аад оны Барууны орнуудын хөгжлийн гол үзэл баримтлал бол Даниэл Беллийн "**Post industrial society**" *(постиндустриальное общество)*-ын онол байсан юм. Уг онолын гол цөм нь **"Их сургууль бол хөгжлийн тэнхлэг"** *(Университет есть ось развития)* гэсэн томъёолол байлаа. Тэгвэл өнөөдөр **Монгол орны хөгжлийн үзэл баримтлалыг чухам ингэж л томъёолж, их, дээд сургуулийн нийгэмд гүйцэтгэх үүргийг төрийн хэмжээнд зохих ёсоор үнэлж, түүнийг байх ёстой байранд нь тавимаар байна.** Чухам ингэж байж л бид их, дээд сургуулийн эрдэм судлалын ажлын үр өгөөжийг дээшлүүлж, эрдэмтэн, профессор, багш судлаачдын оюуны хөдөлмөрийн үнэлэмжийг зохих ёсоор өндөржүүлж чадна.

Үүний тулд юуны өмнө, **дэлхийн оюуны хөдөлмөрийн хуваарьт Монгол орны эзлэх байр суурь, орон зайг тодорхойлох хэрэгтэй байна. Энэ орон зайг бид хоёр том соёл иргэншил,** өөрөөр хэлбэл **өрнө, дорнын соёл иргэншлийн уулзвар огтлолцоон** *(на стыке двух цивилизаций)* **дээр олж харах хэрэгтэй.** Энэ үүднээс би **"нүүдлийн соёл иргэншил гэдгээ арай өөрөөр шинээр авч үзэх цаг болжээ", "Хөгжлийн гарц Монгол байна"** гэсэн доктор, профессор Б.Пүрэв-Очир багшийн саналтай санал нэг байна. Гол үзэл баримтлалаа ингэж томъёолж хүчээ төвлөрүүлбэл олон улсын зүгээс манай эрдэмтэд, судлаачидын оюуны хөдөлмөрийг үнэлэх үнэлгээ эрс өөр болно.

Бид улс орныхоо хөгжлийн чиг хандлагыг <u>*биотехнологи, мэдээлэл, харилцааны технологи, нанотехнологи*</u> гэсэн орчин үеийн шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх салбартай холбох гэж оролдон багагүй зүйл хийж байна. Тухайлбал, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Үндэсний хөгжлийн цогц бодлого, "Монгол улсын шинжлэх ухааны, технологийн 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө", "Монгол улсад үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр (2008-2015)" зэрэг удирдамжийн шинжтэй баримт бичгүүд гарлаа. Мөн Инновацийн тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг боловсруулж байна.

Энэ бүх баримт бичигт анализ хийгээд үзэхэд дэндүү хөвсөн, ихээхэн ерөнхий, амьд ажил багатай, Монгол орон дэлхийн улс орнуудын хувьд хөгжлийн тэргүүлэх чиглэл болж буй эдгээр салбарыг чухам аль хэсэгт нь өөрийн орон зайгаа эзлэх нь тодорхой бус байна. Хятад улс яагаад ийм хурдацтай хөгжиж байна вэ гэвэл <u>*нэгд,*</u> тодорхой үе шатанд ч тэр, тухайн жилд ч тэр гарын таван хуруунд багтах тийм зорилтыг дэвшүүлж, түүнд хүчээ төвлөрүүлж, түүнийгээ дэс дараатай хэрэгжүүлдэг, <u>*хоёрт,*</u> энэ зорилтоо нийт ард түмэндээ болон хүн болгонд хүргэж , түүнийгээ үйл ажиллагааных нь удирдлага болгодогт, <u>*гуравт,*</u> гадаад, дотоод бодлогоо үүндээ зангидаж чаддагт л байдаг юм. Бид үүнээс суралцах учиртай.

**Дэлхийн оюуны хөдөлмөрийн хуваарьт Монгол орны эзлэх байр суурь, орон зайг тодорхойлох гол үндэслэл бол Монгол орны байгаль, түүх, эдийн засгийн онцлог, Монгол хүний оюуны чадавхи, генийн потенциал юм.**

Чухам эндээс л бид Монголын оюуны потенциалын их уурхай болсон Их, Дээд сургууль, тэдгээрийн эрдэмтэн, профессор, багш судлаачдын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын их ирээдүйг олж харах учиртай. Өөрөөр хэлбэл, дэлхийн оюуны хөдөлмөрийн хуваарьт болон Монгол Улсын шинжлэх ухаанд Монголын Их Дээд сургуулийн эзлэх байр, орон зайг бид тодорхойлох ёстой. Монголын Их, Дээд сургууль өөрийн зохих орон зайгаа эзлэх боломжтой, боломжтой. Үүний баталгаа нь түүний нөөц хүч юм.

**2008-2009 оны байдлаар**

| Үзүүлэлтүүд | Үндсэн багш | Багш | Эрдэм шинжилгээний ажилтан | Эрдэм шинжилгээний туслах ажилтан |
|---|---|---|---|---|
| *Их, дээд сургууль, коллежи* | **7020** | **6147** | **99** | **41** |
| 1. Төрийн өмчийн сургуульд | 4710 | 4140 | 78 | 32 |
| 2. Төрийн бус өмчийн сургуульд | 2270 | 1969 | 20 | 9 |

*Нийт эрдэм шинжилгээний ажилтны дунд эрдмийн зэрэгтэй ажилтны эзлэх хувь 2008 оны байдлаар 49.8% байна.*

## Судалгааны байгууллагуудын тоо, зардал

| № | Байгууллагын хэлбэр Тоо | | 2008 | | 2009* | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Зардал /сая.төг/ | Тоо | Зардал /сая.төг/ | |
| 1 | Эрдэм шинжилгээний хүрээлэн | Төрийн өмчийн | 168 | 5,516 | 109 | 4,604 |
| | | Хувийн | 4 | 53,3 | 4 | 73,2 |
| 2 | Их, дээд сургуулиуд түүний харьяа хүрээлэнгүүд | Төрийн өмчийн | 206 | 4,5661,1 | 189 | 3,918,5 |
| | | Хувийн | 6 | 42,4 | ** | ** |
| 3 | Эрдэмтдийн хамтлаг | | 3 | 30,5 | 104 | 504,5 |

*Эрдэм шинжилгээний ажлын зардал, их, дээд сургууль, коллежийн нийт урсгал зардал дөнгөж 1%-г эзлэж байна.*

*Их дээд сургууль, коллежийн төсвийн зардлын гүйцэтгэлийг 2008 оны байдлаар үзүүлэв.*

| № | Сургуулийн нэр | Үндсэн ба нэмэгдэл цалин /мян.₮/ | Үүнээс Багшийн цалин / мян.₮/ | Эрдэм шинжилгээний ажил /мян.₮/ |
|---|---|---|---|---|
| 1 | Төрийн өмчийн их, дээд сургууль, коллежуудын дүн | 35390648.9 | 18561911.1 | 1789790.7 |
| 2 | Төрийн бус өмчийн их, дээд сургууль, коллежуудын дүн | 7642757.7 | 4617892.6 | 498440.8 |
| | **Нийт дүн** | **43778954.4** | **23639155.2** | **2289783.1** |

*2008-2009 оны байдлаар улсын хэмжээнд дээд боловсролын байгууллагуудад хэрэгжиж байгаа хөтөлбөр, төсөл*

| № | Байгууллага | Хөтөлбөр, төслийн тоо | Өртөг |
|---|---|---|---|
| 1 | Төрийн өмчийн сургууль | 67 | 876,901,930₮<br>420,00₮<br>182,000€<br>1,500$/Канад |
| 2 | Төрийн өмчийн бус сургууль | 48 | 11,431,239,000₮<br>14,000$ |
| 3 | **Нийт** | 115 | 12,308,140,930₮<br>434,000$<br>182,000€<br>1,500$/Канад |

***Байгаа энэ нөөц хүчийг үр өгөөжтэй ашиглахад бидэнд юу саад болоод байна вэ?***

1. Хүч тарамдаж, судлаачдын судалгааны ажил бодлого, зохицуулалтгүйгээр, үндсэндээ тэдний сонирхол, эрх ашигт тулгуурлан явагдаж буйтай холбогдон давхардлага их байна. Судалгааны сэдэв хэт явцуурч, жижгэрсэн.
2. Эрдэм судлалын ажлыг зохих түвшинд нь тавьж, эрдэмтэн, профессор, багш нарын үүргийг зохистой үнэлэхгүйгээс, тэднийг жинхэнэ ёсоор оролцуулж чадахгүй байна. Нөгөө талаар тийм хөшүүрэг , механизм ч сул байна.
3. Мэдлэг бүтээх ажил жинхэнэ утгаараа хэрэгжихгүй байна.
4. Материаллаг бааз дутмаг, санхүүгийн бололцоо сул байна.
5. Төрийн дэмжлэг, чиглүүлэх үүрэг их үгүйлэгдэж байна.
6. Төрийн өмчийн Их, Дээд сургууль, хувийн өмчийн Их, Дээд сургуулийн хооронд жинхэнэ ажил хэрэгч хамтын ажиллагаа үндсэндээ байхгүй байна.

Хувийн Их, Дээд сургуулийн нөөц хүч /потенциал/, бололцоог дутуу үнэлж, муу ашиглаж байна.

***Цаашид юу хийх хэрэгтэй байна вэ?***

1. Их, Дээд сургуулиудын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын дагналт, хоршилт, төрөлжүүлэлтийг шинэ шатанд гаргах. Үндсэн гол сэдэв, чиглэлүүдийг нь тодорхойлж өгөх;
2. Судалгааны томоохон хамтарсан багийг бүрдүүлэх;
3. Сургууль дундын эрдэм шинжилгээ, судалгааны нэгдсэн том лаборатори, мэдээллийн бааз, бусад материаллаг нөхцлийг бүрдүүлэх;
4. Сургууль дундын хамтарсан судалгааны нэгдсэн сан байгуулах;
5. Улсаас тодорхой захиалга авч, бүтээгдэхүүн, бүтээлээ худалддаг байх /улс захиалга өгч, бүтээлийг нь, бүтээгдэхүүнийг нь худалдан авдаг тогтолцоо бүрдүүлэх/;
6. Их, Дээд сургуулиудын судалгааны ажлын үр өгөөжийг нийтэд мэдэгдэхүйц болгож, хөрөнгө санхүүгийн нөөцөө ихээхэн нэмэгдүүлэхийн тулд илүү дутуу материал тоног төхөөрөмж шаарддаггүй Программ хангамжийг дагнан хариуцаж улсдаа, цаашдаа олон улсын тавцанд томоохон байр эзлэхийн төлөө хүч, анхаарал төвлөрүүлж ажиллах;
7. Профессорын нэр хүндийг асар их өргөж, профессор цолонд хүрэх босго шалгуурыг ихээхэн өндөрсгөж, түүний цалин хангамжийг эрс сайжруулах, профессорын удирдлаган дор түүний багт ажилласан ажилтан, оюутныг ажлын байраар шууд хангадаг тогтолцоог бий болгох;
8. Эрдэмтэн, профессор, багш судлаачдын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын шалгуур үзүүлэлтүүдийг цоо шинээр тогтоох;
9. Дэлхийн жишигт хүрсэн, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн 1-2 сэтгүүлтэй байх. Энэ сэтгүүлд бүтээлээ нийтлүүлэх шалгуур үзүүлэлт их нарийн, түүнд нийтлэгдсэн бүтээлийн шинжлэх ухааны болон мөнгөн үнэлэмж маш өндөр байх;

Энэ бүхний үр дүнд эрдэмтэн профессор, багш, судлаачдын оюуны хөдөлмөр, бүтээлийн үнэлэмж өсч, үр өгөөж нь дээшлэх болно. Өнөөдөр Монгол Улсад оюуны хөдөлмөр, оюуны бүтээлийн үнэлэмж, "Монгол улсад үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр"-т заан тэмдэглэснээр, маш сул байгаа. Ерөнхийдөө оюуны хөдөлмөр, түүний дотор профессор, багш, судлаачдын оюуны хөдөлмөрийн үнэлэмж гэдэг бол томоохон цогц асуудал юм.

Энд хамгийн наанадаж:

1. Төрийн үнэлэмж
2. Шинжлэх ухааны үнэлэмж
3. Зах зээлийн үнэлэмж
4. Боловсон хүчний үнэлэмж
5. Нийгмийн үнэлэмж гэсэн цогц бүрдэл байх ёстой.

Эдгээр нь манайд ямар байгааг товч авч үзвэл:

## НЭГД, ОЮУНЫ ХӨДӨЛМӨРИЙГ /ТҮҮНИЙ ДОТОР ПРОФЕССОР БАГШ, СУДЛААЧДЫН/ ҮНЭЛЭХ ТӨРИЙН ҮНЭЛЭМЖ

Энэ бол шинжлэх ухааныг хөгжүүлэх, оюуны хөдөлмөрийн үр өгөөжийг дээшлүүлэх, оюуны бүтээлийг аривжуулж, түүний үнэ цэнийг өргөж өгөх гол нөхцөл, үндсэн хөшүүрэг нь юм. Орчин үеийн хөгжилтэй бүх улс оронд энэ үнэлэмж өндөр түвшинд хүрч, энгийн өдөр тутмын хэрэгцээ болчихжээ. Энэ үнэлэмжийн тухай аль хэдүй нь ярихаа больсон тэртэй тэргүй энэ нь нийгмийн, улс орны хөгжлийн бодит, амин чухал хэрэгцээ болчихсон юм. Гэтэл манай оронд энэ нь одоогоор I) Бодлогын хүрээнд мэдлэг, оюуныг улс орны хөгжлийн гол хүчин зүйл, хурдасгуур, хүчирхэг хөшүүрэг гэдгийг удирдамжийн чанартай баримт бичгүүдэд тунхагласан; II) Боловсрол, шинжлэх ухаан, технологи, оюуны өмчийн талаар гаргасан хууль тогтоомжуудад нилээд тусгасан; III) Энэ үнэлэмжийг илтгэсэн зарим нэг алхам хийсэн иймл дүр төрхтэй байна.

Энд би шинжлэх ухаан, технологийн сангаар дамжуулан төслөөр эрдэм шинжилгээний ажлыг санхүүжүүлж байгаа, мөн цоо шинэ бүтээл гаргасан эрдэмтэн засгийн газраас 2008 оноос эхлэн 100 сая төгрөг, мөн Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал, БСШУЯ-наас оны шилдэг бүтээлүүдийн 10-15 сая төгрөгийн шагнал олгодог болсон зэргийг хэлж байна. Гэвч оюуны хөдөлмөрийг үнэлэх төрийн үнэлэмж маань том уттаараа бол нэг л их сайхан амаас цаашгүй байна. Энд оршиж байгаа дутагдлууд гэвэл:

1. Төр оюуны хөдөлмөрийг жинхэнэ ёсоор үнэлэхгүй, хууль тогтоомж, удирдамжийн шинжтэй баримт бичигт тунхаглаж, төсвөөс жаахан хөрөнгө гаргасан төдийгөөр санаа амарч байна.
2. Оюуны хөдөлмөрийг жинхэнэ ёсоор үнэлэх төрийн үнэлэмж алга байна. Энд ам, ажлын зөрүү их байна.
3. Төр оюуны хөдөлмөрийн мөнгөн үнэлэмжийг тууштай нэмэгдүүлж чадахгүй, оюуны чадавхи өндөртэй, авьяаслаг чадвартай хүмүүсээ гадагш нь алдаж байна. Нэг үгээр хэлбэл үүний уршгаар "тархи гадагшаа урсч" байна.
4. Төр оюуны хөдөлмөрийн үр шимийг дээд зэргээр хүртэх орчин бүрдүүлж чадахгүй байна.
5. Үүнээс болоод нийгэмд оюуны хөдөлмөрийн үнэ цэнэ их доогуур байна. Гадаадад өндөр өртгөөр суралцсан мэргэжилтэн эх орондоо эргэж ирэхгүй байна. Үүнд зориулсан 2.7 тэрбум төгрөг үр ашиггүй үрэгдэж байна.
6. Оюуны хөдөлмөрийг үнэлэх төрийн үнэлэмжид социализмын инерци их байна, Тухайлбал,

а/ Голлон мөнгөгүй шагналын систем үйлчилж байна. /цол, тэмдэг, өргөмжлөл гэх мэт/

б/ Бэлэнчлэх сэтгэлгээг өөгшүүлж байна.

в/ Гадаадын мэргэжилтнийг хэт их шүтдэг, өөрийн эрдэмтэн, судлаачид, мэргэжилтнийг үл тоомсорлох, тэдэнд үл итгэх хандлага гаргадаг.

г/ Их сургуулийг ойлгох хуучин ойлголт хэвээр байгаа.

д/ Бодлогын шинжтэй том асуудлаа шийдэхгүй байж, жижиг сажиг зүйлээр оролдож, дотоод ажилд нь хөндлөнгөөс оролцох байдал ажиглагдаж байна.

е/. Эрдэмтнээ бэлдээгүй байж хүрээлэн, судалгааны төв байгуулдаг.

7. Төр асар их үнээр бэлтгэсэн оюуны нөөцөө нам, бүлгээр ялгаварлах, багаар ажиллах нэрийдлээр үрэн таран хийдэг. Эрдэмтэд, өндөр мэргэжлийн боловсон хүчнээ эрт тэтгэвэрт гаргадаг.
8. Төр боловсролыг тэргүүлэх салбар гэсэн тунхаглалаа бодит арга хэмжээгээр баталгаажуулж, амьд ажил болдоггүй. Их, Дээд сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зохих ёсоор анхаарч үздэггүй, зөнд нь хаясан, энэ их нөөцийг муу ашигладаг.
9. Ер нь дээд боловсролын талаархи төрийн бодлого алдаатай талруугаа эргэж байна. Учир нь хуучнаар ТМС, одоогийнхоор МУСТ-ийн үйл ажиллагааг хэт дөвийлгөн, түүн рүү хошуурах боллоо. Уг нь байсан юмаа нураачихаад одоо асар их хүч хөрөнгө гарган нөгөөхөө сэргээх гэж байна. Нөгөө шинэ юм гэдэг хуучнаа сэргээхийг хэлдэг гэдгийн үлгэр болж байна. Үүний нэгэн адилаар одоо дээд боловсролоо, ялангуяа хувийн хэвшлийнхнийгээ адлах янзтай болж байна. Бий болгосон юмаа нураах амархан, сэргээх гэдэг тун хэцүү. Түүнтэй адилаар дээд боловсролын тогтолцоогоороо

нэг их сүржин сүрхий оролдчихоод эцэст нь босгох гэж хөглөх вий дээ.

Энэ салбар бусад салбарын нэгэн адил зах зээлийн гольдролоороо явах гэж тэмтчиж байна. Дээд боловсрол шинжлэх ухааныг бодвол зах зээлд илүүтэй орж байгаа салбар юм.

Энд нэгэн зүйлийг тэмдэглэхгүй бол ер болохгүй нь. Энэ нь юу вэ гэвэл: эдүгээ их, дээд сургуулийн талаархи малчдын шүүмжлэл, дарамтыг УИХ-ын танхимд оруулж ирж, төрийн бодлогод тусгаж, олон түмний сэтгэл зүйд муугаар нөлөөлж байна. Үүнийг зогсоох хэрэгтэй. Салбарын яам энэ зохисгүй үзэгдлийг хэрхэвч дэмжиж болохгүй.

**Цаашид яах ёстой вэ?**

1. Төр оюуны хөдөлмөрийг, тэрчлэн эрдэмтэн, профессор, багш, судлаачдын оюуны хөдөлмөрийг үнэлэх үнэлэмжиндээ эрс эргэлт, хувьсгал гаргах. Үүнийг лоозон, тунхаглалаар биш, бодит арга хэмжээгээр, мөнгөн үнэлгээгээр хийх хэрэгтэй байна. Асар их өртөгтэй оюуны хөдөлмөрийн үнэлгээг цоо шинээр тогтоох;
2. Оюуны хөдөлмөрийн үнэлэмжийг ихээхэн өндөрсгөхийн тулд төр оюуны бүтээлийн өмчийн эрхийг бодитойгоор баталгаажуулж, орлого олдог, ашиг хувь хүртдэг тэр тогтолцоог бүрдүүлж өгөх;
3. Төрийн албан хаагч болохын төлөө хошуурдаг тэр орчинг бүрдүүлсний нэгэн адил эрдэмтэд, их, дээд сургуулийн профессор, багш нар, ер нь оюуны хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийг энэ зүгт хошуурч, бүтээл туурвилаа гаргах тэр таатай орчинг төр бүрдүүлж өгөх;
4. Нам, бүлэг, багаар ажиллах гэдэг бодлогоор оюуны хөдөлмөрийг үнэгүйдүүлж, энэ их нөөцийг үрэн таран хийдгийг таслан зогсоох;
5. Оюуны элитийг бий болгох, давтагдашгүй авъяас чадвартай сод ухаантнуудынхаа хүчийг улс орныхоо тусын тулд үр бүтээлтэй ашиглахын тулд /хүн хүч, материал техникийн баазаар ханган өгч/ тохирох бүтэц байгуулан, тодорхой даалгавар өгч ажиллуулан үр ашгийг нь гаргах хэрэгтэй байна. Эрдэмтэн, өндөр мэргэжлийн монгол хүнийхээ үнэ цэнэ, үнэлгээг төр цоо шинээр авч үзэх, монгол хүний үнэлэмжийг эрс дээшлүүлэх. Эхний ээлжинд өөрийн хүнийхээ ухаан, санал бодлыг сонсдог журамтай болох;
6. Төр энэ салбарт мөнгийг амсуулах төдий бус, үр өгөөжөө өгөхүйц томоохон хөрөнгө оруулалт хийх;

Байгалийн баялагийг ард олонд хүртээнэ гэдэг нэрээр зүгээр нэг тараах, үрэн таран хийх биш, энэ хөрөнгийг мэдлэг, оюуныг жинхэнэ үйлдвэрлэх хүч, улс орны хөгжлийн хурдасгуур болохуйц хэмжээнд хүртэл нь зоригтой томоохон хөрөнгө оруулалт болгон зарцуулах хэрэгтэй байна. Тэр чинь л ядуурлыг арилгах гол арга болно.

## ХОЁРТ, ОЮУНЫ ХӨДӨЛМӨРИЙГ ҮНЭЛЭХ ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНЭЛЭМЖ

Энэ үнэлэмж их хуучирч, их хоцорчээ. Энэ нь манай шинжлэх ухаан зах зээлд шилжиж чадахгүй байгаатай юуны өмнө холбоотой байна. "ШУ-ны менежмент цагийн шаардлагаас хоцорч, төсөв царайчилсан"[1] шинжтэй байгаа бөгөөд "Эрдэмтдийг эцсийн мөнгөн үр ашигтай холбохгүй байна."[2] Уг нь судалгаагаар мөнгө олж чаддаг байх, эрдэмтэн хүн саятан болдог болох тэр л механизм үйлчилж байх учиртай. Нэг үгээр хэлбэл мөнгө олох чадварыг урамшуулдаг тийм тогтолцоо, тийм үнэлэмж хэрэгтэй. Энэ нь судалгааны зүйлд цоо шинэ санаа, шинэ шийдэл, шинэ арга технологи бий болсон цагт л боломжтой. Гэтэл өнөөдөр эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнгийн үнэлгээ нь зүгээр л ямар ч хамаагүй нэг өгүүлэл, илтгэл, ном болж байна.

Энэ бол хуучин үнэлгээ. Би энд шинжлэх ухааны үнэ цэнэтэй сайн өгүүлэл, илтгэл, номыг хэлээгүй. Гол нь энэ ном, өгүүлэл, илтгэлд шинэ санаа, шинэ шийдэл, шинэ арга технологи байгаа эсэх нь, түүнд хүрсэн арга зам, процессыг хэрхэн гаргасан л шалгуур үзүүлэлт байх ёстой.

Шинжлэх ухааныг монопольчлох үзэгдэл амь бөхтэй оршсоор байгаа нь мэдлэгийн бусад салбартай интеграцчилах, залуу судлаачдын эгнээг өргөтгөх, өсөж өндийхөд сөргөөр нөлөөлж байна.

Тиймээс оюуны хөдөлмөрийн шинжлэх ухааны үнэлэмжийг орчин үеийн шаардлагад

[1] *Ё.Отгонбаяр. Шинжлэх ухааны ажилтны нэгдсэн арга хэмжээний хурал дээр хэлсэн үг. ШУТС: "Мэдээлэл" сэтгүүл. 2009. №6, 8-р тал*

[2] *Ө.Сүхбаатар. Ярилцлага. Мөн тэнд 11-р тал*

нийцүүлэн цоо шинээр авч үзэх хэрэгтэй байна.

Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага нь чалал муутай үлбэгэр, шахаад шахаад юу ч гарлагтүй эрдэм шинжилгээний ажилтан нэртэй хүн тэжээдэг газар биш, оюуны асар их чадавхитай, шинэ сэтгэлгээтэй, авьяаслаг IQ өндөртэй хүний ордог, бүтээл туурвилтын их ундарга уурхай байх ёстой.

Дэлхийн шилдэг шинжлэх ухааны 15-н сэтгүүлийн аль нэгэнд нь бүтээл нь хэвлэгдсэн эрдэмтэн, профессор, судлаачийг онцгойд авч үзэн, түүнд маш өндөр шагнал олгодог болох хэрэгтэй байна.

## ГУРАВТ, ОЮУНЫ ХӨДӨЛМӨРИЙГ ҮНЭЛЭХ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛЭМЖ

Зах зээлийн нийгэмд энэ бол гол үнэлэмж байх ёстой. Гэтэл манай орны өнөөгийн нөхцөлд энэ үнэлэмж бараг алга гэж хэлэхэд хилсдэхгүй. Энэ нь нэгдүгээрт, улс оронд маань капиталын анхан шатны хуримтлал явагдаж, бизнесменүүд маань гадны бэлэн технологийг авч, цөөн тооны бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нэг үгээр хэлбэл, хөл дээрээ арай ядан зогсох гэж тэнцэж ядаж яваа, үүний улмаас хоёрдугаарт, юун шинжлэх ухаан, шинэ технологид мөнгө зарахтай манатай, энэ нь түүний нэгдүгээр хэрэгцээ болоогүй байгаатай холбоотой юм. Эм үйлдвэрлэл, мал аж ахуй, хүнсний зарим үйлдвэрлэлд л шинжлэх ухаан, технологийн хэрэгцээ аар саархан гарч ирж байгаа юм.

Материаллаг үйлдвэрлэлийн салбарт оюуны хөдөлмөрийн эрэлт, хэрэгцээ, үнэлэмж хоёр талын урсгалтай болж чадаагүй байна. Тийм учраас төрөөс зориуд бодлоготойгоор Шинжлэх ухаан-Боловсрол-Бизнесийн эталон цогцолборыг бий болгоход бүх талын туслалцаа дэмжлэг үзүүлж, түүний үлгэр дууриаллаар бизнесийн орчинг бүхэлд нь өөрчлөх хэрэгтэй юм.

Хоёрт, Оюуны хөдөлмөрийн нийгэм, эдийн засаг, үйлдвэрлэл, үйлчилгээний бодит хэрэгцээг бий болгоё.

Гуравт, Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг санхүүжүүлэх хувийн секторын санхүүжилтийг ихээхэн нэмэгдүүлэх.

## ДӨРӨВТ, ОЮУНЫ ХӨДӨЛМӨРИЙГ ҮНЭЛЭХ БОЛОВСОН ХҮЧНИЙ ҮНЭЛЭМЖ

Энэ үнэлэмж удирдах боловсон хүчинд хамаатай. Энэ нь хоёр утгаар гарч ирэх ёстой. Нэгд, Удирдах боловсон хүчнийг шилж сонгохдоо түүний оюуны өндөр чадавхи, бүтээлч сэтгэлгээг юун түрүүнд гол шалгуур болгоно гэсэн үг. Хоёрт, Уг удирдах ажилтан байгууллага, хамт олон дотроо оюуны хөдөлмөрийг үнэлдэг мэдлэг ухаан сайтай, авьяас чадвартай, бүтээлч сэтгэлгээтэй хүнийг хөхүүлэн дэмждэг байна гэсэн үг.

Гэтэл манайд өнөөдөр багаар ажиллана гэдэг нэрийн дор өөрт дуулгавартай гарын дор хүнээ цуглуулаад, авьяастай, чадвартай, өөрийн гэсэн өвөрмөц сэтгэлгээтэй хүнээ шахан зайлуулдаг муухай практик газар авчээ. Үүндээ бүтцийн өөрчлөлт хийнэ гэсэн сайхан нэр өгч энэ үйлдлээ хийж байна.

Намын харъяалалаар хоморголдгийг энд бүр ярих ч хэрэг алга. Харин хувийн хэвшлийнхний хувьд бол одоо чадалтай, ухаантай, бүтээлч сэтгэлгээтэй хүнийг эрхэмлэх нь илүүтэй болж байна. Аргагүй шүү дээ. Үүнийг ажил нь, үйлдвэрлэл нь, орчин нь шаардаж байна.

Их, дээд сургуулиуд эрдэмтэн, профессор, багш, судлаачдынхаа оюуны хөдөлмөрийг тодорхой үнэлж, бүтээл туурвилыг нь нэмэгдүүлэх талаар бололцооныхоо хэрээр чамгүй зүйл хийж байна. Шалгарсан бүтээлд сая төгрөг олгож байна. /МУИС/ Богино хугацаатай, жижиг жижиг төслөөр багш, судлаачдынхаа шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлж, орлогыг нь нэмэгдүүлж байна. Тухайлбал, МУБИС хагас жилд гэхэд л 80 гаруй сая төгрөгийг ийм жижиг төсөлд зарцуулжээ. ШУТИС-ийн эрдэмтэн, судлаачид 2008 онд, нийт 2 тэрбум 142 сая төгрөгийн өртөг бүхий 193 эрдэм шинжилгээний болон аж ахуйн гэрээт ажил, гадаадтай хамтарсан төсөл хэрэгжүүлсэн байна. СЭЗДС-ийн 4 багш судалгааны ажлын грант авсан. Засагт Хан дээд сургуулийн профессор, багш нарын зохиосон "Микро эдийн засгийн ухаан", "Макро эдийн засгийн ухаан" зэрэг бүтээлүүдийг 30 гаруй их, дээд сургуульд ашиглагдаж байна.

Энэ мэтчилэнгээр сургууль бүр л энэ хүрээнд өөр өөрийн өнгө төрхтэй ажил зохиож, хамт олноо идэвхжүүлж, эрдэм судлалынхаа ажлын үр өгөөжийг дээшлүүлэх гэж оролдож байна.

Цаашдаа их, дээд сургуулиуд профессор багш, эрдэмтэн судлаачдынхаа боловсруулсан хөтөлбөр, бичсэн ном зохиол, сурах бичиг, гарын авлага зэрэг оюуны бүтээлийг нь түүний өмч гэдэг утгаар зах зээлийн үнэлгээнд оруулж, хувь ашиг хүртдэг тогтолцоог бий болгоё.

Эцэст нь, Их, дээд сургуулиуд оюуны хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх нэг гол нөхцөл бол бидний гаргаж буй бүтээгдэхүүний чанар гэдгийг онцгой анхаарч ажиллах ёстой.

## ТАВД, ОЮУНЫ ХӨДӨЛМӨРИЙГ ҮНЭЛЭХ НИЙГМИЙН ҮНЭЛЭМЖ

Энэ үнэлэмжээс их зүйл шалтгаалдаг. Аливаа зүйлийн нийгмийн үнэлэмж нь уг үзэгдэл юмс өсөж өндийх үү, эсвэл уруудаж доройтох уу гэдгийг шийдвэрлэдэг. Үүнтэй нэгэн адилаар оюуны хөдөлмөрийг нийгэм хэрхэн үнэлж байгаагаас түүний хувь заяа ихээхэн хэмжээгээр шалтгаалдаг. Мэдээж энэ үнэлэмжид олон хүчин зүйл нөлөөлдөг. Нэгдүгээрт, хамгийн гол нь төрийн бодлого, түүний урамшуулал юм. Үүний хамгийн тод жишээ бол тамирчдын амжилтыг төр өндөр үнэлдэг болсноор энэ салбар ихээхэн урагшаа хөгжих болж буйг бид бэлхнээ харж байна. Хүмүүс хүүхдээ тамирчин болгох, сумочин, жүдочин болгохын хүслэн болж, тэгвэл амьдрал ахуй нь эрс дээшлэх юм байна гэсэн сэтгэгдэлтэй болж байна. Бөх ч мөн өөрцгүй. Үндэсний бөхийн холбооны менежмент сайн байгаа нь үүнд бас нөлөөлж байна.

Хоёрдугаарт, Нийгмийн үнэлэмжид маш их хүчтэй нөлөөлдөг зэвсэг бол хэвлэл мэдээллийн хэрэгсэл юм. Нийгмийн уур амьсгал, нийгмийн орчинг хэвлэл мэдээллийн хэрэгсэл ихээхэн хэмжээгээр бүрдүүлж байдаг. Оюуны хөдөлмөрийг үнэлэх нийгмийн үнэлэмжид төрийн бодлого ч олигтой нөлөөлөхгүй, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ч чамгүй сөрөг нөлөө үзүүлж байна. Учир нь Монголд өнөөдөр хэвлэл, мэдээллийн хэрэгсэл өнгөтэй өөдтэйгөө намнадаг том бороохой болжээ. Хамгийн наад зах нь хэвлэл мэдээллийн "буянаар" Монголд нэртэй хүндтэй нэг ч лидер /манлайлагч/ алга. Бүгд л авилгач, бүгд л хог, шаар. Гэтэл тэр хүмүүс маань оюуны чадавхийн хувьд олон арван жил, их хөрөнгө хүчээр бэлтгэгдсэн өндөр зэрэглэлийн боловсон хүчин байдаг. Түүний хүчийг нийгмийн тусын тулд үр өгөөжтэй ашиглахын оронд нэр хүндгүй, хэнд ч хэрэггүй "амьтан" болгож хувиргадаг.

Гуравдугаарт, оюуны хөдөлмөрийг үнэлэх нийгмийн үнэлэмжид өнөөдөр нөлөөлж буй нэг томоохон хүчин зүйл бол ард олны ядуурал, ажилгүйдэл юм. Ядуу тарчиг амьдралтай иргэд маань юун ном худалдаж авч унших манатай. Өдөр тутмын амьдралаа яая гэж байна. Энэ нь ард түмнийг оюуны хоосролд хүргэж байна. Иймээс байгаа бололцоогоо ашиглан ард олныхоо оюуны хомсдолыг арилгахын төлөө тэмцэх нь оюуны хөдөлмөрийг үнэлэх нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэх нэгдэх гол нөхцөл болж байна.

Хоёрт, энэ үнэлэмжийг дээшлүүлэхийн тулд эрдэмтэд багш судлаачдын оюуны хөдөлмөрийг хүмүүс, эрдэмтэд, багш, судлаачдын өдөр тутмын амьдрал, ахуй нөхцөл нь хэн бүхний нүдэнд мэдэгдэхүйц сайжирч, тэр чинээгээр хүмүүс оюуны хөдөлмөр луу хошуурах хандлага, уур амьсгалыг нийгэмд бий болгох хэрэгтэй байна.

Гуравт, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нийгмийг оюунлаг болгохын төлөө, нийгмийн гишүүдэд гоо сайхны мэдрэмж төрүүлж, эерэг энерги нийгэмд алхам алхамаар хуримтлуулахыг эрхэм зорилтоо болгон ажиллах хэрэгтэй байна.

Эцэст нь оюуны хөдөлмөр, бүтээлийг үнэлэх нийгмийн үнэлэмж дээшилснээр оюуны бүтээлийн үнэ цэнэ өсч, бүтээл нь арвижиж, оюуны салбарынхны алдар хүнд, ахуй амьдрал нь эрс дээшлэхээс гадна энэ салбар авъяаслаг ухаантай залуучуудаар ундарч оргилох болно. Ард олны оюуны хэрэгцээ, түүний хангалт бол оюуны хөдөлмөрийн үнэ цэнэ, үнэлэмжийн гол шалгуур юм. Бид энэ шалгуураа орчин үеийн соёлт ертөнцийн түвшинд хүргэх учиртай.

Монгол орноо Монгол хүний оюуны чадавхи, генийн потенциалын их ундарга болсон оюунлаг орон болгоцгооё.

# "ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЧАНАР-БИДНИЙ ОРОЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГАА" СЭДЭВТ АЖИЛ ТӨРЛИЙН УУЛЗАЛТЫГ НЭЭЖ МИДСК-ЫН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ, ШИХИХУТУГ ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭД СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ, ДЭД ПРОФЕССОР Д.ОЮУНЦЭЦЭГИЙН ХЭЛСЭН ҮГ

Эрхэм хүндэт эрдэмтэн, профессор багш нараа

Энд хүрэлцэн ирсэн ноёд, хатагтай нараа

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая

Өнөөдөр бид, МИДСК-иас зохион байгуулж буй "Дээд боловсролын чанар-бидний оролцоо, хамтын ажиллагаа" сэдэвт ажил төрлийн зөвлөлгөөн хийхээр хуран цуглаад байна. Монгол Улсын ерөнхий сайд С.Батболд боловсролын салбарынхантай анхлан уулзаж, хэлсэн үгэндээ манай төр, засгаас боловсролын салбарт ойрын жилүүдэд хэрэгжүүлэх бодлого, зорилтыг тодорхойлсон билээ. Манай өнөөдрийн зөвлөлгөөн энэхүү бодлого, зорилтыг хэрэгжүүлэх ажлын эхэнд болж байгаа нь цаг үеэ олсон чухал ач холбогдолтой юм.

Шинжлэх ухаан, технологийн үсрэнгүй хөгжлийн энэ үед дээд боловсролын салбарт даяаршлын давалгаа хүчтэй түрэн орж ирж байна. Хил, заагтүй боловсролын янз бүрийн хэлбэрүүд үүсэн гарч, улс гүрэн, тив дэлхийг хамран түгэн дэлгэрч байна. Өнөөдөр дэлхийн аль ч өнцөгт дээд боловсролын салбарт нийт нийгмээрээ сурч боловсрох, холбоо, мэдээллийн шинэ технологийн үр нөлөө, мэргэжилтэй боловсон хүчин болон оюутан, суралцагсдын олон улс хоорондын шилжилт хөдөлгөөн, шинжилгээ судалгааны глобаль сүлжээ зэрэг олон олон шинэлэг зүйлүүд бий болж байна.

- Боловсролыг ханган нийлүүлэгч шинэ байгууллагууд бий болсон
- Сургалтын шинэ хэлбэрүүд үүссэн
- Насан туршдаа сурах үйл явц илүү ач холбогдолтой болж, төгсөлтийн дараах боловсролын хэрэгцээ нэмэгдсэн
- Боловсролын салбарт төрийн бус секторын хөрөнгө оруулалтын хэмжээ ихэссэн зэрэг нь боловсролын салбарын бүтэц, боловсролын чанар, хүртээмж, олон янзын хувилбар болон санхүүжилтийн хувьд чухал харилцаа хамаарлыг үүсгэж байна.

Боловсролыг улс орондоо нэг улс- үндэстэн ганцаараа ханган нийлүүлдэг үе улиран өнгөрч, мэдлэгт суурилсан эдийн засгаас мэдлэгт суурилсан нийгэм рүү дэлхий даяараа шилжиж байгаагийн хүчирхэг үр нөлөө эдийн засаг, улс төр, соёл, шинжлэх ухааны салбараас гадна боловсролын салбарт илүүтэй илэрч байгааг бид харж, мэдэрч байна. Эл нөхцөл байдалд дээд боловсролыг бараа бүтээгдэхүүний нэгэн адилаар худалдан авах ба зарж борлуулах, арилжааны бүтээгдхүүн гэж үзэх хандлага улам бүр газар авч байна.

Монгол улсын хувьд дэлхийн дээд боловсролын салбарт гарч байгаа даяаршлын энэхүү эрчимтэй шинэ давалгаанд хөл дээрээ тогтож, өөрийн орны амин эрх ашигт нийцүүлэн улмаар юу хийх ёстойгоо зөвшилцөн хэлэлцэхээр энэхүү арга хэмжээг зохион байгуулж байна. Манай зөвлөлгөөн:

- Дээд боловсролын байгууллагууд цаашид яаж хөгжих ёстой вэ?
- Боловсролын эрх зүйн орчныг шинээр тавигдаж байгаа дээрх шаардлагуудад нийцүүлэн хэрхэн улам боловсронгуй болгох вэ?
- Төрийн болон төрийн бус өмчийн их, дээд сургуулиудад төрөөс адил, тэгш хандах боломжийг яаж бүрдүүлэх вэ?
- Төрөөс дотоодын боловсролын зах зээлээ хэрхэв хамгаалах ёстой вэ, ямар бодлого баримталж байна вэ?
- Боловсролын салбар дахь төрийн зохицуулалт

өнөөдрийн арга, хэлбэрээрээ цаашид үргэлжлэх үү, эсвэл шинэчлэлт, өөрчлөлт хийж, зах зээлийн жам ёсны голдрилд нь оруулах ёстой юу?

- Элсэлт, төгсөлтийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээтэй хэрхэн уялдуулах вэ?
- Боловсролын салбарт хувийн хэвшлийн сургууль байгуулан ажиллаж байгаа үүсгэн байгуулагчид, хөрөнгө оруулагчид Монгол улсын өнөөгийн хөгжилд эерэг үйл ажиллагаа явуулж байна уу, эсвэл ядуурал нүүрлэх, ажилгүйчүүдын эгнээг өсгөх эх сурвалж болж байна уу?
- Бид ажлын байранд зориулан боловсон хүчин бэлтгэж байна уу?, эсвэл хувь хүмүүст нийгэмд байр сууриа олж, ажлын байраа бүй болгон гэр бүл, амьдралаа авч явах чадвар олгож байна уу. Зах зээлийн нөхцөл дэх мэргэжлийн боловсролын үндсэн зорилго, философийг яаж тодорхойлж байна вэ? Оюутны импортыг нэмэгдүүлэх бодлого байна уу. Их, дээд сургуулиуд гадаадаас авах оюутны тоогоо нэмэгдүүлэхэд нь төрөөс ямар дэмжлэг үзүүлэх вэ?
- Боловсролын шинэчлэлт хийхэд их, дээд сургуулиадаас юу хийх вэ, хэрхэн хамтарч ажиллах вэ зэрэг олон асуултанд хариулт өгөөсэй гэж хүсч байна.

**Ингээд МИДСК-нас санаачлан зохион байгуулж буй "Дээд боловсролын чанар бидний оролцоо, хамтын ажиллагаа" сэдэвт ажил төрлийн зөвлөлгөөнийг нээснийг мэдэгдье.**

Манай зөвлөлгөөнд Монгол улсын засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл,шинжлэх ухааны сайд, доктор Ё.Отгонбаяр, УИХ-ын нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга Д.Арвин, УИХ-ын гишүүн Д.Оюунхорол, ШУА-ийн ерөнхийлөгч акедимич Б.Энхтүвшин, шинжлэх Ухаан Технологийн сангийн захирал Т.Ган-Эрдэнэ, БСШУЯ-ны хариуцлагатай ажилтнууд, Боловсролын хүрээлэнгийн захирал, доктор Н.Бэгз, МИУЗ-ийн дэд дарга, доктор В.Алзахгүй, Сургалтын төрийн сангийн дарга Д.Нансалмаа, Боловсролын үнэлгээний төвийн захирал Д.Энхбат, ХИДСХ-ны ерөнхийлөгч Н.Ням-Осор, МИДСК-ын гишүүн сургуулиудын ректорууд, удирдах ажилтнууд оролцож байгааг уламжлахад таатай байна.

Ажил төрлийн зөвлөлгөөнөөс холбогдох баримт бичиг буюу зөвлөмж гаргах болно. Зөвлөлгөөндөө идэвхитэй оролцож, үнэ цэнэтэй санал, шүүмжлэл гаргана гэдэгт Та нөхдөд итгэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа

# НЯЦААЛТ ХИЙХ ЭРХИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АРГА ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

МУИС-ийн докторант Ширчингийн Сүхбаатар

Няцаалт хийх эрхийн тухай ойлголтыг академич С.Нарангэрэлийн "Эрх зүйн эх толь бичиг"-т "Тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараасан бодит байдалд нийцээгүй иргэн буюу байгууллагын нэр төр ба алдар хүндийг гутаасан мэдээ сэлтийг няцаахыг редакцаас шаардах тэдний эрх. Ийм эрхийг хэрэв иргэн өөрөө няцаахыг шаардах боломжгүй бол иргэний хууль ёсны төлөөлөгч эдэлнэ"[1] хэмээн заажээ.

Монгол Улсын Иргэний хуулиудад[2] нэр төр, алдар хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол уул мэдээг няцаах тухай ойлголт анх 1963 оны Иргэний хуулийн зургадугаар зүйлд хуульчлагджээ. Түүнд "Иргэн, буюу албан байгууллагын нэр төр, алдар хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол уул мэдээг няцаахыг дээрх иргэн буюу албан байгууллага шүүхэд шаардах эрхтэй. Хэрэв дурьдсан мэдээг хэвлэлд нийтэлсэн бол зохих няцаалтыг хэвлэлээр дамжуулан гүйцэтгэнэ. Бусад тохиолдолд няцаалт хийх журмыг шүүх тогтооно" хэмээн заажээ.Энэ нь манай улсын Иргэний хуульд хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах талаар анхлан орсон дэвшилтэт заалт юм.

Үүнээс 31 жилийн дараа буюу 1994 онд батласан Иргэний хуулийн шинэчилсэн найруулгын долдугаар зүйлд "Иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах" талаар тодорхой заалт оржээ. Энэ хуулиар өмнөх хуулийн зохицуулалтад байгаагүй "ажил хэргийн нэр хүндийг хамгаалах" асуудал шинээр орж ирсэн байна. "Иргэн, хуулийн этгээд өөрийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ гутаагдсан гэж үзвэл уг мэдээг няцаалгах, ийнхүү гутаагдсанаас учирсан гэм хорыг... арилгуулахыг... шаардах эрхтэй" гэж заажээ. Эл заалтын ач холбогдлыг Академич С.Нарангэрэл "Тус улсад анх удаа нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасныг мөнгөн хэлбэрээр арилгах болсон юм"[3] хэмээн Монголын төр, эрх зүй сэтгүүлд 1997 онд бичсэн өгүүлэлдээ онцлон тэмдэглэсэн байна.

Уг хуулийг дагаж мөрдсөнөөс хойшхи хугацаанд нэр төрөө мөнгөн хэлбэрээр үнэлсэн нэхэмжлэлийн тоо жилээс жилд эрс олширч шүүх улсын хэмжээнд 1992 онд 31 хэрэг хянан шийдвэрлэж байсан бол энэ тоо 1996 онд 110, 1999 онд 140 болж өсжээ.Шүүхээр шийдвэрлэгдсэн эдгээр хэргүүдийг судалж үзэхэд дийлэнхдээ няцаалтыг мөнгөн бус хэлбэрээр нэр төрийг үндэсгүйгээр гутаан доромжилсон нь тогтоогдсон тул нэр төрийг нь сэргээж уучлал гуйхыг даалгасан шийдвэр гаргасан байна.

Монгол Улсын 1994 оны Иргэний хуулийн шинэчилсэн найруулгын нэг онцлог нь юуны өмнө нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан гэдгийг нотлох шаардлагатай болсон байна.

Харин хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасныг няцаах болон албан ёсны баримт бичигт тусгагдсан мэдээг няцаахад баримтлах тусгай журмыг хуулиар тогтоогоогүй орхигдуулжээ. Энэ байдлыг 1999 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Иргэний хуульд оруулсан нэмэлтээр засаж мөн зүйлийн гуравдугаар хэсэгт "Иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасанаас ...учирсан гэм хорын хэмжээ, арилгах аргыг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүх тодорхойлно" хэмээн хуульчилсан байна.

Мөн 1994 оны Монгол Улсын Иргэний хуулийн 392 дугаар зүйлд "Эд хөрөнгийн бус гэм хорыг арилгах" арга замыг дараахь байдлаар хуульчилжээ.

1."Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан эд хөрөнгийн бус гэм хорыг мөнгөн буюу бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ" гэсний

[1] . С.Нарангэрэл "Эрх зүйн эх толь бичиг" УБ 2007 он. 331 дэх тал
[2] Иргэний хуулиуд /1926,1952,1963,1994,2002/, эмхэтгэл,өөрчлөлтүүд 2-р боть. УБ 2002 он.
[3] С.Нарангэрэл. "Монголын төр,эрх зүй" сэтгүүл УБ 1997 он.

Дугаар 4.1 дэх тал

дагуу "бусад хэлбэр"-т оруулах замаар Улсын Дээд шүүх жишээлбэл, ажилчны хөдөлмөрийн дэвтэрт буй ажил тасалсан буюу хөдөлмөрийн сахилгыг ноцтой зөрчсөн гэсэн тэмдэглэл нь бодит байдалд нийцэхгүй тохиолдолд хөдөлмөрийн дэвтрийг нь шинээр сольж өгүүлэх байдлаар шийдвэрлэж болох юм. Иймучраас бусад аргаар няцаалт хийх гэдгийг шүүхийн тайлбараар нарийвчлан тогтоох шаардлагатай байна. Ингэхдээ мэдээг тараасан тэр аргаар нь няцаана гэсэн үзэл баримтлалыг удирдлага болгох нь зүйтэй"[4] гэсэн саналыг Академич С.Нарангэрэл дэвшүүлээд "Мэдээллийн хэрэгслээр бодит байдалд нийцэж байгаа болон нэр хүнд, алдар хүндийг гутаагаагүй боловч иргэний эрх болон хууль ёсны ашиг сонирхлыг тодорхой хэмжээгээр хөндсөн буюу ажил хэргийн нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлсэн мэдээ тараах тохиолдол цөөнгүй гарч байна. Энэ нь ихэвчлэн ажил хэргийн шүүмжлэлтэй холбогдсон байдаг. Ийм тохиолдолд уг иргэн хариу тайлбарыг мэдээг тараасан мэдээллийн арга хэрэгслээр гаргуулах эрхтэй болох"-ыг шүүхэд анхааруулсан байна.

Няцаалт хийхээс гадна иргэнд учирсан эд хөрөнгийн бус гэм хорыг мөнгөн хэлбэрээр арилгах журмыг хуульд заажээ. Монгол Улсын 1994 оны Иргэний хуулийн 392 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Шүүх эд хөрөнгийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан арга, хэрэгсэл, тараасан хүрээ, хохирогчид учирсан сэтгэл санааны үр дагавар зэргийг харгалзан, нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох"-оор заасан байна. Шүүх нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэж үзсэн нөхцөлд юуны түрүүн няцаалт хийх бөгөөд онцгой тохиолдолд мөнгөөр илэрхийлэн тогтоож ирсэн байна.

Хууль тогтоогч эд хөрөнгийн бус гэм хорыг арилгах мөнгөний хэмжээг тодорхойлох гол шалгуурыг мэдээ тараасан арга /амаар буюу бичгээр/, хэрэгсэл /сонин, сэтгүүл, радио, телевиз зэрэг/, тараасан хүрээ /хэдэн хувиар нийтэлсэн, хэдэн хүн үзэж сонссон/, хохирогчид учирсан сэтгэл санааны үр дагавар /ёс суртахууны шаналгаа, зүдүүр/ гэж үзжээ. Эдгээр нь эд хөрөнгийн гэм хорыг нөхөн арилгахад баримтлах бодитой шалгуур болж чадахгүй байна. Энэ нь нэг талаар нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн хэмжээ өөр өөр нөгөө талаар шүүх ч янз бүрээр тогтоож байгаагаас харагдаж байгаа юм.

Хууль тогтоогч "зэрэг" гэсэн нэр томъёо ашигласан байх тул шүүх өөр бодитой шалгуурыг хэрэглэх боломжийг олгосон гэж үзэж болох юм. Бидний үзэж байгаагаар эд хөрөнгийн бус гэм хорыг арилгах хэмжээг тодорхойлоход зайлшгүй харгалзан үзэх шалгуур нь хариуцагчийн гэм буруугийн хэр хэмжээ хохирогчийн хувийн байдлын онцлогоос шалтгаалан бие махбодийн болон ёс суртахууны шаналгаа, зүдүүрийн хэр хэмжээ, гэм хор учруулагчийн эд хөрөнгийн байдал зэргийг анхааран үзүүштэй юм.

2002 оны 9 дүгээр сарын 1-нээс мөрдөгдөж эхэлсэн Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд "Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах" заалт өмнөх хуулийн заалтаас улам бататгагдан оржээ. Уг зүйлд "Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээхээр заажээ.

Мөн бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол няцаах үүрэг хүлээхээр хуульчилсан байна.

Түүнчлэн хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр тарааснаас гэм хор учирсан гэж үзвэл иргэн уг гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй болсон байна.

Мөн хуульд иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс, хөрөг зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн, олон нийтэд үзүүлснээс гэм хор учирсан гэж үзвэл тухайн этгээд гэм хорыг арилгахыг шаардах эрхийг шинээр хуульчилж өгөв.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад аргаар гутаасан гэх мэдээлэл бодит үнэнд нийцэхгүй болох нь шүүхээр тогтоогдвол няцаалт хийх журмаар тэдний нэр төрийг хуулиар хамгаалах, харин мэдээлэл үндэслэлтэй болох нь тогтоогдвол нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох замаар хариуцагчийн хэвлэн нийтлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрхийг хамгаалах, олон ургальч үзэл бодлыг дэмжих журмыг шүүн таслах ажиллагаандаа удирдлага болгохын чухлыг[5] Улсын дээд шүүхийн иргэний хэргийн тэнхимийн 2000 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан зөвлөмжинд тэмдэглэсэн байна.

[4] Мөн тэнд

[5] Улсын дээд шүүхийн мэдээлэл. УБ 2001 он. Дугаар 1.

Мөн "Иргэний эрх зүй нь хүний нэр төрийг хуульчлан баталгаажуулах, хэрэв нэр төрийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадаагүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар шүүх няцаах үүрэгтэй"[6]-г Хууль зүйн тайлбар толь (Legal dictionary)-нд тэмдэглэсэн нь бий.

Монгол Улсын Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгслээр няцаах үүргийг хүлээлгэсэн.

Энэхүү хэм хэмжээнд хууль зүйн тодорхой бүтцийг хамааруулсан байна. Тухайлбал, иргэний хуулнар хамгаалсан ашиг сонирхолыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хөндвөл үүргийн эрх зүйн харилцаа үүсэж, хохирогч өөрийн хариут нийтлэхийг шаардах эрхтэй ба бодит байдалд нийцээгүй нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээлэл тараасан этгээд тухайн хариуг нийтлэх үүргийг хүлээдэг.

Энэ талаар дотоод гадаадын судлаач эрдэмтэдийн зохиол бүтээлд хэрхэн туссаныг сонирхвол Хууль зүйн ухааны доктор О.Жамбалдорж "Монгол Улсын иргэний эрх зүй" бүтээлдээ "Нэр, нэр төр, ажил хэргийн нэр хүнд, алдар хүндийг сэргээхдээ тэдгээрийн сэргээх аргыг тодорхойлох ёстой. Уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр хэрэгслээр няцаах ёстой"[7] хэмээн бичжээ.

Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг "хамгаалах эрх зүйн харилцааны хүрээнд субъект бүр хууль бус үйлдлийг таслан зогсоох эрх, өөрийн эрхийг сэргээх, хохирлоо нэхэмжлэх болон бусад материаллаг-эрх зүйн арга хэрэгслүүдээр хамгаалуулах эрхтэй байдаг"[8] талаар А.П.Вершинин "Способы защиты гражданских право в суде" бүтээлдээ тэмдэглэжээ.

"Бодит байдалд үл нийцэх нэр төр гутаасан мэдээ тараах нь хууль зөрчсөн үйлдэл бөгөөд энэ нь хамгаалалтын чиглэлтэй гэрээнээс гадуур онцгой үүргийг бий болгож, түүний хүрээнд хамгаалалтын ерөнхий ба тусгай аргууд хэрэглэгддэг"[9] талаар М.Л.Шелютто "Гражданско-правовая защита чести, достоинства и деловой репутации" эрдэм шинжилгээний бүтээлдээ тэмдэглэсэн байна. Ерөнхий аргуудын зэрэгцээ материаллаг бус үнэт зүйлсийг хамгаалах иргэний эрхийн тусгай аргууд ч байх шаардлагатай нь эндээс харагдаж байна. Материаллаг бус үнэт зүйлсийг хамгаалах иргэний эрхийн тусгай аргууд дотор үнэн байдалд нийцээгүй нэр төр, алдар хүндийг гутаасан мэдээнүүдийг няцаах нь онцгой байр эзэлдэг.

Моралийн гэм хор эд хөрөнгийнхөөс ялгаатай нь материаллаг бус хохирол юм. Үүний хамт мөнгөн хэлбэрээр нөхөн арилгуулах нь түүнийг хамгаалах эд хөрөнгийн арга болдог. Оросын Холбооны улсын эрдэмтэн Н.С.Малеин, М.Н.Малеина, А.М.Эрделевский, В.Быков нарын ихэнх судлаачид моралийн гэм хорыг арилгах нь юуны өмнө нэр төр, алдар хүндийг сэргээх арга хэмжээ болдог гэдэгтэй санал нэгдэж байна. Нэлээд тооны судлаачид эд хөрөнгийн бодит хохирол, алдагдсан ашгийг нөхөн төлүүлэх нь буруу, арилгуулах нь чухал нөхцөл гэж үздэг.

"Ийм зохицуулалт нэгд, эмх замбараагүй байдлыг арилгана, хоёрт, нэхэмжлэгчийн эд хөрөнгийн хүрээг бүрэн хамгаалах боломж олгодог"[10] талаар Л.Трунова "Компенсация морального вреда" өгүүлэлдээ бичсэн байна.

Гэвч бүрэн дүүрэн хамгаалахад иймэрхүү үнэт зүйлсийг хөндсөн үйлдлийг таслан зогсоох нь хангалттай биш юм.Үнэн байдалд нийцээгүй нэр төр гутаасан мэдээг няцаах үүргийг хариуцагчид хүлээлгэх нь чухал. Зөвхөн материаллаг бус үнэт зүйлсийг зөрчихөөр заналхийлж буй үйлдлийг таслан зогсоох нь өөрийн гэсэн онцлогтой байдаг. Энэ тохиолдолд үүрэг биелүүлэх нь мэдээг няцаахад бус, харин хууль бус үйлдлийг зогсооход чиглэгддэг. Жишээ нь, номыг хэвлэсэн тоогоор хураах, өмнө нь үзүүлсэн теле нэвтрүүлгийг эфирээс хасах зэрэгт оршино. "Хамгаалах ийм аргуудыг няцаалтын адил тусгай арга гэж үзэж болох ба учир нь тэдгээр нь хамгаалалтын ерөнхий аргуудын хүрээнд багтаж байдаг"[11] талаар доктор В.Н.Соловьев "Нематериальные блага в гражданском праве и их защита" номондоо бичжээ.

[6] Хууль зүйн тайлбар толь.УБ 2003 он. 181 дэх талд
[7] О.Жамбалдорж "Монгол Улсын Иргэний эрх зүй" 1-р дэвтэр. УБ 2004 он. 272 дахь талд
[8] А.П.Вершинин "Способы защиты гражданских прав в суде". Петербург 1997 стр 31
[9] М.Л.Шелютто "Гражданско-правовая защита чести, достоинства и деловой репутации". Дисс. Канд. Юрид.наук. М 1997, стр 7
[10] Л.Трунова "Компенсация морального вреда" Современное право. М 2002.№4 стр 30
[11] В.Н.Соловьев "Нематериальные блага в гражданском праве и их защита". Автореф.Дисс.канд. юрид. Наук. Рязань., 2003.

"Няцаалт гэдэг ойлголт няцаалтын хоёр төрлийг нэгтгэдэг. Няцаалт өгөх шаардлагыг ёсоор болгож шүүх нэр төр гутаасан мэдээ үнэн байдалд нийцээгүйг хүлээн зөвшөөрснөөрөө шүүхийн шийдвэр өөрөө няцаалт болдог. Дараа нь шүүх няцаалтыг хариуцагчид үүрэг болгосноор түүнийг гүйцэтгэх явцад няцаалтын хоёрдахь төрөл биеллээ олдог"[12] гэж судлаач М.Л.Шелютто тэмдэглэсэн байна.

Үүнээс гадна хуульд ч, шүүхийн баримт бичгүүдэд ч дурьдагдаагүй гутааж гүжирдсэн мэдээ тараах арга болох Интернетын сүлжээн дэх мэдээлэл юм. Үнэн байдалд нийцээгүй гүтгэж доромжилсон тодорхой мэдээнүүд байгаа талаар нотолгоо авах зорилгоор иргэд, шүүх, прокурор, өмгөөлөгч, бусад сонирхсон этгээдийн хүсэлтээр интернетын тодорхой сайтуудын агуулгыг тэмдэглэн авах, баталж чадах төрийн байгууллага бий болгох, түүнчлэн "Интернетын сүлжээг ашиглах тухай" ОХУ-ын хууль батлах талаар доктор А.А.Власовын санал зүйтэй юм. Энэ нь манайд ч шаардлагатай байна.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл /ОНМХ/-ийн редакцийн өөр бусад ажилтнууд бус чухамхүү зохиогч тараасан мэдээнүүдэд ашигласан материалын талаар хамгийн сайн мэдэж буй. Иймд "Хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ ОНМХ-ээр цацагдсан, эдгээр мэдээний зохиогч нэр заагдсан байхад тэрбээр мэдээллийн байгууллагатай хамт уг мэдээнүүдийг няцаах тухай нэхэмжлэлийн хариуцагч байх ёстой"[13] хэмээн судлаач С.В.Потаненко "Судебная защита от диффамации" бүтээлдээ бичсэн байна.

Иргэний эрх, ашиг сонирхлыг хөндсөн мэдээ тараасан ОНМХ-ээр хариу нийтлэх шаардлагыг нэхэмжлэлийн бие даасан шаардлага болгох тухайд нэгдмэл санал байхгүй байна. Ихэнх судлаачид үндсэндээ энэ шаардлагыг бие даасан гэж үзэхгүй байна. Судлаач П.Я.Трубников зөвхөн ийм нийтлэлээс ОНМХ татгалзсан, эсвэл хариу нийтлэх тогтсон журмыг зөрчсөн тохиолдолд тухайн шаардлагын талаар шүүхэд хандах боломжтойг тэмдэглэжээ. Энэ төрлийн хэргийг хянан үзэхэд практик дээр хэл зүйн экспертиз ашиглах тохиолдол байдаг. Хэлний мэргэжилтнүүд, шинжээчдийн хүчийг ашиглах хамгийн өргөн дэлгэр тохиолдлууд нь нийтлэл дэх мэдээг хүний нэр төр, алдар хүндийг гутаасан, эсвэл үгүй гэдгийг нэг утгаар зүйлчлэх, мөн сэтгэл хөдлөлийн өнгө аясын хэмжээ, үг хэллэгийн холбоог тодорхойлоход бэрхшээл учирдаг юм.

Хууль зүйн ном зохиолд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах тухай нэхэмжлэл гаргах нөхцөл эсвэл нотлох зүйлд орж буй бусад баримт нь тараасан мэдээний батлагдсан шинж болдог гэсэн санал байдаг. "Зохиогч нь баталсан мэдээг гутаасан шинжтэй гэж хүлээн зөвшөөрдөг. Хэрэв тэдгээр нь урьдчилсан байдлаар, хувилбар, таамаглалын хэлбэрээр бичигдсэн бол ийм мэдээг гутаасан гэж хүлээн зөвшөөрөх боломжгүй"[14] гэж судлаач эрдэмтэн А.Б.Пчелинцев үзсэн байна.

"Шүүх ийм тохиолдолд үнэн байдалд нийцээгүй гэж хүлээн зөвшөөрөгдсөн зөвхөн тэр баримтуудыг няцаахыг хариуцагчид үүрэг болгодог ч бүх баримт тусдаа шалгагдаж үнэлэгдэнэ. Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалахаас татгалзах нь зөвхөн эдгээр баримтуудын хувьд боломжтой юм"[15] гэсэн дүгнэлтийг судлаач Д.Ж.Марович хийжээ.

Няцаалт нь тухайн нэр төр, алдар хүндийг гутаасан мэдээг тараасан этгээдээс шууд гарсан байхыг шаарддаг. Нэр төр, алдар хүндийг гутаасан мэдээний талаар төрийн байр суурь олон нийтийн сонорт шүүхийн нэрээр хүрдэг.

Няцаалтын аргыг тодорхойлсны дараа түүний журмыг тогтоох нь чухал. Эдгээр ухагдхуунууд өөр хоорондоо нягт холбоотой байдаг. Үүний хамт тэдгээрийг хооронд нь ялган зааглах хэрэгтэй. Одоо үед ОНМХ дэх няцаалтаас бусад няцаалтыг шүүх тогтоож байна. Гэвч энэ нь хэн нэгний үзэмж дур зоргоор шийдэж болохгүй асуудал юм. Шүүх үнэн байдалд нийцээгүй мэдээг тараасан газар, тэдгээрийн агуулга, мэдээлэл хүлээн авсан хүмүүсийн тоо тухайн хэргийн онцлогоос хамаарсан бусад нөхцөл байдал зэргийг харгалзан үзэх ёстой. Энэ төрлийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх онцлог нь хариуцагчид биечлэн тараасан мэдээг няцаах үүрэг хүлээлгэх явдлаар илэрдэг байна.

Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд

---

[12] М.Л.Шелютто Указ соч.стр15

[13] С.В.Потаненко "Судебная защита от диффамации в СМИ" Краснодар 2002 стр 15.

[14] А.В.Пчелинцев "Свобода совести и злоупотреб ление свободой массовой информации: защита чести, достоинства и деловой репутации" М 1998 стр 17

[15] Д.Ж.Марович "За хрупкий приз, который зовется репутацией. Российская юстиция. 2001 № 7. стр 53.

халдах янз бүрийн хувилбар практик дээр байдаг. Үүнийг дагаж няцаалтын янз бүрийн арга байж болно.

ОНМХ-ийн Интернетын сүлжээнүүд хариуцагчийн зүгээс няцаалтын бичвэрийг ямар нэг байдлаар тайлбарлахыг хориглох талаархи доктор А.А.Власовын санал өнөөгийн нөхцөлд хамгийн бодитойд тооцогдож байна.

Иймд няцаалтын бичвэр зөв байх хариуцлагыг шүүхэд хүлээлгэдэг. Тараасан мэдээг няцаах өөр журам, түүний дотор хохирогчын өмнө уучлалт гуйх нь ОНМХ-д нийтлэгдсэн мэдээлэл үнэн байдалд нийцээгүйг хүлээн зөвшөөрч байна гэсэн үг. Бусад тохиолдолд няцаалтыг зөвхөн шүүхээр тогтооно.

Дээр дурдсан бүхэн үндсэндээ үнэн байдалд нийцээгүй нэр төр, алдар хүндийг гутаасан мэдээнүүдийг няцаах шаардлага, мөн хариут нийтлэх шаардлагын талаар гаргасан шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлыг хөндсөн болно. Гэвч нэр төр, алдар хүндийг гутаасан мэдээг тараагч тодорхойгүй байхад үнэн байдалд нийцээгүй мэдээний талаар шүүхэд өргөдөл гаргахыг хуулиар зөвшөөрдөг. Мэдээж ийм тохиолдолуудад шүүхийн шийдвэр гүйцэтгэх аргыг хэрэгжүүлэх нь тодорхой онцлогтой байдаг. Судлаач эрдэмтэн К.Б.Ярошенкогийн үзэж байгаагаар энэ тохиолдолд "няцаалтын тухай асуулт хохирогчын үзэмжээр шийдвэрлэгдэх ёстой. Гарсан шийдвэрийг иргэний өөрийн сонгосон ямарч хууль ёсны аргаар ашиглаж болно"[16] гэсэнтэй санал нэг байна.

Дээрхээс дүгнэлт хийж үзэхэд няцаалт хийх эрхийг улам боловсронгуй болгохын тулд доорхи арга замаар шийдвэрлэх нь зүйтэй гэж судлаачын хувьд үзэж байна. Үүнд:

1.Эрх зүйн агуулгаараа иргэний нэр төр, алдар хүнд нь төгс чанарыг агуулсан салгаж үл болох эдийн бус баялаг юм. Тийм учраас энэхүү баялгийг эзэмшигч нь бусад хүн тус бүртэй түйлын эрх зүйн харилцаанд оролцож байгаа бөгөөд энэхүү эрх зүйн харилцаанд бусад этгээд нь тухайн этгээдийн нэр төр, алдар хүндийг гутаахгүй байх пассив үүрэг хүлээж байдаг. Иймд эдийн бус баялаг болох нэр төр, алдар хүндийг нь гутаасан хэнээс ч эрхийг нь зөрчихгүй байхыг тухайн баялаг эзэмшигч шаардаж няцаалт хийлгэх эрхтэй.

2.Эрхлэх ажил, үүрэгтэй нь холбогдуулан хуулиар хувь хүнд ёс зүйн өндөр шаардлага тавьж байгаа нөхцөлд нэр төр, алдар хүндийг тусгайлан хамгаалах шаардлага тавигддаг. Иймд иргэний эрх зүйн салбарт "мэргэжлийн төрөлжсөн нэр төр, алдар хүнд" гэсэн ойлголтыг нэвтрүүлэх саналыг дэвшүүлж байна. Тэдгээрийг хамгаалах онцлогийг тусгайлан хуульчлах, учир нь тэдгээрт халдах нь иргэдийн бусад эрхийг, тухайлбал, хөдөлмөрийн эрхийг зөрчдөг гэдгийг анхаарах.

3.Ажил хэргийн нэр хүндийн нэр төр, алдар хүндээс ялгаатай нь мөнгөн хэлбэрээр үнэлэх илүү боломжтой байдаг. Зарим төрлийн гэрээний зүйлд түүнийг хамруулж болно, тухайлбал, санхүүгийн концесс, хамтран ажиллах гэрээнүүдэд. Энэ утгаар нь ажил хэргийн нэр хүндийг эдийн баялагтай хосолсон эдийн бус баялаг гэж ойлгох нь зүйтэй байна.

4.Хэрэв хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан мэдээлэл нь иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсан утга санааг агуулсан бол ийм аргаар цацагдсан мэдээллийн агуулгын төлөө хэвлэл мэдээллийн хэрэгсэл хариуцлага хүлээх ёстой. Зарим тохиолдолд хариуцагч болох хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь шүүхийн шийдвэрийн дагуу няцаалт хийхдээ шүүхийн шийдвэрийг үгүйсгэсэн шинжтэй нэмэлт тайлбар гаргадаг. Иймд хэрэв няцаалт нь түүнийг үгүйсгэсэн шинжтэй мэдээлэл агуулсан байвал хохирогч шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхтэй байхаар хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

5.Үүсгэн байгуулагдсан үеэсээ эхлэн хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүнд нь тухайн хуулийн этгээдтэй салшгүй холбоотой бөгөөд түүний эрх зүйн чадварын салшгүй хэсэг байна. Мөн ажил хэргийн нэр хүндэд тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны явцад өөрчлөлт орж болно.

6.Ажил хэргийн нэр хүндийн тухай ойлголтыг зөвхөн ашгийн төлөө хуулийн этгээд, хувиараа аж ахуй эрхлэгчдийн хүрээнд бус, мөн нийгэмд чухал ач холбогдол бүхий ажил үүрэг гүйцэтгэж байгаа бусад этгээдийн хүрээнд хэрэглэж болно. Энэ зарчмыг бататгахын тулд Иргэний хуульд зохих өөрчлөлтийг оруулж мэргэжлийн болон албан тушаалын нэр хүндийг хамгаалах зохицуулалтыг хуульчлах шаардлагатай гэж үзэж байна.

[16] К.Б.Ярошенко Указ.соч. стр 84

# БНХАУ-ЫН ӨВ ЗАЛГАМЖЛАЛЫН ХУУЛЬ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

*Т. Мөнхжаргал*
*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш, доктор, профессор*



Монгол, БНХАУ хоёр гүрэн олон зуун жилийн турш айлсан оршиж ирсэн урт хугацааны түүхэндээ эв найртай харилцаж, зарим он жилүүдэд дайн байлдаан ч хийж байсны зэрэгцээ хоёр ард түмний хооронд улс төр, эдийн засаг, эрх зүй, соёл боловсрол, зан заншил, шашин шүтлэг зэрэг нийгмийн амьдралын олон чиглэл сэжмээр холбоотой байсаар өнөөдрийн өндөрлөгт хүрч иржээ.

Сүүлийн жилүүдэд хоёр орны хооронд бүх талын харилцаа, ялангуяа эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалт, бизнесийн салбар дахь хамтын ажиллагаа өргөжин тэлж байна.

Хэдийвээр хоёр орны улс төрийн бүтэц, дэглэм өөр боловч эдийн засгийн өндөр хөгжилтэй хөрш зэргэлдээ орныхоо хуулийг судлах зарим эрх зүйн актын зүйл, заалтын зохицуулалтын арга, хэлбэрийг өөрийн нөхцөлд тохируулан бүтээлчээр авч хэрэглэх нь зүйд нийцэх учиртай. Хятад улс ч манай хуулийн үзэл баримтлалаас авч хэрэглэж болохыг үгүйсгэх аргагүй биз ээ. Энэхүү өгүүллэгт БНХАУ-ын өв залгамжлалын хууль, түүний онцлогыг эрхэм уншигч нартаа толилуулах нь зүйтэй гэж үзэв.

1985 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Зургаадугаар хуралдааны Бүх Улсын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын гуравдугаар хуралдаанаас "Бүгд Найрамдах Думдад Ард Улсын өв залгамж хууль"-ийг (цаашид хууль гэх) баталсан бөгөөд 1985 оны 9 дүгээр сарын 11-ны өдөр Ардын Дээд Шүүх Хорооны дарамаллан тогтоосон "Бүгд Найрамдах Думдад Ард улсын өв залгамжлах хууль"-ийг туушлуулан хэрэгжүүлэх асуудлуудын тухай санал[1] (цаашид санал гэх)-ыг боловсруулан мөрдөж иржээ.Энэ тухай Хятадын эрдэмтэн Дун Гао энэ нь манай улсын нийгэм журмын хууль цааз нэгэн шинэ шат үед шилжин оржээ гэдгийг харуулж байна[2] гэж бичжээ.

"Өв залгамжлах хууль" 5 бүлэг, 37 зүйлтэй.Үүнд:

**Нэгдүгээр бүлэг** - "Ерөнхий дүрэм" 8 зүйл;

**Хоёрдугаар бүлэг** - "Хуульд тогтоосон өв залгамжлалт" 7 зүйл;

**Гуравдугаар бүлэг** - Гэрээсээр өв залгамжлах ба өв өгөх" 7 зүйл;

**Дөрөвдүгээр бүлэг** - "Өв хөрөнгийг шийдвэрлэх" 12 зүйл;

**Тавдугаар бүлэг** - "Дагалдуулал дүрэм" 3 зүйл бүхий бүтэцтэй юм."Өв залгамжлах явдал нь ард иргэн үхэхдээ үлдээсэн хувь хүний хууль ёсны эд хөрөнгө болно" хуульчлаад тэрхүү эд хөрөнгө нь:

1 Ард иргэний орлого
2. Ард иргэний гэр, байшин, хадгаламж ба амьдралын хэрэгсэл
3. Ард иргэний ой мод, уналга мал хийгээд гэрийн жигүүртэн
4. Ард иргэний түүхийн дурсгалт зүйл, ном материал
5. Ард иргэний хууль цаазын зөвшөөрөл бүхий үйлдвэрлэлийн хэрэгсэл

---

1 *Хятад улсад Дээд шүүхээс гаргасан хуулийн албан ёсны тайлбарыг санал гэж бичсэн байдаг.*
2 *Дун Гао "Өв залгамжлах хуулийн үзэл" Өвөр монголын ардын хэвлэлийн хороо", 1994, Хөх хот, 7-р талд*

6 Ард иргэний зохиол бүтээлийн эрх, тусгай ашгийн эрх доторхи эд хөрөнгийн эрх ашиг

7. Ард иргэний хууль ёсны бусад эд хөрөнгө зэрэг багтана гэж нэрлэн зааж ангилсан байна.

Хуулийн 9,10 дугаар зүйлд эрэгтэй, эмэгтэй өв залгамжлах тэгш эрхтэй гэж заасны сацуу хуульд тогтоосноор өв залгамжлах хүмүүсийн дэс дараалныг **нэгд:** үрагласан нөхөр, үр хүүхэд, эцэг эх, **хоёрт:** ах, дүү, эгч, охин дүү, өвөө, эмээ, нагац, өвөө, эмээ хамаарна гэжээ.

Эхний дараалалд өв залгамжлах эрх бүхий хүмүүсийн үр хүүхэд гэдэгт ураглаад (гэрлэсэн) төрсөн ба ураглаагүй төрсөн хүүхэд, тэжээсэн (үрчилсэн) болон асарч тэжээх харилцаа бүхий хойт (дагавар хүүхэд) үр хүүхэд байна. Эцэг, эх гэдэгт төрсөн ба үрчилсэн, мөн хойт эцэг, эх хамаарна.

Хуульд: эр нь үхсэн бэр, эм нь үхсэн хүргэн хадам эцэг, эхээ асарч, тэжээх гол үүрэг гүйцэтгэж байсан бол нэгдүгээр дараалалд өв залгамжлагч болно гэж заасныг Шүүх хорооны саналд амьд байгаа бэр, хүргэн дахин урагласан, эсэх хамаарахгүй эхний ээлжинд өв залгамжлагч болохоор тайлбарласан байна.

Адил дэс дараалалд өв залгамжлагчид өв хөрөнгийг тэгш хувааж авах эрхтэй боловч тэдгээрийн дотор хөдөлмөрлөх чадваргүй, амьдралын хүнд нөхцөл байдалд байгаа өв залгамжлагчид хөрөнгө хуваахдаа харгалзан үзэхээс гадна өв залгамжлуулагчийг асарч тойлж байсан буюу түүнтэй хамт амьдарч байсан өв залгамжлагчид бусад өв залгамжлагчийг асарч тэжээх үүрэгтэй бөгөөд асрах нөхцөл боломжтой өв залгамжлагч уг үүргээ гүйцэтгээгүй бол оногдох хувийг өгөхгүй буюу хорогдуулан өгч болохоор заасан байна.

Элгээр заалтыг манай хуульд авч хэрэглэж болно гэж үзэж байна. Үүнтэй холбогдуулан манайд гарсан нэгэн жишээ хэлье. Өндөр настай өвгөн П-ийн хоёр хүү 1992 онд наймаа хийхээр гадаадад гараад ямарч хэл сурагтүй 8 жил болжээ. Энэ хугацаанд гэртээ ганц бие П-г нутгийн нэгэн эмэгтэй асарч тэтгэж, эм тан ойртуулж сувилсаар нас эцэслэхэд нь бусадтай хамжин ёслол төгөлдөр оршуулжээ. Сарын дараа хоёрдуу ирээд аавынхаа эд хөрөнгийг авна, нөгөө эмэгтэйд юу ч өгөхгүй гэсэн маргаан үүссэн бөгөөд шүүх эмэгтэйд зохих хувь хөрөнгө өгмөөр байдаг. Гэтэл өгч болно, болохгүй гэсэн хуулийн заалтгүй тул шийдвэрлэхэд бэрхшээл тохиолдсон билээ.

Хуулийн 16 дугаар зүйлд: ард иргэн гэрээс үлдээж хувийн эд хөрөнгөө улс орон, хамт нийтэд буюу хууль ёсны өвлөгчөөс өөр хүнд өгч болно гэжээ. Гэрээслэлийг 1 .Бичгээр, 2.Амаар, 3.Дуу шингээгч (дуу хураагч)-ийн хэлбэрээр хийж болно гэж заажээ.

Гэрээслэлийг өв залгамжлуулагч өөрөө бичих үүрэгтэй. Харин гэрээслэлийг өөр хүнээр орлон бичүүлэхээр бол хоёроос дээш гэрчийг байлцуулж гэрчлэх эрх бүхий албан газар (манайхаар бол нотариат буюу орон нутгийн захиргааг хэлж байна)-аар гэрчлүүлдэг. Дуу шингээлтийн хэлбэрээр үлдээсэн гэрээслэлийг хоёроос дээш гэрчлэгчтэйгээр албан газар гэрчлэнэ.

Өв залгамжлуулагч бачим түгшүүртэй нөхцөл байдалд аман гэрээс үлдээж болох бөгөөд түүнийг хоёроос дээш хүн тухайн албан газар гэрчлүүлдэг. Бачим түгшүүртэй байдал өнгөрсний дараа гэрээслэл үлдээгч бичгээр буюу дуу шингээлтийн хэлбэрээр гэрээслэлээ үлдээж чадвал аман гэрээслэлийг хүчингүй болгоно гэж заасан байдаг.

Дараахи хүмүүс гэрээслэлийг гэрчлэгч байжболохгүй. Үүнд:

а/ Үйл ажиллагааны чадваргүй хүн, үйл ажиллагааны чадвар нь хязгаартай хүн

б/ Өв залгамжлагч, өв хүртэгч

в/ Өв залгамжлагч, өв хүртэгчтэй ашиг хорын харьцаатай хүн

Энд "өв хүртэгч" хэмээх субъектэд хууль ёсны ба гэрээслэлээр өв залгамжлагчаас гадна өвлүүлэгчийг асрах буюу эсвэл түүний асрамжинд байсан хүмүүс хуульд заасан нөхцөлд өв хөрөнгөөс хувь авах эрх олгогдсон хүн болно. Жишээ нь: хуулийн Арван дөрөвдүгээр зүйл, түүнийг тайлбарласан саналд: "Өв залгамжлуулагчийн амьдралд гол аж ахуйн ирэлт олгож өгсөн буюу ажил хөдөлмөр зэрэг талаар гол хавсарлага (туслалцаа) үзүүлсэн бол түүнийг асарч тэжээсэн гол үүрэг буюу гол тэтгэн тэжээх үүргийг гүйцэтгэснээр магадлах хэрэгтэй" гэсэн заалтын үүрэг гүйцэтгэсэн этгээд нь өв хүртэгч байна.

Хуулийн 19 дүгээр зүйлийн утга нь өвлүүлэгч эд хөрөнгөө бусдад гэрээслэх эрхтэй боловч тийнхүү гэрээслэсэн нь түүний хууль ёсны өв залгамжлагчийн цаашдын амьдрал ахуйд сөргөөр нөлөөлөхөөр байвал өв хөрөнгийн зохих хувийг үлдээх хэрэгтэй. Энэ санаа манай Иргэний хуулийн 522,3 зүйлтэй адил байна. Харин манай хуульд: гэрээслэгч бүх эд хөрөнгөө хууль ёсны бус этгээдэд гэрээслэх тохиолдолд өвлүүлэгчийн насанд хүрээгүй буюу хөдөлмөрийн чадваргүй түүнчлэн түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, түүний асрамжид байсан хөдөлтмөрийн чадваргүй нөхөр (эхнэр), төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх, хууль ёсны бусад өвлөгчдөд хуульд зааснаар өвлүүлбэл зохих хөрөнгийн хоёрны нэгээс багагүй хэсгийг заавал өвлүүлнэ гэж арай дэлгэрэнгүй заасан,

Хуулийн 21 дүгээр зүйлд: гэрээсээр өв залгамжлуулах буюу өв өгөхдөө үүрэг дагалдуулсан байвал өв залгамжлагч буюу өв хүртэгч тэрхүү үүргийг гүйцэтгэх хэрэгтэй. Зүй ёсны учир шалтгаангүйгээр үүрэг гүйцэтгэхгүй бол холбогдол бүхий нэгж ба хувь хүний гуйчлалаар (нэхэмжлэлээр) ардын шүүх хороо өв эдлэх эрхийг нь хасаж болно гэжээ. Манай хуульд өв хүлээн авагчид даалгасан үүргийг биелүүлээгүй бол хэрхэн шийдвэрлэж болох талаар заалтгүй бөгөөд үүнийг хуульдаа тусгаж болохыг үгүйсгэхгүй юм.

Дараахи гэрээсийг хүчингүй гэжүзнэ. Үүнд.

Үйл ажиллагааны чадваргүй хүн

Үйл ажиллагааны чадвар нь хязгаартай (хязгаарлагдсан) хүн

Хуурамчаар зохиосон гэрээс

Гэрээс өөрчлөгдсөн байвал өөрчлөгдсөн агуулга нь хүчингүй

Өв залгамжлалын хуулийн дөрөвдүгээр бүлэг нь өв хүлээн авах, хадгалах, өвийг хэрхэн хуваарилах тухай заажээ. Өв нээгдэж өв залгамжлуулагч үхсэнийг мэдэж байгаа өв залгамжлагч бусад өв хүлээн авагчдад цаг тухайд нь мэдэгдэх үүрэгтэй. Хэрэв мэдэх хүн байхгүй, мэдсэн боловч мэдэгдэх боломжгүй байсан бол өв залгамжлуулагчийн амьд байхдаа сууж байсан газрын ардын буюу гацааны зөвлөл хариуцан мэдэгдэх үүргийг гүйцэтгэдэг.

Өв хөрөнгийг хадгалж байгаа хүн түүнийг сайтар хадгалах үүрэгтэй бөгөөд өвлөгчдийг хүрэлцэн иртэл ямар ч хүн "шамшин залгих буюу булаан авч болохгүй" гэж заасан байна.

Өв нээгдсэний дараа өв залгамжлагч өвийг авахгүй гэдгээ өв хуваах шийдвэрлэхээс өмнө мэдэгдэх, хэрэв мэдэгдээгүй бол өвийг хүлээн авсанд тооцдог бол өв хүртэгч өвийг авахгүй гэдгээ хоёр сарын дотор мэдэгдэх, хэрэв мэдэгдээгүй байгаад хугацаа дуусвал өв авах эрхгүй гэж заажээ. Энэ заалтыг хуулийн саналд(тайлбарт): өв залгамжлагч өв залгамжлахаа болих гэвэл бусад өв залгамжлагчид бичгээр илэрхийлэх хэрэгтэй. Амаар өв залгамжлахаа болих гэж илэрхийлснийг хэрэв тус бие нь (өөрөө) зөвшөөрөх буюу бусад гэрч баримт гүйцэт гэрчилж байвал хүчинтэйгээр магадлах хэрэгтэй. Өв залгамжлагч өв залгамжлахаа болих гэсэн санаагаа өвлөх эрх үүссэний дараа, өв хөрөнгө хуваахаас өмнө илэрхийлэх хэрэгтэй. Өв хуваасны дараа өв залгамжлахаа болих гэж илэрхийлсэн нь өв залгамжлах эрх биш болж, харин өмчлөх эрх болно гэж тайлбарлажээ.

Энэ тайлбарын утга нь өвлөгдөх эд хөрөнгийг хууль буюу гэрээслэлээр өвлөгчдөд хуваарилж өгсний дараа өв залгамжлалын харилцаа дуусгавар болох, түүнээс хойш хөрөнгийг авна, өгөхгүй гэсэн хүсэлт, маргаан нь иргэд хооронд үүссэн эд хөрөнгийн маргааныг зохицуулах журмаар шийдвэрлэнэ гэсэн ойлголт юм.

Хуулийн 26 дугаар зүйлд гэр бүл дэх эд хөрөнгийг хэрхэн өвлөх эрх зүйн зохицуулалтыг заажээ.Тухайлбал: эр, эм хоёр хамтран амьдрах хугацаандаа олсон, түүнийгээ хамтран өмчилж байсан эд хөрөнгийг болзож тогтсон хэсгээс гаднахи өв хөрөнгийг хуваахад хүрвэл урьдаар хамтран өмчилж байсан эд хөрөнгийн хагасыг хуваан гаргаж (ялгаад) холбосон (ураглсан) нөхөрт нь өмчлүүлээд үлдсэнийг нь өв залгамжлуулагчийн өв хөрөнгө болгох хэрэгтэй. Өв хөрөнгө нь гэр бүлийн хамтран өмчлөх эд хөрөнгийн дотор байвал өв хөрөнгийг хуваахдаа урьдаар бусдын хөрөнгийг ялгаж гаргах үүрэгтэй гэжээ.

Хуулийн 29 дүгээр зүйлд: өв хөрөнгийг хуваахад үйлдвэрлэл ба амьдралын хэрэгцээнд ашигтай байлгаж өв хөрөнгийн үйлдлийг (хэвийн ажиллагаа) хувиргахгүй байх хэрэгтэй, хуваахад зохисгүй (боломжгүй) өв хөрөнгийг үнэлэн бодох, зохих хэмжээгээр нөхвөрлөж төлөх буюу хамтран эзэмших аргаар шийдвэрлэж болно.

Хуулийн 31 дүгээр зүйлд сонирхолтой заалт байна. Жишээ нь: ард иргэн асран тэжээгчтэй өв өгөх, асран тэжээх хэлцээр байгуулж болно. Хэлэлцээр ёсоор асран тэжээгч нь уул ард

иргэнийг амьд байхад нь асарч, үхвэл оршуулах үүргийг гүйцэтгэх хэрэгтэй бөгөөд өв хөрөнгө эрхийг эдлэнэ гэж заасан байна. Ийм заалт манай хуульд байхгүй. Асран тэтгэгч бол хууль ёсны ба гэрээслэлээр өвлөгч биш, зөвхөн хэлэлцээрт хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлсэн тохиолдолд нас барагчийн өвийг авах эрхтэй өв хүртэгч болно. Тэгэхдээ өвийг бүгдийг уу, тодорхой хэсгийг авах уу гэдгийг хэлэлцээртээ нарийвчлан тохиролцдог бизээ.

Өв залгамжлах болон өв хүртэгч хүнгүй нас барагчийн өв хөрөнгийг улсын өмчлөлд шилжүүлдэг. Хуульд: үхсэн нь амьд байхдаа хамтын өмчлөлд зохион байгуулалтын бүрэлдэхүүнд байсан бол өв хөрөнгийг нь түүний байсан хамтын өмчлөлд зохион байгуулалт нь өмчлөнө гэж заасан.

Энэ заалтын агуулга нь нас барагчийн хууль ёсны ба гэрээслэлээр өв залгамжлагч, өв хүртэгч байхгүй бөгөөд нас барагч амьд ахуйдаа аль нэгэн аж ахуйн нэгжид хөрөнгө оруулж, хамтран үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэж, эд хөрөнгөө хамтран өмчилж байсан бол түүний хувь эд хөрөнгийг улсад биш тухайн аж ахуйн нэгж өмчилдөг онцлогтой заалт юм,

Манай Иргэний хуулийн 535.1-д: өв хүлээн авсан өвлөгч ............................................................ өвлүүлэгчийн

гүйцэтгэвэл зохих үүргийг өвлөн авсан эд хөдөнгийн хэмжээнд хувь тэнцүүлэн хүлээнэ гэж заасныг Хятад улсын өв залгамжлах хуулийн 32 дугаар зүйлтэй харьцуулбал: өв залгамжлахдаа өв залгамжлуулагчийн хууль ёсоор тушаавал зохих гаалийн мөнгө, өрийг төлөх хэрэгтэй. Гаалийн мөнгө, өрийг төлөхөд түүний өв хөрөнгийн бодит өртгөөр хязгаар болгоно. Бодит өртгийн давсан хэсгийг өв залгамжлагч сайн дураараа төлвөл үүгээр хязгаарлахгүй гэсэн байна.

Өв залгамжлах хуулийн тавдугаар бүлэг нь уг хуулийг Хятад улсын нийт нутаг дэвсгэрт, олон үндэстэн ястнууд хэрхэн дагаж мөрдөх нөхцөл журмыг хуульчлан тогтоосон байдаг.

Үндэстний өөртөө засах газар орны ардын төлөөлөгчдийн их хурал нь энэхүү хуульд тогтоосон зарчмыг үндэслэн тус газрын үндэстний эд хөрөнгийг залгамжлан өмчлөх бодит байдалтай уялдуулж зохицуулан хувируулсан (өөрчилсөн) буюу нөхвөрлүүлсэн тогтоол гаргаж болно. Өөртөө засах орны тогтоолыг бүх улсын ардын төлөөлөгчдийн Их хурлын байнгын хороонд мэдүүлж зөвшөөрүүлсний дараа хүчинтэй болохын хамт түүнийг бүх улсын ардын төлөөлөгчдийн их хурлын байнгын хороонд мэдүүлж данслуулна гэжээ.

Думдад улсын иргэн Бүгд Найрамдах думдад ард улсын хилийн гадна байгаа өв хөрөнгийг залгамжлах буюу хилийн дотор байгаа гадаад хүний өв хөрөнгийг залгамжлахдаа хөдлөх хөрөнгийг залгамжлахад өв залгамжлуулагчийн сууж байсан газрын хуулийг, үл хөдлөх хөрөнгөө залгамжлахад үл хөдлөх хөрөнгийн байгаа газрын хуулийг тус тус хэрэглэхээр заажээ.

Гадаадын хүн Хятад улсын хилийн дотор байгаа өв хөрөнгийг залгамжлах буюу хилийн гадна байгаа думдад улсын ард иргэний өв хөрөнгийг залгамжлахдаа хөдлөх хөрөнгийг залгамжлуулагчийн сууж байсан газрын хууль, үл хөдлөх хөрөнгийг түүний байгаа газрын хуулийг тус тус хэрэглэнэ гэжээ.

*"Business law" эрдэм шинжилгээний бага хурлаас тэргүүн байранд шалгарсан илтгэл*

# "БИЗНЕСИЙН ХУУЛИУДЫГ ХЭРЭГЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ"

/Бизнесийн эрх зүйн үндсэн харилцаан дээр тулгуурлан хууль хэрэглэх жишээн дээр/



*Илтгэгч: М.Түвшинжаргал /Шихихутуг-ХЗДС-ийн Бизнесийн эрх зүйн 4-в ангийн оюутан/*

***Эдийн засгийн харилцааг эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулна гэдэг бол харанхуйн дунд нүдээ таглан алхах мэт нарийн мэдрэмжийг хууль тогтоогчоос ямагт шаарддаг .***
***/ Б.М.Т /***

***Сэдвийг судлах шаардлага:*** Аливаа хуулийг зөв хэрэглэх нь хэрэг маргааныг зөв зүйлчлэх хийгээд эрх зүйн хөгжилд чухал ач холбогдолтой ойлголт юм. Энэ үүднээс бизнесийн шинжтэй харилцааг зохицуулсан хэм хэмжээнд дүн шинжилгээ хийж хуулийн маргаан бүхий зүйл заалтыг зөв тайлбарлана хэрэглэх нь сонирхолыг татсан асуудал юм. Мөн бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалахын тулд байгаа хуулийн хэм хэмжээг улам төгөлдөржүүлэх, цаашлаад холбогдох хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах нь бизнесийн эрх зүйд тулгамдаж буй томоохон асуудал юм.

**Судалгааны зорилго:** Энэ үүднээс судлаач оюутны зүгээс дараах зорилгыг тавина судласан болно. Үүнд:

***1.*** Бизнесийн харилцааг зохицуулсан холбогдох хуулинд дүн шинжилгээ хийж гаргалгаанд хүрэх

***2.*** Бизнесийн харилцааг зохицуулаж буй иргэний хуулийн гэрээний үүргийг зохицуулсан хэм хэмжээг үг зүйн үүднээс тайлбарлах

***3.*** Монгол Улсын бизнесийн хуулиудын чиг хандлагыг тодорхойлохыг зорьсон болно.

**Судалгааны судлагдсан байдлын хувьд** онол болон практикийн хувьд шинэлэг судлагдсан байдал бага байгаа нь судлах хэрэгцээ шаардлага байгааг нэг талаараа харуулж байгаа юм.

**Уг илтгэлийн судалгааны арга нь** харьцуулалт хийгээд логикийн үндсэн арга, мөн структурализм /системчлэх/ болон дескриптив арга зүйг ашигласан болно.

**Судалгааны объект буюу судалгааны зүйлийн хувьд** Бизнесийн харилцааг зохицуулсан холбогдох хуулиудын зүйл заалт болон Иргэний хуулийн 243-485 дугаар зүйл заалт.

**Судалгааны практик ач холбогдол хийгээд** судалгааны түвшиний хүрээнд бизнесийн харилцааг зохицуулсан хэм хэмжээ нь үзэл санаа болон агуулгын хувьд харьцангуй хоцрогдсон, бизнесийн чөлөөт нөхцөлийг боогдуулсан, хуулийн төрөлжсөн хэлбэрт орж чадаагүйн бизнесийн эрх зүйн төдийгүй бизнес эрхлэгч субъектүүдийн хувьд нэгэн томоохон хаалт болж байгаа юм. Мөн Иргэний хуулинд тусгагдсан үгийн утгыг ангилан нарийвчлан судлах нь тус зүйл заалтын утга агуулгыг зөв илэрхийлэх байх ёстой түвшинд судлаж эцсийн дүндээ хэрэглэх арга зүйг боловсронгуй болгож цаг хугацаа хийгээд гэрээнээс гарах эрсдлээс бага ч гэсэн талуудыг хамгаалах юм.

## НЭГ. БИЗНЕСИЙН ХУУЛЬ, ТҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ

### 1.1 БИЗНЕСИЙН ХУУЛЬ, ТҮҮНИЙ ОЙЛГОЛТ

Манай орны хувьд бизнесийн эрх зүйн хөгжил харьцангуй байдлаар түүхэн он цаг үед хөгжин улмаар тухайн нийгмийн үзэл суртлыг өөртөө агуулан иржээ. 1950-иад он хүртэл хувийн өмчтэй байсны ачаар хязгаарлагдмал зах зээлтэй ч гэсэн бизнес буюу аж ахуйг эрхэлж ирсэн байна. Гэтэл 1958 онд хувиараа аж үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнээ худалдаа эрхлэхийг хориглож, эхлээд 1960 оны үндсэн хуулиар "хувийн өмчийг устгасан[1]" гэж тунхагласнаар хувиараа үйлдвэрлэл, худалдаа, арилжаа эрхлэх боломжийг бүр мөсөн хааж эрх мэдэлгүй болгосон байна .

Харин 1990-д оноос Монгол улсад ардчилсан хувьсгал гарсны үр нөлөөгөөр хүний өмчлөх эрх сэргэж, хувийн аж ахуй эрхлэх эрхийг хүлээн зөвшөөрсөн. 1992 оны Үндсэн хуульд Монгол улсын иргэн, " хөдлөх, үл хөдлөх хөрөнгө олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй", ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй гэж заасан байна. Энэ нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих цаг хугацааны залгаан дээр бизнес эрхлэж эхэлсэн түүхэн хугацаа юм. Энэ үеэс **бизнес, бизнесийн эрх зүй, бизнес эрхлэх** гэсэн шинэлэг шинжтэй ойлголтууд төрөн гарч ирсэн. Монголын анхны парламент байсан Улсын Бага Хурлаас 1990-1991 оны хооронд бизнесийн шинжтэй харилцааг зохицуулсан анхны хуулиуд[2] болон хувийн өмч, аж ахуй бизнесийн анхдагч нөхцөл бүрдүүлэхэд шууд чиглэсэн бусад хууль гаргасан нь бизнесийн эрх зүйн хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан юм.

Бизнесийн харилцааг зохицуулсан олон хууль тогтоомж, дүрэм, журам байдаг. Харин үүнийг яаж эрх зүйн хүчин чадлаар нь ангилаж үзэх, сонгон хэрэглэх нь нэлээд төвөгтэй байдаг. Бизнесийн эрх зүйн харилцаануудын[3] онцлогоос хамаарч ямар харилцаанд ямар хууль хэрэглэхийг тогтоох боломжтой юм. Өөрөөр хэлбэл бизнесийн эрх зүйн харилцаа түүн дээр тулгуурлан хуулиа сонгох боломжтой гэсэн үг юм. Бизнесийн харилцаа хөгжихийн хэрээр түүнийг зохицуулсан хэм хэмжээ, дүрэм журам батлагдан гарч байгаа хэдий ч тухайн харилцааг түйлийн утгаар зохицуулаж чадаж байгаа эсэх нь эргэлзээтэй юм. Бизнесийн хууль тогтоомж нь өөр хоорондоо зөрчилдсөн агуулга зарчмын хувьд нэг нь нөгөөгөө үгүйсгэсэн байгаа нь хууль тогтоомжийг зөв тайлбарлан хэрэглэхэд саад учируулж байна.

Бизнесийн хууль тогтоомжуудыг хүчин чадал, зохицуулсан харилцаагаар нь шалгуур болгон авч үзвэл Бизнесийн харилцааг зохицуулсан ***ерөнхий хууль*** нарийвчлан, тусгайлан зохицуулсан шинжээр нь ***тусгай хууль*** гэж ангилах боломжтой.

**Нэгэн жишээ татвал**

Компани үүсгэн байгуулахтай холбоотой харилцааны хувьд авч үзвэл компани үүсгэн байгуулахтай холбоотой холбоотой харилцаанд нийтлэг, ерөнхий, тодотгосон байдлаар компаний ашгийн төлөө хуулийн этгээдийн нэг төрөл болох тухай Иргэний хуулиар зохицуулсан утгаараа Иргэний хууль энэ харилцаанд ***ерөнхий хууль*** болж харин компанийг хэн ,яаж үүсгэн байгуулах тухай Компаний хуулиар нарийвчлан, тусгайлан, зохицуулсан учир Компаний хууль ***тусгай хууль*** болох жишээтэй[4].

### 1.2 БИЗНЕСИЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛСАН ХУУЛЬ ТОГТООМЖУУДАД ТАЙЛБАР ХИЙЖ ХЭРЭГЛЭХ НЬ

Манай улсад хүчин төгөлдөр үйлчилж буй бизнесийн шинжтэй харилцааг зохицуулсан хуулиудад гол төлөв цаг хугацааны хувьд харилцан адилгүй цаг үед батлагдан гарсан. Мөн ихэвчлэн захиргааны шинжтэй хууль тогтоомжууд байгаа

1 Т.Мөнхжаргал. Эдийн засгийн харилцааны эрх зүйн зохицуулалт. УБ.2004.,13-14-дэх тал.

2 Өмчийн тухай, Түрээслэгчийн тухай, Аж ахуйн нэгжийн тухай, Албан татварын тухай, Банкны тухай, Гаалийн тухай, Өмч хувьчлалын тухай, гэх мэт

3 Иргэний эрх зүйд хамаарах Бизнесийн эрх зүйн харилцаа:

Энэ харилцааг бизнесийн бусад харилцаанаас ялгахад амархан боловч, иргэний эрх зүйн бусад харилцаанаас ялгахад төвөгтэй юм. Бусад харилцаанаас зохицуулалтын арга субъектын чиг үүргээр ялгагддаг бол иргэний эрх зүйн харилцаанаас эрх зүйн зохицуулалтын хэлбэр, харилцааны зорилго болон давтамжаар ялгагдана. Энэ харилцаа өмчлөх эрхтэй холбоотойгоор эсхүл гэрээний болон гэрээний бус үүргээр илэрдэг.

Захиргааны эрх зүйд хамаарах бизнесийн эрх зүйн харилцаа:

*Энэ харилцаа Бизнесийн эрх зүйн бусад харилцаанаас эрх зүйн зохицуулалтын төрөл, үүсгэн байгуулах аргаар нь мөн захиргааны эрх зүйн бусад харилцаанаас субъектын чиг үүргээр ялгардаг. Энэ харилцаа хөрөнгө оруулалтыг зохицуулах, өрсөлдөөнийг хянах, зохицуулах, эрх олгох буюу тодорхой үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, бүртгэх, татан буулгах харилцаагаар илэрч байдаг.*

***Цэвэр бизнесийн эрх зүйн харилцаа:***

*Бизнесийн цэвэр харилцаа нь бизнесийн бусад харилцаанаас эхлэл дуусгавар болох үндэслэл цар хүрээ, хамаарах субъектээрээ эрх зүйн зохицуулалтын хэлбэр, үр дагавараар ялгагдана. Аль ч утгаараа харилцааны нэг талд бизнес эрхлэгч буй харилцааг бизнесийн эрх зүйн цэвэр харилцаа гэж ойлгоно.*

4 *Г.Амаржаргалан, С.Доржсүрэн, С.Цэрэнчимэд, Ё.Болормаа, П.Баянбаатар, П.Түвшинтөгс, С.Батбуян. Салбар эрх зүйн тохиолдолд шинжлэх аргачлал УБ.2009., 80 дахь тал*

нь хууль хэрэглэх үед заавал нэмэлт тайлбар хийж хэрэглэхийг шаардаж байгаа юм. Мөн хуулийн үг зүй, нэр томъёог зөв, нэг мөр ойлгох явдал нь бизнесийн хууль тогтоомжуудад дутмаг байгаа нь мөн хуулийн бичилт үг зүйг өөрт ашигтай ямарч байдлаар тайлбарлах боломжтой болж байгааг харуулж байгаа юм.

**Хуульд дараах байдлаар тайлбар хийж хэрэглэх боломжтой.**

- Логик гаргалгааны үүднээс
- Хэл зүйн үүднээс
- Хуулийн хэрэглээний үүднээс
- Онолын үүднээс

**Нэгэн жишээ татан тайлбарлавал:** Хоршооны тухай хуулийн 3.1 дэх[5] хэсгийг жирийн иргэн Дорж уншвал ямар утгаар ойлговол үнэнд дөхөж очих бол нөгөөтэйгүүр мэргэжлийн өмгөөлөгч тус заалтыг өөрт ашигтай ямар байдлаар тайлбарлаж болох бол. Мөн Улсын дээд шүүхээс тус хуулийн 3.1 дэх хэсгийн зарим үгийн утгыг тайлбарласан[6] хэдий боловч хоорондох ялгааг мөн агуулгыг нь хангалттай тайлбарлаж чадсан эсэх нь эргэлзээтэй юм.

Энэ үүднээс тус зүйл, заалтыг өөрийн зүгээс дээр өгүүлсэн хэлбрээр шалгуур болгон тайлбар хийвэл.

***Эдийн засгийн хэрэгцээ*** - Эцсийн үр дүн нь ашиг олох болон мөнгөн гүйлгээ хэлбрээр илрэнэ.

***Нийгмийн хэрэгцээ*** – *Хамрах хүрээний хувьд өргөн нийтлэг ашиг сонирхолд тулгуурласан нийгмийн үнэт зүйлсэд нийцсэн байдлаар ойлгоно.*

***Соёлын хэрэгцээ*** – *Зөвхөн гишүүдийн соёлын хэрэгцээ шаардлагыг хангасан хамрах хүрээний хувьд нийгмийн хэрэгцээг бодвол бага байгаа юм.*

***Нийтлэг хэрэгцээ*** – *Бүх гишүүдийн эрх ашигт нийцсэн байх учиртай.*

***Хэд хэдэн этгээд***-*Иргэн хуулийн этгээд аль аль нь байх боломжтой.*

***Ардчилсан хамтын удирдлага*** – *Ардчилсан гэдэг үгийг оруулж өгсөн шаардлага нь хоршооны даргыг сонгох арга хэлбэр нь бусад хуулийн этгээдийг бодвол өвөрмөц шинжтэй байгаа юм.*

***Дундын эд хөрөнгө дээр үндэслэн*** – *Иргэний хуульд заасан 108 зүйлийг үндэслэн тогтооно.*

## 1.3 МОНГОЛ УЛСАД ХҮЧИН ТӨГӨЛДӨР ҮЙЛЧИЛЖ БУЙ БИЗНЕСИЙН ХАРИЛЦААГ[7] ЗОХИЦУУЛСАН ЗАРИМ ХУУЛИНД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ НЬ

Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй бизнесийн харилцааг зохицуулсан гол хуулиудад[8] тодорхой бус агуулга бүрхэг бүхий зүйл заалтанд хэм хэмжээний бүтцийн үүднээс шинжилгээ хийв. Судалгааны явцад эрх, үүргийг тогтоосон, үйл ажиллагааг заан дурьдсан хэм хэмжээнүүд байгаа хэдий ч ерөнхий туннхаг шинжтэй хуулийн зүйл заалтууд байгаа нь ажиглагдсан болно. Мөн нэг агуулга бүхий ойлголтыг өөр өөр хуулинд нэр томъёоны хувьд өөр байдлаар тусгаж өгсөн нь хууль хэрэглэж буй жирийн субъектүүдийг төөрөгдөлд оруулах улмаар хүссэн үр дүндээ хүрч чадахгүй байх сөрөг үр дагавар үүсэж байна[9]. Бизнесийн харилцааг зохицуулсан хууль өөрөө бизнес эрхлэгч субъектүүдийн ашиг сонирхолыг тэргүүн ээлжинд хамгаалах ёстой байдаг. Энэ зарчмын үүднээс юуны урьд тухайн хуулийн зорилтыг судлан, шинжлэх нь зүйтэй. Дээрх хуулиудын зорилтыг шинжлэхэд нийтлэгдээ тухайн этгээдийн эрх зүйн байдал, үүсгэн байгуулах, татан буулгах, өөрчлөгдөх харилцаа төдийгүй тухайн төрлийн харилцааг зохицуулахад оршиж байгааг анзаарч болно[10].

Тус хуулиудын хариуцлагыг авч үзвэл бусад хуулиудын санкцтай харьцуулхад захиргааны хариуцлагын арга хэмжээ зарим хуулиудад байгаа хэдий ч өгт хариуцлага гэж тусгайлан зааж өгөөгүй хуулиуд ч байгаа нь ажиглагдаж байна. Энэ нь бизнесийн эрх зүйн хариуцлагын өнцөгтэй шууд холбоотой бөгөөд бизнесийн өвөрмөц хариуцлага болох ёс зүйн хариуцлагын илрэл юм. Хамгийн чухал ажиглагдсан зүйл бол хуулиудын уялдаа холбоо хамгийн хангалтгүй байгаа нь тогтоогдсон болно[11]. Хуулийн нэг заалт нөгөө заалтуудын үзэл санааг төөрөгдүүлсэн, хуулинд заасан хугацаа

5 Х.т.х-ийн 3.1 Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, ардчилсан, хамтын удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.

6 *Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан "эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилго" гэдэгт хоршоо хамтарсан үйл ажиллагааныхаа үр дүнгээр бүх гишүүдийнхээ ашиг сонирхол, шаардлагыг хангах явдлыг ойлгоно.*

7 Захиргааны эрх зүйд хамаарах бизнесийн эрх зүйн харилцаа болон цэвэр бизнесийн эрх зүйн харилцааг хэлсэн болно.

8 *- Компаний тухай хууль., УБ.1999 он*
*- Нөхөрлөлийн тухай хууль., УБ.1995 он*
*- Хоршооны тухай хууль., УБ.1998 он*
*- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль., УБ.2003 он*
*- Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль., УБ.1993 он*

9 *Судалгаанд орсон нийт хуулиудыг хавсралт-1 схемээр харуулсан болно.*

10 Мөн тэнд.

11 Мөн тэнд.

ногоо хуулийн хугацаатай зөрөлдлөг гэх мэт олон алдаа дутагдал байна.

### 1.3 БИЗНЕСИЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛСАН ЗАРИМ ХУУЛИЙГ[12] ХЭМ ХЭМЖЭЭНИЙ БҮТЦИЙН ҮҮДНЭЭС АВЧ ҮЗЭХ НЬ

Хэм хэмжээний бүтцийн үүднээс авч үзвэл материаллаг хэм хэмжээ нь

1. Гипотез /нөхцөлт/
2. Диспозиц /заалт/
3. Санкц / хариуцлага/ гэсэн гурван хэсгээс бүтэх бөгөөд эдгээр гурав нь материаллаг хэм хэмжээний үндсэн бүрдэл юм.

Ерөнхийд нь гипотезыг материаллаг хэм хэмжээ гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл материаллаг хэм хэмжээг тунхаг шинжээр зааж өгсөн зүйл гэж ойлгож болно. Харин диспозиц бол процедурын хэм хэмжээ юм. Өөрөөр хэлбэл нөхцөлт хэсэгт заасныг хэрхэн яаж, хэн хэзээ хэрэгжүүлэх вэ гэдгийг зааж өгсөн хэсэг юм. Санкц оршин учир нь диспозицэд зориулагдсан байх ёстой юм. Харамсалтай нь манай улсад диспозицыг нарийн ойлгомжтой зааж өгөөгүйгээс, түүний ач холбогдолыг ойлгохгүйн улмаас санкцыг гипотезцтэй уялдуулан холбож байна. Мөн гипотезийн агуулга олон утга санаагаар тайлбарлагдсан утга ойлгомжгүй байгаа нь харагдаж байна[13].

### ХОЁР. ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙД ХАМААРАХ БИЗНЕСИЙН ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛСАН ХУУЛИЙГ ҮГ ЗҮЙН ҮҮДНЭЭС ТАЙЛБАРЛАНА ХЭРЭГЛЭХ НЬ

Иргэний эрх зүйд хамаарах бизнесийн эрх зүйн харилцааг зохицуулсан хуулиудын нэг бол Монгол улсын Иргэний хууль юм. Бизнесийн байгууллага гэрээний үндсэн дээр аливаа харилцаанд орохдоо иргэний хуулийн холбогдох зүйл заалтанд нийцүүлэж гэрээ байгуулах ёстой байдаг. Тиймдээ ч бизнесийн ач холбогдол өндөр бүхий гэрээнд холбогдох үгийг сонгон хэрэглэхдээ анхаарах хэрэгтэй. Бизнесийн хэрэг маргааны ихэнх нь гэрээний маргаан болон түүний үгийн утга санаааннаас маргаан үүсэж талууд хүссэн үр дүндээ хүрч чадахгүй байх нь нийтлэг ажиглагддаг. Хууль хэрэглээний хувьд гэрээнд үгийг сонгон хэрэглэхдээ агуулга утга санааг нь хуулийн өөрийн зүйл заалт агуулгаар нь тайлбарлан хэрэглэх нь гэрээний эрсдлээс таныг бага ч гэсэн хамгаалах болно. Энэ үүднээс Иргэний хуулийн гэрээний үүрэгтэй холбоотой үг зүйг тайлбарлан хэрэглэхийг энэ хэсэгт зорьсон болно.

### 2.1 ИРГЭНИЙ ХУУЛИЙН ГЭРЭЭНИЙ ҮҮРЭГТЭЙ ХОЛБООТОЙ ЗААЛТЫГ ХУУЛЬ ТАЙЛБАРЛАХ ҮҮДНЭЭС АВЧ ҮЗВЭЛ

Тайлбарлах[14] гэсэн нэр томъёо нь олон утга илэрхийлнэ. Зарим судлаачид "хуулийг тайлбарлах үйл ажиллагааг зөвхөн эрх зүйн агуулгыг нь ухаж ойлгох үйл ажиллагаа" гэж үздэг бол бусад судлаачид "хуулийг тайлбарлах үйл ажиллагаа бол эрх зүйн хэм хэмжээг тайлбарлаж таниулах үйл ажиллагаа" хэмээн тодорхойлдог байхад гуравдах хэсэг нь "эрх зүйг тайлбарлах ажиллагаа нь дээрх хоёр үйл ажиллагааны нэгдлээс бүрдэнэ" гэж үздэг байна[15]. **Үүнээс дүгнэн үзэхэд:**

*Хуулийг тайлбарлах гэдэг нь эрх зүйн хэм хэмжээний утга санаа, нэр томъёог тодруулах, нээн харуулах тодийгүй эрх зүйн актыг амьдралд зөв хэрэглэх зорилгоор түүний агуулгыг тодорхойлох үйл ажиллагаа юм.*

**Дээрх тодорхойлолтыг агуулгын хувьд задлан тайлбарлавал:**

*Хуулийг тайлбарлах үйл ажиллагааны эхний хэсэг тухайн эрх зүйн хэм хэмжээний утга санаа агуулгыг ухаж ойлгох явдал байдаг бөгөөд уг үйл ажиллагаа эрх зүйн тайлбарын танин мэдэхүйн мөн чанарыг тодорхойлж, эрх зүйн хэм хэмжээг хэрэглэж байгаа субъектын ухамсарт үйл ажиллагаагаар дамжин илэрдэг дотоод сэтгэхүйн процесс юм[16].*

Монгол улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар нь хуулийг нэг мөр, зөв хэрэглэхэд ач холбогдол бүхий юм. Монгол Улсын Үндсэн хуулийн 50.1 дэх хэсэгт шүүхийн дээд байгууллагын хэрэгжүүлэх бүрэн эрхийг тодорхойлохдоо *"Монгол Улсын Дээд шүүх Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах"-аар тусгасан байна.* Мөн шүүхийн тухай 15.6.5 дэх хэсэгт *"Үндсэн хуулиас бусад хуулийг нэг мөр ойлгож,*

12 Захиргааны эрх зүйд хамаарах бизнесийн эрх зүйн харилцаа болон цэвэр бизнесийн эрх зүйн харилцааг зохицуулсан хуулиудыг хэлсэн болно.

13 Судалгаанд орсон нийт хуулиудыг хавсралт-1 схемээр харуулсан болно

14 *interpretatio-тайлбарлах гэсэн латин гаралтай үг*

15 *Ч. Нямсүрэн. Эрх зүй төрийн ерөнхий онол. УБ. 2004., 209-дэх тал*

16 *Н.И.Матузов, А.В. Малько. Теория государства и права курс лекций. М., С-418 /дам ишлэл/*

*зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар /цаашид хуулийн тайлбар гэх/ гаргах"* гэж тусгаж өгсөн байна.

Монгол Улсын Дээд шүүх хуулийн үгийн утга санааг тайлбарлах онцгой эрх бүхий субъект байдаг. Энэ утгаараа тухайн хуулийг зөв хэрэглэх үндэс суурийг тавьж өгдөг . Одоогийн байдлаар Монгол Улсын Дээд шүүхээс иргэний хуулийн зүйл, заалтыг тайлбарласан тайлбар гаргасан бөгөөд[17] Иргэний хуулийн 243-485 хүргэлх заалтуудаас 445- 447 болон 452-455, 457 зүйл заалтуудын зарим хэсгийг тайлбарласан байна.

Үүнээс бяцхан дүгнэлт хийвэл Монгол Улсын Дээд шүүхийн тайлбар ихэнх тохиолдолд хууль тогтоогчийн санааг нэмэн дэлгэрүүлж, түүний гипотезд /нөхцөлт/ нэмэлт тайлбар хийх, нөхцлийг тодорхойлох, диспозец /заалт/ хэсэгт үйлдлийн хэр хэмжээ, шинжийг тодорхойлон тогтоосон тайлбар байх нь цөөнгүй байна. Энэ цаашлаад Улсын Их Хурлаар батлагдсан хууль тогтоомж нь агуулга бүрхэг байгаагаас болоод Улсын Дээд шүүх түүнийг нэмэн дэлгэрүүлэн тайлбарлдаг. Ингэснээр Улсын Дээд шүүхээс гарсан тайлбар нь бусад хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилдэг тэгэхээр Улсын Дээд шүүх хууль тогтоох эрх мэдэл рүү хутгалдан орох тал ажиглагдаж байгаа юм.

## 2.2 ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙ ДЭХ ҮГ ЗҮЙН БҮЛЭГ, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Иргэний хуулийн гэрээнүүдэд[18] үг зүйн үүднээс авч дүн шинжилгээ хийв. Судалгааны явцад гэрээтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээ байгаа боловч түүнийг илэрхийлсэн үг нь утга санаа бүрхэг, олон салаа утгатай нөгөө талаар олон салаа утга бүхий хуулийн заалт дээр өмгөөлөгч тоглолт хийж хуулийн утга санааг гуйвуулан тайлбарлаж хууль тогтоогчийн үзэл санааг замахруулах тал ажиглагдаж байна. Хууль хэдий хүчин чадалтай, заавал биелэгдэх, нийтээр дагаж мөрдөх шинж чанартай ч гагцхүү тэрхүү хуулийг хэрэгжүүлэх, иргэдэд ойртуулах, тэднийг болоод хууль сахиулагчид, хууль хэрэглэгчдийг өөрсдийг нь төөрөгдөлд оруулахгүй байх зүйл бол тэр хуулийн үзэл санааг илэрхийлсэн үг түүний сонголт, утга санаа юм.

Гэрээнд оролцож байгаа талуудын хүсэл зориг түүнийг тайлбарлах, хэрэг маргааны зүйлчлэл дээр тогтсон нийтлэг арга түүнийг үнэлж үзэх нэгдсэн стандарт дутмаг шинж байгаа. Хэдий хуулийг мэдэхгүй буюу буруу ойлгосон нь хуулийг хэрэглэхгүй байх, хуульд заасан хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй гэж заасан ч хуулийг зөв ойлгоно хэрэглэх нь нэн ярвигтай шинжийг агуулж байна. Орчин цагийн монгол хэл түүний үгийн сангийн бүтцийг[19] авч үзвэл хуулинд хэрэглэсэн үгийн нэр томъёог ангилах боломж нөхцөл байгаа юм. Энэ үүднээс гэрээтэй холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээг илэрхийлсэн үгийг монгол хэлний үгийн сангийн бүтцээр ангилан авч дүн шинжилгээ хийж хууль хэрэглээний үүднээс тайлбар өгсөн болно[20].

## 2.3 ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙД ХЭРЭГЛЭХ ҮЙЛ ҮГИЙН БҮЛЭГ

Үйл үг[21] түүний холбоо үгээр илэрхийлсэн үг Иргэний хуулинд маш олон тусгагдсан бөгөөд түүнийг бүтэцлэн ангилаж дараах хэлбэрт оруулсан болно. Үүнд:

1. Хууль зүйн үр дагавартай, хууль зүйн үр дагаваргүй
2.

17 *- Иргэний хуулийн 10, 11 дүгээр бүлгийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай /дугаар-17/*
*- Иргэний хуулийн 12 дугаар бүлгийн 1,2 дугаар дэд бүлгүүдийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай /дугаар-18/*
*- Иргэний хуулийн 12 дугаар бүлгийн 3 дугаар дэд бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /дугаар-20/*
*- Иргэний хуулийн 44, 45, 46 дугаар бүлэг, банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /дугаар-53/*
*- Иргэний хуулийн өмчийн эрх зүйн хэсгийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай /дугаар-442/ 1997 он*
*- Иргэний хууль мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны үйл ажиллагааны тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /дугаар-197/ .1996 он*

18 *- Бусдын өмчлөлд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээний үүрэг*
*- Бусдын эзэмшил, ашиглалтанд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдсон гэрээний үүрэг*
*- Ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэхтэй холбогдсон үүрэг*

19 *Жинхэнэ нэр, тооны нэр, үйл үг, төлөөний үг, тэмдэг нэр, орон цагийн нэр*

20 *Хавсралт хэсэгт схемээр үзүүлэв.*

21 *Өгүүлбэрт тусах, эс тусах байдлаар илэрч мөн, хэрэгт гэх агуулгатай харицалддаг үгийг хэлэх бөгөөд холбоо болон дан үгээр илэрхийлэгддэг.*

3. Иргэний хуулийн хэрэглээний босоо журмын дагуу / А, Б, В/ гэсэн III хэсэгт хамаарах[22]
4. Өөрөө үйлдэх хэвээр/гэрээний хоёр тал оролцоно/, бусдаар үйлдүүлэх хэвээр/ гэрээний талууд оролцоогүй эрх бүхий субъект оролцоно/
5. Гэрээний хэлбэрээс хамаарч бичгийн хэлбэрт хамаарах, амаар хийх, үйлдэл хийхээр гэрээнд хамаарах гэж төрөлжүүлнэ.
6. Тухайн үйл үгийг шууд утгаар, дамжмал утгаар хэрэглэх үйл үг гэж ангилна.

Гэрээний эрх зүйд хэрэглэгдэх үйл үгийн бүлгийг IX бүлэг болгон хувааж нийт 42 холбоо үйл үгэнд дүн шинжилгээ хийж үзэхэд хоорондоо утга тостэй хэрэглэхэд онолын тайлбар хийж хэрэглэх үг нэлээд байна тухайлбал "гэрээнд тусгах", "гэрээнд заах" жирийн иргэн уншвил утга санаа нэг мэт, хуулинд байгаа зүйл заалт бүр дээр дүн шинжилгээ хийвэл[23] агуулга утга нь өөр өөр байх юм.

## 2.4 ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙД ХЭРЭГЛЭХ ТЭМДЭГ НЭРИЙН БҮЛЭГ

Тэмдэг нэр гэдэг нь юм үзэгдлийн өнгө зүс, шинж чанар, овог дүр тоо хэмжээг зааж аль?, ямар? гэсэн асуултад хариулагддаг өгүүлбэрт байц гишүүнээр илэрдэг ойлголт юм. Тэмдэг нэр өгүүлбрийн утга санааны гол илэрхийлэл болож өгдөг шинжтэй. Иргэний хуулинд тэмдэг нэр түүний төрөл хэлбэрт дүн шинжилгээ хийж нийт VI бүлэг болгон 23 холбоо үгийг тайлбарласан болно. Тэмдэг нэрийн бүлгийг дараах байдлаар ангилсан. Үүнд:

1. Хууль зүйн үр дагавартай, хууль зүйн үр дагаваргүй /иргэний хуульд олон тэмдэг нэрийн шинжийг агуулсан үгүүд байгаа бөгөөд ихэнх нь хууль зүйн үр дагаваргүй боловч зүйлчлэлийн хувьд гол үнэлж үзэх утга байгаа юм. Энэ бүгдийг бололцоотой хувилбараар тайлбарлахыг оролдсон болно[24].
2. Хууль зүйн нэр томъёогоор тайлбарлагдах, монгол хэлний үгийн утгаар тайлбарлагдах / Монгол хэлний үг түүний утгыг хууль зүйн үүднээс тайлбарлавал агуулга нь өөр байдлаар илэрхийлэгдэж байгаа юм./
3. Зүйлчлэлийн тайлбар хийгдэх, үгийн хуулийн хэрэглээний тайлбар хийгдэх ангилсан болно / Доорх тайлбарыг хийхдээ гэрээний зүйлчлэл болон үгийн утгын тайлбарыг хослуул болно/

**Тайлбар:**

*Доорх тайлбарыг[25] дараах шалгуураар тайлбарлахыг зорьсон болно. Үүнд:*

1. *Үгийн тайлбарыг хийхдээ хууль зүйлийн заалтаар илэрсэн агуулга бүрт дүн шинжилгээ хийж хэм хэмжээний агуулга зорилгоор тайлбарлахыг хичээсэн болно.*
2. *Тус зүйл, заалтын хэрэглээний хувьд хамт хэрэглэх заалт зүйлчлэлийн аргыг хослуулахыг хичээсэн болно.*

---

22

| А хэсэг | Б хэсэг | В хэсэг |
|---|---|---|
| 8.1.5 -/497/<br>8.1.6 - /492/<br>8.1.8 /дээн тохиолдол / | 8.1.1 | 8.1.5<br>8.1.6<br>8.1.8 /227 228 229 / |
| Өмнөх харилцаа | Гэрээний үүргийн харилцаа | Дуусгавар болсоны дараах харилцаа |

***III хэсгийг тогтоох арга 1:***
А хэсэг тогтоох арга : 187.2 187.3
Б хэсэг тогтоох арга: 8.1.1-т 227.1 хамт үнэлж үзэж болохгүй.
В хэсэг тогтоох арга: 8.1.5 8.1.6 8.1.8 –д 227 228 229

***III хэсгийг тогтоох арга 2:***
Гэрээ дуусгавар болход /тус утга орсон бол Б хэсэг/
Гэрээ дуусгавар болох үед / тус утга орсон бол Б хэсэг/
Гэрээний хугацаа дуусахад / тус утга орсон бол В хэсэг/
Гэрээ дууссаны дараа / тус утга орсон бол В хэсэг/
Гэрээ дууссанаас хойш / тус утга орсон бол В хэсэг/
Гэрээний хугацаа дууссаны дараа / тус утга орсон бол В хэсэг/

23 *Хавсралт-3 схемээр үзүүлэв.*

24 *Хавсралт-3 схемээр үзүүлэв*

25 *Хавсралт-2, 3*

## ГУРАВ. ЭРХ ЗҮЙН БҮЛҮҮДИЙН ИРГЭНИЙ БОЛОН ХУДАЛДААНЫ ЭРХИЙН ХАРЬЦУУЛАЛТ

### 3.1 ЭХ ГАЗРЫН ЭРХ ЗҮЙ ДЭХ ИРГЭНИЙ БОЛОН ХУДАЛДААНЫ ЭРХ

Эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий орнууд **дуализм** [26] буюу иргэний эрх зүйн, худалдааны эрх зүйн ялгамжтай кодификаци бүхий тогтолцоотой байдаг. Нэг үгээр хэлбэл худалдааны хууль болон иргэний хууль нь тус тусдаа байж тухайн төрлийн харилцаагаа зохицуулдаг байх юм. Ийм тогтолцоо бүхий оронд Франц, Герман, Япон улсууд багтана[27].

Худалдааны төрөлжсөн, тусгай хуулиар зохицуулагддаг /Герман, Франц, Япон/ болон бусад орнууд дараах шинжүүдээр Худалдааны эрх зүйн **бие даасан шинжийг** дүгнэн авч үзсэн байдаг[28].

Үүнд: **1.** Худалдааны тусгай шүүхтэй байх, / Бизнесийн харилцааг зохицуулсан процесстой гэсэн үг./

**2.** Хуулийн этгээд болон худалдааны хэлцлийн тусгайлсан бүртгэлтэй байх,

**3.** Худалдааны эрх зүйг их, дээд сургуульд тусгайлан боловсруулж, судалдаг байх.

Зарим улс орнуудад дуализмын талаарх тусгаарласан зохицуулалтаас **нэгдсэн байх хандлагын**[29] илүүтэйгээр баримталж байна. Жишээ нь, 1911 онд Швейцарь, 1942 онд Итали иргэний болон худалдааны хуулиудаа нэгтгэсэн байна.

### 3.2 АНГЛИ –АМЕРИКИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ИРГЭНИЙ БОЛОН ХУДАЛДААНЫ ЭРХ

Англи-Америкийн эрх зүйн тогтолцооны үндсэн эх сурвалж нь шүүхийн прецедент бөгөөд хууль хоёрдогч байр суурийг эзэлдэг. Эрх зүйн тогтолцооны хуваагдал болон дуализм байдаггүй. Англи, Америкийн эрх зүйн тогтолцоонд шүүхийн шийдвэр үндсэн эх сурвалж байх бөгөөд хууль тогтоомж нь дагалдах байр суурь эзэлдэг. Англид өнөөдрийг хүртэл Иргэний болон худалдааны төрөлжсөн хууль байхгүй байна.

Мөн Англи, Америкийн эрх зүйн талаарх онол, үзэл баримтлалд "нийтлэг үндэслэл" гэсэн хэсэг байдаггүй бөгөөд иргэний эрх зүйн бүхий л институтэд хамаарах хэм хэмжээний цогц шинж энэ тогтолцоонд байдаггүй[30]. Английн хувийн эрх зүйн үндсийг тухайн бүс нутгийн заншлыг удирдлага болгон шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр бий болгосон. Шүүхийн шийдвэрт үндэслэн бий болсон дүрын эрх зүй нь парламентийн актыг өөрчилж, хүчингүй болгож байдаг байна[31].

К.Маркс, Ф.Энгельс, нар нэгэн бүтээлдээ дурьдахдаа "Английн хууль-энэ бол энгийн эрх буюу бичигдээгүй эрх, статусыг цуглуулж эхлэх тэр үеэс л байж байсан ба дараа нь хууль зүйн нэр хүндтэй хүмүүс түүнийг нэгтгэснээр-энэ эрхийн үндсэн заалтууд нь тодорхойгүй, эргэлзээтэй болж-статус эрх нь бие биетэйгээ зөрчилдөөн, эрхийн байдлыг эрхийн бус байдалд тавьсан гэх зэргээр 500 жилийн турш цуглуулсан парламентын салангид, тасралтгүй үргэлжилсэн төгсгөлгүй актуудын эгнээнээс бүрдсэн цогц болжээ" хэмээсэн нь бий.

**Английн эрх зүйд иргэний болон худалдааны чиглэлээр**

- худалдааны тухай,
- нэхэмжлэх хугацааны тухай /1980/,
- эд хөрөнгө, үйлчилгээний тухай,
- зээлийн төлбөрийн тухай,
- патентын тухай /1977/,
- компанийн тухай /1985/ гэх мэт хуулиудыг тус тус баталж байсан бөгөөд дунджаар жил бүр Их Британид 2000 шүүхийн шийдвэр, 300 эмхтгэл, 80 дүрэм /статут/ нэмэгдэж байна. Мөн олон тооны шийдвэр, хууль, хууль тогтоомжийн актууд нь шүүхийн бодит байдлыг үнэлэх хүрээг өргөтгөж байна.

---

26 *Дуализм нь Иргэний эрх зүй ба худалдааны эрх зүйг тусган бие даасан хуулиар зохицуулдаг орнуудын тогтолцоо юм.*

27 *Дуализм зарчим бүхий орнуудын иргэний хууль болон худалдааны хуулийн харьцуулалтыг хавсралт-4 схемээр харуулав.*

28 Г.Амаржаргалан. Бизнесийн эрх зүйн лекцийн эмхтгэл. Дэвтэр-1.УБ,2010 он.,24 дахь тал

29 Нэгдсэн байх гэдэг нь худалдааны хууль болон иргэний хууль нэг статус бүхий нэгдсэн нэг хуулиар тус харилцааг зохицуулдаг байна.

30 Г.Амаржаргалан. Бизнесийн эрх зүйн лекцийн эмхтгэл. Дэвтэр-2.УБ,2010 он.,19 дахь тал

31 ***Түүхийн хувьд,*** *14-р зуунд Англи улсыг Роучууд эзэлж авсан. Нэгэндээ Английн уламжлалд бичигдэх хуулийг /статутын эрхийг/ нэвтрүүлсэн байна. Гэвч Английн шүүх эсэргүүцэн, хамааралгүйн шийдэх болсон, ромын эрх зүйн хэм хэмжээний дагуу бус бие даасан шийдвэр гаргах болсон. Энэ үеэс энэ уламжлал хоригдсон Английн шүүх эрх зүйг бүрэн байгуулалга болж "жишээлэлийн эрх зүй" тогтсон байна. /Их Альфредын үе 871-900, 1066-XIV зууныг Вильгельмийн үе/*

## 3.3 МУСУЛЬМАНЫ ЭРХ ЗҮЙ ДЭХ ИРГЭНИЙ БОЛОН ХУДАЛДААНЫ ЭРХ

**Мусульманы эрх дэх эх сурвалж нь:**

- Коран /Мусульманы эрх зүйн үндсийг тогтоож өгдөг, Аллахын зөвшөөрсөн хэм хэмжээгээр тодорхойлогддог/
- Хуульчдын хэлбэржүүлсэн хэм хэмжээ /энэ нь хууль боловч Аллахын илгээсэн Кораны үзэл санаанд нийцсэн байх ёстой. Энэ агуулгаараа гэрээний чөлөөт байдал, гэрээний хууль тогтоомж гэж үгүй[32]./

Коран нь худалдааны харилцаанд багахан анхаарал хандуулсан байдаг. Энэ утгаараа худалдааны харилцааны ихэнх хэсгийг хуульчдын тогтоосон хэм хэмжээгээр зохицуулна.

**Худалдааны талаар Коран 3 хандлагыг зөвшөөрсөн байна. Үүнд:**

1. Аллах худалдаа хийхийг зөвшөөрсөн боловч хөрөнгийн илүү гарсан хэмжээг хориглодог- "Исламын банк"
2. Аллах гэрээг биелүүлэх ёстой гэж үздэг.
3. Бусдад үүрэг өгч байгаа бол бичгээр хийх хэрэгтэй гэж үздэг. /Энэ нь эргээд нотлох шинжтэй, түүнчлэн бусдад өгсөн мөнгөө буцаан авах ёстой байдагтай холбоотой/

## ДҮГНЭН ХЭЛЭХ НЬ

**Өнөөгийн түвшинд:**

1. Бизнесийн хууль тогтоомж уялдаа холбоо муу нэгдсэн байдлаар системчлэлд орж чадаагүйгээс болож хууль буруу хэрэглэх мөн бизнесийн харилцааг эрх зүйн хэм хэмжээгээр хангалттай баталгаажуулж өгөөгүйгээс энэ нь цаашлаад бизнес эрхлэгчдийн хувьд бизнесийн маш том эрсдэл болон хувирч байна.
2. Бизнесийн харилцааг зохицуулсан хуулиудын хоорондын уялдаа холбоо, агуулгын зөрчилдөөнийг арилгах үүднээс холбогдох хуулийн зүйл заалтанд нэмэлт өөрчлөлт оруулах мөн хуулийн нэр томъёо агуулгыг эдийн засгийн хөгжил, шинэчлэлтэй уялдуулан холбогдох хуулинд шинэчилсэн найруулгыг оруулах шаардлагатай байна.
3. Хууль бүтээх ажиллагаанд иргэд, бизнес эрхлэгч субъектүүдийн санал хүсэлтийг тусгана хуулийг зүй ёсны утгаар нь батлан гаргадаг байх тогтолцоо шаардлагатай.

**Цаашид:**

4. Бизнесийн хэрэг маргаан дээр Иргэний эрх зүйн зарчим үзэл санаанаас илүү бизнесийн үнэт зүйл, зарчимд тал өгч хандах нь цаашлаад Бизнесийн эрх зүйн чиглэлээр дагнасан хуульч бэлтгэх, бие даасан бизнесийн процессын ажиллагаа, түүний эрх зүйн орчныг бий болход харгалзан үзэх санаа болно.
5. Дуализм болон нэгдсэн байх зарчмын үүднээс Монгол улсын иргэний хууль болон бизнесийн харилцааг зохицуулсан хуулиудыг авч үзэхэд аль ч зарчимд хамаарагдахгүй байгаа нь харагдаж байна.Өөрөөр хэлбэл Монгол улсын бизнесийн харилцааг зохицуулсан хуулиуд болон бизнесийн эрх зүй чиг хандлага хаашаа хөгжиж яваа нь мөн тодорхой бус байна.
6. Энэ үүднээс Иргэний хуулийн үзэл санааг бизнесийн эрх зүйн зарчим,үзэл санаатай нийцүүлэх, аль эсвэл бизнесийн эрх зүйн үнэт зүйлсийг шингээсэн бие даасан худалдааны хуультай болох шаардлагатай байна.

Эцэст нь дүгнэн хэлэхэд бизнесийн харилцааг зохицуулсан хэм хэмжээ нь бусад төрлийн харилцааг зохицуулсан хэм хэмжээг бодвол ялгагдах өөрийн гэсэн онцлогтой бөгөөд хуульчдаас илүү мэргэжлийн ур чадварыг шаарддаг бөгөөд мөн түүнд хэрэглэх хэм хэмжээг нарийвчлан задлан утга санаа, нэр томъёог ухаж ойлгон хэрэглэх нь бизнесийн эрх зүйн хөгжилд бага ч гэсэн хувь нэмэр орох болов уу

32 *К.Г.Судакова. Дуализм итальянского частного права.*

# ЭРХ ЗҮЙ БА СЭТГЭЛ ЗҮЙ



*Э.ЭРДЭНЭБАТ*

*/Шихихутуг ХЗДС-ийн дадлагажигч багш, магистрант/*

*Verba debent intelligi cum effectu.*

*/Words ought to be understood with effect/*

Эрх зүй гэх ойлголт нь одоогоор мэдэгдэж буй 2500 жилийн хөгжлийнхөө явцад нийтээр хүлээн зөвшөөрөгдөх, нэг утгат эрх зүйн ухагдахуунтай болж чадсангүй, болох шаардлага ч байхгүй. Учир нь ***"Эрх зүй"*** гэдгийг хэрэглэгчид нь тухайн үед өөрийнхөө санааг л түүгээр илэрхийлэх боломжтой. Эрх зүй нь хувь хүний амьдралын туршид утга агуулгын хувьд байнга өөрчлөгдөж ирсэн. Үүнээс үүдэн эрх зүйн ойлголт өөрчлөгдөж, түүний утга агуулгын талаар маргаан үүсээр, бас үргэлжилсээр байх болно.

Шарль Луй Монтескьен алдарт бүтээл болох ***"Хуулийн амин сүнс"***-дээ:

> *"Оюун ухаан, зүрх сэтгэлийн тэчьяадал янз бүрийн цаг агаарын нөлөөгөөр онцгой өөр өөр гэдэг нь үнэн юм бол хууль цааз энэ тэчьяадал, энэ шинж чанарын ялгавартай нийцэж байж таарна."*[1] гэдгээс үзвэл,

**Эрх зүй гэдэг нь яг л хэл, хөгжим лугаа адил үндэстэн, ард түмэн бүрийн уламжлал, соёл, *сэтгэл зүй*, сэтгэцийн түүхийг илэрхийлэх тэрхүү хэм хэмжээ хэмээн ойлгож болно. Дэлхий дээр ижилхэн үндэсний эрх зүйн систем гэж байхгүй, байх ч боломжгүй юм** гэсэн аксиомыг Кристофер Осаквегийн бүтээлд тусгагдсан байна.[2] Өнөөдөр *эрх зүйг* өргөн хүрээнд тайлбарлах болсон. Эрх зүй нь хүний амьдралд нэвтрэн орж л байгаа бол амьдрал шиг баялаг хүрээгээр тайлбарлагдах ёстой.

Хүмүүс анх овгийн байгуулалт руу нийгэмшин шилжих үед ёс заншил, бөө мөргөл, бишрэл шүтлэг аяндаа бий болж, улмаар зан үйлийн дэг, хориг, аман зарлиг, горим журмууд үүсч, тэдгээрт эрх зүйн төсөөллийн анхны илрэл, хэлбэр тусгалаа олсон байна. Эрх зүй хэмээх ойлголтыг ***байгаль орчин, бурхан,ээн тэнгэр, далд ертөнцөөс*** заяагдан ирж, түүнд итгэх хандлага эхэндээ нилээд түгээмэл шинжтэйгээр анхлан буй болжээ. Шүтлэг мөргөл, шашны зан үйлээр дамжуулж хүний шунал, хүсэл, төрөлхийн муу авир араншинг номхотгох, заавал дагах зам мөрийн чигийг заах зэрэг үзэл онол ихэд дэлгэрсэн байна.[3] Психоанализ-хүмүүсийн ухамсарлагдсан ба ухамсарлагдаагүй субьектив зан үйлийн харьцааг зохистойгоор хангах, дур

1 Шарль Луй Монтескье. *Хуулийн амин сүнс*. Орч. Т.Томорхуяг. УБ., 2009. Х.203 дахь тал

2 К.Осакве. *Сравнительное Правоведение: схематический комментарий*. М., 2008. Стр.136
*"Право, как язык или музыка, есть нормативное выражение истории, психики, психологии, традиций и культуры каждого народа. Нет и не может быть двух идентичных национальных правовых систем в мире."*/Орч./

3 The Philosophy of Law. Encyclopedia. Editor. Christopher Berry Gray. *Historical Philosophy of Law.* London. 1999. P.350-359

зоргын замбараагүй хүсэл, хэрэгцээг бодитойгоор тооцох, хянаж, харгалзах замаар хүний сэтгэхүйн шаардлагад уялдуулж, субъектив харилцааг зохицуулахад оршино.[4]

Хүний гарал үүслээр төдийгүй, төрөлх уг чанараараа муу, муухай зүйлс, шунал тачаал, буруу үйлдэл хийх авир зуршилтай байдгаас түүнийг нь хорьж цагдах, нийтгэх, журамлах шаардлага буй болов. Хүн бол биологи, байгалийн хийгээд *хувь хүний сэтгэхүйн бүтээгдэхүүн* болохын хувьд физиологийн, аюулгүйн, нийгмийн хэрэгцээг өөртөө чанд хадгалсан, түүнийгээ бүрэн дүүрэн хангахын төлөө ямагт эрмэлзэж байдаг.[5]

Эрх зүй нь сэтгэл зүйгээр дамжин заншил, уламжлал хийгээд ерөөсөө хувь хүний дадал зуршил, ахуй амьдрал, соёлд нэвтрэн орсон.[6] Төрөөс өөрийн ашиг сонирхлыг эрх зүйн хэлбэрт оруулж бүрэлдэн байгаа мэдрэмж, сэтгэл хөдлөл, догдлол зэргийг ба эцсийн эцэст сэтгэл зүйн байдлыг бүхэлд нь барьж байхад эрх зүйн мэдлэгийн ач холбогдол нь илэрдэг.

XX зуун сүүлчид Франкфуртын их сургуулиас гарсан сэтгэлгээний задрал[7] нь ертөнцөд обьектив бодит байдал гэж байхгүй. Бодит байдал гэдэг бол социал бүтэц бөгөөд энэ нь бидний мэндлэхээс өмнө аль хэдийн угсрагдсан байдаг. Тиймээс бидэнд жам ёсны гэх нэрийн дор хүлээн зөвшөөрөгдсөн үнэн чанартаа зохиомол ертөнц юм. Үүнийг менарратив хэмээдэг. Тухайлбал, эрх зүйн либерализм, хууль зүйн позитивизм, постмодернизм гэсэн нэрийн дор хөгжиж буй мета-нарративууд биднийг өөр өөрийнхөө хэвэнд цутган, гагцхүү өөрийнхөө логикт захируулж, нийгэм даяар өөрийн хяналтыг бүрэн тогтоож чаддаг. Үүний үндсэн дээр жинхэнэ би гэж байхгүй болдог. Түүнчлэн, мэдлэг бол хүч. Хэрэв бодит байдал нийгмийн зохиомол ертөнц байх аваас түүнийг зохиосон, сэдсэн этгээд[8] агуу их эрх мэдэлтэй. Тэгээд үүнийг жам ёсны хэмээн нэрийдлээр бидэнд ухуулга хийдэг. Төрийн зүгээс эрх зүйд тавьдаг нийтлэг шаардлага бол хүний амьдралын дийлэх асуудлыг шийдвэрлэх чадвартай байх ёстой. Энэ нь ерөнхий нөхцөл болох "тэг, эсхүл үгүй" гэсэн логикт үндэслэж байсан.

Сэтгэлгээний өөрчлөлт өөрөө нийгмийн өөрчлөлтийг дагуулдаг гэсэн ерөнхий зүй тогтлын өнцгөөс ажиглавал эрх зүй нь нийгмийн хяналтын хэрэглүүр болохын хувьд шууд хамааралтай гэсэн үг. Эрх зүйн хэм хэмжээ, горим журам хэмээн үзэх уламжлалт хандлага нь ***"тэг эсхүл, үгүй"***(all-or-nothing)[9] гэсэн хүрээгээр хязгаарладаг учраас түүний дунд орших ***асар олон хувилбарт сэтгэх боломжийг хааж***, дээрхи шаардлагыг биелүүлэхэд хүчин мөхөсддөг.

oooOOooo

*Ингээд үзэхээр эрх зүй бол ...хувь хүнийг "**тодорхой хүлээснд**" оруулдаг. Нэг үгээр хэлбэл эрх зүй нь зөвшөөрч, шаардаж, таатай бищ үр дагавраар заналхийлж, боломж гарвал түүнийгээ биелүүлж байдаг.*[10] Энэ тухай Жон Локк ***"Засаглалын хоёр шастир"*** хэмээх бүтээлдээ:

> *"Муу бүхний Эзэн, Адамыг айдаст нь дулдуйдаж захирахын тулд Эзэн тэнгэрийн эрхшээлээс зүй бус аргаар хулгайлсан.*
>
> *Харин Төр хэмээх нь ард түмнийг захиран удирдах шилдэг арга нь тэдний айдас юм. Хүний төрөлх шинж ариун дагшин чанараас нь салгаж байх нь түүний зорилго нь билээ."*[11] хэмээжээ.

Чезаре Беккариа, ***"Гэмт хэрэг ба ялын тухай"*** хууль зүйн утга зохиолдоо:

> *"Балар цагийн зэрлэг байдлаасаа дөнгөж гараад байгаа ард олны сэтгэлд илүү хүчтэй, туйлд нь хүртэл айлгаж балмагдуулсан хүчээр нөлөөлөх нь зөв. Арсланг айлгахад аянгын ниргээн хэрэгтэй. Чавхдах нь өдөхийн нэмэр. Харин хүмүүс нийгэмшиж боловсрохоороо мэдрэмж нь өсдөг тул тэр хэрээр ялын хатуу, харгисыг зөөлрүүлэх ёстой."*[12]

Ф.А.Хаекын "***Боолчлогдох зам***" бүтээлдээ:

4 Milovanovic D. *Postmodern Law and Psychoanalytic semiotics*. Chicago. 1994

5 Д.Баярсайхан. *Эрх зүйн онол*. УБ., 2010, х.35 дахь тал

6 Robert L. Hayman. Jr, Nancy Levit, Richard Delgado. *Jurisprudence classical and contemporary: From Natural Law to Postmodernism*. American Casebook Series. West group. St.Paul, MN. 2002. P.67

7 Теодор Адорно (1903-1969), Макс Хоркхаймер (1895-1973), Герберт Маркузе (1898-1979), Эрих Фромм (1900-1980), Вальтер Беньямин (1892-1940), Юрген Хабермас нар үлэмж хувь нэмэр оруулжээ.

8 Хүн төрөлхтөнг хэлэв. /Э.Э/

9 Dworkin R. Is Law a System of Rules? Harvard Law Review p. 45.

10 С.Нарангэрэл. *Монголын ба дэлхийн эрх зүйн тайлбар толь*. УБ., 2001., х.157 дахь тал

11 John Locke. *Two Treatises of Government*. Edited by W.S.Carpenter. London. 1992. P.15

12 Чезаре Беккариа. *Гэмт хэрэг ба ялын тухай*. Орч.Г.Эрдэнэбат. УБ., 2009. Х.122 дахь тал

*Таны сэтгэхүй төлөвлөгдсөн... төлөвлөгчдийн санаандгүй бий болгосон дарангуйллын үед, ямар ч өөр үзэл бодол, санаа сэтгэхүйн өрөө олдохгүй. Зурагт хуудсууд, радио, хэвлэл-бүгд танд нөгөө худал үгээ хэлэх болно. Эцэст нь энэ бүхэн танд үнэн, бодит зүйл болж хувирна.*

Шарль Луй Монтескьеи ***"Хуулийн амин сүнс"***-дээ:

*"...эрчүүд нь санаанд багтамгүй зовлонд биеэ тушаадаг, эмэгтэйчүүд нь төрсөн биеэ шатаадаг. Тийм сул шинж чанарт баймааргүй хүч гаргаж буй хэрэг шүү.* ***Энэ хүмүүсийг бүрэг номой болгогч сул чанарыг байгаль эх биднээ өгчээ."***

Хуулийн амин сүнс гэх бүтээлийн 14-р дэвтэрт хүмүүсийн зан байдал, сэтгэл зүй нь цаг агаартайгаа хэрхэн холбогддог тухай, төр энэхүү хүчин зүйлийг хэрхэн ашигладгийг харьцуулсан судлалын аргаар Шарль Монтескье дэлгэрэнгүй судалгааг харуулсан байна.[13]

А.Ж.Тойнби, ***"Түүхийг ойлгохуй"*** зохиолд:

*"...төр, эрх зүй хэмээх эдгээр байгууламж оршин амьдрах гэж бараг* ***шулмасын аранши*** *гаргадгийг тэдгээрийн төгсгөлийн төрх байдал гэрчлэн харуулдаг... хэрэв бид иргэдийнх нь адил дотроос нь харах юм бол тэдгээр иргэд нэгэнт тогтоосон түгээмэл дэг журмыг мөнх байлгахыг үнэхээр хүсдэг нь мэдэгдэнэ. ...хамгийн гайхмаар зүйл нь хүмүүсийн сэтгэл зүйд маш гүнзгий нөлөөлсөн болохоор..."*[14]

Тэрээр тайлбарлахдаа, дараах хэд хэдэн шалтгааныг дэвшүүлсэн байна.

- *Төрийг төлөөлж, эрхийг хэрэгжүүлж байгаа хүмүүсийн сэтгэл татам гадаад дүр төрхийн увидас. Ийм сэтгэгдэл дээр цааш цаашдаа улам нэмэр хачир нэмэгдсээр домог болж дараа дараачийн үеийнхэнд уламжлагддаг ёсон буй.*

- *Тухайн эрх зүйн нөлөөллийг хэрэгжүүлж байгаа байгууламж асар сүрлэг учир их сэтгэгдэл төрүүлдэгт оршино.*

- *Төрийн цагдан захирах бүх нийтийг хамарсан хатуу журам юм.*

Тэгэхээр, иргэншсэн болоод нүүдлийн соёлтой аль ч нийгэмд хүний сэтгэл зүй нь эрх зүйн цутгамал хөшөө болж хувирдаг гэдгийг А.Ж.Тойнбийн судалгаа харуулж байна.

oooOOooo

Өнөө цагт хүний сэтгэцэд хандах эрх зүйн нөлөөлөл нь балар эртний соёлоос уламжлагдсан табу */хорио цээрийн айдас/* нь сэтгэц-неврозонд гүн шингэснээс эрх зүйн амь бөхийг хадгалах нэгэн шалтгаан нь болдог байна.[15] Яагаад бидний төсөөлөлд эмэгтэй хүн сайн улс төрч, удирдагчийн дүрээр бус, харин гэрийн эзэгтэй, сайн ээж хэмээн буудаг юм бэ? Учир нь табугаас уламжлан авсан сэтгэл зүйн тусгал юм. Эрх зүйг тодорхойлох асуудал бол эрх зүйг ойлгох, түүнд хандах улс үндэстний сэтгэлгээний арга, соёл янз бүр байгаа болон; жирийн иргэн тэр ч бүү хэл эрх зүйтэй өдөр бүр харьцаж байдаг хуульч (*шүүгч, хууль зүйн байгууллагын ажилтан, прокурор, мөрдөн байцаагч, нотариатч, хуулийн зөвлөх, өмгөөлөгч, эрх зүй судлаач*) нарт тодорхой эсвэл хялбар хариулт олоход нэн бэрхтэй.

**"Эрх зүй гэдэг нь яг л хэл, хөгжим лугаа адил үндэстэн, ард түмэн бүрийн уламжлал, соёл, *сэтгэл зүй*, сэтгэцийн түүхийг илэрхийлэх тэрхүү хэм хэмжээ хэмээн ойлгож болно"** хэмээн К.Осакве өөрийн бүтээлдээ тусгасан байдаг. Тэгэхээр, эрх зүй нь хүний сэтгэл зүйтэй гүн холбоотой гэдэг нь төр нь эрх зүйн арга хэрэгслээр хүний сэтгэл зүй тогтолцоонд нөлөөлж номхон хүлцэнгүй болгодог. Тэгэхээр эрх зүй нь сэтгэл зүйгээр тодорхойлогдох хүчин зүйл мөн. Эрх зүй гэдэг нь: төрөөс эрх зүйн тусламжтайгаар хүний сэтгэл зүйг хүлцэнгүй болон неврозонд оруулж залших эрмэлзэл юм гэж дүгнэмээр байна.

13 Шарль Луй Монтескье. *Хуулийн амин сүнс*. Орч. Т.Төмөрхүлэг. УБ., 2009. Х.200-210 дахь тал

14 D. C. Somervell, *a Study of History: Abridgement of Vols I-X in one volume*. Preface by Arnold J. Toynbee (Oxford University Press 1960). P.317

15 Зигмунд Фройд. *Онгон шүтлэг ба хорио цээр*. УБ., 2009. Х.17

# ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХАРИЛЦААН ДАХЬ ЗАРААС ҮҮДЭЛТЭЙ ГЭМ ХОРЫГ АРИЛГАХ ЗАРИМ АСУУДАЛ



**С.БАТБУЯН**

/Шихихутуг ХЗДС-ийн багш, хууль зүйн ухааны магистр/

**Сэдвийг хөндох учир:** Зах зээлийн эдийн засгийн замыг сонгосон Монгол Улсын иргэн, бизнесийн байгууллага, аж ахуй нэгжүүд нийгмийн харилцаанд оролцохдоо хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрэх зар сурталчилгаанд тулгуурлан сонголт хийх шаардлага үүсэж, сонголтыг зар сурталчилгаа чиглүүлдэг нь ойлгомжтой. Үүнтэй холбоотой нийгмийн тодорхой төрлийн харилцаанууд үүсч өөрчлөгдөж, дуусгавар болох явцад эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулах нь эрх зүйн мөн чанар. Өнөөгийн нийгэмд зар сурталчилгаанд итгэл өгч харилцаанд орцох хэв маяг тогтжээ. Харилцаанд оролцоход удирдлага болгодог зар сурталчилгаа хуурамч, итгэл эвдсэн, төөрөгдөлд оруулсан хэлбэрт шилжиж нийгэмд бухимдал үүсгэхийн зэрэгцээ зар сурталчилгаа хүлээн авагчид гэм хор учруулж байгаа нь тодорхой юм. Зараас үүдэлтэй тодорхой болон тодорхой бус этгээдэд учирсан гэм хорыг арилгахад иргэний эрх зүйд анхаарах ямар асуудал байгааг судлах хэрэгцээ шаардлага урган гарч байна.

**Судалгааны ажлийн зорилго, судалгааны арга:** Зараас үүдэлтэй гэм хор учирсан тохиолдолд иргэний хууль болон холбогдох хуулийн заалтуудад тулгуурлан эрхээ сэргээлгэх, гэм хорыг арилгах эрх зүйн орчин бүрдсэн эсэх хэрэв бүрдсэн бол гэм хорыг арилгахад, хууль хэрэглэхэд анхаарах ямар асуудал байгааг судлаж, түгнэлт өгөхийг зорьлоо. Шинжлэх ухааны судалгааны **микро харьцуулалтын, анализ, синтизийн** аргыг ашигласан.

### 1. Иргэний эрх зүйд зар сурталчилгаанаас үүдэлтэй гэм хор учирахад чиглэсэн ямар төрлийн үүргийн зөрчлүүд үүсдэг бэ? Яагаад....

Иргэний эрх зүйн суурь зарчим нь зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулахад[1] оршиж, иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрхийн хамгаалалт нь зөрчигдсөн эрхийг сэргээх зорилгод[2] үндэслэнэ. Өөрөөр хэлбэл иргэний эрх зүйн харилцаанд эрх тэгш байдлаар оролцож байгаа хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага аль нь боловч бусдын учруулсан гэм хор, хохирлоо арилгуулахаар шаардах эрхтэй байна.[3] Иргэний хуулинд мэдээлэл нь иргэний эрх зүйн харилцааны объект[4] байх ыг тусгаж Зар сурталчилгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт *"зар сурталчилгаа" гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагаа /цаашид "бүтээгдэхүүн" гэх/-ны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл*

1 Иргэний хууль УБ., 2002 он, 1,2 дэх заалт
2 Иргэний хууль УБ., 2002 он, 9,1 дэх заалт
3 "Зар сурталчилгаа ба гэм хор" судалгааны тайлан Хууль зүйн үндэсний хүрээлэн. УБ хот., 2009 он. 33 дахь тал.
4 Иргэний хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дахь хэсэг

*болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг*"[5] ойлгох гэжээ. Зар сурталчилгаа нь иргэний эрх зүйн харилцааны объект болох нь тодорхой байна. Харин судлаачийн зүгээс зар сурталчилгаа гэх нэр томъёонд ач холбогдол өгч судлах бус тэдгээрээс үүдэлтэй гэм хорыг арилгахад иргэний эрх зүйд ямар асуудалтай бид тулгарч болохыг төсөөлсөн болно. Зар сурталчилгаатай холбоотой харилцаанд оролцогч захиалагч, бүтээгч, түгээгч, зар сурталчилгааг хүлээн авагч аль аль нь иргэний эрх зүйн харилцааны субьект мөн бөгөөд өөрт учирсан гэм хорыг арилгуулахаар эрх бүхий байгууллагад хандах эрх нээлттэй. .

**Гэрээний үүргийн зөрчил:** Зар сурталчилгааны эрх зүйн харилцаа нь нэг талаас иргэний эрх зүйн, нөгөө талаас захиргааны эрх зүйн харилцаагаар илрэх ба иргэний эрх зүйд үүсэх харилцааг нарийвчлан төрөлжүүлж, төрөл бүрт үүсэх үүргийг тогтоох зорилгыг анхаарч үүнд иргэний эрх зүйн ямар үүрэг үүсч болохыг үзье. Зар сурталчилгааг захиалах, бүтээх, түгээх харилцаанууд үүсч болох юм. Эдгээр харилцааны үүсэх үндэслэл нь иргэний хуулийн 8 дугаар зүйлээр үүсэхээс гадна. Зар сурталчилгааг түгээх харилцаа гэрээ байгуулах бэлтгэл үе шатанд үүсч болно. Иймээс тус харилцаа үүсэх, дуусгавар болох заг ялгаа, харилцаанаас үүсэх үр дагаварыг нарийн тогтоосноор учирсан гэм хорыг бодитой, үндэслэлтэй тогтоох болов уу. Түүнчлэн гэрээ байгуулах бэлтгэл үе шатанд дээрх үүргийн харилцаа үүсч болох нь тогтоогдох ёстой. .

*Иргэний хуулиар "Тодорхой бус этгээдүүдэд хандсан хүсэл зоригийн илэрхийлэлд гэрээ байгуулах санал болохыг шууд заагаагүй бол түүнийг санал гаргах дуудлага гэнэ".*[6] *Нэгэнт зар сурталчилгаа гэдэг нь олон нийтэд чиглэсэн өөрөөр хэлбэл тодорхой бус этгээдүүдэд чиглэсэн мэдээлэл байдаг тул түүнийг гэрээ байгуулах санал гаргах дуудлага гэж үзэх нь зөв. Иймд тухайн зарын захиалагч гэрээ байгуулах саналын дуудлага гаргаж байгаа бөгөөд тухайн зарыг хүлээн авсан этгээд гэрээ байгуулах санал гаргах эсэхээ шийдэх эрхтэй.* ***Загварчилвал:***

Зар захиалагч, зар хүлээн авагчийн хооронд урьдчилсан нөхцлөөр үүсэх харилцааг тогтооход "Аливаа үүргийн харилцаа нь зөвхөн талууд гэрээний нөхцөлийг хэлэлцэн тохиролцож, гэрээ байгуулсан тэр үеэс үүсэх бус, харин гэрээ байгуулахаас өмнө буюу гэрээ байгуулах бэлтгэл үе шатанд үүсч болмоор". Энэхүү гэрээ байгуулагдахаас өмнө үүсэж буй үүрэг нь гэхдээ ямар нэгэн гэрээний үндсэн үүргийн гүйцэтгэлийг шаардахгүй[7]. Учир нь тухайн гэрээ байгуулагдаагүй. Харин гэрээ байгуулах бэлтгэл үе шат нь тухайн этгээдэд гэрээний нөхцөлүүдийн талаар анхны зар сурталчилгаа түгээсэн үеэс үүснэ. Тиймээс Иргэний хуулийн 187.2-т заасан гэрээ байгуулах бэлтгэл үе шат эхэлсэн гэж үздэг[8] учир цаашлаад Иргэний хуулийн 186-д заасан үүрэг үүсэх юм[9].

***Загварчилвал:***

Зар сурталчилгаа захиалагч 195.4-р зүйл Саналын дуудлага

Гэрээ байгуулах бэлтгэл үе шат үүргийн харилцаа ИХ-ийн 187.2-р зүйл

Зар сурталчилгаа хүлээн авагч ИХ-ийн 195.1-р зүйл гэрээ байгуулах санал гаргах эрхтэй

5 Зар сурталчилгааны тухай хууль УБ., 2002 он.3.1.1 дэх хэсэг.

6 Иргэний хууль 2002 УБ., 195 дугаар зүйлийн 195.4 дэх хэсэг
7 Монгол улсын Иргэний хуулийн тайлбар 2006 он., 624 дахь тал.
8 Иргэний хуулийн 187.2-т "Гэрээ байгуулах бэлтгэл үе шатанд энэ хуулийн 186 дугаар зүйлд заасан үүрэг үүсч болно."
9 Иргэний хуулийн 186.1-т Хууль буюу гэрээгээр үүрэг гүйцэтгэгч нь ямар нэгэн үйлдэл хийх, эсхүл тодорхой үйлдэл хийхээс татгалзах үүргийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээх бөгөөд үүрэг гүйцэтгүүлэгч нь түүнээс уг үүргээ гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
186.2-т Үүргийн агуулга, шинж чанарыг харгалзан талуудын аль ч нөгөө талын эрх, эд хөрөнгийн хувьд онцгой үүрэг хүлээлгэж болно.

Нөгөө тал/зар хүлээн авагч/ Иргэний хуулийн 219-р шаардах эрхтэй[10] байна. Мөн Иргэний хуулийн 187.3-ын дагуу нэг талын хайхрамжгүй үйлдлийн[11] улмаас гэрээ байгуулагдаагүй бол хэлэлцээ хийхтэй холбогдон гарсан зардлаа нөгөө тал нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй[12]. Энэхүү үүрэг нь гэрээ байгуулагдахаас өмнөх үе шатанд хэрэглэгддэг тул зар хүлээн авагч тал нөгөө талаас /зар захиалагч/ хайхрамжгүй үйлдлээс бий болох хохирол, гарах зардлаа шаардана. Дээрх байдлаар үүргийн эрх зүйн харилцаа үүсч зар хүлээн авагч талд гэм хор учирч байгааг үгүйсгэх аргагүй.

**Гэрээний бус үүрэг буюу гэм хор учруулснаас үүсэх үүрэг үүсч болох уу?** Гэм хор гэдэг нь тодорхой этгээдийн эрх зөрчигдсөнөөс түүнд бий болсон эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус сөрөг үр дагавар юм. Үүнд эд хөрөнгө устгасан, гэмтээсэн, иргэний эрүүл мэндэд гэмтэл учруулснаас эмчилгээний зардал гарсан, цалин дутуу авсан, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас олох ёстой байсан орлого алдагдсан, зарлага гарсан, биеийн болон сэтгэл санааны шаналал зэрэг ордог[13]. Иргэний хуулийн дагуу гэм хор учруулсан нь иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл[14] болох ба иргэний харилцаанд оролцогчид учруулсан хохирлыг арилгуулах замаар харилцаанд оролцогчийн эрхийг хамгаалдаг[15]

Өөрөөр хэлбэл зар түгээх харилцаанд аль нэг талд гэм хор учирсан бол Иргэний хуулийн 497.1-р гэм хор учруулсан этгээд хариуцан арилгах үүрэг хүлээнэ. Мөн түүнчлэн Иргэний хуулийн 497.3 дахь хэсэгт "Гэм хор учруулахад хэд хэдэн этгээд оролцсон бол тэдгээр нь уг гэм хорыг хамтран хариуцах бөгөөд энэ тохиолдолд шууд гэм хор учруулсан этгээд төдийгүй, түүнийг уруу татсан, дэмжин тусалсан, түүнчлэн гэм хор учруулсны үр дүнг санаатай ашигласан этгээд нэгэн адил хариуцлага хүлээнэ" гэж заасан[16]. Үүнээс харахад энэ заалтын гэм хор учруулахад оролцсон хэд хэдэн этгээд гэж зар захиалагч, түгээгчийг нарыг ойлгож, тэдгээрийг нэгэн адил хариуцлага хүлээлгэх боломжтой. Гэвч бодит байдал дээр зөвхөн захиалагч хариуцлага хүлээдэг практик тогтсоныг харуулах зорилгоор Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн "Зар сурталчилгаа ба гэм хор" судалгааны тайлан дахь шүүхийн шийдвэрт хийсэн судалгааг иш татан гэм хороос үүдэлтэй зар сурчилгааны харилцаанд үүссэн маргаан шийдсэн шүүхийн шийдвэрт үнэлэлт өгвөл. хавсралт-1 үз/ Энэ хэргийн хувьд Зар сурталчилгааны тухай хуульд заасан олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэгч ТББ хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалан буруутай этгээдийг шүүхэд хариуцагчаар дуудсан нь дэвшилттэй байгаа хэдий ч иргэний эрх зүй талаасаа зар сурталчилгааны гэм хорыг тогтооход анхаарвал зохих хэдэн асуудал байна. Үүнд:

10 Иргэний хуулийн 219.1-т Үүрэг гүйцэтгэгч хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч учирсан хохирлоо арилгуулахаар шаардах эрхтэй.

11 Монгол улсын Иргэний хуулийн тайлбар 2006 он., 626 дахь "Хайхрамжгүй үйлдэл гэдэг талууд гэрээ байгуулах чин хүсэлтэй байсан боловч түүнийгээ хэрэгжүүлэхэд нь ямар нэгэн саад , алдаа гарснаас гэрээ хүчин төгөлдөр байгуулах боломжгүй болохыг хэлнэ."

12 Иргэний хууль 2002 он. УБ., 187.3-р зүйл.

13 Т.Мөнхжаргал, Иргэний эрх зүй /тусгай анги/, УБ., 1997., 48 дахь тал

14 Иргэний хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь хэсэг

15 Иргэний хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.4 дэх хэсэг

16 Иргэний хууль 2002 он. УБ., 497.3-р зүйл.

Нэхэмжлэгчийн хувьд:

Зар сурталчилгааны тухай хуульд олон нийтийн хяналтыг хувь хүн, байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага хэрэгжүүлж болохоор заасан байдаг. Ийнхүү заахдаа төрийн бус байгууллагад хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үүднээс шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй гэсэн боловч энэ эрхийг хувь хүн, байгууллага, аж ахуйн нэгжийн хувьд дурдаагүй. Гэсэн хэдий ч үндэслэлтэй гэж үзвэл хувь хүн, байгууллага, аж ахуйн нэгж шүүхэд нэхэмжлэл гаргаж болох эрх нь иргэний хуулийн дагуу нээлттэй байгаа юм.

Хариуцагчийн хувьд:

**Хавсралт-1** дэх хэрэгт нэхэмжлэгч зар сурталчилгаа түгээгчдийг хариуцагчаар татсан байдаг. Зар сурталчилгааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт "Хууль бус зар сурталчилгаа захиалах, бүтээх, түгээхийг хориглоно"[17] гэж заасан учраас гурван субъект гурвуулаа Иргэний хуулийн 497.3-т зааснаар буруутайд тооцогдох боломжтой буюу гурвууланг нь хариуцагч байхаар нэхэмжлэл гаргах боломжтой.

Нэхэмжлэлийн шаардлагын хувьд:

Зар сурталчилгааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт "Шүүх энэ хуулийн агуулга, зарчимд нийцүүлэн энэ хуулийн 7 дугаар зүйлд заасанаас бусад үндэслэлээр зар сурталчилгааг хууль бус гэж тооцож болно" мөн хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Хэрэглэгчийн эрх ашиг, түүнчлэн зар сурталчилгаа бүтээх, түгээх үйл ажиллагаанд оролцогчийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий төрийн бус байгууллага зар сурталчилгаанд хяналт тавих чиглэлээр дараахь эрх эдэлнэ:

-хэрэглэгчийн нэрийн өмнөөс зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчсөн тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргах"[18] гэж заажээ.

Хэргийн хувьд нэхэмжлэлийн шаардлага гаргахдаа нийтлэгээр

а/ явуулж байгаа ил болон далд зар сурталчилгааг таслан зогсоох,

б/ албан тушаалтанд хуульд заасан хариуцлага ногдуулах гэсэн 2 шаардлагыг тавьсан байна.

Энэ тохиолдолд тухайн зар сурталчилгааны улмаас учирсан шууд гэм хорыг тооцон гаргах, шалтгаант холбоог тогтоох нь хүндрэлтэй учраас мөнгөн хэлбэрээр гэм хорыг арилгах талаар нэхэмжлэх нь хүндрэлтэй байж болох юм. Гэхдээ нэхэмжлэлийн шаардлагыг хязгаарласан заалт Иргэний хууль, Зар сурталчилгааны тухай хууль болон бусад хуульд байхгүй учраас тухайн төрийн бус байгууллага тэрхүү зар сурталчилгааны эсрэг (жишээ нь архины хэрэглээг багасгах, хор уршгийг тайлбарласан)[19] зар сурталчилгаа явуулахад гарах зардлыг нэхэмжилж болох юм.

Зар сурталчилгаанаас үүдэлтэй гэм хор манайд ямар хэлбэрээр оршиж байгааг харвал гэм хорын шинж, онцлогийг тогтооход хялбар, хялбар биш эсэх болон гэм хор учирсан субъектээр нь доорх байдлаар ангилж үзсэн болохыг судалгааны тайлангаас харж болно[20]. Үүнд:

1. Тогтооход хялбар буюу хувь этгээдэд учирсан гэм хор

2. Тогтооход хялбар биш, нийгэмд учирч буй гэм хор

1. Тогтооход хялбар буюу хувь этгээдэд учирсан гэм хор гэдэгт дараах хэлбэрээр илрэнэ. Үүнд: Эрүүл мэндээрээ хохирох (тураах тос, гоо сайхны бүтээгдэхүүн гэх мэтээс хүмүүс хордох, харшлах), Эд хөрөнгө нь устсан, гэмтсэн (Хөргөгч дууддлагаар засна гэсэн зарын дагуу хөргөгчөө засуулсан боловч бүр эвдэлсэн), Бизнесийн нэр хүндээ алдах,

2. Тогтооход хялбар биш, нийгэмд учирч буй гэм хор гэдэгт доорх гэм хорыг хамруулж үзэх боломжтой. Үүнд: Буруу, ташаа мэдээлэл цацах замаар төөрөгдөл бий болгох (Хадгаламж зээлийн хоршоо), Нийгэмд муу зуршил бий болгох (архи, тамхи, садар самууны зар сурталчилгаа) Ийнхүү гэм хорыг субъект, хамрах

[17] Зар сурталчилгааны тухай хууль УБ., 2002 он. 7.7-р зүйл.
[18] Зар сурталчилгааны тухай хууль УБ., 2002 он. 25.2-р зүйл
[19] Хууль зүйн үндэсний хүрээлэн "Зар сурталчилгаа ба гэм хор" судалгааны тайлан. УБ хот., 2009 он. 40 дахь тал.
[20] Хууль зүйн үндэсний хүрээлэн "Зар сурталчилгаа ба гэм хор" судалгааны тайлан. УБ хот., 2009 он. 44 дахь тал.

хүрээ, онцлог шинжээр нь ангилж авч үзэх нь гэм хорыг зөв үнэлэх, түүн дээрээ үндэслэн нэхэмжлэлийн шаардлагаа үндэслэлтэй гаргах, зар сурталчилгаа хүлээн авагчийн зөрчигдсөн эрхийг бодитой сэргээхэд чиглэгдэх учиртай болохыг судлаачийн зүгээс дэмжиж байгаагаа илэрхийлмээр байна.

## ДҮГНЭЛТ

1. Иргэний эрх зүйн харилцаанд зар сурталчилгаа түгээх харилцаа иргэний эрх зүйн гэрээний болон гэрээний бус үүрэгтэй холбоотой нилээд онцлог оршиж байна. Энэ харилцаанд зар сурталчилгаа захиалагч, хүлээн авагч гэсэн субъектууд оролцож, захиалагчийн зүгээс зар сурталчилгаа түгээснээр харилцаа үүсч, нөгөө тал гэрээ байгуулах санал гаргаснаар /ямар нэг үйлдэл хийснээр/ дуусгавар болдог харилцаа. Энэ хугацаанд захиалагч тал саналын дуудлага буюу зар сурталчилгаа гаргасан /түгээсэн/ байх, зар сурталчилгаа хүлээн авагч саналын дагуу гэрээ байгуулуулах хүсэл зоригоо илэрхийлэх үедээ захиалагч, түгээгчээс санал дурьдсан үүргээ гүйцэтгэхийг зар хүлээн авагч ИХ-ийн 186.1, 219.1-р шаардах эрх үүснэ. Харин хэлэлцээрийн явцад аль нэг талын хайхрамжгүй үйлдлээс гэрээ байгуулагдаагүй бол хэлэлцээ хийхтэй холбогдсон зардлыг хайхрамжгүй хандсан тал нөхөн төлөх үүрэг үүснэ. Тэгэхээр зар сурталчилгааны үнэн бодит байдлыг захиалагч хариуцна гэсэн хуулиар тогтоогоогүй гажиг зарчим үйлчилдэг. Гэтэл дээрх заалтын дагуу үүрэг үүсч байгаа учир учирсан гэм хорыг гэрээний үүргийн дагуу хайхрамжгүй хандсан тал хариуцна.

2. Гэрээний бус үүрэгтэй холбоотой гэм хор учирсан бол иргэний хуулийн 497.1-т заасан үүрэг захиалагч талд үүсдэг практик байна. Уг зүйл нь иргэний хуулийн 497.3-т заснаар захиалагч, түгээгч, бүтээгч нар нэгэн зэрэг хариуцлагад татагдах учиртай боловч дээр дурьдсан хууль зүйн бус зарчмаар маргааны шийдэгдэж, зөрчил гаргаж, гэм хор учруулсан бусад субъектууд хариуцлагаас чөлөөлөгдөж байгаа нь нэг талаас шүүхийн зүгээс 497.3-ийг үнэлэж, оновчтой хэрэглэдэггүй, нөгөө талаас зар сурталчилгаа хүлээн авагч гэм хороо арилгуулах нэхэмжлэлдээ туулийн утгаар захиалагчийг л хариуцлагад татдаг явцуу сэтгэлгээтэй холоотой гэж дүгнэж байна. Иймд зар сурталчилгаа хүлээн авагч гэм хор учирсан маргаанд нэхэмжлэл гаргахдаа дан ганц захиалагчийг биш тэрхүү зар сурталчилгааг үнэн бодит бус бүтээсэн, түгээсэн этгээдийг /хэвлэл мэдээллийн байгууллагууд/ хамтран хариуцагчаар татснаар зөрчигдсөн эрхээ сэргээх оновчтой алхам болох юм.

# ШИНЭ НОМ




**Хууль зүйн шинжлэх ухааны доктор /ScD/, профессор О.Амархүү Монголын орчин цагийн экологийн эрх зүй**

Зохиогчийн энэхүү номын анхны хэвлэл 2004 онд хэвлэгдэн нийтийн хүртээл болсон билээ. Өдгөө 5 жилийн дараа уншигч түмний хэрэгцээ шаардлагаар нэмж засварласан хоёрдахь удаагийн хэвлэлээ толилуулж байна. Энэхүү ном урьдахийгаа улам баяжуулж, сурах бичгээс өргөн хүрээнд, онол, танин мэдэхүй, практик амьдралын үр өгөөжийг түлхүү бодолцож, баялаг агуулгатай болсноороо давуу талтай болжээ.

Байгаль орчны салбарын эрх зүйн орчныг дэлхийн болон бүс нутгийн жишиг, үндэсний онцлог, экологийн төлөв байдлын өнөө, ирээдүйн шаардлагыг харгалзан төгөлдөржүүлэх нь уг номноос харагдана.

Зохиогчийн олон жилийн нор их хөдөлмөрийн үр дүнд бий болсон энэ бүтээл бүх нийтийн экологийн боловсролд, оюутан, сурагчдад, судалгаа, шинжилгээний ажилд хүчээ сорингчдод, байгаль орчныг хамгаалах алармаатай ажил үйлст хүчин зүтгэж буй хүмүүн болгонд хүртээл болж, тэр бүхний оюун ухаан, сэтгэлгээний хөгжилд тус нэмэр үзүүлэх оюуны хөрөнгө оруулалт болсон гэдэгт бүрэн итгэл төгс байна.




Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ч.Энхбаатар багшийн энэхүү бүтээл нь Герман улсын үндсэн хуульт ёсны түүхэн хөгжил, хүний эрх зүйн байдал, парламент, ерөнхийлөгч, засгийн газрын эрх, үүрэг, үйл ажиллагаа, улс төрийн намуудын эрх зүйн байдал, шүүхийн тогтолцоо, үндсэн хуулийн хяналт, орон нутгийн удирдлага зэрэг сэдвүүдийг судалж, энгийн үг хэллэгээр, ойлгомжтой илэрхийлсэн нь их, дээд сургуулийн оюутнууд, судлаачид, эрдэмтэн багш нар болон нийт уншигчдын эрдэм шинжилгээ, судалгааны ажилд багагүй хувь нэмэр оруулна гэдэгт итгэл төгс байна.

**Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ч.Энхбаатар Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Төрийн эрх зүй**




Зохиогчийн энэхүү бүтээл нь Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн тусгай ангийн хүрээнд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ойлголт, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах журам, ерөнхий нөхцөл байдал, эрүүгийн байцаан шийтгэх тодорхой ажиллагаа, яз сонсгох, яллагдагчийг байцаах, прокурорын хяналт зэрэг сэдвүүдийг хамарсан, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн онолын томоохон бүтээл юм. Энэхүү бүтээл нь таны эрдэм шинжилгээ, судалгааны ажил болон практикт багагүй тусламж үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

**Б.Бат-эрдэнэ**
**Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй**

Зохиогч нь Эрүүгийн эрх зүйн гэмт хэргийн үндсэн институцийн онолын асуудлуудыг тусгайлан судалж, улмаар сурах бичиг, гарын авлагын агуулгаас өргөн хүрээнд иж бүрэн авч үзэх шаардлага хурцаар тавигдаж байгаа бодит байдлыг иш үндэс болгон уг бүтээлээ туурвижээ. Энэ нь эрүүгийн эрх зүйн эх сурвалж, түүний түүхэн уламжлал, шинэчлэл, гэмт хэргийн сургаал, гадаадын зарим орнуудын эрүүгийн эрх зүйн онцлог, эрүүгийн эрх зүйн онолын сэтгэлгээ , үзэл баримтлалыг багтаасан зохиогчийн нөр их хөдөлмөрийн үр дүн болжээ. Зохиогч эрүүгийн эрх зүйн онолын цуврал бүтээлүүдийнхээ эхний ботийг уншигч та бүхэнд өргөн барьсан байна.

Энэхүү бүтээл нь эрүүгийн эрх зүй дэх гэмт хэрэгтэй холбоотой асуудлуудыг авч үзэхдээ практик арга ажиллагаа болон өөрийн орны хийгээд гадаадын эх сурвалжуудыг өргөнөөр ашиглаж, эрүүгийн эрх зүйн онолд нэг мөр шийдвэрлэгдээгүй болон маргаантай асуудлуудад шүүмжлэлтэй хандан өөрийн санал дүгнэлт өгснөөрөө шинжлэх ухаан, судалгааны ихээхэн ач холбогдолтой болсныг уншигчид тунгаан соёрхох буй за.




**С.Жанцан Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол**




Зохиогч нь 1996 онд эрх зүйн онолын анхны сурах бичгийг бичиж хэвлүүлсэн бөгөөд дараа нь 2000 онд шинэчлэн хэвлүүлсэн ажээ. Энэ удаад хэвлэн гаргаж буй эрх зүйн онолын сурах бичиг нь хууль зүйн шинжлэх ухааны сүүлийн үеийн ололт, үр дүнг бүтээлчээр тусгаж, англи хэл дээр хэвлэгдсэн эрх зүйн онолын эх сурвалж, ном, сурах бичиг, онол, арга зүйн сэргүүлгүүдийг өргөнөөр бичсэн ном юм. Энэхүү номд философийн категори, ухагдахууныг зохих хэмжээнд тусгалаа олсны дараа харьцуулсан эрх зүй судлалын онолын тулгамдсан асуудлууд ч хөндөгдсөн төдийгүй схем, үзүүлбэр, зүүлт, тайлбар, тест зэргийг оруулж өгсөн нь сайшаалтай болжээ. Энэхүү ном нь уншигч та бүхний ширээний ном болно гэдэгт итгэлтэй байна.

**Д.Баярсайхан Эрх зүйн онол**

Зохиогчид энэхүү бүтээлдээ гэмт явдал түүний шалтгаан нөхцлийн талаар янз бүрийн онол, үзэл баримтлал боловсруулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх оновчтой арга замыг эрэлхийлэн, криминологийн онолын уламжлалт үзэл баримталыг түүхэн шинэ нөхцөл байдалд тайлбарлах оролдлого хийсэн байна. Түүнчлэн гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ажлыг хэрхэн сайжруулах талаар зохиогчид гадаад, дотоодын туршлагад тулгуурлан санал дэвшүүлсэн нь сонирхол татууштай. Уг бүтээл нь хууль зүйн их, дээд сургуулийн багш, оюутнууд эрдэмтэн, судлаачид, практикийн ажилтнуудын ажил үйлст хувь нэмэр болно гэдэгт итгэлтэй байна.




**Ж.Болдбаатар, О.Нямдаваа Криминологи**

ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭД СУРГУУЛЬ

# ШИХИХУТУГ

ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ОНОЛ, АРГА ЗҮЙ, МЭДЭЭЛЭЛ 2008

# ЭНЭ ДУГААРТ

## Сэтгүүлийн зөвлөл

Д. Лүндээжанцан /эрхлэгч/
О. Амархүү /ерөнхий редактор/

Гишүүд: Ж. Болдбаатар
Ч. Энхбаатар
Н.Лүндэндорж
Б. Мандахбилэг
Б. Ганпүрэв
/нарийн бичгийн дарга/

## ОНОЛ АРГА ЗҮЙ, УЛАМЖЛАЛ, СОЁЛ ИРГЭНШИЛ

**Б. Чимид**
Харьцуулах эс харьцуулах эрх зүй
**Ч.Энхбаатар**
Харьцуулсан эрх зүй судлалын өнгөрсөн, одоо, ирээдүй
**Д.Оюунцэцэг**
Эрх зүйн бүл ба эрх зүйн эх сурвалж
**Н.Лүндэндорж**
Үндэсний эрх зүйн хөгжилд харьцуулсан эрх зүйн үүрэг

## ШИХИХУТУГ СУРГУУЛИЙН МЭДЭЭЛЭЛ

- ШИХИХУТУГ ХЗДС-ИЙН ТӨГСӨГЧИД, БАГШ, ОЮУТНЫ "ЧАНДМАНЬ ХОЛБОО" АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТ ЁСЛОЛ ТӨГӨЛДӨР БОЛЖ ӨНГӨРЛӨӨ.
- ШИХИХУТУГ ХЗДС-ИЙН ТӨГСӨГЧИД, БАГШ, ОЮУТНЫ "ЧАНДМАНЬ ХОЛБОО" АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТАНД ОРОЛЦОГЧИД САНАМЖ БИЧИГ ГАРГАЛАА.

РЕДАКЦИЙН ХАЯГ:
Сүхбаатар дүүрэг 6 дугаар хороо,
Их сургуулийн гудамж-1,
Шихихутуг ХЗДС-ийн хичээлийн I байр.
Web site: www.shihihutug .edu.mn
E-mail:shikhi_setguul@yahoo.com
Утас: 96687080, 91181909, 314977

## ШИНЭ НОМ

Б.Чимид
- Сонгуульд суралцахуй
- Үндсэн хуулийн мэдлэг

О. Амархүү
- Эрх зүйн онолын арван таван сэдэв

Н.Лүндэндорж
- Төрийн онол

# ХАРЬЦУУЛАХ ЭС ХАРЬЦУУЛАХ ЭРХ ЗҮЙ

**Б.Чимид**
*(Хууль зүйн үндэсний төвийн эрдэмтэн нарийн бичгийн дарга
Хууль зүйн ухааны доктор, профессор)*

## 1. Харьцуулсан эрх зүй хэрхэн хөгжиж байна вэ?

### *1.1. Өнгөрсөн үеийг нэхэн санаваас*



Энэ бол жаахан этгээд мэт боловч манай өнөөгийн хэрэгцээнээс үүссэн сэдэв юм. Өнөөг мэдье гэвэл "эхээс нь" бүүр үүслээс нь авч үзвэл арай л углуургатай.

Харьцуулсан эрх зүй судалгааны арга болохын хувьд аль эртний угшилтай. Бүүр МЭӨ аугаа их Аристотель Грек, Афины олон хот улс, аймгийн 150-иад Үндсэн хуулийг судалсандаа үндэслэн улс төрийн шинжилгээний зохиолоо бичсэн бол алдарт шинэтгэгч Салон хуулиудаа их Грекийн хотуудын хууль зарлигуудыг судалсны үндсэн дээр гаргасан; Дундад зуунд Англи, хожим Франц, Германд Ромын эрх зүйг судалсны үндсэн дээр зааншлын болон хувийн (тусгай) эрх зүйг бүрдүүлэхийг чармайсан; наашлуулбал энэ уламжлалыг эх газрын хэмжээнд өгүүлдэг билээ. Бүхэлд нь үзвэл эрх зүйн шинжлэх ухаан бий болсон цагаас харьцуулан судлах арга зэрэгцэн хөгжсөн гэж үздэг. Бас хууль зүйн шинжлэх ухаан бол дэлхийн ууган шинжлэх ухааны нэг гэж хүлээн зөвшөөрдгийг иш үндэс болговол харьцуулсан эрх зүй нэн эртний улбаатайдаг.

### *1.2. Монголынхоо тухайд эцэг өвгөдийн үйл хэргийг үгүйсгэж болохгүй*

Дэлхийн улсуудын нэгэн адил Монголд ч ийм нөлөө хэзээ хэр туссаныг бид лавтай нотлоогүй ч харьцуулсан эрх зүй (арга) дөнгөж л одоо үүсч байгаа биш юм. Бидний мэдэх ойрмогхоноос таслан үзвэл XX зууны эхнээс Монголд харьцуулан судлах арга, хууль зүйн амьдралын янз бүрийн хүрээ, түвшинд хэрэглэгдэж ирсэн түүхэн баримт элбэг бий.

Тоймолвол:

Бүр Богд хаант засгийн үед (1911-1921) Цэвээн, Жамсранов нарын судлаачид дэлхийн олон орны төрийн эрх зүйн харьцуулсан судалгаа хийж байсан; 1920-иод оны эхээр Монголын анхны Үндсэн хуулийн төсөл боловсруулагч үндэсний ардчилсан үзэлтнүүд барууны нэлээд орны Үндсэн хуулийг харьцуулан судалсан зэрэг дорвитой баримт буй:

- Монгол орон социалист чиг баримжаанд шилжсэний дараахнаас Зөвлөлт эрх зүйг үлгэр жишээ болгох үндсэн дээр шинжлэх судлал, практик ажлыг зохион явуулж ирсэн;
- "Социалист байгууллын үе" гэх 1960-аад оноос 80-аад оны эцэс хүртэл ЭЗХТЗ (СЭВ)-ийн гишүүн орнуудын хамтын ажиллагааны цогцолбор хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хууль тогтоомжийг уялдуулан жигдлэх арга хэмжээг засаг төрийн бодлогын түвшинд зохион явуулсан;
- Монгол Улс 1990-ээд оноос ардчилал, зах зээлийн харилцаанд шилжиж эхэлснээр хөгжингүй орнуудын хууль тогтоомж, практикийг жишиг болгох гэсэн албан ёсны хандлага баримталж ирсэн зэрэг нь шинжлэх ухааны өндөр түвшинд биш ч гэсэн эрх зүй, хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа үргэлжилж ирснийг харуулна.

Харин цаг цагийн эргэлтэд "хэт хувьсгалчирхах", зөвлөлт маягаар "интеграцчилах", өдгөө "даяаршиx" гэхчлэн өрөөсгөлдөж хошуурснаас өөрийн орны хөгжлийн түүхэн үеүд дэх дотоодын хууль тогтоомжийг харьцуулан судалж "хөрсөн дээрээ бууж хөгжихөд" бага анхаарч ирснийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Зиндээс «хууль тогтоомжийг харьцуулах» гэдэг тухайд юу хэлж болох вэ? Хэдийгээр «өөрийн систем дотроо харьцуулалт хийх нь харьцуулсан эрх зүй судлалын зорилго биш»[1] гэлээ ч нийгмийн өөр өөр байгуулал дамжсан Монгол шиг орны хувьд тэр түүхэн үе бүрийнхээ эрх зүй, түүний эх сурвалж (хуулиуд)-ийг харьцуулан судлах нь чухлыг үгүйсгэж болохгүй. Учир нь өнгөрсөн алдаанаас сургамж авахын сацуу үнэт зүйлсийг нь өвлөн залгамжлах, ингэхээр "хөрсөн дээрээ" урган хөгжихөд зайлшгүй хэрэгтэй нь маргаангүй.

Гэтэл өдгөөг хүртэл өөрийн орны эрх зүйг харьцуулсан онол-эрдэм шинжилгээний судалгааг төдийлөн анхаарахгүй, харин бусад орны хууль тогтоомжийг шууд хуулбарлах арга, хандлага зонхилж байгаа нь харьцуулсан эрх зүй судлал жинхэнэ утгаараа хөгжихөд муугаар нөлөөлж байна.

Дээр дурдсан өөрийгөө үгүйсгэх, бусдыг хуулбарлах хоёр хандлагаас үүдэн бид харьцуулсан эрх зүй гэж чухам юуг ойлгож, түүнд онол, арга зүйн ямар үндэс зарчим баримтлах вэ? гэдгийг бодитой, шүүмжлэлтэйгээр эргэн харах цаг болсон. Энэ цагийн "хонхыг дахин дахин дэлдэхэд" "Шихихутуг" хууль зүйн дээд сургуулийн санаачлагаар хийсэн

[1] Б.Амарсанаа. "Харьцуулсан эрх зүй судлал". УБ., 2005. 8 дахь тал

**"Харьцуулсан эрх зүйн онол-практикийн өрчин үеийн асуудал"** сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал бас нэг шинэ түлхэц өгнө гэж найдаж байна. "Шинэ түлхэц" гэдэг тухайд ойрмогхон үеийн өөрчлөлт шинэтгэлийн явцтай холбон үзэх гэсэн санаа болно.

### *1.3. Өнөө үеийн өнгө төрх*

Хоёр зууны заагаас Монгол Улсад болж буй эрх зүйн шинэтгэлийн хүрээнд харьцуулсан эрх зүй шинжлэх ухааны утгаараа шинэ түвшинд хүрч хөгжих суурь тавигдаж эхэлсэн гэж болно. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль, Хууль зүйн үндэсний төв, бие даасан судлаачид дангаар болон дотоод гадаадын ТББ-уудтай хамтран шинжлэх ухааны өгүүлэн буй чиглэлээр онол, арга зүйн болон зохион байгуулалтын дорвитой ажил санаачлах болов.

Манай судлаачид эрх зүйн ерөнхий онол, тодорхой салбарын чиглэлээр харьцуулсан судалгаа хийж эрдэм шинжилгээний ном зохиол нийтлүүлж, олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, судлаач, сонирхогчдын хүчийг нэгтгэх зарим алхам хийж ирснийг дашрамд тэмдэглэж байна. 2003 онд бидний санаачлагаар **"Монголын харьцуулсан эрх зүйн нийгэмлэг"**, 2004 оны 1 дүгээр сард академич Ж.Амарсанаагийн санаачлагаар МУИС-ийн Хууль зүйн сургуульд **"Харьцуулсан эрх зүй, ОУ-ын эрх зүй судалгааны төв"** байгуулагдсан. Мөн Х.Тэмүүжин нарын залуу судлаачдын хамтлаг энэ чиглэлээр зохих нэгдэл бий болгов. Ханнс-Зайделийн сангийн Эрх зүйн боловсрол академи, мөн Улс төрийн боловсрол академи зэрэг харьцуулсан эрх зүйн судлалаар голчлон сургалт, судалгаа явуулдаг төвүүд бий болов. Монгол хууль зүйн эрдэм шинжилгээний шинэхэн голомт, **Хууль зүйн үндэсний төв** энэ талаар мэдэгдэхүйц үр дүнтэй ажил хийж байгаа гээд тоймолбол ахиц нэлээд буй.

Академич Ж.Амарсанаа "Хүний эрх, Үндэсний болон ОУ-ын харьцуулсан эрх зүй" (УБ., 1990), академич С.Нарангэрэл "Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо" (УБ., 2001), докторант Н.Отгончимэг "Монголын харьцуулсан эрх зүй судлал" (УБ., 2001), докторант Б.Амарсанаа "Харьцуулсан эрх зүй судлал" (УБ., 2005), Б.Гүнбилэг, А.Төмөр "Харьцуулсан эрх зүй" (УБ., 2005), ХЗҮТ, Дэлхийн банкны ШЭМШ төсөл хамтран "Монгол Улсын эрх зүйн хөгжил ба харьцуулсан эрх зүй судлал" гэх мэт нэг сэдэвт зохиол, харьцуулсан нэр томъёоны толиуд, түүнчлэн дотоод, гадаадын олон судлаачдын хамтын цөөнгүй бүтээл нийтлэгдсэн нь энэ чиглэлээр хөгжил урагшилж байгаагийн баримт мөн. Сүүлийн 2 жил гэхэд Хууль зүйн үндэсний төвөөс ХЗС, бусад байгууллагатай хамтран:

- «Хоёр Солонгос, Монгол улсын иргэний болон газрын эрх зүйн чиг хандлага» (2006 он);
- «Монгол ба өмнөд, хойд Солонгос улс дахь эрүүгийн болон газар, олон улсын эрх зүйн өөрчлөлт» (2007 он);
- Нагоягийн Их сургуультай хамтран «Үндсэн хуулийн шүүхийн асуудал» зэрэг дотоод, гадаадын олон улсын хурал, семинар зохион байгуулав. Доктор, профессор Т.Доохүү, Ч.Энхбаатар нарын харьцуулсан судалгааны бүтээл "Гадаад орнуудын Үндсэн хуулийн эрх зүй" суралцах (2006) нийтлэгдсэн байна.

Энэ салбарт нэлээд дорвитой үр дүн үлдээсэн хамтын ажиллагааны нэг хэсэг нь Германы Ханнс Зайделийн сангийн хөтөлбөрийн захирал доктор Ц.Сарантуяагийн санаачлагаар тус сангийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж ирсэн Монгол-Германы эрдэмтдийн нийтийн эрх зүйн хүрээн дэх харьцуулсан эрх зүйн төсөл-судалгаа мөн. Тус төслийн явцад олон улсын чанартай хэд хэдэн уулзалт, хурал зохион байгуулж, зохих хууль боловсруулж, харьцуулсан **судалгааны цувралууд** гаргасны дотор **"Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл Дэлхийн улсуудын жишиг"** (2004 он) хамтын бүтээл нийтлүүлсэн.

Мөн профессор Н.Лүндэндорж нар эрхлэн нийтлүүлсэн АНУ-ын судлаач Кристофер Осакевегийн "Харьцуулсан эрх зүй судлал: Ерөнхий ба тусгай анги" (2005 он) зэрэг гадаад эрдэмтдийн номыг орчуулан гаргасан. **Энэ бүхэн "Монголд харьцуулсан эрх зүйн шинжлэх ухаан", бас судалгааны арга хүрээгээ тэлсээр буйг нотлох буй зүй.**

Ийнхүү хүрсэн түвшинг ахиулан хөгжүүлэхэд хуульч судлаачид энэ талаар онол-арга зүйн нэгдсэн ойлголтод хүрсэн, гар нийлсэн байх нь чухал юм

## 2. "Харьцуулсан эрх зүй" гэдэг чухам юу, түүний зорилго юунд оршин вэ?

### *1. 2.1. Энэ хавийн өргөн, явцуу хоёр утга*

Уг асуудал эртний уламжлалтай ойлголт боловч Монголын эрх зүйн өнөөгийн онол-практикт эргэлзээтэй үзэл болон илэрсээр байна.

Монголын болон гадаадын судлаачдын бүтээлүүд, мөн хууль тогтоох, хэрэглэх практикаас үзэхэд **"харьцуулсан эрх зүй"** гэдэг ухагдахууныг наанадаж **хоёр утгаар хэрэглэх нь зөв** болов уу.

***Нэгд,*** Эрх зүйн шинжлэх ухааны тогтолцоон дахь түүний **бие даасан нэгэн салбар,** өөрөөр хэлбэл эрх зүйн мэдлэг, соёлын нэг чухал хүрээ мөн.

Энэ ангиллыг тодруулбал «харьцуулсан эрх зүй» ("Сравнительное право-Comprative law) гэдэг нь чухам ямар утга агуулга, багтаамж, үүрэг, ач холбогдол бүхий ойлголт вэ?

Түүнийг бид юунд, ямар зорилгоор "ашиглаж" байна вэ? гэдгийг эрдэм шинжилгээний танин мэдэхүйн үүднээс нягтлан үзэж, чиг баримжаагаа цэгцтэй тодорхойлж авах нь зайлшгүй чухал. Өдгөө ном зохиолд «харьцуулсан эрх зүй», «харьцуулсан эрх зүйн судлал», «эрх зүйн харьцуулан судлах арга» гэх янз бүрийн томъёолол (нэр) гарган бичдэг. Эдгээр нь яг адил утга, багтаамжтай биш нь ойлгомжтой боловч аль нь ерөнхий (их буюу үндсэн), аль нь түүнээс үүсмэл (тусгай), эсвэл хоорондоо хамааралгүй ойлголтууд юм уу гэдэгт зөв хариу олж байж цааш «хөдлөх» ёстой болов уу.

## 2.2. Асуудлыг бүүр язгуураас ургуулан үзвэл

Бидний хүрсэн дүгнэлт гэвэл: «Харьцуулсан эрх зүй» гэдэг нь хамгийн ерөнхий (их) ухагдахуун юм. Түүнд «харьцуулсан эрх зүй судлал», «эрх зүйн харьцуулан судлах арга», бас «хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа» гэх ойлголтууд багтана. Өөрөөр хэлбэл «харьцуулсан эрх зүй» гэдгээс бусад нь үүсмэл гэж болно. Гэтэл цаана нь **"эрх зүй"** гэдэг суурь буюу язгуур ойлголт бий. Энэ нь биднээс үл хамааран орших эрх зүйн хэм хэмжээнүүдийн нийлбэр цогц, түүнийг тусгаж буй ухамсар, хэрэглэж буй арга тэргүүтний тогтолцоо гэх бодит үзэгдлийг илэрхийлдэг. Энэ утгаар «зохицуулах зүйл», «зохицуулалт» энэ тэр гэж ярьцгаадаг. Харин энэ бүхнийг шинжлэн судалж, нэгтгэн дүгнэж, хөгжлийн чиг хандлага, арга замыг нь тодорхойлдог тэр утгаар "эрх зүйн шинжлэх ухаан", энэ "шинжлэх ухааны салбар" гэлцдэг. Үүний учир «судлах зүйл», «судлах арга» гэхчлэн өгүүлдэг. Эдгээр нь тогтсон ойлголт гэж болно.

Энэ язгуур (суурь) ойлголтыг тулгуур, «загвар» болговол «харьцуулсан эрх зүй» гэдгийг аль утгаар нь хэрэглээд байгаа юм бэ? «Харьцуулсан эрх зүй» гэж объектив эрх зүй шиг нийгмийн харилцааг зохицуулдаг хэсэг хэм хэмжээ хаа ч байхгүй. Иймд түүнийг "салбар эрх зүй" гэсэн утгаар хэрэглэх нь үнэнд нийцэхгүй. Харин эрх зүй, эрх зүйн түүх, гүн ухаан зэрэг нийтлэг хийгээд эрх зүйн бүл, тогтолцоо, салбар, төрөл зүйг дэлхийн хоёр буюу бүлэг улсын (бүс нутгийн г.м), үндэсний, олон улсын түвшинд тухайлан судалдаг шинжлэх ухаан бол байсаар ирсэн. Монголд ч оноосон нэрээр олон хөгжиж байна. Үүнийг **«харьцуулсан эрх зүй судлал»**[1] (сравнительное правоведение) гэх болсон. Үүнээс:

> «Харьцуулсан эрх зүй судлал» бол эрх зүйн шинжлэх ухааны нэгэн бие даасан салбар мөн гэж урьдчилан хэлж болно.

Эрх зүйн түүхийн юм уу, ерөнхий онолыг "салбар эрх зүй" гэж болохгүй ч **энэ шинжлэх ухааны салбар** гэдэг шигээр өөрийн судлах зүйл, арга зарчим, зорилго, үр дүнтэй байдгаар нь шинжлэх ухааны салбар хэмээн ойлгохоос аргагүй.

Харьцуулсан эрх зүйн шинжлэх ухааны **судлах зүйлийн** тухайд гэвэл:

- Харьцуулсан эрх зүйн онол, арга зүйн үндсэн асуудлууд;
- Эрх зүйн бүлүүдийн нийтлэг хийгээд онцлог;
- Улсуудын буюу үндэсний эрх зүйн тогтолцоонуудын нийтлэг хийгээд онцлог;
- Олон улсын ба үндэсний эрх зүйн нийтлэг, онцлог;
- Дотоодын эрх зүйн салбар, институтын нийтлэг, онцлог;
- Үндэсний хууль тогтоомжийн хөгжлийн **түүхэн үе шатуудын** нийтлэг, онцлог гэхчлэн эрэмбэлж, тоймолж болох юм. Гэхдээ энэ бол бүрэн гүйцэд жагсаалт огт биш бөгөөд жич дэлгэрэнгүй авч үзвэл зохих баримжаа төдий зүйл.

## 2.3. Арга гэдэг тухайд

«Харьцуулсан эрх зүй» гэхийн хоёрдахь бие даасан (тусгай) утга нь эрх зүйн үзэгдлүүдийг зохих түвшинд **харьцуулах** буюу жишиж, судлан буй үзэгдлүүдийн хоорондын **нийтлэг, онцлог, тусгай** шинжийг нээн илрүүлэхэд зориулагдсан **судалгааны арга** мөн болоход оршино. Энэ арга бол угтаа диалектикийн "ерөнхий", "тусгай", "онцгой" гэсэн гурвал категорийг эрх зүйн үзэгдэл, юуны өмнө түүх, гүн ухаан, ерөнхий ба салбар эрх зүйн онол, практикийн үзэгдэлд хэрэглэж байгаа нь болно. Эрх зүйн хөгжлийн дэлхийн болон улс дундын, мөн үндэсний хэмжээний **гол чиглэл, өвөрмөц байдал** хийгээд **давтагдашгүй (тусгай) онцлогийг** шинжлэх ухааны түвшинд тодорхойлоход түүний **зорилго**, практик **ач холбогдол** оршино. Эрх зүйн судалгаанд энэхүү аргыг өргөн хэрэглэж үр дүнг амьдралд нэвтрүүлэхдээ **нэг талаар** эрх зүйн хөгжлийн олон улсын (даяаршлын) чиг хандлагыг; **нөгөө талаар** монгол орныхоо бүх талын өвөрмөц нөхцлийг тус тус зөв харгалзаж, басхүү давтагдашгүй онцлогоо нарийн тооцон үзэж байхыг ямагт бодолцож байвал зохино. Энэ бол харьцуулан судлах аргыг хэрэглэхэд баримтлах зарчим, тавигдах бодит шаардлага мөн. Түүнээс биш бид бусад орон ялангуяа хөгжингүй орнуудын олон зуун жилийн зангисан хийгээд орчин үеийн шинэчлэгдсэн түвшний эрх зүй, хууль тогтоомжийн практикийг харьцуулан судлахдаа өнгөцөөр хуулан дуурайх, түйлшруулан дөвийлгөж, өөрийн орныхыг үгүйсгэх буюу үл ойшоон орхигдуулах, эсвэл бусдын ашигтай

[1] Ж.Амарсанаа, Б.Амарсанаа, Н.Отгончимэг нарын тус тусын дээр дурдсан ном зохиолд үз

бөгөөд монголд нийцэлтэй практикийг үл хайхрахын аль аль нь Монголын харьцуулсан эрх зүйн шинжлэх ухаанд хийгээд аргад сөрөг нөлөөтэй. Ялангуяа харьцуулсан **судалгааны арга** бол хуульч бүрийн үүрэг зорилгоо хэрэгжүүлэхэд хэрэглэх түгээмэл арга мөн. Өөрөөр хэлбэл харьцуулсан эрх зүйг шинжлэх ухаан болохын хувьд нь зөвхөн энэ чиглэлээр мэргэшсэн хуульч-судлаач эрхэлдэг бол судалгааны аргын хувьд хүн бүр хэрэглэх боломжтой юм.

Харьцуулсан эрх зүйн:

- "шинжлэх ухаан"
- "судалгааны арга" гэсэн энэ хоёр өөр утгыг, тэр нь хуульчдад хэрхэн ямар хэмжээгээр холбогдох (хэрэглэгдэх)-ыг Рене Давид энгийнээр зураглан бичсэнийг би нотолгоо болгон доор сийрүүлэв.

«Бүх хуульч өмнөх зорилтоо их сайн биелүүлэхийн тулд харьцуулсан эрх зүйг сонирхох хэрэгтэй. Харьцуулсан эрх зүй бол хуульчдын нэг хэсэг нь зөвхөн арга, яг хэлбэл харьцуулах (судлах) арга, нөгөө хэсэгт нь огт өөр, эрх зүйг танин мэдэх шинжлэх ухааны харьцангуй бие даасан салбар мөн.

Харьцуулсан эрх зүйг зүгээр л арга болгон ашигладаг хуульчдын зэрэгцээ харьцуулсан судлаачид нь зөвхөн бусдаас ажил хэрэгтээ харьцуулалтыг амжилттай ашиглах хөрс суурийг нь бэлтгэж өгөх зорилго бүхий өөрийн гэсэн байр суурьтай.»[3] гэжээ.

## 3. Харьцуулан судлах аргыг хэрэглэхэд гардаг алдаанаас болгоомжил

### *3.1. Ажиглалт ба бусдын судалгаанаас үзэхэд*

«Харьцуулсан эрх зүй», «Харьцуулсан эрх зүй судлал» (шинжлэх ухаан), «Эрх зүйн харьцуулан судлах арга» гэсэн холбоотой боловч нарийн хэмжүүр (шалгуур)-ээр ялгагдах хэдэн ухагдахуун-(нэр томъёо)-ны тухай дээр дурдав.




Бүдүүвчилбэл манайхны нэрлэн буйгаар[4] "Харьцуулсан эрх зүй судлал» нь шинжлэх ухаан болохын хувьд "харьцуулан судлах аргыг" онол-арга зүйн үүднээс судлан боловсруулдаг. Өөрөөр хэлбэл тэр нь судлах зүйлийнх нь нэг. Дурдсан арга нь бас "харьцуулсан эрх зүй судлал"-д хэрэглэдэг (бусад түүхчилэх, логик шинжилгээний, социологийн тодорхой судалгааны гэхчилэн бусад аргын зэрэгцээ) гол арга. Энэ аргыг хэрэглэхэд ямар алдаа ихэвчлэн гардгийг Оросын академич Ю.А.Тихомиров «залуу хуульчдад» зориулсан[5] бүтээлдээ дэлгэрэнгүй авч үзсэн байна. Үүнээс санаа авч Монголынхоо өөрийн бодит "амьдрал"-ыг ажиглан үзэхэд харьцуулан судлах аргыг (нэг үгээр хэлбэл энэ тухай онолыг) хэрэглэхэд олонтаа ажиглагддаг болгоомжилууштай ганц хоёр алдаа хэрхэн гардгийг энд тухайлан дурдая!

### *3.2. Объектоо буруу сонгох*

Шинжлэх ухаан бол "багцаалах, нуруулдах"-ыг биш, ширхэгчлэн барьж авч, задлан үзэхийг шаарддаг. Эрх зүйд **харьцуулах аргыг** хэрэглэхдээ хооронд нь жишиж үзэх гэж буй асуудал буюу үзэгдлээ чухамхүү харьцуулсан эрх зүйн шинжлэх ухааны үүднээс урьдчилан сонгож тогтоох ёстой. Яг л химийн урвал хийж туршихад эхлээд түүнд орох элемент тэргүүтнээ илүү ч үгүй, дутуу ч үгүй олж тугнах хэрэгтэй шиг. Эрх зүйн судлал, туршилтад бол жишиж болохуйц буюу гол шинж бүрдлээрээ дүйхүйц үзэгдлүүдийг л харьцуулна шүү дээ. Улс бүр, улсын доторхи эрх зүйн салбар бүр **харьцуулагдах, эс харьцуулагдах** өөр өөр тогтолцоо, бүтэцтэй байдаг. Ижил хоёр нь даанч үгүй билээ. Бас харьцуулахдаа тодорхой зорилго, сонголт хийдэг. Номчирхох гэж биш, танин мэдэхээс гадна улсдаа, эрх зүйн орчиндоо хэрэглэх, сайжруулах, шинэтгэх арга ухааныг олох, нэмэрлэх гэж харьцуулдаг. Харин харьцуулагдашгүйг сонговол "холиох" тийш эргэнэ.

- эрх зүйн бүлгүүдийн нийтлэг хандлага;
- Монголын үндэсний эрх зүйн өвөрмөц нөхцөл, зүй тогтол;
- бусад орны Монголд «шилжүүлэн суулгаж» тохирохуйц үр ашигтай ололт энэ **гурван талыг нэгэн зэрэг харгалзахад** харьцуулсан эрх зүйн шинжлэл судлалыг чиглүүлэх нь зөрэг хандлага болно. Чингэхдээ зайлшгүй баримтлах нэг гол шаардлага буюу арга зүйн үндсэн зарчим нь **«харьцуулагдах, эс харьцуулагдах»** хоёрыг лавтай ялган үзэж сэрэмж болгоомжтой хандах явдал чухал юм. Энэ бол харьцуулсан эрх зүй судлалд гардаг элдэв алдаанаас сэргийлэн болгоомжлох гол арга зам мөн билээ. Энэ хүрээнд нэлээд давтагддаг алдаа нь: Обьект буюу судлагдахууны төрөл зүйлийг зөв сонгоход ваанадаж:

- эрх зүйн бүлийг зөв баримжаалах;
- үндэстнүүдийн эрх зүйн тогтолцооноос өөрийн улсад боломжтойг;
- эрх зүйн тогтолцооныхоо салбар, төрөл хэсэг (институт), тэдгээрийн дэд хэсгүүдээс

[3]Рене Давид. Камилла Жоффре Спиноза. "Основны правовые системы современности" М/О Москва. 14 дэх тал

[4]Б.Амарсанаа, Н.Өлзийчимэг нарын энэ тухай ноцын нэр нь ийм. Өөнө дурдсаныг үз!

[5]Ю.А.Тихомиров. Курс сравнительного правоведения. Москва., 1996. 422 тал хуудас

үеэр нь оноож сонгож (юм л бол «Монголд байгаагүй» гэж "залгаа" үтэр түргэн хөсөр хаях) харьцуулах;

- үндэсний болон олон улсын эрх зүйн хамаарлыг үнэн зөв харгалзах;
- (Үндсэн хууль, эрүү, иргэний болон байцаан шийтгэх) тодорхой хуулийг эрэмбэлэн, төрөлжүүлж ерөнхий онолын хүрээнд **тус тусад нь харьцуулан судалбал нийтлэгт нь** тулгуурлаж, онцлогийг олох, нөхцөлөө зөв тодорхойлоход илүү боломж олгоно.

### *3.2.1. Объектыг зөв сонгоход луужин (онол) хэрэгтэй.*

**Бүлийн харьцуулалтыг барууны орнуудын болон** мөн Оросын эрдэмтэд чамгүй судалж, нилээд үндэслэгээ гаргасан байдаг. Францын нэрт судлаач агсан Рене Давидын **«Орчин цагийн эрх зүйн үндсэн тогтолцоод»** гэдэг бүтээл энэ талаар «сонгодог» тооцогддогийг дурдахад илүүдэхгүй. Хуучин ЗХУ ба өнөөгийн ОХУ-д бусад орны Үндсэн хууль тогтоомжийг орчуулан цувралаар нийтэлж, АНУ, ХБНГУ, Франц, Япон зэрэг хөгжингүй орны эрх зүйн судалгааны томоохон бүтээлүүдийг олноор нь орчуулж шинжлэх ухааны зохих тайлбартайгаар нийтэлж ирсэн нь Монголчууд бидэнд ч тус нөлөөгөө үзүүлсээр буй. Өдгөө манай залуу үеийнхэн Англи, Герман, Франц Хятад, Япон зэрэг хэлнийг түргэн эзэмшиж байгаа нь мэдээлэл хүлээн авах чадавхийг эрс нэмэгдүүлэв. Одоо **онолын чадавхийг** дээшлүүлэхэд онц анхаарах шаардлагатай байна. Ялангуяа харьцуулах зүйлсийн нэг гол суурь тал болох "Монголоо" уйтай судалж мэдэх хэрэгтэй нь бидэнд алхам тутам ажиглагдаж байна. Дэлхий гэж дээгүүр хий шуугилгүй дэргэдэхээ төрөлх Монголоо мэд!

Ингэхгүйгээр харьцуулах зүйл чинь хаягдлаа шүү гэмээр ажиглагдана. Цаадуул чинь бидэнд «Та нар манайхныг харьцуулаад өгөөч» гэхгүй «өөрсдийгээ л янзал» гэх байх шүү.

Монголын эрх зүйн салбаруудыг, ялангуяа дэд салбар, төрөл хэсгийг "дэлхийн эрх зүйн" тохирох **бүлийн дотор нь биш**, харин түүний дотор харьцуулалт хийлгүй алгасаж, эсвэл нийлэмж муутай өөр өөр бүлэгс аль нэг хэсгийг тасалан авч харьцуулах хийгээд хэрэглэхийг оролдох нь элбэг үзэгдэх болжээ. Энэ хандлага **танин мэдэхүйд төөрөгдөл авчирч, Монголын эрх зүйд хямрал нүүрлэхэд хүргэх** нь гарцаагүй юм.

Нийтийн эрх зүйн хүрээнд гэхэд л төрийн байгууллагт, шүүх эрх мэдлийн асуудлаар аль «наашаа» гэсэн орны хууль зүйн практик судалж (угтаа өнгөц танилцаж) түгээмэл (common) болон эх газрын эрх зүйн хэм хэмжээ, практикийг хольцолдуулан будилуулж байна. Алив тодорхой баримт гэвэл өнөөдөр төрийн удирдлагын ("засаглалын" гэх болж) хэлбэр, дэглэмийг харьцуулахдаа юуны урьд парламентын болон Ерөнхийлөгчийн бүгд найрамдах улсуудын Үндсэн хуулийн эрх зүйн практикийг биш, Үндсэн хуульт болон хоёрдмол **хаант засагтай Англи, Японыхыг** судалж гол барих болсон нь гайхалтай. Яагаад гайхалтай гэвэл Үндсэн хуульт хаант засгийг судалж болохгүй гэдэг талаасаа биш, адил төстэй хоёр дүрсийг нь алгасаад байгаа нь харамсалтай. Ингээд л парламент, Засгийн газар хоёроо холиод, төрийн тэргүүнээ гаргуунд нь хаядаг болж байна. Энэ бол «байнд ч үгүй, банзанд ч үгүй» гэгчийн жишээ юм.

Хувийн эрх зүй ч ялгаагүй. Иргэн, газар, экологийн эрх зүйд юу болж байна. Жишээлбэл, ашигт малтмал өмчлөх, эзэмших, ашиглах талаарх хууль тогтоомж гэхэд зэгээр обьект нь **хувийн өмчид байдаг орны хуулийг дууриалгаж**, тэдгээр орны "зөвлөх"-үүдийг сонсчихоод Монголд энэ нь ард нийтийн хөрөнгө, төрийн (улсын) өмч гэсэн хууль, танин мэдэхүйн утгыг хүртэл алдагдуулж, асар их баялаг **уурхайгаа хэдхэн долларын лицензээр хувийн өмчид** шилжүүлдэг болов. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулиа "хуга нуга" зөрчөөд улсын хөрөнгийг үзэглээгүй ихээр завшилцаж үндэсний аюулгүй байдалд харш нөхцөл бүрдүүлэхэд чирч гулдарч байна.

Уг нь эсийн нөөцөөр алдартай Чили зэрэг орны төрийн өмчийн ордуудын тухай хууль, XX зууны эхэн үеийн буюу Богд хаант Монгол Улсын дэг журамтай жишвэл Монгол түмэнд маань илүү нийлэмжтэй, тустай шүү дээ. Дээр нь онцлон хэлэхэд эрх зүйн тогтолцоо бол улс улсдаа яахын аргагүй онцлогтой, өөр өөрийн нь байдаг. Ийм болохоор хотонд байгаа хонинныхоо хүч таргыг гадаадын биш, Монгол малчнаараа шинжүүлж үгийг нь сонсдог байвал тэнгэр суудалтнуудад газар дээр тогтох цаг нь уртасмаар.

### *3.3. Харьцуулах зүйлсийн түвшинг тохируулан сонгох нь*

Энэхүү нэгэн **гол шаардлагыг** эс анзаарснаас элдэв гажиг үүсч байна. Бид бараг л хэнээрхэж, хэтэрхий давилуун хандаж байна гэмээр ч юм шиг.

**Түүний тод жишээ нь, эрх зүйн хоёр түвшиний тогтолцоотой холбоот улсуудын дээд түвшинтэй нь өөрийн орны эрх зүй, хууль тогтоомжийг жишихийг урьтал болгодог.**

**Тэгснээрээ арга буюу ихээхэн зорүүтэйг** (тийм байлгүй яахав бидэнд ахдах юм чинь) **олж хармагцаа «Монголынх» болохгүй байна гэх ухааны том том хийсвэр дүгнэлт хийдэг өвчин дэлгэрч байна.**

Энэ бол "харьцуулашгүйг" харьцуулсны уршиг юм.

Яагаад ингэдэг билээ гэхээр бид чинь өөрийгөө мэддэггүй, "жижигхэн" (ирээдүйд томорноо) орон гэдгээ анзаарахгүй их гүрнүүдтэй дүйж «империализмд шийдвэрлэх цохилт өгнө» гэж хийрхэж байсан улс. Бодоод байхад бидний монголчууд нэг талаар их гүрний удамтай, нөгөө талаар хоёр хөрш маань их гүрэн байдаг болоод ч тэрүү өөртэйгээ дүйх түвшний орнуудын жишгийг биш, өөрөөсөө асар том, огт өөр байгууламжтай орны жишээг загварчлан хуулах гэж оролддог туршилтай. Одоо ч энэ «өвчин» бүрэн илааршаагүй байна.

Жишээлэхэд, Монгол нь төрийн байгууламжийн хувьд нэгжээс (баг, сум, аймгаас) бүрддэг **нэгдмэл улс.** Тийм байтал гишүүн (муж) улсуудаас бүрддэг АНУ, ОХУ зэрэг их гүрнүүдийн төрийн байгууламжийн **эрх-зохион байгуулалтын үндсийг** (зөвхөн **холбооны түвшинд нь "харьцуулж"**) хууль, номоо бичиж, боловсруулдаг, зарладаг. Нутгийн захиргааг өөрчлөх төсөл хийхдээ л 200 хол давсан сая хүн амтай АНУ «50 аймагтай» байхад 2 сая гаруйхан хүнтэй манай "Монгол 21 аймагтай байна, юу болж байна аа" гэхчлэн уухайлдаг. Тэнд 50-ийн 1 муж улс нь хэдэн арван мянган "Каунти" (сумтай) байгааг огт судлан үзэлгүй дээгүүр шүүрч олны, юуны өмнө дарга нарынхаа толгойг эргүүлдэг. Энэ мэт нь аргагүй л **хулгана заантай гэрлэсэн** тухай онигоог санагдуулдаг.

Жижиг улс бүхэл бүтэн холбоот их гүрний хэв загварыг бүх араг ясаар нь хуулах гэж оролдох биш, өөрт хэрэгтэй газар нь, тохирох юмаа тааруулж олж жиших хэрэгтэй.

Дээрх байгууламжийн асуудлыг бид холбооны түвшинд нь биш харин **муж улсынхтай** нь буюу өөр нэгдмэл улсынхтай харьцуулбал илүү тохиромжтой биш үү. "Сав савандаа" гэдэг шүү дээ. Энд бас "харьцуулагдах", "эс харьцуулагдах"-ын учир шалтгаан оршино. Залуу судлаач Б.Амарсанаа харьцуулсан эрх зүйн судалгаа хийх гэж зорьговол «харьцуулж болох эсэхийг тунгаах»[6] нь уул судалгааны анхны дүрэм болно гэж зөвлөснийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй юм.

Хувийн туршилгаас үзэхэд бид захиргааны эрх зүйн шинэтгэлийн тухайд **"эх газрын"** гэдгээр нь ХБНГУ эрх зүйг **бүлийн хувьд** баримжаалж, харин хууль, тогтолцооны хувьд илүү дүйцэхээр нь түүний муж улс (жишээ нь, Бавари, Бранденбург зэрэг) буюу Земелийн түвшинг шууд харьцуулж судлаад өвөрмөц нөхцлөө харгалзан боловсруулсан билээ. Гэтэл Үндсэн хуулийн Цэц холбооны хэмжээнд тэрвээсхэн хараад л хуульд нөцтөй буруу өөрчлөлт хийлгэж будилуулан иргэдийн эрхийг хохироож орхив.[7] Энэ бол объектын түвшинг буруу ухаарч харьцуулагдашгүй хоёр зүйлийг шууд холбон үзэх гэсний алдаа мөн.

Тэгэхээр бүл, түвшин, зүйлсийн хувьд **харьцуулагдахууныа** зөв сонгож байгуулштай. Сүүлийн үед зарим залуус "Монгол-Их Британий жишигийн эрх зүй" гэсэн чиглэлээр сонголт хийн сонирхолтой судалгаа явуулсан байна. Бусдыг танин мэдэхүйн ач холбогдолтой боловч Монголд 1921 оны хувьсгалын өмнөх «Улаан хацарт» (Шашины шүүхийн хэрэг шийдсэн данс бүртгэл)-ыг эс тооцвол албан ёсны "шүүхийн **прецидент** байгаагүй". Иймд "хэрэглэдэг", хэрэглэх боломжтой гэх санаа эх газрын тогтолцоот орны эрх зүйд нэгэнд эргэлзээтэйг эрдэмтэд хэдийнээ тэмдэглэсэн байдгийг бодуушгай.

Чингэхдээ **эх газрын бүлийг** жишиг болгох ерөнхий чиг шугамаа баримтлахын сацуу **бусад бүлийн орнуудын эрх зүйгээс,** тэгэхдээ хууль тогтоомжоос нь эх газрынхтай ижилсэх илүүтэй сайн практикийг оновчтой сонгон хэрэглэж болохыг үгүйсгэхгүй. Прецедентийн тухайд Англи-Саксоноос эх авсан жишээлбэл **тангарагтны шүүх дэх мэтгэлцэх зарчмыг** хэрэглэх оролдлого мөрдөн байцаалтын нотолгоонд голлон үндэслэдэг эх газрын эрүүгийн шүүх эрх зүйд хэр тохирч байна вэ? Хуульд бичиж болох боловч мэтгэлцээн нь практикт нотлох баримтын үнэлэмжгүйд хүрээд байгааг анзаарахгүй, ёс болгоод байгаа юм биш биз!!! Энэ хандлагыг ЭБШ эрх зүйн харьцуулсан судалгаанд гүнзгий авч үзмээр бологдоно.

### *3.4. Бүгдийг харьцуулах гэсэн хандлага байж болохгүй*

Харьцуулсан эрх зүйд ашиглагдаж буй бас нэг анзааруушгай (зөв, бурууг дүгнэх гэсэнгүй!) зүйл бол **бусад улсад байдаг бүхэн Монгол Улсад** байх ёстой,

**Монголд байгаа бүхэн бусад улсад байдаг** юм шигээр сэтгэх хандлага юм. Улсын Их Хурал дээр байн байн сонсогддог "дэлхийн бүх улс ийм байдаг" гэдэг үг бий. Иймэрхүү тойм хандлагаас үүдээд монголын эрх зүйг **"бүх бүлийн хамаатан"** болгож орон орны тохирох, тохирохгүй эрх зүйн дэглэм, хууль журмыг учрыг нь тунгаасан, үгүйгээр хуулбарлах болсон явдал юм. Иргэний хуулиа хар! Төсвийн хууль тогтоомжоо хар! Төвлөрлийг багастах Засгийн газрын хөтөлбөртэй атал Шинэ Зеландаас **«Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн»** маягийн хууль зээвэрлэн иржэ захиргаадлын үед ч байгаагүй бараг л "дайны үеийнх" шиг хатуу төвлөрөл бий болгож, аймаг, сумын орлого, зарлагын төсвийг устгаад орон нутгаа хоосолж, олон сайдаа санхүүгийн "магнатууд" болгоод байна. Хажуугаар нь Шведийн вант улсаас нутгийн захиргааны шинэтгэл (реформ)-ийг судлан нэвтрүүлж **"төвлөрөл сааруулж байна"** гэж лоозондоод жил бүр

---

*[6] Ухаацай Батболдын Амарсанаа. "Харьцуулсан эрх". УБ., 2005. 17 дахь тал*

*[7] Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4-р зүйлээс зарим заалтыг хасуулж Засгийн газар, сонгуулийн маргааныг Захиргааны хэргийн шүүхийн бүрэн эрхээс хасаж тонуулсныг хэлэв-Б.Ч*

цөөнгүй тооны судлаач, түшмэдүүд тэр улсаар аялж, "төсөл тэргүүнтэн хэрэгжүүллээ" гэж байна. Түүнээс сум, багт юу ивалдав. Хатан хаант Англи буюу Их Британи Умард Ирландын вант Улсаас парламент Засгийн газрын "холиос", парламент дахь намын арга барилыг авлаа гэвэл одоо юунд хүрэв? АНУ-ын Холбооны (дээд түвшний) засаг захиргаанаас "агентлаг" аваад ямтай зөрүүлж олшируулснаас өөр дорвитой хожсон нь юу байна вэ? Эдгээр улстай харьцуулж болохгүй гэсэндээ биш. Харин харьцуулшгүй зүйл, дүйхгүй түвшинг нь объект болгосныг шүүмжилж байна.

Багцлан ярихвал ийм зүйл олон байгаа ч энэ бүхнийг харьцуулсан эрх зүйн үүднээс нэгтгэн дүгнэсэн нь юн ховор үзэгдэнэ. Судлаачид маань гол төлөв гадны мэдээлэл цуглуулан дамжуулж, хууль хуулж, эсвэл номоос ном бүтээж байгааг хэлэхэд хатуудахгүй.

## 4. Дүгнэлтийн оронд

Энд **эрх зүйг зөвхөн бясалгах биш, харин өөрчлөн шинэтгэж, зовтгон сайжруулахад харьцуулсан судалгааны гол зорилго оршиж байна.** Өөрийн эх сурвалжийг өрөөлийнхтэй орон зай, цаг хугацаа, нийгэм байгалийн, түүх иргэншлийн нөхцөлд нь жишиж шинжиж, дүгнэх, зөвлөх нь харьцуулсан эрх зүй судлалын эрхэм шаардлага мөн.

Энэ талаар мөнөөх Рене Давидаас дахин дурдууштай: Харьцуулсан эрх зүй манай (XX) зууны эхээр эрчимтэй хөгжиж өнөө үед эрх зүйн шинжлэх ухаан, соёлын чухал язгуур махбодь болов. Эхэн үед, "эрх зүйн шинжлэх ухааны бие даасан салбар уу, шинжлэх ухааны харьцуулан судлах арга уу", түүний мөн чанар, судлах зүйл, арга зорилго, шинжлэх ухаанд эзлэх байр, хэрэглэгдэх хүрээ гэхчлэн маргаан өдгөө хуучирч **харьцуулсан эрх зүй хөл дээрээ босов**[8].

Харьцуулсан эрх зүй нь эрх зүйн түүх, гүн ухаан, ерөнхий онол, хийгээд салбаруудад хэрэглэгдэж **«үндэсний эрх зүйг сайтар судлан мэдэх хийгээд боловсронгуй болгох боломжийг олгодог»** гэж тэмдэглэжээ[9].

Тиймээ мэдэх, хэлэхээс гадна хийж бүтээх гэж судалдаг. Эцсийн хүчээ шавхах зүйл чинь бүтээхэд оршино. Ингэж үзэх нь зөв бол Монгол Улс эрх зүйнхээ шинэтгэлийг гүнзгийрүүлж буй өнөө үед харьцуулсан эрх зүйг:

- **шинжлэх ухааны салбарын хувьд нь эрчимтэй хөгжүүлэх** («харьцуулсан судалгааны ажлыг төлөвшүүлэн зангиддаг эрх хэмжээтэй аппарат»[10] судлаачдыг бий болгох зэргээр),
- **судалгааны аргын хувьд** нь өргөн бөгөөд оновчтой хэрэглэх, хуульч бүр суралцах явдал улам чухал болж байна. Энэчлэн хоёр талаасаа хичээвээс бид харьцуулсан эрх зүйг нэг талаар **шинжлэх ухаан,** нөгөөтэйгүүр **судалгааны арга** болгож чадна.

Тийм чухал хэрэгцээ ч байна. Гэхдээ харьцуулж судлахын оронд хаа хамаагүй зүйл хуулбарлахыг тэвчишгүй. Академич Ж.Амарсанаа тэмдэглэн бичихдээ «УИХ-ын хууль тогтоох ажиллагааны сүүлийн 10 гаруй жилийн дүр зургийг тоймлохдоо зарим асуудалд шүүмжлэлтэй хандах нь зүйтэй... Энэ нь цаашид хуулийг цэгцлэх сайжруулахад хэрэгтэй байж болох талтай. Үүнд хууль батлахдаа үзэл баримтлалгүй байх, эрх зүйн тогтолцооны үүднээс асуудалд хандахгүй байх..., гадны хуулийг хийсвэрээр хуулах зэргийг дурдаж болох юм. Ялангуяа Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцээгүй эрх зүйн янз бүрийн тогтолцоотой орны хуулийг хуулбарлаж байгаа нь хууль тогтоомж дотоодоо авцалдаа муутай, зөрчилтэй болж хэрэгжих, бататгах үр нөлөө нь муу болдог байна» гэхчлэн тэмдэглэжээ[11].

**Ном зүй**

1. Ж.Амарсанаа нар (ХЗҮТ) - "Монгол Улсын эрх зүйн тогтолцоо ба харьцуулсан эрх зүй судлал". УБ., 2004
2. Ж.Амарсанаа - "Хүний эрх: Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал". УБ.,2000он.
3. Б.Амарсанаа - "Харьцуулсан эрх зүй судлал". УБ., 2005
4. Б.Гүнбилэг, А.Төмөр - "Харьцуулсан эрх зүй". УБ., 2005
5. С.Нарангэрэл - "Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо". УБ., 2001
6. Н.Отгончимэг - "Монголын харьцуулсан эрх зүй судлал". УБ., 2001
7. Б.Чимид, Ц.Сарантуяа, Вольф Шоллер бусад - "Захиргааны хэргийн шүүх. Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг". УБ.,
8. Ч.Энхбаатар, Т.Доохүү - Гадаад орнуудын Үндсэн хуулийн харьцуулсан эрхзүй". УБ.,2006
9. Кристофер Осакеве - "Харьцуулсан эрх зүй судлал. Ерөнхий ба тусгай анги". УБ., 2005
10. Ю.А.Тихомиров - "Курс сравнительного правоведения". М., 1996
11. И.Рене Давид, Камила Жозеффе Спиноза - "Основное правовые системы современности" .Москва., М/О 1990
12. "Нийтийн ба хувийн эрх зүй: Харьцуулсан судлал". Эрдэм шинжилгээний семинар. УБ., 2006. 8 дахь тал

---

[8] Рене Давид, Камилла Жозеффе - Спиноза. "Основные правовые системы современности" М/О Москва., 1990, 8-9

[9] Мөн тал. 11 дэх тал

[10] Л.Болсан. "Нийтийн ба хувийн эрх зүй: Харьцуулсан судлал". Эрдэм шинжилгээний семинар, илтгэлийн эмхтгэл. УБ., 2006. 8 дахь тал

[11] Ж.Амарсанаа. "Монгол Улсын эрх зүйн тогтолцоо ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил". (Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил) ХЗҮТ. УБ., 2004. 11 дэх тал.

# ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙ СУДЛАЛЫН ӨНГӨРСӨН, ОДОО, ИРЭЭДҮЙ

**Ч.Энхбаатар**

*(Монгол Улсын Засгийн Газрын Хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын Академийн Эрх зүйн тэнхимийн эрхлэгч Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор)*



Харьцуулсан эрх зүй судлал эдүгээ эрчимтэй хөгжиж байгаа, нэн ирээдүйтэй хууль эрх зүйн сургалт, судалгаа шинжилгээний чиглэл болсон бөгөөд түүний хөгжилд бүтээлч хүч, оюун ухаанаа зориулж буй эрдэмтэн, багш нарын тоо жил ирэх тутам улам өсөн нэмэгдэж байна. Хууль зүйн их, дээд сургуулиудад харьцуулсан эрх зүйн ерөнхий болон тусгай хичээлүүд орж, энэ чиглэлийн эрдэм судлалын ажил хүрээгээ тэлж, эрдэмтдийн гаргасан бүтээлийн тоо ч чамлахааргүй хэмжээнд хүрчээ. Энэ чиглэлээр судлаач нар гадаад, дотоодод магистрын зэрэг хамгаалж, доктор төрөх цаг ч улам ойртсоор.

Гэхдээ харьцуулсан эрх зүй судлалын хөгжлийн өнөөгийн түвшинг хүсэн хүлээж буй үр дүнгээр хэмжих юм бол төдийлөн хангалттай биш байна. Үүнд олон хүчин зүйл нөлөөлж байгаагийн дотор юуны өмнө тухайн үеийн нийгэм-улс төрийн нөхцөл байдлын харгайгаар нийгмийн болон бусад шинжлэх ухаанд олон жил ноёрхсон үзэл суртлын хандлага, түгжигдмэл байдлын сөрөг үр дагавар өнөө хэр мэдрэгдэж байгаатай, нөгөө талаас хэлний бэрхшээлээс шалтгаалж гадаадын тэргүүлэх эрдэмтдийн зохиол бүтээлтэй танилцах, эрдэмтдийн чуулга уулзалт зохион байгуулж илэн далангүй ярилцлага, бүтээлч маргаан үүсгэх, харилцан санал бодол солилцох, нөхөрсөг шүүмжлэл өрнүүлэх, шинэ сэргэг санаа дэвшүүлэх, асуудлыг хамтын хүчээр шийдвэрлэх явдал илт дутагдаж байгаатай холбоотой гэж үзнэ. Тийм ч учраас өөрийн орондоо харьцуулсан эрх зүй судлалын онол-арга зүйн түвшинг дээшлүүлэх, эрдэмтэн багш нарын хүчийг энэ чиглэлд татан төвлөрүүлж нэгтгэн зангидах талаар нилээдгүй ажил зохиох шаардлага бидний өмнө тулгарч байна.

Энэхүү өгүүлэлд харьцуулсан эрх зүй судлалын хөгжлийг түүхэн талаас нь, өнгөрсөн, өнөө, ирээдүй гэсэн гурван цагийн хэлхээ холбоост авч үзэхээр зорьсон юм. Бид өнгөрсөн түүхээ үргэлж эргэн санахгүйгээр харьцуулсан эрх зүй судлалын өнөөгийн төлөв байдал, цаашдын хөгжлийн хандлагад зөв үнэлэлт дүгнэлт өгөх нь бэрхшээлтэй байх болно. Нэгэн ухаантны хэлснээр, түүхээ мэдлэгүй хүн ойд төөрсөн сармагчин лугаа адил болой.

Түүхэн үйл явдлу удыг зүгээр нэг тоочих нь төдийлөн ач холбогдол багатай нь ойлгомжтой, тийм учраас судлаач хүний хувьд харьцуулсан эрх зүй судлалын хөгжлийн явцад мөн чанар, чиг үүрэгт гарсан чанарын өөрчлөлтүүд, тэдгээрт хүргэсэн нөхцөл байдалд анхаарлаа хандуулах нь үр дүнгийн хувьд илүү өгөөжтэй байх болов уу гэдгийг иш үндэс болгосон юм. Иймд хэдийгээр харьцуулсан эрх зүй судлал өнөөгийн өндөрлөгт хүрэхдээ түүхийн урт удаан замыг туулсан боловч түүний хөгжлийн гол гол үйл явдлуудыг хураангуйлахаас илүү энэ салбарт хөгжлийнх нь явцад танин мэдэхүйн чанарын ямар өөрчлөлт гарч байсныг тодруулан дүгнэх нь чухал байлаа.

Харьцуулсан эрх зүй нь түүхэн хөгжлийнхөө явцад хэд хэдэн үе шатыг дамжсан билээ. Эхний шатанд харьцуулсан эрх зүй төдийлөн хөгжөөгүй, аугаа их сэтгэгчид харьцуулалтыг онолын үр дүнгээ бататгах, нөгөө талаас хууль тогтоогч хуулиа боловсронгуй болгох зорилгоор алдаг оног ашигладаг байсан гэж үздэг. Тухайлбал хүн төрөлхтний хөгжил дэвшлийн нэгэн оргил болсон Эллиний соёл иргэншил цэцэглэж байх үед амьдарч байсан Платон **"Хуулиуд"** хэмээх алдарт бүтээлээ туурвихдаа Грекийн хот улсуудыг, Аристотель **"Улс төр"** хэмээх суурь бүтээлдээ улс төрийн шилмэл тогтолцооны шинжийг тодорхойлохын тулд тухайн үеийн Грекийн хот улсуудын улс төр-эрх зүйн байгуулалтыг хооронд нь харьцуулан судалж байжээ.[1] Эртний Грекийн алдарт төрийн зүтгэлтэн Солон Афины хуулиудыг боловсруулахдаа,[2] Ромчууд Арван хоёр хүснэгтийн хуулийг боловсруулахдаа гадаадын хуулийг судалж байсан баримт ч түүхийн буурал хуудаснаа үлджээ.[3]

Дийлэнх судлаачид дурьдсан үе шат нь хугацааны хувьд хэдэн мянган жилээр хэмжигдэх боловч харьцуулсан эрх зүйн хөгжлийн түүхэн талаас нь дүгнэвэл энэ нь зөвхөн харьцуулалтын үр сууж байсан эхлэлийн үе хэмээн үздэг.

Гэхдээ биднээс даруй хоёр мянга гаруй жилээр алслагдсан энэ үед харьцуулсан эрх зүй нялх балчир

---

[1] Н.Өлзийсайхан. Харьцуулсан эрх зүй судлал. УБ. 2001, 25 дахь тал; Б.Амарсанаа. Харьцуулсан эрх зүй судлал. УБ, 2005, 21 дэх тал.

[2] Б.Амарсанаа, дурьдсан бүтээл, 21 дэх тал.

[3] Мөн тэнд. Түүнчлэн Н.Өлзийсайхан. Харьцуулсан эрх зүй судлалын үүсэл, хөгжлийн тойм. "Эрх зүй", 2001, дугаар 6-7, 49-50 дахь тал.

байсан гэдэгтэй би хувьдаа санал нийлмээргүй байгааг нуух юун. Учир нь хүн төрөлхтний түүхэнд онцгой байр эзэлдэг, өнөө хэр ач холбогдлоо алдаагүй, Европын эрх зүйн хөгжилд юутай ч харьцуулшгүй хүчтэй нөлөө үзүүлсэн ромын эрх зүй нь чухамхүү харьцуулсан эрх зүйн үр дүн байсан гэдэгтэй маргах хүн цөөн байх болов уу. Энэхүү дүгнэлт нь миний нийтлэг хандлагаас гажсан байр суурийн үндэс мөн. Түүнээ нотлохын тулд Ромын эрх зүйн түүхэн хөгжлийн зарим онцлогоос дурдья.

Ромын эрх зүй нь эрт дээр үед жижигхэн хүй элгэнд үүссэн бөгөөд эхэн үед түүнийг төрүүлсэн хүй элгэний нэгэн адил бүдүүлэг патриархаль шинжтэй, хязгаарлагдмал үйлчлэлтэй байсан юм. Ромын эрх зүй энэ чигээрээ хадгалагдсан бол хэзээ ч хожмын манлайлалд хүрэхгүй байхсан. Гэхдээ түүх өөрөөр шийдвэрлэсэн юм. Оршин тогтнохын төлөөх өдөр тутмын тэмцэлд хатуужин хүчирхэгжсэн Ромын жижигхэн хүй элгэн аажмаар хаяагаа тэлж, гарынхаа дор эхэлж нийт Итали, улмаар газрын дундад тэнгисийн эрэг хавийн улсуудыг нэгтгэснээр тухайн үедээ дэлхийтэй зүйрлэгдэж байсан агуу их хүчирхэг гүрэн түүхийн тавцнаа гарч ирсэн билээ.

Ром дэлхийн улс төрийн амьдралын төв болохын зэрэгцээ арилжаа наймааны төв болсон юм. Орон орны худалдаачид Ромд ирж худалдаа наймаа эрхлэх болсноор нутгийн онцлогоос ангид, грекүүд, египетчүүд, ромчуудын хэнд нь боловч нэгэн зэрэг тохирох, нийтээр хүлээн зөвшөөрөгдөх эрх зүйн хэм хэмжээ үгүйлэгдэв. Иймд олон улсын харилцаа, ялангуяа худалдаа наймаанд хэдэн зуун жилийн турш хуримтлагдаж ирсэн улс улсын эрх зүйн зан заншил, хэм хэмжээг шингээн авч, шинэ нөхцөл байдалд нийцүүлэн улам боловсронгуй болгох замаар гадаадын худалдаачдад зориулсан ард түмнүүдийн эрх зүй буюу **ius gentium**-ыг бүтээж чадсан нь ромын хуульчдын цаглашгүй гавьяа мөн. Хожим дэлхийг эзэгнэсэн, хувийн өмчийг хүлээн зөвшөөрч буй аль ч нийгэмд үйлчлэх боломжтой, түгээмэл шинжтэй Ромын эрх зүй чухамхүү ингэж бүтээгдсэн юм.[4] Иймд харьцуулах аргыг системтэйгээр ашиглаж нийтээр хүлээн зөвшөөрөхүйц эрх зүйн тогтолцоо буюу **ius commune-г** бий болгох анхны амжилттай оролдлогыг хоёр мянгаад жилийн тэртээ эртний ромчууд хийсэн гэсэн дүгнэлтийг эн түрүүнд хийж байна.

Цаг үе улиран өнгөрч, цаггаа дэлхийн хувь заяаг гартаа атгаж байсан аугаа их гүрэн аажмаар суларсаар эцэст нь зэрлэг омгийн дайралтанд өртөж устан үгүй болжээ. Европын тайзнаа шинээр гарч ирсэн ард түмнүүд их нүүдлийнхээ дараа шинэ нутагтаа төвхнөн суурьшиж тайван хөгжлийн замд орсноор яваандаа олон улсын харилцаа холбоогоо хөгжүүлж худалдаа наймаагаа эхлүүлэв. Эдийн засгийн хурдацтай хөгжил нь бие хүнийг хүй элгэний, патриархаль, феодал зэрэг ямарваа дөнгө, хүлээснээс чөлөөлөхийг, хувь хүнд аж ахуйн үйл ажиллагааны эрх чөлөөг олгохыг шаарджээ. Түүх давтагдаж хэдэн зуугаар тоологдох тархай бутархай жижиг улсуудын худалдаачдын өөр хоорондоо хийж буй арилжаа наймааг зохицуулах, гарсан маргааныг шийдвэрлэхэд баримтлах түгээмэл шинжтэй эрх зүйн хэм хэмжээ хурцаар үгүйлэгдэх болов. Гэтэл эдгээр жижиг улсад төгс боловсорсон эрх зүйн хэм хэмжээг тогтоох нөхцөл бололцоо хараахан бүрдээгүй байсны дээр албатуудын хооронд үүссэн иргэний шинжтэй эрх зүйн маргааныг шийдвэрлэхдээ аль улсын хэм хэмжээг баримтлах нь тодорхойгүй байсан. Мэдээж аль ч улс гүрэн аливаа асуудлыг өөрийнхөө хэм хэмжээгээр шийдвэрлэх эрмэлзэлтэй байх нь зүй, гэхдээ бусад улс түүнийг зөвшөөрөн дэмжих нь юу л бол. Үүний улмаас хэм хэмжээний зөрчилдөөн, мухардмал байдал үүсдэг. Дээрх нөхцөл байдлын улмаас нийгэмд үүсч байсан эрх зүйн маргаануудыг шийдвэрлэхийн тулд нийтээрээ хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ хурцаар үгүйлэгдэхэд хүргэсэн бөгөөд өөрийг нь төрүүлсэн Ромын эзэнт гүрэнтэй хамт хэдэн зуун жилийн өмнө түүхийн тавцанаас арчигдсан ромын эрх зүй чухамхүү авралын од болсон гэлтэй. Ромын эрх зүйг их сургуульд судлан шүүхүүдэд хэрэглэн, хэм хэмжээг нь үндэсний хууль тогтоомжуудаар бэхжүүлэх явц эрчимжив. Өөрөөр хэлбэл ромын эрх зүй нь эртний бусад алдарт хуулиудын нэгэн адил эрх зүйн түүхэн дурсгал болохын оронд олон орны хувьд шууд дагаж мөрдөх эрх зүй болж хувирав.[5] Ийнхүү ромын эрх зүй дахин сэргэж, дэлхийг хоёр дахь удаагаа нэгтгэв.

Алдарт эрдэмтэн Ирнериус Болонийн их сургуульд хичээл зааж эхэлснээр эхлэлээ тавьж, Ром-Германы эрх зүйн бүлийн ихэнх орон хувийн эрх зүйгээ кодификацчилснаар дуусгавар болсон, барагцаалбал долоон зуу гаруй жил үргэлжилсэн энэхүү үйл явцын үр дүнд эх газрын Европын ius commune буюу нийтлэг эрх зүй бүтээгдсэн юм.[6]

Тэр үед Европын олон зуун тархай бутархай жижиг улсуудад үйлчилж байсан эрх зүйн хэм хэмжээнүүд нэгэн хэвэнд цутгасан мэт адил байгаагүй боловч нэгэн үндсэн зарчим, гол гол баримтлал, зохицуулалтан дээр суурилж байсныг тэмдэглэх хэрэгтэй. Үүний гол үндэс нь тэдгээр улсууд Ромын эрх зүй буюу түүний үндсэн илэрхийлэл болсон эзэн хаан Юстинианы алдарт **Corpus Iuris**-ыг өөрийн эрх зүйн үндсэн эх сурвалж хэмээн нийтээрээ хүлээн зөвшөөрч, шууд хэрэглэж байсантай холбоотой.[7] Нэг үгээр хэлбэл түүнийг гадны хууль бус өөрийн үндэсний иргэний хууль тогтоомжийн эх сурвалж хэмээн үзэж энэ байдлаар хандаг болов. Европын

---

*[4]О.С. Иоффе. Избранные труды по гражданскому праву. М., "Статут", 2000, 14 дэх тал*
*[5]Г.Берман. Западная традиция права: эпоха формирования. М., Изд-во МГУ, 1998, 134 дэх тал.*
*[6]Rudolf B. Schlesinger, The Past and Future of Comparative Law, "The American Journal of Comparative Law", vol. 43, 1995, 477 дахь тал.*
*[7]Мөн тэнд, 478 дахь тал; Э.Анерс. История европейского права.М., "Прогресс", 1994, 180-181 дэх тал.*

шинжлэх ухааны нийтлэг хэл нь Латин хэл байсан нь үүнд нөлөөлсөн болно. Эрх зүйн энэхүү онцгой үзэгдлийг эрх зүйн онол, түүхэнд рецепци[8] хэмээн нэрлэсэн билээ.

Бодит байдал ийм байхад харьцуулсан эрх зүйн судлалын чиг хандлагыг тодорхойлж ирсэн зарим улс, үүний дотор ялангуяа Ромын эзэнт гүрэн өөрсдийн эрх зүйн тогтолцоог төгс төгөлдөр хэмээн үзэж бусад эрх зүйн тогтолцоог үл тоомсорлож байсан тухай гадаадын тэргүүлэх зарим эрдэмтдийн бүтээлд анх дурьдагдаад[9] дараа нь манай судлаачдын нэлээн хэдэн бүтээлд хуулбарлагдсан саналыг[10] судлаач хүний хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй. Авах гээхийн ухаанаар бусад орны хамгийн дэвшилттэй эрх зүйн зохицуулалтыг судлан илрүүлж, өөрийн нөхцөлд тохируулан хэрэглэх замаар өнөөг хүртэл ач холбогдол, үнэ цэнээ алдаагүй нийтлэг эрх зүйг бий болгож чадсан Ромын эзэнт гүрэн, ромын хуульчдыг өөрийн эрх зүйн болон улс төрийн тогтолцооны давуу чанарт хэт итгэн гадаадын хууль тогтоомжийг үл хэрэгсэж байсан гэх нь бодит байдлаас хэгэрхий гажсан, шудрага бус дүгнэлт гэж үзэхээс өөр аргагүй.

Баруун европын эрдэмтэн судлаачдаас явуулсан ромын эрх зүйн олон зуун жилийн судалгаа нь эрх зүн сэтгэлгээ бүрдүүлж, чадварлаг хуульчдийн бүхэл бүтэн давхаргаа бүрдүүлэхэд тус дөхөм болсон билээ.[11]

Тэр үед харьцуулсан эрх зүйн гол онцлог, чиг үүрэг нь үндэсний хууль тогтоомжуудыг *ойртуулан нягтруулах*, нэгдмэл шинжтэй болгоход нь үйлчилхэд оршиж байсан гэсэн дүгнэлтийг хийж байна.

Түүхэн хөгжлийн явцад Европ тархай бутархайбайдлыгдавантуулснаартомоохонхүчирхэг гүрнүүд аажмаар бүрэлдэн тогтсоны зэрэгцээ XVI-XVII зуунд парламентууд үүссэнээр хууль тогтоох ажиллагаа тогтмолжив. Үүнтэй холбогдож XVIII зууны хоёрдугаар хагаст Европын нөлөө бүхий томоохон улсад иргэний хуулиа кодификацчлах үйл явц явагдсанаар Юстинианы бүрэн эмхтгэлийн шууд үйлчлэл зогссон билээ.

Эрх зүйн үндсэрхэг үзэл газар авсантай холбоотойгоор **jus commune** буюу нийтээр хэрэглэж болох эрх зүйн тухай ойлголт аажим аажмаар суларснаар адаг сүүлдээ устаж үгүй болсон билээ. Энэ үеэс харьцуулсан эрх зүйн мөн чанар, чиг үүрэг үндэс сууриараа өөрчлөгдөн урьд нь нийтээрээ зөвшөөрсөн түгээмэл шинжтэй эрх зүй бий болгоход чиглэсэн, нэг ёсны нэгтгэх арга хэрэгсэл байсан бол эдүгээ түүний эсрэгээр үндэсний эрх зүйн өвөрмөц шинжийг товойлгох, бусдаас ялгаатай талуудыг онцлох чиг хандлагатай болж ирснээр тэдгээрийг салган тусгаарлах нь энэ үеийн харьцуулах эрх зүйн гол чиг үүрэг болж хувирчээ.

XX зуун харьцуулсан эрх зүйн хөгжилд шинэ хандлага, чанарын олон өөрчлөлтүүдийг авчирсан билээ. Энэ зууны бүр эхэнд буюу 1900 онд харьцуулсан эрх зүйн өмнөх үеийн түүхийг дүгнэх, хойшдын чиглэлийг тодорхойлох зорилгоор олон улсын бага хурлыг Парис хотноо зохион байгуулсан нь мэдлэгийн энэ салбар эрийн цээнд хүрч байгаагийн нэг ёсны бэлгэ тэмдэг болжээ.[12] XX зууны туршид харьцуулсан эрх зүй эрчимтэй хөгжиж ирсэн бөгөөд эдүгээ судалгааны аргаасаа илүү өөрийн зорилго, чиг үүрэг бүхий шинжлэх ухааны тодорхой салбарт зүй ёсоор тооцогдож байна.

Үүнд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлсөн билээ. Нэгд Европын Холбоо байгуулагдсанаар Холбооны гишүүн орнууд болон тэдгээрийн эрх зүйн тогтолцоонууд нь хоорондоо ойртон нягтрах зайлшгүй шаардлагатай тулгарсан бөгөөд үүгээр энэ тивд эдүгээ хуульчид болон эрдэмтэд XX зууны хоёрдугаар хагасаас шинэ **ius commune**-гийн эрэлд мордсон гэж хэлж болно.[13] Харьцуулах эрх зүй эргээгээд эрх зүйн үндэсний тогтолцоонуудыг *тусгаарлах* бус хэрэгсэл болж даяарчлалын өнөө үед энэ өөрчлөлт нь Европын хил хязгаараас хальж дэлхийг хамарсан үйл явц болов. Харьцуулсан эрх зүйн нэгдэн нягтруулах энэхүү чиг үүрэг олон хүндрэл, бэрхшээлтэй тулгарч байгааг өнөөгийн Европын интеграцын үйл явц бидэнд бэлхнээ харуулж байна. Нэг холбоон дотор хууль тогтоомжоо ижилсүүлэн төгөлдөржүүлэх ажиллагаа ийм амаргүй байгаа юм чинь бусад орны хувьд энэ нь бүр ч хүндрэлтэй байх нь ойлгомжтой. Гэхдээ л харьцуулсан эрх зүй судлалын ирээдүй нь чухамхүү түүний энэхүү өөр өөр эрх зүйн тогтолцоонуудыг холдуулахаасаа илүү ойртуулах замаар нэгтгэн төгөлдөржүүлэх үүрэгт оршино гэдэгт итгэж байна. Монгол улс ч үүнээс ангид байх учиргүй. Дээр тэмдэглэсэнчлэн, харьцуулсан эрх зүй нь олон зуун жилийн түүхэн хөгжлийн замыг туулсан боловч бие даасан шинжлэх ухааны салбарын хувьд чухамдаа XX зуунд бүрэлдэн тогтсон билээ. Мэдлэгийн энэ салбар бусад эрх зүйн салбараас ийнхүү хоцрогдонгүй хөгжиж ирсний учир шалтгаан

[8] *Ю.А.Тихомиров. Курс сравнительного правоведения. М., 1996, 113 дахь тал; А.Э.Черноков. Введение в сравнительное правоведение, Санкт-Петербург, 2004, 29 дэх тал.*

[9] *К.Цвайгерт, К.Кётц. Введение в сравнительное правоведение в сфере частного права, т. 1, М., 1998, 78 дахь тал*

[10] *Н.Отгончимэг, дурьдсан бүтээл, 25 дахь тал; Б.Амарсанаа, дурьдсан бүтээл, 22 дахь тал.*

[11] *И.А.Покровский. История римского права. Санкт-Петербург, "Летний сад", 1998, 261 дэх тал.*

[12] *Ю.А.Тихомиров. Курс сравнительного правоведения. М., 1996, 33 дахь тал; Н.Отгончимэг. Харьцуулсан эрх зүй судлалын үүсэл, хөгжлийн тойм. "Эрх зүй", 2001, дугаар 6-7, 53-54 дэх тал.*

[13] *Rudolf B. Schlesinger, дурьдсан зохиол, 479-480 дахь тал.*

нь ийнхүү хөл дээрээ тогтохоос өмнө хэд хэдэн урьдач нөхцлийг хангах шаардлагатай байсанд оршино. ***Эн түрүүнд*** улс хоорондын харилцаа одоогийн өндөр түвшинд хүрэх, өөр хоорондоо үзэл суртлаар талцах явдал эцэс болж олон ургальч үзэл ноёрхсон, эдийн засаг, улс төрийн болон бусад ашиг сонирхлоор нягт хэлхэлдэх, холбоо харилцаа үлэмж хөгжих нь нэгэн зайлшгүй нөхцөл байсан. ***Хоёрдугаарт,*** харьцуулсан эрх зүйн хөгжлийг зөвхөн Европын орнууд тодорхойлдог европоцентризмын хандлагаас ангижирч, ази, латин америк, африкийн орнуудын гүйцэтгэх үүрэг, үр нөлөө дээшилсэн байна. ***Гуравдугаарт,*** эрх зүйн салбар шинжлэх ухаантай харьцуулбал харьцуулсан эрх зүй нь давхрагын буюу арга зүйн шинжтэй шинжлэх ухаан учраас эхлэж эрх зүйн онол болон эрх зүйн тусгай салбар шинжлэх ухаанууд хөгжиж байж улмаар тэр суурин дээр харьцуулсан эрх зүй хөгжих зүй тогтолтой билээ. Суурь нь хэдий чинээ бөх байна, давхарга нь төдий чинээ бөх байна. Энэ шаардлага эдүгээ хаа сайгүй хангагдсан гэж хэлж болно. ***Эцэст нь*** харьцуулсан эрх зүйн талаарх системтэй суурь мэдлэгийн эрэл хэрэгцээ хаа сайгүй үүсэв. Өөрөөр хэлбэл, харьцуулалтын аргыг алдаг оног хэрэглэх явдлаас эрх зүйн практик, шинжилгээ судалгааны өмнө тулгарсан асуудлуудыг шийдвэрлэхэд харьцуулсан эрх зүй судлалын үр дүнг ашиглах эрэлт хэрэгцээ өсөн нэмэгджээ. Дээрх урьдач нөхцлүүд бүрэн хангагдсанаар харьцуулсан эрх зүй судлал өөрийн судлах зүйл, арга зүйтэй, зорилго, чиг үүрэгтэй, үндсэн ухагдахуунуудтай шинжлэх ухааны бие даасан төрөл гэдгийг эдүгээ ихэнхи эрдэмтэн судлаачид хүлээн зөвшөөрдөг.[14] Ихэнхи гэдгийн учир нь харьцуулсан эрх зүй судлалын бие даасан статусыг өнөө хэр нь хүлээн зөвшөөрдөггүй, судалгааны арга төдий үзэх хандлага байгаатай холбоотой.[15]

Орчин үеийн бас нэг хандлага нь уг эрх зүйн салбарын хүрээ өргөжиж иргэний эрх зүйн салбараас хальж эрх зүйн өөр бусад салбар түүний дотор олон улсын эрх зүй, улмаар нийтийн эрх зүйг хүртэл хамрах болсон байна. Үүнтэй холбогдож тухайн эрх зүйн салбарын онцлогоос шалтгаалж харьцуулалтын үр дүн өөр өөр байдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй болов уу. Хувийн эрх зүйн салбар нь ард түмний амьдрал, нийгмийн ёс суртахуун болон соёлтой шууд холбоотой, олон зуун жилийн туршид аажмаар бүрэлдэн тогтсон байдаг. Өөрөөр хэлбэл нийгмийн жам ёсны хөгжлийн үр дүн байдаг бөгөөд тэр ч утгаараа эрх зүйн уламжлал, зан заншлыг амь бөхтэй хадгалдаг. Иймч учраас хувийн эрх зүйн салбарыг өөрчлөн шинэчлэх, хуулбарлан хэрэглэх нь амаргүй зорилт байдгийг харьцуулсан эрх зүйн түүхэн хөгжил бэлхнээ гэрчилнэ. Тэгвэл нийтийн эрх зүйн салбар илүү уян хатан бөгөөд үзэл суртал, улс төрийн нөлөөнд өртөмтгий байдаг нь ажиглагдсан. Энэ нь иргэний эрх зүйтэй харьцуулбал нийтийн эрх зүйн салбарууд нь үндэсний уламжлал, зан заншилтай нягт уялдаагүй байдагтай холбоотой болов уу. Ганц жишээ хэлэхэд төрийн байгуулалт, удирдлагын хэлбэр, сонгуулийн тогтолцоо, төрийн үйл ажиллагааны зарчим зэргийг өөрчлөх нь иргэний хуулиа шинэчлэн нийгмээ түүнд дасгахаас л илүү хялбар байсныг бидний нэн шинэ үеийн түүх гэрчилнэ. Ер нь ардчилсан засаглал бүхий аливаа улс орон Англо-Саксоны эсхүл Ром-Германы эрх зүйн бүлд хамаарахаас үл шалтгаалан эрх зүйт төр, төрийн эрх мэдэл хуваарилах тогтолцоо, үндсэн хуулийн хяналт, олон намын тогтолцоог тогтоосон байдаг. Иймд харьцуулалтыг ашиглахдаа тухайн салбарын онцлогийг давхар харгалзах шаардлагатайг дээрхи жишээнүүд харуулж байна.

Зарим нэг санал дэвшүүлэхийг хүсэж байна. Харьцуулсан эрх зүй судлал сургалтын тогтолцоонд ямар байр суурь эзлэх вэ гэдэг асуудал чухал ач холбогдолтой. Энэ асуултанд бид ямар хариулт өгөхөөс харьцуулсан эрх зүйн ирээдүйн хувь заяа багагүй хэмжээгээр шалтгаална. Ер нь энд онцлон тэмдэглэхэд 1990 оноос хойш улс төр, нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээнд эрчимтэй өрнөсөн өөрчлөлт шинэчлэлийн үр дүнд бүх шатны сургалтанд олон жил бугшсан, сурганы эрх чөлөөг боогдуулж оюуны хүлээс болсон үзэл сурталжсан хандлага эцэс болсны ачаар мэргэжлийн дээд боловсролын сургалт, түүний дотор хууль зүйн сургалтын агуулга, стандарт өөрчлөгдөн боловсронгуй болсоор ирсэн билээ. Түүнчлэн боловсролын салбарт хэрэгжиж байгаа төслүүд хуулийн дээд боловсролыг үндсэн хуульт ёс, эрх зүйн шинэтгэлийн үзэл баримтлал, гадаадын олон орны хууль зүйн сургалтын жишгийг харгалзан өөрчлөн шинэчлэхэд зохих хувь нэмэр оруулж байна. Үүний нэг жишээ нь Хууль зүй, дотоод хэргийн болон Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын хамтарсан тушаалаар баталсан хууль зүйн их, дээд сургуульд заавал үзэх хичээлийн жагсаалтанд харьцуулсан эрх зүй судлал орсон явдал юм.

---

[14] *А.Х.Саидов. Сравнительное правоведение. М., "Юрист". 2000, 19 дэх тал; М.Н.Марченко. Сравнительное правововедение. Общая часть. М., "Зерцало", 2001, 79 дэх тал; Ю.А.Тихомиров. Курс сравнительного правоведения. М., "Норма", 1996, 6 дахь тал; W.Ewald. Comparative Jurisprudence (1): What Was It Like To Try a Rat, "Pennsylvania Law Review", vol. 143, 1995, p. 2115; M.Bogdan. Comparative Law. Kluwer/Stockholm, 1994, pp. 21-25; В.С.Нерсесянц. Сравнительное правоведение в системе юриспруденции. "Государство и право", № 4, 2001, 5-15 дахь тал, ба бусад.*

[15] *O.Kahn Freund, Comparative Law as an Academic Subject, "Law Quarterly Review", vol. 40,41, 1966; P.de Kruz, Comparative Law in a Changing World, London/Sydney, 1999, p. 5; H.Gutteridge, Comparative Law: An Introduction to the Comparative Method of Legal Study and Research. Cambridge University Press, 1949, ба бусад.*

Гэхдээ сургалтанд гарч буй наахтай хандлага, өөрчлөлтийн зэрэгцээ зарим сөрөг зүйл ч байгааг дурьдахгүйгээр өнгөрч болохгүй байна. Эдүгээ "Дэлхийн улсуудын төр, эрх зүйн түүх", "Ромын эрх зүй" зэрэг харьцуулсан эрх зүйн шинжтэй, онол-түүхийн суурь хичээлүүд үндсэндээхуучь зүйн их, дээд сургуулийн сургалтын төловлөгөөнөөс хасагдах хандлагатай байна. Үүнийг бид академик сургалтаас тодорхой хэмжээгээр татгалзаж прагматик сургалтыг чухалчилж байгаагаар талбарладаг. Ер нь суралцагчдад онолын мэдлэг олгохын зэрэгцээ олсон мэдлэгээ амьдралд хэрэглэх дадлага чадвар эзэмшүүлэх нь туйлын чухал гэдэгтэй маргах хүн гарахгүй л болов уу. Нөгөө талаас хэрэв бид сэтгэлгээний өргөн цар хүрээтэй, гүн бат мэдлэгтэй, эрх зүйн өндөр соёлтой хуульчдыг бэлтгэх зорилт тавьж байгаа бол эрх зүйн философи, социологи, онол түүхийн суурь хичээлүүдийг сургалтын хөтөлбөрөөс бүрмөсөн таягдан хаяж болохгүй мэт санагдана. Үүнд ухаалаг тэнцвэржүүлэлт шаардлагатай болов уу.

Энэ асуудал бусад орны хувьд ч анхаарал татсан асуудал гэдгийг бид харьцуулсан эрх зүй судлалын тэргүүлэх эрдэмтдийн бүтээлээс харж болно. Франц улсад харьцуулсан эрх зүй нь нарийн мэргэшиж эрх зүйн өндөр соёлтой болохыг хүссэн цөөн тооны шилмэл оюутны хүртээл болох хандлагатай болсныг Рене Давид тэмдэглэсэн байдаг.[16] К.Цвайгерт. Х.Кетц нар ч ирээдүйд харьцуулсан эрх зүй судлалыг германы хууль зүйн их, дээд сургуулийн төлөвлөгөөнд тэдийлэн багтахаа байсан эрх зүйн түүх, эрх зүйн социологи, эрх зүйн философийн гунигт хувь заяа хүлээж байна гэсэн дүгнэлтэнд хүрчээ.[17] Учир нь Германы хууль зүйн их, дээд сургуульд үзэх хичээлийн тоо олширсноор прагматик сургалтыг голлох нэрийдлээр эрх зүйн өндөр соёл, хуулийн сэтгэлгээг төлөвшүүлэхэд ихээхэн ач холбогдолтой онол түүх, харьцуулсан эрх зүйн хичээлүүдийг хамгийн түрүүнд золиосолдог юм байна. Дээрхи эрдэмтэд харьцуулсан эрх зүй судлалыг хичээлийн программаас хэрхэвч хасч болохгүйг хэд хэдэн үндэслэлээр тайлбарласан байдаг.[18]

Үүнтэй холбогдуулж өөр өөр эрх зүйн бүлд хамаардаг орнууд харьцуулсан эрх зүй судлалын сургалтыг хэрхэн зохион байгуулдаг нь анхаарал татсан юм. Хэрэв Ром-Германы бүлийн орнууд дэлхийн орнуудын төр, эрх зүйн түүх, эрх зүйн философи, ромын эрх зүй зэрэг онол түүхийн суурь хичээлүүдийг түлхүү ашигладаг[19] бол Англи-Саксоны орнууд эрх зүйн салбарын үндсэн хичээлийн зэрэгцээ үндсэн хуулийн харьцуулсан эрх зүй ("Comparative Constitutional Law"), байгаль хамгаалах харьцуулсан эрх зүй ("Comparative Environmental Law"), эрүүгийн харьцуулсан эрх зүй ("Comparative Criminal Law") зэрэг хичээлийг сургалтын төлөвлөгөөнд түлхүү оруулах замаар энэ чиглэлийн шаардлагыг хангадаг.[20]

Гэтэл манайд онол түүхийн суурь хичээлүүд нь ч ад үзэгдээд, салбар эрх зүйн харьцуулах чиглэл ч алдагдаж байна. Үүнийг эрх зүйн нэг салбараар жишээлэн авч үзье. "Үндсэн хуулийн эрх зүй" хичээлийг өмнөх тогтолцоонд тухайн үеийн нийгэм, улс төрийн байдлаас шалтгаалж "БНМАУ-ын төрийн эрх зүй", "Социалист орнуудын төрийн эрх зүй", "Хөрөнгөтний болон хөгжиж буй орнуудын төрийн эрх зүй" гэсэн гурван чиглэлээр зааж байсан бол эдүгээ зарим цөөн дээд сургуульд "Монгол Улсын үндсэн хуулийн эрх зүй"-н зэрэгцээ "Гадаад орнуудын (харьцуулсан) үндсэн хуулийн эрх зүй" хичээл орж байгааг эс тооцвол уг хичээлийн харьцуулсан эрх зүйн чиглэл үндсэндээ орхигдсон гэж хэлж болно. Гэтэл монголчууд биднийг XXI зуун руу хөтлөн залах учиртай 1992 оны Үндсэн хууль барууны сонгодог ардчилсан ёсыг өөртөө шингээж, улс төрийн шилдэг онолд тулгуурлан монголын нийгмийг бүхэлд нь ардчилах, эдийн засгийг чөлөөлөх, төрийн тогтолцоог шинэчлэх, төрийн эрх мэдлийг тэнцвэртэйгээр хуваарилах, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн тунхаглах, үндсэн хуулийн хяналтыг нэвтрүүлэх талаар шийдвэртэй алхам хийсэн билээ. Нөгөөтэйгүүр даяарчлалын эрин үед Монгол Улс нэгэнт сонгосон ардчилсан хөгжлийн замаас ухарч буцахгүй байх үндсэн нөхцөл, арга зам нь том, жижиг гэлтгүй дэлхийн бусад орны үндсэн хуулийн эрх зүйн ололт, практик туршлагыг цаг ямагт судлан үйл ажиллагаандаа хэргэлзэхад оршино. Ингэхгүйгээр бид цаашдаа ч үндсэн хуулиа гүйцэд ойлгож зөв хэрэглэхэд бэрхшээлтэй байх болно.

Бид ч дээрхи орнуудыг туршлагыг харгалзан харьцуулсан эрх зүй судлалын онол-практикийн ач холбогдлыг өргөх л гэж бодож байгаа бол уг хичээлийн цагийг нэмэх, сэдвийн хүрээг өргөтгөх, нөгөөтэйгүүр салбар эрх зүй бүрийн харьцуулан судлах чиглэлийг өргөтгөх шаардлагатай болов уу.

[16] *Р.Давид. Основные правовые системы современности [сравнительное право]. М., 1967, 33-34 дэх тал.*

[17] *К.Цвайгерт, К.Кётц, дурьдсан зохиол, 38 дахь тал*

[18] *Мөн тэнд.*

[19] *Мөн тэнд, 35-36 дахь талд.*

[20] *D.Winterton, Comparative Law Teaching, "The American Journal of Comparative Law", '975, vol. 23, p. 69; D.Henderson, Comparative Law in Perspective, "Pacific Rim Law and Policy Journal", 1992, vol. 1, #1, p. 2. Үүнтэй холбогдуулан харьцуулсан эрх зүйн аспектыг түлхүү оруулах замаар их, дээд сургуулиудын сурах бичгүүдийг үндсээр нь өөрчлөх тухай санал дэвшигдэж байсан юм. К.Цвайгерт, К.Кётц, дурьдсан зохиол, 39 дэх тал; R.Schlesinger. The Role of the "Basic Course" in the Teaching of Foreign and Comparative Law. "The American Journal of Comparative Law", 1971, vol. 19, p. 616*

# ЭРХ ЗҮЙН БҮЛ БА ЭРХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖ

**Д.Оюунцэцэг**

*(Шихихутуг ХЗДС-ийн захирал, дэд профессор)*



Эрх зүйн бүл буюу уламжлалын шалгуур эрх зүйн эх сурвалж болох эсэх асуудал өдгөө харьцуулсан эрх зүй судлалын судалгааны эргэлтэд хангалттай хэлэлцэгдсэн байдаг. Энэхүү хандлагаас харахад эрх зүйн эх сурвалжийг эрх зүйн бүлийн шалгуур болох эсэх асуудал шинжлэх ухааны маргаанаас гарч, энэ хэрээр түүнийг хүлээн зөвшөөрч байгаа болно.

Эрх зүйн эх сурвалжийн тухай онол нь өөрөө өөрчлөгдөн хувьсан хөгжиж байдаг зүйл.[1] Бидний хувьд эрх зүйн эх сурвалжийг түүний илрэн гарах гадаад хэлбэр хэмээн тодорхойлдог хэвээр билээ. Энд яригдаж буй эрх зүйн тухай ойлголтыг эрх зүйн бүлийн шалгуураар авч үзэн жишгийн эрх зүйн бүлд эрх зүйг нийхүү ойлгодог, эх газрын эрх зүйд ингэж ойлгодог гэх нь төдийлөн оновчтой биш бөгөөд харин ***Жам ёсны эрх зүйн онол эсвэл Позитив эрх зүйн онолд*** үндэслэсэн үү гэх мэтээр онолын хувьд зааглан авч үзэж болохуйц юм.[2] Нөгөө талаас, "эрх зүйн эх сурвалж" гэсэн нэр томъёогоор эрх зүйн ***"агуулга"***-ын болон ***"хэлбэр"***-ийн эх сурвалжуудийн аль алиныг нь тэмдэглэн илэрхийлдэг.[3] Эрх зүйн агуулгын эх сурвалж бол эрх зүйн хэм хэмжээг материаллаг үндсээр хангаж байдаг нийгэм дэх анхдагч нөхцөл байдлын шаардлагуудаар илрэн гарч байдаг.

Орчин үед харьцуулсан эрх зүйд эрх зүйн эх сурвалжийн асуудлыг ***"давуутай байдлын зарчим"***-аар авч үзэж байгаа болно. Энэ зарчмын гол агуулга бол аливаа эрх зүйн тогтолцоо зөвхөн эрх зүйн нэг эх сурвалжаас хамааралтай байх боломжгүй, ийм нөхцөл байдал байдаггүй гэсэн ерөнхий ухагдахуунд үндэслэж байдаг билээ. Энэхүү "давуутай байдлын зарчим"-ыг хэрэглэж үзвэл, бодит нөхцөл байдлын хувьд хууль болон шүүхийн прецедентийг эрх зүйн аль аль тогтолцоо хэрэглэж байгаа. Харин аль нь эрх зүйн голлох эх сурвалж болж байна гэдгээр авч үзвэл илүү үр дүнд хүрч болохоор байгаа юм. Тухайлбал, жишгийн (англи-саксоны) болон эх газрын эрх зүйн бүлийг аваад үзвэл аль аль нь хууль болон шүүхийн прецедентийг хэрэглэж байгаа боловч аль нь эрх зүйн гол эх сурвалж болох асуудлаар ихээхэн ялгаатай байдалтай байгаа бөгөөд энгээрт хандах хандлага, хийсвэрлэлийн арга, техник нь хангалттай ялгаатай болохыг тодорхой харуулж байгаа юм.

Энэхүү ялгаа, гол үндэслэлийг эх газрын эрх зүйн болон жишгийн (англи-саксоны) эрх зүйн бүл дээр харьцуулан авч үзье.

## (1). Эх газрын эрх зүйн бүл-

эрх зүйн эх сурвалжийн талаар энэхүү бүлд өнөөдрийг хүртэл тогтсон нэгдмэл нэг ойлголт байхгүй байна. Энэ бол улс үндэсний эрх зүйн уламжлал, зан заншил, эрх зүйн соёл зэрэг хүчин зүйлүүдтэй холбоотой бөгөөд эдгээр хүчин зүйлүүдийн нөлөө мөн хүчтэй хадгалагдсаар байгаагийн илрэл юм. Хэдий тийм боловч, харьцуулсан эрх зүй судлаачид эх газрын эрх зүйн бүлийн эх сурвалжийн талаар ерөнхий төсөөлөл, ойлголтыг тодорхойлон гаргасаар байна.

Эх газрын эрх зүйн эх сурвалжийг бусад бүлийн эх сурвалжтай харьцуулахад товчний ялгаанаас гадна иргэншлийн онцлогоос үүдсэн үнэлэмжийн шинжтэй өвөрмөц онцлогууд олон бий. Онцолж үзмээр нэг зүйл бол эрх зүйн эх сурвалжийн "норматив байдал" давамгайлах чиг хандлага байдагт оршино. Тийм учраас эрх зүйн эх сурвалжид хандах энэхүү хандлагаас салсан байх шаардлага өнөөдөр зүй ёсоор эрх зүйн эх сурвалжийн асуудал дээр тавигдаж байгаа болно. Өөрөөр хэлбэл, албан ёсоор л хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг л эх сурвалж гэж үзэхээс зайлсхийх явдал юм. Орчин үед эрх зүйн эх сурвалжийг хууль зүйн төдийгүй философи, социологи, түүхийн хүчин зүйлийн уялдаанд авч үзэх нь ач холбогдолтой болжээ.

Эрх зүйн эх сурвалж бол зөвхөн шүүхээс тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хэрэглэх төдий зүйл биш бөгөөд тодруулбал, эрх зүйг бүтээхэд болон хэрэглэхэд баримталж, тулгуурлаж байгаа эх үндэс болно.

Эх газрын эрх зүйн бүлийн хувьд эрх зүйн эх сурвалжийн асуудлыг хөндөх тохиолдолд заавал биелэгдэх шинжтэй эх сурвалж болон заавал биелэгдэх шинжгүй эх сурвалж гэж авч үзэх нь зүйтэй юм. Үүнд:

А. *Заавал биелэгдэх шинжтэй эх сурвалж*

(Франц, Герман)

1. Үндсэн хууль (гол хууль)
2. Олон улсын гэрээ
3. Хууль *(хууль болон салбарын хууль тогтоомжууд). (Францад хуулийн адил хүчин төгөлдөр үйлчилдэг акт нь Ерөнхийлөгчийн зарлиг байдаг байна)*

---

[1] *Rene David, J.E.C.Brierly, Major Legal Systems in the World Today: An Introduction to the Comparative Study of Law. 1990. 328 дахь тал*

[2] *Б.Амарсанаа. Харьцуулсан эрх зүй. 2005. 75 дахь тал*

[3] *Ж.Л.Бержель. Общая теория право. 2003. 40 дэх тал*

4. Хуульчилсан актууд
5. Худалдааны заншил
6. Шүүхийн прецедент *(jurisprudence constant). (Жишээ нь: Герман, Испани болон бусад орнуудад, харин Францад хэрэгжидэггүй)*
7 Эрх зүйн ерөнхий зарчмууд *(principes generaux, genera=klauseln)*
8. Иргэний эрх зүйн хэлцлүүд *(гэрээ болон бусад)*

Б. *Заавал биелэгдэх шинжгүй эх сурвалжууд*

9. Шүүхийн прецедент
10. Номлол (эрдэмтдийн үзэл сургаал)
11. Гадаад орнуудын хууль
12. Гадаад орнуудын шүүхийн шийдвэр
13. Шүүхийн практик болно

**(2). Жишгийн (англи-саксоны) эрх зүйн бүл**-энэ бүлийг бусад бүлээс ялгах гол шалгуур нь шүүхийн прецедент буюу хэвшүүлэн хэрэглэх хэм хэмжээ гэж үздэг. Өөрөөр хэлбэл, түүний үндсэн эх сурвалж нь төрөөс тогтоосон хууль бус, харин шүүхийн хэвшүүлсэн шийдвэр бөгөөд түүгээрээ эрх зүйн өөр бусад бүлээс онцлон ялгардаг.

Түүнчлэн эх газрын эрх зүй шиг нарийн заагласан салбаруудад хуваагддаггүй, заншлын хэм хэмжээг голлон, процессын хэм хэмжээг материаллаг эрх зүйнхээс давуу үздэг[4] зэрэг шинжүүдээр тодорхойлогддог. Мөн нөгөө талаас нь авч үзвэл, англи-саксоны эрх зүйн бүлийн бусдаас ялгарах шинж нь шүүгчийн бүтээсэн эрх зүй үйлчилдэг явдал мөн Тэгвэл хууль тогтоогчийн бүтээсэн эрх зүй нь шүүгчийн бий болгосон эрх зүйг "засварладаг", "гүйцээдэг" гэдэг утгаараа хоёрдогч шинжтэй эх сурвалж гэж үзэх явдал түүхийн хувьд байсаар ирсэн бөгөөд харин өдгөө хууль тогтоомжийн ач холбогдол өсөн нэмэгдэж байгаатай холбоотой энэ хандлага ач холбогдлоо алдаж байна.

Жишгийн (англи-саксоны) эрх зүйн бүлд хамаарагддаг улс орны хувьд эрх зүйн эх сурвалжийг авч үзвэл бас ялгаатай дүр төрх харагдана. Англи улсын хувьд хууль тогтоомжоос илүү шүүхийн прецедентэд илүү их ач холбогдол өгч байсан бол Америкийн хувьд Үндсэн хууль, хууль тогтоомж чухал үүрэг гүйцэтгэж ирсэн байдаг байна. Энэ хоёр улсын хувьд энэ бүлийн эрх зүйн эх сурвалжуудыг харьцуулан авч үзье.

**Англи улсын эрх зүйн эх сурвалж:**

А. *Заавал биелэгдэх шинжтэй эх сурвалж*

1. Шүүхийн прецедент
2. Хууль тогтоомж-Статут
3. Хуульчилсан актууд
4. Эртний зан заншил (convention)
5. Худалдааны зан заншил
6. Олон улсын гэрээ
7. Зан заншил (custom)
8. Шударга ёсны зарчим (equity)
9. Вангийн дархан эрх ямба (voyal prerogalive)
10. Каноны эрх зүй (canon law)
11. Оюун ухаан (reason, natural law)
12. Иргэний эрх зүйн хэлцлүүд (гэрээ болон бусад)

Б. *Заавал биелэгдэх шинжгүй эх сурвалжууд*

13. Эртний номлолууд (books of authority)
14. Гадаад орнуудын хууль
15. Obiter dictum/dictum/
16. Гадаад орнуудын шүүхийн шийдвэр
17. Шүүхийн практик

**Америкийн эрх зүйн эх сурвалж**

А. *Заавал биелэгдэх шинжтэй эх сурвалж*

1. Үндсэн хууль
2. Шүүхийн прецедент
3. Хууль тогтоомжууд-Статут
4. Хуульчилсан актууд
5. Шударга ёсны зарчим (equity)
6. Худалдааны зан заншил
7. Олон улсын гэрээ
8. Иргэний эрх зүйн хэлцлүүд (гэрээ болон бусад)

Б. *Заавал биелэгдэх шинжгүй эх сурвалжууд*

9. Номлол (эрдэмтдийн үзэл, сургаал )
10. Гадаад орнуудын хууль
11. Obiter dictum/dictum/
12. Гадаад орнуудын шүүхийн шийдвэр
13. Шүүхийн практик болно

Тэгэхлээр нийгмийн хөгжлийн явцад эрх зүйн эх сурвалжийн тухай ойлголт өөрчлөгдөж, түүний мөн чанар, хэлбэр нь хувьсан шинэчлэгдсээр иржээ. Энэхүү хөгжил нь даяаршилтай мөн эрх зүйн соёлыг ээлдэн нутагшуулах

---

[4] *Б.Чимид. Засистой эрх зүйг баримжаалах нь эрх зүйн шинэтгэлийг үр нөлөөтэй хийх үндэс болох нь. Эрх зүйн шинэтгэл ба үндсэний эрх зүйн төлөвшил. Олон улсын симпозиум, 2000 оны 04 сарын 25-27. 18 дахь тал*

## шихихутут

*(эрх зүйн рецепци*)* ба конвергенц хийх явдалтай басхүү холбоотой юм. Мөн нөгөө талаас аваад үзвэл, дэлхийн улсуудын эдийн засаг интеграцчилагдаж, олон улсын худалдаа арилжаа, өргөжиж, харилцаа холбоо, мэдээллийн олон улсын сүлжээ бий болж, хүний эрх глобальчлагдаж, тусгай (хувийн) эрх зүйн салбарт олон улсын олон талт гэрээ, НҮБ-ын конвенц, баримт бичгүүд олширч, тэдгээрт оролцогч улсуудын Засгийн газрууд нэгэн адил үүрэг хүлээх болов.[5] Энэ бүхнээс шууд хамааран үндэсний хууль тогтоомж адил төстэй болж, түүгээр дамжин эрх зүйн бүлгүүд ойртож буй нь илэрхий юм. Иймд нийгмийн хөгжлөө даган орчин үеийн хууль зүйн шинжлэх ухаанд эрх зүйн бүл ба эрх зүйн эх сурвалжийн асуудал дээр "давуутай байдлын зарчим"-ыг хэрэглэж байна. Энэ нь аливаа улс оронд өөрийн бодит хүчин зүйлээр нөхцөлдсөн төрөлх шинжтэй уламжлалт үнэт зүйлсүүд ч байгааг үгүйсгэх аргагүйтэй бас холбоотой билээ.

---

**Рецепци гэх өнөөгийн дэлхий нийтийн хэрэглээний үг нь "receptio" гэдэг латин үгнээс гаралтай. "Receptio" нэр томъёо хүлээн авах, тээдэх, сэргээх гэсэн утгыг агуулна. Англи хэлний Оксфордын тайлбар толь бичигт энэ нэр томъёо нь латины "receptio" гэдэг үгнээс хүчин цагийн франц хэлээр "reception" гэх үгнээс дамжин англи хэлний үгийн санд орж ирсэн гэжээ. Герман хэлний тайлбар толь бичигт мөн адил тайлбарыг өгсөн байх ба мөн нэг тайлбар нь "ромын эрх зүйг рецепцилэх" гэсэн тайлбар. Мөн "ромын эрх зүйг ээлдэн авч нутагшуулах" гэсэн ойлголттой утга нэг гэсэн тайлбар байх ба энэ тайлбараас тодотгол хийвэл ерөнх дэлхийн эрх зүйн тогтолцооны хөгжил Ромын эрх зүйг европчууд рецепцилж авснаар эхэлсэн түүхтэй. Ромын эрх зүйг европ даяараа хүлээн авч улмаар өөрсдийн эрх зүйн тогтолцоондоо ээлдэн авч нутагшуулсан түүхэн үеийн эхлэл нь XI зууны сүүлчээр Италийн нэгэн номын сангаас илрүүлсэн Ромын Юстиниан хааны дэргэд бүрдүүлсэн хуулийн эмхэтгэлтэй холбоотой. Тэгэхлээр нэг улсын эрх зүйг бусад нь ээлдэн авч нутагшуулж болдгийн хамгийн сонгодог жишээг Европын улсууд нь дэлхийн бусад улс орнуудад тод томруун харуулсан байна. Эрх зүйн рецепцийн объект нь эрх зүйн тогтолцоо, түүний элементүүд болно. Үүнд: Эрх зүйн хэм хэмжээ ( хууль тогтоомж), эрх зүйн үзэл сургааль, эрх зүйн соёл, эрх зүйн эх сурвалж, бусад элементүүд хамаарч байна.*

*[5] Б.Чимид, Зохистой эрх зүйг баримжаалах нь эрх зүйн шинэтгэлийг үр нөлөөтэй хийх үндэс болох нь. Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо. Олон улсын симпозиум, 2000 оны 04 сарын 25-27.*

# ҮНДЭСНИЙ ЭРХ ЗҮЙН ХӨГЖИЛД ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН ҮҮРЭГ

**Н.Лүндэндорж**
*Философийн доктор*
*Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D)*
*МУИС-ийн профессор*



Дэлхийн улс орнууд эрх зүйн аль нэг бүлд багтах хэдий ч ив ижилхэн үндэсний эрх зүйн тогтолцоо гэж хаа үгүй гэдэг. Эрх зүйн олон тогтолцоо оршиж байгаа нь чухамхүү үндэстнүүдийн менталитет олон янз байгаатай шууд холбоотой байх. Үндэстнүүдийн менталитет олон янз байгааг бурханы хишиг гэхээс илүү байгаль, цаг агаар, иргэншил, соёл, арьс өнгө, улс төр, эдийн засгийн нөхцөл[1] дэлхийн бөс нутаг, өнцөг булан бүрд өөр өөр байдагтай холбоотой биззэ. Тэрхүү олон янз байдал нь танин мэдэхүйн анхдагч арга харьцуулалтын хараа хяналтад өртөж, харьцуулсан эрх зүй гэсэн эрх зүйн аналитик шинжилгээний арга[2] эрх зүйн шинжлэх ухаанд орон зай эзлэх шалтгаан болсон байна.

**Харьцуулсан эрх зүйн ач холбогдол:**

- тухайн үндэстний эрх зүйн онцлогийг тодорхойлох,
- хөжлийн чиг хандлага, давуу болон сул талаа олж харах,
- эрх зүйн соёлын солилцоо хийх
- үндэстнүүдийнэрхзүйнтогтолцоогтөгөлдөржүүлэх боломж бий болжээ.

Харьцуулсан эрх зүй хөгжөөгүй, түүний ололтыг ашиглаагүй үндэстэн эрх зүйн хувьд хөгжингүй байх боломж үгүй гэж үзэхэд өдгөө хүрчээ. Тийм учраас үндэсний эрх зүйн хөгжлийг харьцуулсан эрх зүйгээс ангид авч үзэх боломжгүй юм.

Монгол улс социалист эрх зүйн тогтолцооноос эх газрын эрх зүйн тогтолцоонд эргэж шилжих үйл явц эхлээд арав гаруй жил болж байна. Энэ он жилүүдэд харьцуулсан эрх зүйн ололтыг хэрхэн ашигласныг эргэцүүлэх оролдлого хийлээ.

Өдгөө дэлхий дахин эрх зүйн сонгодог ойлголт, нийтлэг үнэт зүйлс байгаа гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрөх хандлага руу явж байна. Гэхдээ үнэт зүйлийг ойлгох, хүлээн авахад өөрийн үндэстний эрх зүйн онцлог, мөн чанар, давуу болон сул талаа ойлгосон байх нь зүй ёсны шаардлага мөн.

Өөрийн эрх зүйн онцлогоо бүрэн танаагүй тохиолдолд бусдын эрх зүйг ойлгодог гэдэг нь ихээхэн эргэлзээтэй. Үндэсний эрх зүйн онцлогийг тодорхойлоогүй нөхцөлд бусдын эрх зүйтэй жинхэнэ ёсоор харилцах эрх нээгдээгүй, юуг зээлдэн нутагшуулах тухай ч сонголт хийх боломж үгүй билээ. Энэ нь үндэсний эрх зүйн онцлогоо тодорхойлоогүй нөхцөлд бусдын эрх зүйтэй харьцаж огт болохгүй гэсэн үг бас биш. Харилцаж болно. Гэхдээ үр нөлөөтэй харилцаа тогтоох магадлал байхгүй. Тухайлбал, манай улс XX зууны эхэнд өөрийн уламжлалт эрх зүйгээ феодалын хоцрогдсон эрх зүй гэж орхиод орос-зөвлөлтийн социалист эрх зүйг шууд хүлээн авч 70 орчим жил болсон. Зөвлөлтийн эрх зүй бидэнд юу өгсөн авсны тухайд эерэг, сөрөг олон зүйлийг нэрлэж болно. Харин үр нөлөөний тухайд болох юм их бий. Ямар ч байсан тэр эрх зүйн үлдэгдлээс түргэн салахыг хөгжлийн гол шалгуур өдгөө болгож байгаа нь үнэн юм.

Он жилүүдийн шалгуур даасан эрх зүйн хөгжингүй үзэл санаа, зохицуулалтын аргаас конвергенци хийх, зээлдэн нутагшуулах үзэгдэл чухамхүү харьцуулсан эрх зүйн хөгжлийн үр дүн юм. Хэрэв харьцуулсан эрх зүй бий болж хөгжөөгүй бол хөгжлийг товчилсон эрх зүйн хөгжлийн энэ үсрэлтийг хүн төрөлхтөн мэдэхгүй байх байсан билээ. Өнөөдөр харьцуулсан эрх зүйн ач холбогдол зөвхөн бага буурай орон ч гэхгүй аливаа улс орон эрх зүйн тэргүүний үзэл санаа, арга, механизмыг зээлдэн нутагшуулах үзэгдэл нийтлэг үзэгдэл болсон байна.Энэ үзэгдлийн үр дүнд үндэстнүүдийн эрх зүйн хөгжил асар их хэмжээр урагшилсан төдийгүй, дэлхий улс түмэн зарим салбарт эрх зүйн нэг хэлээр ярих алс хэтийн боломжийг ойртуулж байна гэж үзэж болох юм. Эрх зүйн рецепци буюу эрх зүйн тэргүүний үзэл санааг зээлдэн нутагшуулах үйл явцыг арга зүйн хувьд шийдвэрлэхгүй бол үндэсний эрх зүйн тогтолцоог эрлийзжүүлэх, тогтолцооны гажиг үүсгэх, улмаар эрх зүйн хомсдолд ч хүргэж болзошгүй сөрөг үр дагавартай байдаг. Өөрөөр хэлбэл, эрх зүй үйлчлэх орон зай, ахуй нь соёлын нөлөөтэйгээ зөрчилдөж, эрх зүйн хомсдолд хүрдэг. Эрх зүйн хомсдол бүхий улс оронд тэр орон зайг өөр зүйл эзэлж авдаг.

---

[1] Abel R. Comparative Law and Social Theory// The American Journal of Comparative Law.Vol. 26P. 219-224, 1978

[2] Kahn-Freund O. Comparative Law as an Akademic Subject. 82 law Quarterly Rev. 40,41, 1966

Тэр нь голчлон аль нэг гадаад орны, эсвэл удирдагчийн, олигархуудын хүсэл зориг байх жишээтэй. Энэ бол бага буурай олон орны туулж байгаа замаас харагдаж байгаа, дэлхийн судлаачдын хараа хяналтад өртсөн асуудал юм. Тэгэхлээр эрх зүйг үр нөлөөтэй байлгахын тулд үндэсний эрх зүйн онцлогийг тодорхойлох шаардлагатай гэсэн дүгнэлт шууд гарч байна.

Аливаа үндэстний эрх зүй бол тухайн үндэстний хэл, соёл шиг өөрийн гэсэн өнгө төрхтэй байх ёстой гэж харьцуулсан эрх зүй үздэг. Энэ өнгө төрхийг харьцуулсан эрх зүйн тусламжтайгаар тогтоодог. Монголчууд бид түүнийг тогтоосон уу, тогтоохын ач холбогдол бий юу гэсэн асуулт эндээс гарна. Бид үүнийг тогтоогоогүй байгаа, нөгөө талаас тогтоох хэрэгтэй гэж хэлмээр байна. Тогтоогоогүй байгаа нь олон шалтгаантай. Юуны өмнө тогтоох хэмжээнд эрх зүйн шинжлэх ухаан монголд хөгжөөгүй байна. Үүний улмаас эрх зүйн тухай бидний төсөөлөл ихэхэн хуучинсаг, марксист агуулгаас бүрэн салаагүй, эрх зүйг үндэстний менталитетад тулгуурласан оюун соёлын эх сурвалжтай, Ш.Монтескьегийн хэлснээр амин сүнстэй гэдгийг одоо ч бүрэн ухаараагүй байгаатай холбоотой.

Үндэсний эрх зүйн онцлогийг тодорхойлохын утга учир ач холбогдлыг бас зөв ухаарах ёстой. Зөвхөн монголоороо байх гэж тодорхойлж байгаа гэх эсвэл бусдаас юм зээлж авахдаа харгалзах гэсэн санаа ч гэж бас ойлгож болохгүй. Хамгийн гол зорилго нь өөрийгөө зөв ойлгох. Өөрийгөө зөв ойлгоогүй бол бусдыг зөв ойлгох нь юу л бол. Өөрийгөө зөв ойлгоогүй бол юу хэрэгтэй, юу болохгүйг олж харах нь юу л бол.

Монгол улс иргэний хуулийг ХБНГУ-аас зээлдэн нутагшуулж байгаа гэж хэлж болно. ХБНГУ-ын иргэний хууль бол хувь хүний эрх, эрх чөлөөг чиг баримжаа болгосон хөгжингүй хуулийн жишээ мөн байх. Гэтэл бид өөрийн эрх зүйн соёл, сэтгэлгээний онцлогийг тодорхойлоогүй учраас юу манайд тохирох эс тохирохыг мэдэхгүй зээлдэн нутагшуулалтыг хийж байгаа гэж үзэж болно. Үүнийг улмаас соёлын ялгаа гарч эрх зүйн үр нөлөө буурч байна. Жишээ нь, эдийн засгийн либерал бодлогын дагуу гэрээний эрх чөлөөт байдал, хувийн бие даасан байдал, нийгмийн тэнцвэрт байдлыг хангах, итгэл үнэмшлийг хамгаалах зэрэг бизнесийг дэмжсэн зохицуулалт Иргэний хуулийн 109.3, 114.1, 8.1.1, 189,5 зэрэгт туссан байна. Ялангуяа гэрээ байгуулагдсан гэж үзэх иргэний хуулийн зохицуулалт иргэншлийн нэлээд өндөр төвшний, хувь хүний өөрийн бие даасан үйлдлээс шууд хамааралтайгаар зохицуулсан бол монгол нийгэм, монголчуудын менталитет дахь хүй элгэний (община) сэтгэлгээний илрэл болох бие биеийн дотоод хэрэгт дур мэдэн оролцох, төрхөмсөн бие биеэ төлөөлөх, түүнийгээ нөгөө хүний эрхийг зөрчиж байна гэж үзэх бус харин элгэмсэг хандаж, тусалж байгаа сайхан сэтгэлгээний илрэл гэсэн үнэлэмж нь одоогийн иргэний хуулиар нөгөө хүнийгээ иргэний эрх зүйн хариуцлагад унагах, эсвэл бизнесийн алдагдалд оруулж байх жишээтэй.

Бид өөрийн эрх зүйн болон соёл, сэтгэлгээний онцлогийг харгалзалгүйгээр зээлдэн нутагшуулалт хийж байгаа баримт бол Эрүүгийн хууль юм. Манай улс эрүүгийн хуулийн ерөнхий ангийг ХБНГУ-аас зээлдэн авсан атлаа Эрүүгийн эрх зүйн тусгай ангийг ОХУ-ын хуучин марксист агуулгатай хуулийг зээлдэн авч байгаа нь нэлээд болхи рецепцийн тод жишээ мөн. Монголчуудын үндэсний эрх зүйн соёл, менталитетад ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий анги, тусгай ангид ОХУ-ынх таарч байна гэж арай хэлж болохгүй байх. Энэ бол харьцуулсан эрх зүйн ололтыг үл ашиглан, эрх зүйн өөрчлөлтийг таамгаар, мэргэжлийн бус аргаар хийх гэж оролдож байгаан тод жишээ мөн.

Энэ бүхэн бол үндэсний эрх зүйн онцлогоо судалж, тодорхойлоогүй байгаагаас үүдсэн зовлон бэрхшээл юм.

Нөгөө талаас гадаадын хуулийг зээлдэн нутагшуулж байгаа бол түүний нутагшилтийн үйл явцыг нухацтай ажиглан судалж байх ёстой билээ. Харин манай улсын тухайд хаанаас юу зээлдэн нутагшуулж байгаагаа ил тод хэлдэггүй, нутагшилтыг эрх зүйн социологийн онол, арга зүйд тулгуурлан судалдаггүй орхидгоос энэ зээлдэн нутагшуулалт биш, харин механик хуулбар болж хувирдаг талтай. Гадаадын хуулийг зээлдэн нутагшуулна гэдэг нь монголын хөрсөнд шинэ сортын ургамал тарьж ургуулахтай л ижил үйл явц. Энэ хичнээн нарийн арга ажиллагаа, технологи, уйгагүй хөдөлмөр шаардсан ажил байдгийг хүн бүр төсөөлнө. Гэтэл бид зээлдэн авсан болон авах гэж байгаа хууль дээрээ ингэж ажилладаггүй учраас тэдгээр хуулиуд нь нутагшдаггүй, нутагшаагүй болохоор бүрэн хэрэгждэггүй. Хэрэгждэггүй хуулийг хэрэгжүүлэх гэж зүтгүүлэх үйл ажиллагаа нь аяндаа хүчирхийлэл рүү халтиран орох хамгийн өндөр магадлал бүхий байдаг билээ. Тийм учраас зээлдэн нутагшуулалт бас ноцтой үр дагавартай гэдгийг санах ёстой билээ.

Харьцуулсан эрх зүйн ололтыг ашиглан үндэсний эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох, болзошгүй эрсдэлээс сэргийлэх боломжоотой. Үүний тулд дэлхий улс орнуудын эрх зүйн хөгжил, туршилгын судалгаа зохих төвшинд хийсэн байх учиртай. Гэтэл өдгөө манай оронд дэлхий улс орнуудын эрх зүйн хөгжил, туршилгыг бараг судлаагүй байна. Улмаар хөрш орнуудын эрх зүйг ч олигтой судлахгүй байгаа нь бидний дутагдал юм.

Ганцхан зүйлийг тодруулахад өдгөө манай улсад хууль тогтоох ажил эрхэлдэг төлөөлөгчдийн дээд байгууллага УИХ, түүний бүрэлдэхүүнийг улс төрийн намд эрх мэдлээ алдсан, үүний улмаас ард түмнийг төлөөлөх шинж нь буурсан тухай дээр доргүй ярьж, гайхаж суугаа нь үнэн билээ. Байдал ч бас ийм юм. Гэтэл нэр дэвшүүлсэн нам нь намын бодлого нэрээр парламентын гишүүнийг "дарамталдаг" энэ бохир аргыг шийдвэрлэх арга замыг аль хэдийн олчихсон билээ. Хамгийн ойрын жишээ дурьдахад манай хойт хөрш- ОХУ-ын Төрийн Думын регламентад бие даах нэр дэвшиж сонгогдсон гишүүд болон намын бүлэгт орохыг хүсээгүй

гишүүд тодорхой тоонд хүрвэл бие даасан депутатын хэсэг байгуулан, фракцийн эрхтэй ажиллах эрхийг нээсэн байдаг. Энэ бол улс төрийн намын хяналт, оролцоноос төлөөлөгчдийн дээд байгууллагын гишүүдийг чөлөөтэй ажиллуулах чухал механизм мөн. Үүнийг авч ашиглах тухай бид бодоогүй л байна. Энэ мэт зүйлийг харьцуулсан эрх зүйн ололтыг ашиглан зээлдэн нутагшуулаад байвал үндэсний эрх зүйн хөгжил эрчимтэй урагшлах нь гарцаагүй.

Хэдийгээр үндэсний эрх зүйн тогтолцоо бүр өөр өөрийн өнгө аястай хэдий ч түүнээсээ үл хамааран эрх зүйн үнэт зүйлсээр дамжин ойртох, нэжилсэх хандлага нэлээд тод ажиглагдах болжээ. Энэ бол харьцуулсан эрх зүйн хөгжлийн зүй ёсны түүхэн үр дүн мөн. Хаалттай нийгмээс нээлттэй нийгэмд шилжиж байгаа улс орны тухайд энэ асуудал бүр ч чухал юм. Тухайлбал, манай улс гадаад ертөнцтэй нээлттэй болсноор эрх зүйн янз бүрийн тогтолцоо бүхий улс орнуудтай тал бүрийн харилцаанд орж, эрх зүйн олон талын үр дагавар бүхий харилцаанд улам бүр оролцсоор байна. Гэтэл бидний тухайд эрх зүйн хэл, ойлголтын аппаратын тухайд шинэтгэх, нэгтгэх, эх хэл дээрээ зөв оноолт хийх зэрэг асуудал тулгарсаар байна. Жишээлбэл, АНУ-аас ирж лекц уншиж байгаа профессор **due process of law** гэсэн ухагдахууныг аксиом байдлаар шууд хэрэглэхэд монголын эрх зүйчид түүнийг маш удаан тайлбар хийсний дараа бага зэрэг ойлгож байх жишээтэй. Гэтэл эрх зүй хөгжсөн орнуудад **due process of law** гэсэн ойлголт нь **Rule of law**-ийн салшгүй хэсэг төдийгүй, эрх зүйн хэрэглээний тулгуур зарчим болсон байх жишээтэй. Гэтэл бид социалист эрх зүйн нөлөөгөөр процессийн эрх зүй өөрийн онолтой, **Rule of law**-ийн зарчим хэрэгжих хамгийн гол баталгаа гэдэгт итгэл үнэмшил болоогүй, түүнийг илэрхийлсэн аксиом байдаг гэдгийг мэдэхгүй байх жишээтэй юм.

Бас нэг өөр жишээ авахад "лиценз" гэсэн нэр томьёо байна. Энэ нэр томьёоны эрх зүйн нийтлэг утга нь тухайн ажил, үйлчилгээг эрхлэх мэргэжил, мэргэшлийн шаардлага хангасан этгээдэд олгох зөвшөөрөл мөн. Гэтэл бид үүнийг зөвхөн зөвшөөрөл гэж ойлгож, хуульчилснаас мод, чулуу хоёрыг ч муухан ялгадаг нөхдөд ашигт малтмал хайх зөвшөөрөл олгож, лицензийг иргэний гүйлгээний хэрэгсэл болгосон байх жишээтэй. Үүний хор нөлөөгөөр монголын ард түмний Үндсэн хуулиар хамгаалсан баялаг харийнхний гарт орж, улмаар үндэсний аюулгүй байдал ч хөндөгдөхөд хүрээд байгаа билээ. Энэ бол харьцуулсан эрх зүйн ололтоор дамжуулж үндэсний эрх зүйн хэл болон ойлголтын аппратыг хөгжүүлэх боломжоо, шаардлага тулгарсныг гэрчилнэ.

Харьцуулсан эрх зүйн ачаар үндэсний эрх зүйн онолын сэтгэлгээг хөгжүүлэх, дэлхийчлэх боломжоо байна. Харьцуулсан эрх зүй бол эрх зүйн аливаа ололтыг тодруулагч, түгээн дэлгэрүүлэгч юм.

Хүн төрөлхтөн харьцуулсан эрх зүй гэдэг эрх зүйн аналитик арга зүйг хөгжүүлээгүйсэн бол эрх зүйн соёлын солилцоо ийм хэмжээнд дэлхий дахинд хөгжихгүй байсан нь лавтай. Бидний тухайд харьцуулсан эрх зүйг судлагдахуун болгож хууль зүйн их, дээд сургуульд зааж эхлээд арваад жилийн нүүр үзэж байна.

Харин харьцуулсан эрх зүйг эрх зүйн танин мэдэхүйн нэг гол арга болох хувьд нь иж бүрнээр судалгаанд болон практикт ашиглах, хэрэглэх явдал хангалтгүй байна. Энэ нь зөвхөн судлаачдын хэрэг биш юм.

Өдгөө харьцуулсан эрх зүй судлалд шинжлэх ухааны харьцуулалтаас илүү практик хэрэглээний харьцуулалтын ач холбогдол улам бүр өсөж байна. Ялангуяа хууль тогтоогчид улам бүр нарийсан хөгжиж байгаа нийгмийн харилцааг оновчтой зохицуулах гарцыг харьцуулсан эрх зүйн туршилгад тулгуурлан шийдвэрлэх өргөн гарц, боломжоо бий болсон байна.[3] Харин түүнийг ашиглаж сурах явдал нэн чухал байна. Тухайлбал, үндэсний эрх зүйн салбар хоорондын харьцуулалтыг ч бид хийж сураагүй учраас хуулиуд маань зөрчилдөөний цуглуулга болоход хүрээд байна. Зах зухаас нь дурьдахад эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй холбоотой 40 гаруй зүйл заалт бусад хуулиудтай илэрхий зөрчилдөөнтэй байсаар байгааг судлаачид[4] тогтоосон байна.Өөрөөр хэлбэл, эрүүгийн хуульд **гэмт хэрэг** гэж үзэж байгаа зүйл бусад хуулиудад **захиргааны зөрчил** болон хувирч эрс өөр санкцтай байх жишээтэй. Жишээлбэл, Эрүүгийн хуулийн 117.1-д төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдээ хаясан, төөрүүлсэн бол 251-300 цаг албадан ажил хийлгэх, эсхүл 3-6 сар хүртэл хугацаагаар баривчлах **ял** ногдуулахаар заасан бол Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 25.8-д төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдээ хаясан, төөрүүлж орхисон иргэнийг **захиргааны зөрчилд** тооцон 50000 мянган төгрөгөөр торгох, эсхүл 30 хүртэл хоногоор баривчлах шийтгэл ногдуулсан байх жишээтэй. Энэ мэтийг манай хуулиудаас үй олноор олох боломжоотой. Энэ бол харьцуулсан эрх зүйн арга, ололтоос бид хичнээн хол байгаагийн тод жишээ мөн.

Харьцуулсан эрх зүйн аргыг шүүхийн практикт хэрэглэхийн ач холбогдол улам бүр өсөж байна. Шүүгч шийдвэрийн үндэслэлээ гаргахдаа харьцуулсан эрх зүйн аргыг ашиглан хуулийг тайлбарлах нь хуулийн хийдлийг арилгах, шүүхийн шийдвэрийн үндэслэлд талууд эргэлзэх эргэлзээг багасгах, шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх улмаар шүүх эрх мэдлийг бэхжүүлэхэд нэн чухал үүрэгтэй. Энэ бас л биднээс санаачилга, боловсрол, хөгжил шаардсан, ашиглах ёстой боломжоо байсаар байна.

Тэгэхлээр, үндэсний эрх зүйн үзэл санаа болон хэрэглээний практикт ч харьцуулсан эрх зүйн ололтоос өдгөө ангид биш болжээ. Тийм учраас харьцуулсан эрх зүйн ололтыг хэрхэн ашиглаж байгаагаар үндэсний эрх зүйн хөгжлийг хэмжих нь зүйд нийцнэ хэмээн бодож байна

[3]Цвейгерт К. Введение в сравнительное правоведение в сфере частного права. М, 1998, с. 15

[4]Эрдэнэбат Г. "Nullum crimen sine lege" зарчмын социалист хуваабараас үүдэлтэй зөрчил//Эрх зүй сэтгүүл, 1/2007(15), 83-114 талаас үзнэ үү

## ШИХИХУТУГ ХЗДС-ИЙН ТӨГСӨГЧИД, БАГШ, ОЮУТНЫ "ЧАНДМАНЬ ХОЛБОО" АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТАНД МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА, ТУС СУРГУУЛИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, МОНГОЛ УЛСЫН ГАВЪЯАТ ХУУЛЬЧ, ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР, ПРОФЕССОР Д.ЛУНДЭЭЖАНЦАНГИЙН ХЭЛСЭН ҮГ

Хуульч мэргэжилтэн бэлтгэдэг Монгол Улсын хувийн хэвшлийн ууган дээд сургууль **Шихихутуг ХЗДС**-ийн үе үеийн төгсөгчид, профессор, багш нар, оюутан, магистрантуудын төлөөлөгчид Та бүхэндээ энэ сургуулийн үүсгэн байгуулагчийн хувьд, Монгол Улсынхаа хууль тогтоох дээд байгууллага - УИХ-ын даргын хувьд, хуульч мэргэжилтэй багш хүнийхээ хувьд **чин сэтгэлийн халуун дотно мэндчилгээ дэвшүүлье.**

Одоогоос 17 жилийн өмнө өөрийн биеэр үүсгэн байгуулалцаж, анхных нь хичээлүүдийг зааж байсан энэ сургууль өнөөдөр хууль зүйн шинжлэх ухааны олон салбараар бакалавр, магистрын зэрэгтэй өндөр мэргэжлийн хуульч боловсон хүчнийг бэлтгэдэг дээд боловсрол, эрдэм шинжилгээний томоохон төв болтлоо хөгжиж, төгсөгчдийнхээ анхны чуулга уулзалтыг зохион байгуулж байгаад сэтгэл нэн ханамжтай байна.

Шихихутуг ХЗДС-ийн үе үеийн төгсөгчид улс орондоо хууль зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэх, эрх зүйн шинэтгэлийг эрчимжүүлэх, эрх зүйт төрийг төлөвшүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах, олон нийтэд хууль зүйн үйлчилгээ үзүүлэх зэрэг олон чиглэлээр үр дүнтэй ажиллаж, төрөлх сургууль, эрдэмтэн багш нарынхаа нэр төрийг өндөрт өргөж явдагт би гүнээ талархаж байдагаа илэрхийлье.

Цаашдаа энэ сургуулийн эрдэмтэн багш нар, одоо суралцаж байгаа болон ирээдүйд элсэн суралцаж, хуульч мэргэжилтэн болох олон мянган залуучууд ахмад үеийнхээ эхлүүлсэн сайн үйл хэргийг нэр төртэй үргэлжлүүлж, улс орныхоо хөгжил цэцэглэлт, хууль зүйн шинжлэх ухаан, эрх зүйт төрийн төлөвшилд урьд урьдынхаасаа илүү үүрэг гүйцэтгэнэ гэдэгт миний бие бүрэн дүүрэн итгэж байна.

**Багш, шавь, төгсөгч** гэсэн үүрдийн гурван субъектийн "Чандмань холбоо"-гоор бэлгэдэн нэрлэсэн төгсөгчдийн анхдугаар чуулга уулзалт Шихихутуг ХЗДС-ийн тулгын гурван чулууны өнө мөнхөд орших хүйн холбоог бататган бэхжүүлж, сургуулийнхаа цаашдын гэгээн саруул ирээдүйг оновчтой зөв тодорхойлоход чухал хувь нэмэр оруулна гэдэгт эргэлзэхгүй байна.

Шихихутугийн эрдмийн их өргөө ном, шавь, багш гурваар цаг үргэлжид бялхан цалгиж байх болтугай.

**Багш, шавь, төгсөгчдийн "Чандмань холбоо" үеийн үед өргөжин тэлж, батжин хөгжих болтугай.**

Чуулга уулзалтын үйл ажиллагаанд амжилт хүсье.

Та бүхэндээ эрүүл энх, эрдэм ухаан, аз жаргалын эрхэм дээдийг ерөөе.

## ШИХИХУТУГ ХЗДС-ИЙН ТӨГСӨГЧИД, БАГШ, ОЮУТНЫ "ЧАНДМАНЬ ХОЛБОО" АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТАНД ШИХИХУТУГ ХЗДС-ИЙН ЗАХИРАЛ, ДЭД ПРОФЕССОР, Д.ОЮУНЦЭЦЭГИЙН ТАВЬСАН ИЛТГЭЛ

Хүндэт зочид төлөөлөгчид өө
Эрхэм хүндэт төгсөгчид өө,
Профессор багш нараа,
Оюутан залуучуудаа

Он цагийн элэлд хүний амьдрал хэдхэн арван жилээр тоологдох ахархан боловч хүмүүний сэтгэлгээ, түүний бүтээлч чанар зуун зуун жилээр дуурсагдах түүхэн үнэнийг цогшлуулдаг. Цаг хором бүрээр энэ үнэнийг бичилцэн, цааз эрхэмжийн орон зайд баларшгүй ул мөрөө үлдээсээр Шихихутугаар овоглосон эрдмийн өргөө эдүгээ 17дахь жилтэйгээ учран золгож байна.



Хүмүүн өөртөө мэдлэг хуримтлуулах нь хувь хүний хүчин чармайлттай холбоотой бол хүмүүнд мэдлэг түгээх нь улс орны хөгжилтэй шууд уялдаатай. Чухам энэ л утгаар "**Гэрэлтэхгүй юм бол гэгээрээд яахав**" хэмээх мэргэн үг гарсан билээ. Төрөөс хүнийг нийгэмшүүлэх, гэгээрүүлэх тэр л ачаанаас үүрэлцэн өнөөдрийг хүрэхдээ өөрийн эрхээс илүү бусдын эрхийг хүндэтгэн хамгаалдаг мэргэжил болсон, хуульч-эрх зүйчдийг бэлтгэн гаргаж байдагтаа бид сэтгэл хангалуун байгаа билээ.

**"Төгсөгчид манай брэнд, төгсөгчид манай бахархал" гэж бид цаг ямагт бодож, эрхэмлэж явдаг юм.**

Төрүүлсэн үрээ хайрлан өсгөх нь эх үрийн ариун холбоо, төгсгөсөн мэргэжилтнээ халамжлан хөгжүүлж, хамтран ажиллах нь эрдэм оюуны чандмань холбоо мөн. Энэ томъёоллыг санан байж, эрхэм зорилгыг өмнөө тавьж "**Чандмань холбоо**" нэртэй төгсөгчдийн анхдугаар чуулга уулзалтыг өнөөдрийн өлзий учрал бүрдсэн энэ өдөр зохион байгуулж байна.

Хүн төрөлхтний жам ёсны хөгжлийн чиг баримжааг бидэнд мэдрүүлсэн 1990-ээд оны эхээр бидний хэдэн нөхөд айсуй цагийн өнгө төрхийг шинэ цагийн боловсрол шийдвэрлэнэ гэдгийг ухаарч, тус сургуулийг үүсгэн санаачилсан билээ. Бидний энэ санаачлагыг дэмжиж тухайн үеийн БНМАУ-ын Хууль зүйн сайд асан, одоо Монгол Улсын гавьяат хуульч, академич Ж.Амарсанаа, БНМАУ-ын Боловсролын яамны тэргүүн дэд сайд асан, академич Б.Энхтүвшин нарын гарын үсэг зурсан "Хууль зүйн хувийн дээд сургууль байгуулахыг зөвшөөрсүгэй" гэсэн шийдвэрийг 1991 оны 10 дугаар сард гаргажээ.

Үүгээр манай сургуулийн түүхийн эхний хуудас нээгдэж, эдүгээ сургалт судалгааны нэгэн томоохон төв болон өсч өндийлөө.

Манай сургуулийг анхлан нээх тусгай зөвшөөрлийг олгосон академич Ж.Амарсанаа, Б.Энхтүвшин нар болон өнөөгийн Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаа, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд М.Төрбаяр нарын хүндэтэй зочид бидний чуулга уулзалтад хүрэлцэн ирж оролцож байгаа явдалд чуулга уулзалтын нийт оролцогчдын нэрийн өмнөөс чин сэтгэлийн баяр хүргэж, ажлын их амжилт хүсэн ерөөе.

Сургууль маань анх байгуулагдаж байх үедээ тэр үеийн Төр эрхийн хүрээлэн, Техникийн Их Сургуулийн хичээлийн байрнаас нэг нэг өрөөг түрээслэн үйл ажиллагаагаа эхэлж байсан бол өдгөө өөрийн гэсэн эрдмийн тохилог өргөөтэй боллоо. Сургууль анхан шатны магадлан итгэмжлэлээс эхлэн ахисан түвшингийн магадлан итгэмжлэлийг хийлгэн шалгуурыг амжилттай давсан зэрэг улиран өнгөрсөн он жилүүдэд тоочиж ярих амжилт бүтээл багагүй хуримтлуулжээ. Энэ бол сургалт, хүмүүжлийн бүхий л үйл явцад "багш-шавь-ном" гурвыг шүтэн барилдуулж, шинжлэх ухааны шим, утгын гүнрүү тэмүүлэх сэтгэлгээг ямагт урьтал болгож байсны ач, үр өгөөж гэж хэлж болно.

**Аливаа их, дээд сургуулийн тулгуур хүч, шинжлэх ухаанд уриалан дуудагч, гүйцэтгэн хөтлөгч нь багш нар мөн.**

Сургуулийн хичээлийн жилийн анхны өдрөөс эхлэн мэргэжлийн болон ерөнхий эрдмийн хичээлийг зааж оюуны хүч мэдлэг, хөрөнгө оруулалтаа харамгүй зориулж ирсэн нэрт эрдэмтэд, хуульчид, улс төрчид, олон бий. Тухайлбал Академич С.Нарангэрэл, Хууль зүйн шинжлэх ухааны доктор профессор Г.Совд, Л.Баасан, С.Жанцан, Хууль зүйн ухааны доктор профессор, Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж, Ж.Бямбаа, Т.Мөнхжаргал, эдийн засгийн ухааны доктор, профессор Б.Түмэн, хэл шинжлэлийн ухааны доктор профессор Дамдин, Монгол улсын гавьяат хуульч Н.Чинбат, Удирдлагын Академийн сургалтын төвийн эрхлэгч дэд профессор Р.Эрдэнэбаатар, Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Р.Оттонбаатар нараар ямагт

бахархан баярлаж явдгаа илэрхийлж, гүн талархал дэвшүүлье.

Бидний хүндтэй анхны багш нараас Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн анхны дарга, Монгол улсын гавьяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Г.Совд, хууль зүйн шинжлэх хааны доктор, профессор С.Төмөр, доктор, профессор Ү.Чимид, Б.Шаравнямбуу, доктор Б.Түмэн, УИХ-ын гишүүн асан, өмгөөлөгч Г.Ганболд, ахмад дипломатч О.Хосбаяр, М.Дүгэрсүрэн, түүнчлэн манай ахмад ажилтан И.Дугарсүрэн, Э.Нямаа нар ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн хэдий ч хамтран зүтгэгчид, тэдний олон зуун шавь нар үеийн үед дурсаж явах болно. Эдгээр эрхэм хүндтэй, алдар цуут багш, ажилтан нарынхаа гэгээн дурсгалыг босч хүндэтгэцгээе.

Олоо манай багш нар насны хувьд ч, эрдмийн зэрэг цолны хувьд ч ахмад-дунд-залуу үеийн жинхэнэ хослол болж байгаа юм. Мэргэжлийн тухайлбал, төр эрх зүйн тэнхимийн хийгээд магистрын сургалтын албаны эрхлэгчээр Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, Монгол Улсын гавьяат хуульч, ахмад багш Осорын Амархүү, Ерөнхий эрдмийн тэнхимийн эрхлэгчээр Академич, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Жигжидийн Болдбаатар нар ажиллаж байна.

Сургуулийг үүсгэн байгуулагч Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, Монгол Улсын гавьяат хуульч Д.Лүндээжанцан, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, Удирдлагын Академийн тэнхимийн эрхлэгч Ч.Энхбаатар нар төр, засгийн ажлын их ачааллынхаа зав чөлөөгөөр сургалт эрдэм шинжилгээний ажилд идэвхитэй оролцсоор байна.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Л.Баасан, доктор профессор Т.Мөнхжаргал, философийн ухааны доктор, профессор С.Цэдэндамба, доктор, профессор Ч.Даваадаш, Монгол Улсын гавьяат хуульч, анхны эмэгтэй хурандаа Р.Оюунбадам, сургалтын албаны даргаар ажиллаж байсан орос хэлний ахмад багш, боловсролын тэргүүний ажилтан, дэд профессор Г.Уламбаяр, англи хэлний ахмад багш, боловсролын тэргүүний ажилтан, дэд профессор Р.Цэндсүрэн нар шавь нарынхаа хүндтэй багш нар байсаар байна.

Профессор профессорыг төрүүлдэг гэдэг. Үнэхээр профессор багш нарын гараар бэлтгэгдсэн залуу багш нар ирээдүйн хуульч профессоруудыг бэлтгэх гинжин холбоосыг тасалдуулахгүйгээр шамдан ажиллаж байна. Манай дунд болон залуу үеийн багш нар бүгд магистр зэрэгтэй. Зарим нь удахгүй докторын зэрэг хамгаалах гэж байна. Сургалтын албаны эрхлэгч, боловсролын тэргүүний ажилтан, ахлах багш Д.Отгонтуяа, эчнээ сургалтын эрхлэгч, магистрын сургалтын албаны нарийн бичгийн дарга, хууль зүйн албаны тэргүүний ажилтан, ахлах багш С.Оюунбилэг, түүнчлэн ахлах багш Ц.Цэлмэг, Г.Амаржаргалан, Ж.Наранпүрэв нар 10 ба түүнээс дээш жил багшилж байна. Энэ бүхнийг дурьдахын учир гэвэл эрхэм оюутан төгсөгч та нар маань чухам ямар сайхан нэрт хүмүүсийн эрдэм оюуны арвин их сангаас хүртэж явсан, одоо ч хүртэж буйг нүдэнд харагдтал, сэтгэлд хадагдтал дахин нэг цохон тэмдэглэх гэсэн юм.

**Сургуулийн маань гол хараа түшиг, номын далайд цаг хормоор таниг мэдэхүйн баяслыг амсан эрдэм оюунд хичээнгүйлэн суралцагч асар том хүчин бол оюутан залуус та нар билээ.**

Өнөөдрийн байдлаар манай сургуульд нийтдээ 600 гаруй оюутан эрдэм номын ширээнд тохой нийлүүлэн суурцгааж байна. Оюутнуудад маань бахархан тэмдэглэх сайхан үйлс олон бий. Оюутнуудын 35 орчим хувь нь А, В үнэлгээтэй суралцаж байна.

Оюутнуудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Эврика" эрдэм шинжилгээний бага хурал, мөн Улсын дээд шүүхээс зарласан онол, практикийн бага хурал зэрэг 9 уралдаан тэмцээнүүдэд дөрөвдүгээр дамжааны оюутан Э.Мөнгөнзалаа, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойд зориулсан болон **"Leader-2006"**, Хууль зүйн үндэсний төвөөс зарласан **"Эрх зүй ба хөгжил"** зэрэг эрдэм шинжилгээний удаа дараагийн бага хуралд дөрөвдүгээр дамжааны оюутан П.Баянбаатар нар тус бүр нэгдүгээрээс тусгай байрын шагналд шалгарч байв. Мөн оюутан Н.Даваажанцан, П.Түвшинтөгс, Б.Эрдэнэбат, С.Батбуян нарын зэрэг хэд хэдэн оюутан эрдэм шинжилгээний бага хурлуудад нэг бус удаа амжилттай оролцож байна.

Хичээл, сургалтын зэрэгцээ урлаг, спортын уралдаан тэмцээнд амжилт гаргаж яваа оюутан манайд цөөнгүй байдаг юм. Дөрөвдүгээр дамжааны оюутан, Морин хуурын чуулгын хөгжимчин Д.Альяабазар өнгөрсөн жил Соёлын тэргүүний ажилтан цол, тэмдэг хүртлээ. Нэгдүгээр дамжааны оюутан, Олон улсын шатрын холбооны мастер Б.Гүндаваа саяхан болсон Дэлхийн оюутны аварга шалгаруулах тэмцээнээс багаараа хүрэл медаль авлаа. Энэ мэтчилэн манай сургууль бууддлагын спортын мастер Б.Очирхуяг, Үндэсний сурын спортын мастер Б.Отгонболд, чөлөөт бөхийн спортын мастер Б.Баттулга, дэд мастер Ч.Жамъян, жудо бөхийн спортын дэд мастер Т.Түвшинтулга нарын зэрэг авъяаслаг оюутнуудаараа бид бахархдаг билээ.

Сурлага, урлаг, спортын амжилтаар бусдыгаа хошуучилж яваа нэр бүхий оюутнууд болон нийт оюутан залуусдаа энэхүү чуулга уулзалтыг тохиолдуулан баяр хүргэж, их амжилт хүсье.

**Та бидний чандмалсан холбооны нэг гол багана нь яах аргагүй төгсөгчид минь билээ. Өнөөдрийн чуулга уулзалт ч төгсөгчдийн гэсэн тодотголтой. Төгсөгчдөөрөө бахархахгүй юм бол сургууль өөр юугаараа бахархах билээ.**

Сургууль өнөөдрийг хүртэлх хугацаандаа өдрийн ангийн **12 дахь,** эчнээ ангийн **9 дэх,** магистрын сургалтын **5 дахь** төгсөлт хийж нийт **700** гаруй эрх зүйчдийг бэлтгэн гаргаж, монголын хуульчдын эгнээг өргөжүүлэхэд өөрийн зохих хувь нэмрийг оруулсаар байна.

Манай олон арван төгсөгчид мэргэжлийнхээ дагуу практик үйл ажиллагаанд, тухайлбал хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, хуулийн зөвлөхөөр нэр төртэй ажиллаж байна. Үүнийг тоон үзүүлэлтээр дурьдвал: Манай төгсөгчдийн **43 хувь** нь төрийн байгууллагад ажил алба хашиж байгаагийн дотор **5 хувь** нь шүүх эрх мэдлийн байгууллагад, **9 хувь** нь прокурорын байгууллагад, **6 хувь** нь гаалийн байгууллагад, **10 хувь** нь цагдаагийн байгууллагад, **13 хувь** нь төрийн бусад байгууллагад ажиллаж байна. Үүнээс гадна их, дээд сургуульд **26 төгсөгч багшилж,** хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид захирал, гүйцэтгэх захирлын албан тушаалаас эхлээд **бусад ажилд 17,** арилжааны **банкуудад 9, төрийн бус байгууллагад 13,** олон улсын байгууллагад ч манай төгсөгчдөөс ажиллах боллоо.

Сургуулийнхаа нэр төрийг өндөрт өргөж яваа олон зуун төгсөгчдөөсөө нэр цохон зарим нэгийг дурьдвал, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, ХЗДХЯ-ны газрын орлогч дарга Ж.Майзориг, Увс аймгийн прокурор Ц.Насанбат.Өмнөговь аймгийн ерөнхий шүүгч С.Энхтөр, Булган аймгийн ерөнхий прокурор С.Энхбат, Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны газрын дарга Э.Ганбат, ШШБЕГ-ын тамгын газрын дарга М.Баттогтох, Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын орлогч дарга Б.Амар, MCS Холдингийн бизнес захирал Д.Батжаргал, Монголын үндэсний олон нийтийн телевизийн "MN" агентлагийн захирал Д.Энхтуяа, "Дарьзагд" ХХК-ны захирал Д.Алъяахүү, "Сүхбаатар принтинг" ХХК-ны захирал П.Баатарсүрэн, "Мөнхийн тун" ХХК-ны захирал Д.Батхишиг нарын зэрэг хүмүүсийг нэрлэж болно. Мөн төгсөгч Д.Чилхаажав Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр бүрэн эрхийн хугацаанд ажиллаж байлаа. Төгсөгчдөөс маань одоо **Улсын Их Хурлын Тамгын газарт 4, Хууль зүй, дотоод хэргийн яаманд 3 хүн** хариуцлагатай алба хашиж байна.

Мэргэжлийн болон бизнесийн үйл ажиллагаанд хүчээ сорьж, амжилт бүтээл гаргаж яваа төгсөгчиддөө баяр хүргэж улам их амжилт гаргахыг хүсэн ерөөе.

Манай төгсөгчдөөс олон хүн шинжлэх ухаан, судалгааны ажилд хүч тэнхээгээ үзэж, оюуныхаа чадавхийг энэхүү үйл хэрэгт зориулж, Монголын боловсролын хөгжилд багагүй хувь нэмэр оруулсаар байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй гэж бодож байна.

1998 онд манай сургуулийг онцсайн төгссөн А.Алтанзул ОХУ-ын Кубаны Их сургуульд 2006 онд хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан. 1997 оны төгсөгч Д.Үүрцайх ХБНГУ-ын Бонны Их сургуульд хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалаад одоо мөн сургуулийн докторантурт үргэлжлүүлэн суралцаж байна. Төгсөгч Э.Мөнхболд ОХУ-ын Дотоод явдлын яамны академид, Ц.Цэлмэг, М.Батсуурь, Ч.Өнөрбаяр, нар Монгол Улсын Их сургуулийн докторантурт тус тус амжилттай суралцаж байна. Хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан хэдэн арван төгсөгчид байгаагийн дотор гадаад орнуудад тухайлбал: Австралийн Сиднейн Их сургууль, Японы Нагоягийн Их Сургууль, Кейеогийн Их сургууль, Шинэ Зеландын Виктория Вилингтоны Их сургууль, Унгарын Төв Европын Их сургуульд манай төгсөгчид магистрын зэрэг хамгаалжээ.

Одоо манай төгсөгчдөөс гадаад, дотоодын их, дээд сургуульд олон хүн хууль зүйн ухааны магистрантурт суралцаж байна.

Эрх зүйч мэргэжлээр бакалаврын зэрэг олж авахаар Шихихутуг ХЗДС-ийн эчнээ ангид Анагаах ухааны доктор С.Түндэврэнцэн, Биологийн ухааны доктор Т.Оюунчимэг нар элсэн суралцаж амжилттай төгссөн юм. Доктор С.Түндэврэнцэн өдгөө энэ сургуульдаа шүүх эмнэлэг, шүүхийн сэтгэл судлалын хичээлүүдийг зааж байна. Эдгээр баримт тус сургуулийн нэр хүнд, олонд танигдсан байдлыг илтгэсэн нэг үзүүлэлт гэж үнэлж болно.

Төгсөгчдийн маань оюуны хүч тэнхээг харуулсан өөр нэг баримтыг би энд тэмдэглэн хэлэхийг хүсэж байна. Манай төгсөгчдөөс 26 нь хуулийн их, дээд сургуульд багшилж байгааг дээр дурдсан. Тэдгээс хоёр нь Монгол Улсын Их Сургуулийн Хуулийн сургуульд, хоёр нь Санхүү, Эдийн засгийн дээд сургуульд гэх зэргээр Монгол улсын нэр хүндтэй сургуулиудад багшилж байгаа юм.

Төгсөгчдөөс маань өнөөдрийн байдлаар **11 нь** нэг сэдэвт зохиол, сурах бичиг, гарын авлага, орчуулгын зэрэг **27 ном** бичиж хэвлүүлэн нийтийн хүртээл болгожээ. Энэ бол боловсролын хөгжилд оруулж буй оюуны томоохон хөрөнгө оруулалт мөн.

Бүтээл туурвигчдын дотор манай анхны төгсөгчдийн нэг, багш Ц.Цэлмэг эрх зүйн сэдэвт 8 ном, мөн төгсөгч Ц.Минжин төр, эрх зүйн түүхэн сэдэвт "**Их гүрний сод хүмүүс**" томоохон таван цуврал боть хэвлүүлж бусдыгаа хошуучилж явна.

Оюуны хөрөнгө оруулалт, шинжлэх ухаан, судалгаа, сургалтын ариун үйлсэд хүч тэнхээгээ зориулж яваа төгсөгч шавь нартаа халуун баяр хүргэж, улам ихийг бүтээх "ном дор мөргөмү", "номын буян дэлгэртүгэй" гэсэн ардынхаа сайхан ерөөлийг өргөн дэвшүүлье.

Төгсөгчдийн дотор сонирхолтой, бас сайхан гэж хэлж болох нэгэн зүйлийг Та бүхнийхээ сонорт хүргэе.

Юу гэвэл, аав, ээж нь эчнээ ангийг дүүргэсэн бол охид, хөвгүүд нь өдрийн ангид суралцаж төгссөн, ээж хүү хоёул магистрын сургалтыг амжилттай дүүргэж, хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан, нэг үгээр хэлбэл гэр бүлээрээ манай төгсөгчид болсон тийм эрхэм баримт нэг бус байдаг гэдгийг цохон хэлэх гэсэн юм.

Төгсөгчдийн маань энэ сайхан ололт амжилтууд түүхэн өнгөрсөн цаг хугацааных биш, одоо үргэлжилж байгаа, ирээдүйд ч хөврөн цувах гурван он цагийн хэлхээс гэж үзэж байна.

Манай төгсөгчид сургуулиа төгслөө, одоо баяртай гэж цааш харчихдаг хүний мөс чанар дорой жудаггүй хүмүүс огт бишээ. Тэд сургууль, багш нартайгаа байнгын харилцаа холбоотой байдаг. Бид үүнд баярлаж явдаг юм. Олон жилийн өмнөөс байгуулагдсан ***"Төгсөгчдийн холбоо"*** түүний удирдах бүрэлдэхүүнд ажилладаг 10 гаруй шавь минь үнэхээр бахдалтай ажиллаж байна. Төгсөгчдийн холбоог тэргүүлдэг Цагдаагийн хурандаа Н.Одон холбоогоо олон талын санаачлагатай, зохион байгуулалт, идэвхи зүтгэл, эв нэгдэлтэйгээр удирдан зохицуулж, сургуулийн материаллаг баазыг бэхжүүлэх, сургалт хүмүүжлийг ахиулах, сургууль, хамт олноо сурталчлах, онол, практикийн бага хурал зохиох, сургуулийнхаа 10, 15 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд зохих туслалцаа дэмжлэг үзүүлэх зэрэг бодит ажил олныг өрнүүлсээр ирснийг сэтгэл дүүрэн тэмдэглэж байна.

Багш, оюутан, төгсөгчдийн чандмань холбооны өнгөрсөн түүх, өнөөгийн амьдралаас баримт сөхөж, нэр зааж товчхон дурдахад ийм байна. Одоо бидэнд маргааш руугаа ирээдүй өөдөө харж чандмань холбооныхоо зорилтыг тодорхойлох нь юу юунаас эрхэм чухал билээ. Чухам энд л тус чуулга уулзалтын арга хэмжээний утга учир оршино.

**Бидний зорилт бол юуны өмнө:**

**1.Шихихутуг ХЗДС-ийн нэр хүндийг ямагт өндөрт өргөж, эх орныхоо хийгээд дэлхийн боловсролын орон зайд өөрийн гэсэн байр суурийг эзлэх,**

**2. Төгсөгчид нь сургуулиа дэмжин ажиллах, сургууль нь төгсөгчдөө тасралтгүй хөгжүүлдэг хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах, үүнийг тунгаан ухаарах нь энэхүү чуулга уулзалтын нэг зорилт гэж үзэж байна.**

**3. Мэдээлэл, технологийн эрчимтэй хөгжлийн өнөөгийн зуунд бидний нэг эрхэм зорилт бол сургалт, хүмүүжил, эрдэм шинжилгээ судалгааны ажлын чанарын үзүүлэлтүүдийг бүхий л үйл ажиллагааныхаа шалгуур болгох явдал юм.**

Төгсөгчид маань сургуулиа дэмжих, сургууль нь төгсөгчдөө байнга хөгжүүлэх эргэх холбоо бүхий бидний хамтын ажиллагаа шинэ шинэ арга хэлбэрээр цаашид улам өргөжиж баяжина гэдэгт итгэл дүүрэн байгаагаа илэрхийлье. Энэхүү ялдамд, **"Чандмань холбоо"** анхдугаар чуулга уулзалтыг тохиолдуулан, түүний ач холбогдлыг үнэлж, өөрийнхөө байгууллагад амжилт, бүтээлтэй ажиллаж байгаа манай төгсөгчдийг болон манай сургуулийн зарим багш нарыг байгууллагынхаа нэрийн өмнөөс шагнаж урамшуулж буй Улсын Их Хурлын Тамгын газар, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам, Хууль Зүй дотоод хэргийн яам, Улсын дээд шүүх, Хууль зүйн үндэсний төв, Удирдлагын ухааны академи, Монгол Улсын Их сургуулийн Хуулийн сургууль, Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сурогууль, MCS Холдинг, Нотариатын танхим, Өмгөөлөгчдийн холбоо, Санхүү эдийн засгийн дээд сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Монголын лектор төв зэрэг төр, захиргаа, их дээд сургууль, бизнесийн байгууллага, тэдгээрийн удирдлага, хамт олонд Шихихутуг ХЗДС-ийн захиргаа, оюутан, эрдэмтэн багш нар болон нийт ажилтан, ажилчдынхаа нэрийн өмнөөс, мөн хувиасаа гүн талархал илэрхийлье.

Зорилтоо амжилттай шийдвэрлэхийн тулд юуны өмнө сургалтын шинэ арга зүйг нэвтрүүлэх ажил удаашралтай, номын сангийн номын тооны хүрэлцээ дутмаг, уншлагын танхимын суудал цөөн, багш нарын хүчин чармайлт харилцан адилгүй, оюутнуудад үзүүлэх анхаарал халамж багадах, зарим оюутны сурах хүсэл эрмэлзэл, идэвхи чармайлт, соёл үгүйлэгдэх, төгсөгчдөөс хуульчийн сонгон шалгаруулалтын шалгуурыг хангаагүй хүмүүс ч байгаа зэрэг дутагдал, доголдлыг даван туулах зайлшгүй шаардлагатай байгаа юм. Энэ бол дааж давшгүй зүйл биш. Цаана нь гарч чадах зүйл юм.

Сургууль хичээлийнхээ байрны анги танхимын тоог өргөтгөх, яваандаа оюутны дотуур байрны асуудлыг шийдвэрлэх, багш, ажилтаны нийгмийн асуудалд туслалцаа дэмжлэг үзүүлэх, багш бүрийг улам чадваржуулах, улмаар эрдэмжүүлэх, тэднийг сургалтын шинэ арга зүйд суралцуулах, оюутнуудыг эрдэм шинжилгээ, судалгааны ажилд сургаж дадлагажуулах, төгсөгчидтэйгээ байнга холбоотой ажиллах үйл хэргийг бид төлөвлөгөөтэй, дэс дараатай хийх болно.

Хамтран ажиллах, харилцан туслалцах, суралцах, мартагдан тасалдахгүй явах зорилгыг өвөрлөсөн "Чандмань холбоо" анхдугаар чуулга уулзалт өмнөө тавьсан зорилтыг амжилттай шийдвэрлэж, цааш цаашдаа улам ажил хэрэгч байдлаар үргэлжлэх болно гэдэгт итгэл төгс байна.

Эрдэм ухаан, эрч хүч, итгэл сэтгэлийн нэгэн зорилгоор холбогдсон багш, оюутан, төгсөгчдийн үл тасалдах хэлхээ холбоо улам улам батжин бэхжихийн эрхэм дээд ерөөлийг өргөн дэвшүүлье.

***Багш, шавийн барилдлага,***
***номын буян орших болтугай.***

## ШИХИХУТУГ ХЗДС-ИЙН ТӨГСӨГЧИД, БАГШ, ОЮУТНЫ "ЧАНДМАНЬ ХОЛБОО" АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТАНД БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД Н.БОЛОРМААГИЙН ХЭЛСЭН ҮГ

Эрхэм хүндэт эрдэмтэн профессорууд, энд хүрэлцэн ирсэн төгсөгчид та бүхэнд Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны Яамны нэрийн өмнөөс чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлж байна.

Шихихутуг ХЗДС бол манай улсад үүсэн байгуулагдсан хувийн хэвшлийн дээд боловсрол олгодог байгууллагуудын нэг юм. Өнгөрсөн хугацаанд 700 гаруй хуульчид бэлтгэсний ихэнх нь хууль эрх зүйн байгууллагуудад үр бүтээлтэй үндсэн мэргэжлээрээ ажиллаж байна. Тус сургуулийн төгсөгчид хуульчдын жил бүрийн сонгон шалгаруулалтанд идэвхтэй оролцож, эхний байрууд эзлэж байдаг нь энэ сургуулийн сургалтын чанарын нэг чухал илэрхийлэл юм.

Шихихутуг ХЗДС хоёрдахь удаагаа магадлан итгэмжлэгдсэн байна. Эх орондоо төдийгүй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шилдэг менежменттэй дээд сургууль болж байгаа гэж бид үнэлж байдаг юм.

Тус сургууль харьцангуй цөөн оюутантай, элсэгч бүрдээ сайн боловсрол мэргэжил олгох зорилтыг дэвшүүлж ажиллаж байгаа хамт олон.

Энэ сургуулийг үүсгэн санаачилж,тулгын чулуут нь тавилцаж,өнөөдрийг хүртэл хөгжиж дэвшихэд нь үнэтэй хувь нэмэр оруулж ирсэн бүх хүмүүст чин сэтгэлийн талархалаа илэрхийлье.

Төгсөгч, оюутан, багш, сурагчдын хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр бусад байгууллагуудыг үлгэрлэн дагуулж төгсөгчдийн холбоог байгуулж,энэ сайхан чуулга уулзалтыг зохион байгуулж байгааг бид бас сайшааж байна.

Монгол улсын дээд боловсролыг дэлхий дахины жишигт ойртуулах,дээд боловсролын чанарыг сайжруулах асуудал өнөөдөр бидний өмнө тавигдаж байна. 1991 оноос хойш хувийн хэвшлийн олон их, дээд сургуулиуд бий болсон. Энэ сургуулиудын тоо бидний зорилго биш, хамгийн гол нь чанаржуулах, дэлхий нийтийн жишигт хүрсэн боловсрол олгох асуудал чухал юм.

Би энэ ажилд тавигдсанаас хойш олон их, дээд сургуулиудын үйл ажиллагаатай танилцаж эхэлсэн. Тухайлбал багш бэлтгэдэг их, дээд сургуулиуд, эмч бэлтгэдэг ЭМШУИС-с эхлээд олон төрийн болон хувийн өмчийн сургуулиудын үйл ажиллагаатай танилцаж багш,сурагчдын санаа бодлыг сонсох боллоо. Боловсролын шинэчлэл,үйл ажиллагаа гэдэг бол бидний үйлчилгээг хүртэж байгаа хүмүүсийн сэтгэл ханамжаар үнэлэгдэх ёстой юм. Энэ ажлыг авсаныхаа дараахан хувийн хэвшлийн их, дээд сургуулиудын удирдлагуудтай уулзаж ярилцаж байхад "төрийн сургуульдаа төрсөн эх шиг, хувийн сургуульдаа хойт эх шиг байж болохгүй шүү" гэсэн ийм санамж, ийм сургамж үгийг надад хэлж байсан. Түүний дараахан Сангийн яамнаас санаачлан Дэлхийн банктай хамтарч хувийн хэвшлийг дэмжих стратегийн асуудлаар бид техник уулзалт зохион байгуулсан. Манай салбарт байгаа хувийн хэвшлийг хэрхэн дэмжих вэ? гэдэг асуудлаар бид бодлого тодорхойлох чиглэлээр идэвхтэй ажиллаж байна. Цаашдаа Монгол улсын төрөөс дээд боловсролын чанарыг сайжруулахын тулд, дэмжихийн тулд олон чухал ажлыг хийх ёстой гэж үзэж байна.

Өнөөдөр зөвхөн суралцагчдын төлбөрөөс санхүүждэг их, дээд сургуулиуд оюутан, залуучуудад чанартай боловсрол олгож чадахгүй. Тийм учраас их, дээд сургуулиудын эрх зүйн орчинг илүү оновчтой, тодорхой болгох, нөгөө талаас их, дээд сургуулийн санхүүжилтын тогтолцоо, эх үүсвэрийг баталгаажуулах шаардлагатай байна. Зөвхөн оюутны төлбөрөөр санхүүжиж байгаа их, дээд сургуулиуд эрдэм шинжилгээний ажлыг цаашид хэрхэн хийх вэ, үүнд төр засаг анхаарах ёстой гэж үзэж байгаа юм. Ер нь дээд боловсролын шинэчлэлийн асуудлаар бид эхний ээлжинд Дэлхийн банктай анхны тохиролцоонд хүрч дээд боловсролыг шинэчлэх тодорхой хөтөлбөр, төслийг үе шаттай хэрэгжүүлэх бэлтгэл ажилд ороод байна. Энэ оноос эхлэж Монгол улсын Засгийн газар анх удаа төрийн өмчид суурилсан их, дээд сургуулиудад тогтмол зардлыг өгч эхэллээ. Цаашид энэ жишгийг бид үргэлжлүүлэх болно.



Хувийн өмчид суурилсан сургуулиудаа хэрхэн дэмжих вэ, сургалтын материаллаг баазыг хэрхэн баяжуулах вэ, ямар лабораторитой байх ёстой вэ, гадаадын адил төстэй их, дээд сургуулиудтай хэрхэн ямар хэмжээнд хамтран ажиллах вэ, төгсөлтийн дараах сургалтыг яаж чанаржуулах вэ гээд олон асуудал бидний өмнө тавигдаж байгаа. Бид цаашдаа Хууль зүй, Дотоод хэргийн Яамтай хамтарч хуульч бэлтгэж байгаа их, дээд сургуулиудын чанарын асуудалд анхаарах болно. Дээд боловсрол гэдэг бол

улс орны хөгжлийг тодорхойлоход чухал үүрэгтэй. Чанартай боловсролыг өнөөдөр иргэд, суралцагчид маань хүлээж байгаа. Дээд боловсролыг чанартай болгохын төлөө та бүхэнтэй бид хамтран ажиллах болно.

Та бүхний цаашдын сурлага, хөдөлмөрийн ажилд амжилт хүсье.

Багш хүний ажиллах орчин, оюутан залуусын суралцах орчинг бүрдүүлсэн бүтээлч хамтын ажиллагаа хамгийн чухал юм. Цаашдаа бид оюутанд үзүүлэх нийгмийн үйлчилгээний стандарт ямар байх вэ, багш бэлтгэж байгаа их, дээд сургуулиудын чанарыг хэрхэн сайжруулах вэ, тодорхой мэргэжлийн их, дээд сургуулиудын элсэлтийг хэрхэн зохицуулах вэ гээд олон асуудал бидний анхаарлыг татаж байгаа.

Өнөөдөр боловсролын үйл ажиллагааг чанаржуулахад хөндлөнгийн үнэлгээний асуудал их чухал юм. Магадлан итгэмжлэлийг цаашдаа бид жинхэнэ сонгодог утгаар нь хөгжүүлэхэд анхаарлаа хандуулна. Танай сургууль, хамт олон хоёр удаа магадлан итгэмжлэгдсэн, олон улсын магадлан итгэмжлэлийг ч гэсэн бид хүлээн зөвшөөрч үүнтэй эн зэрэгцэхийн төлөө та бүхэнтэй хамтран ажиллана. Энэ сургуулийг хөгжүүлж, дэвжүүлж ирсэн бүх хүнд баяр хүргэе. Энэ уламжлалт арга хэмжээ улам дэлгэрч олон сургууль энэ туршлагыг хүлээж аваасай гэж хүсэж байна.

***Анхаарал тавьсанд баярлалаа.***

## ШИХИХУТУГ ХЗДС-ИЙН ТӨГСӨГЧИД, БАГШ, ОЮУТНЫ "ЧАНДМАНЬ ХОЛБОО" АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТАНД МУИС-ЫН ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ, АКАДЕМИЧ, ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ДОКТОР, ПРОФЕССОР С.НАРАНГЭРЭЛИЙН ХЭЛСЭН ҮГ

Чуулга уулзалтанд оролцож байгаа бүх хүмүүст энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Шихихутуг ХЗДС-ийг үүсгэн байгуулагчид нь миний зарим шавь нар байсан. Түүнчлэн би УИХ-ын гишүүнээр ажиллаж байх үедээ тус сургуулийн анхны төгсөгч нарын гарын нь багш болж явж байсандаа их баяртай байдаг. Үүнээс гадна бас тус сургуулийг магадлан итгэмжлэх улсын комиссыг удирдан ажиллаж тус сургуулийн ажил байдалтай албан ёсоор танилцах хувь тохиол надад заяаж байсан юм.

Нэг суут мэргэн хүн ингэж хэлсэн байдаг. Аливаа их, дээд сургуулиудын чанар, нэр хүндийг багш, оюутны тоо, төгсөгчдийн тоогоор биш, харин тэдний нэр хүнд, алдар суугаар хэмжинэ гэж.

Тэгэхээр Шихихутуг ХЗДС-ийн төгсөгчид манай орны хууль зүйн бусад их, дээд сургуулиудтай харьцуулахад нэлээд сайн нэр хүндтэй, төгсөгчид нь чанартай байдгийг би тодорхой ганц нэг жишээгээр хэлье. Тухайлбал, МУИС-ын Хууль зүйн сургуулийн магистрантурыг тус сургуулийн төгсөгчид маш сайн суралцаж төгсдөг, элсэлтийн шалгалтыг сайн даван туулж тэнцдэг. Үүнээс гадна энэ сургуулийн хоёр төгсөгч МУИС-ын Хууль зүйн сургуулийн багшаар үр бүтээлтэй сайн ажиллаж байгааг зориуд тэмдэглэж хэлмээр байна.

Цаашдаа Шихихутуг ХЗДС-ийн нэр хүндийг улам өргөж явах, олон жил үе үеийн хуульчдийг бэлтгэх үйлсэд хувь нэмэр оруулахад төгсөгчид та бүхний хичээл зүтгэл, нэр хүнд, цөхрөлтгүй хөдөлмөрөөр шийдэгдэнэ гэдгийг би өнөөдөр зориуд та бүхэнд ахмад багшийн хувьд, эрдэмтэн хүний хувьд хэлье гэж бодсон юм.

*Баярлалаа.*

## ШИХИХУТУГ ХЗДС-ИЙН ТӨГСӨГЧИД, БАГШ, ОЮУТНЫ "ЧАНДМАНЬ ХОЛБОО" АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТАНД МОНГОЛЫН ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДЫН КОНСЕРЦИУМЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Ц.ЛХАГВАСҮРЭНГИЙН ХЭЛСЭН ҮГ

Юуны өмнө Шихихутуг ХЗДС-ийн төгсөгчдийн чуулга уулзалтад оролцож байгаа зочид, төлөөлөгчид, мөн сургуулийн удирдлага Д.Оюунцэцэг захирал, энэ сургуулийн эрдэмтэн, профессор, багш нар, бүх хүмүүст баярын мэндчилгээг МИДС-ын консерциумын нэрийн өмнөөс дэвшүүлж байна.

Шихихутуг ХЗДС Монголын Их, Дээд сургуулиудын консерциумын гишүүн сургуулийн хувьд нэр хүндтэй, байр сууриа олсон сайн сургууль гэж боддог. Энэ сургуулийн захирал, удирдлагууд сургуулиа хөгжүүлэхийн төлөө байнга чармайн ажилладагийг харахад сайхан санагддаг. Аливаа их, дээд сургуулийн үнэт баялаг нь юу вэ гэвэл тэр сургуульд, оюутны өргөөнд оюуны хур буулгаж байдаг эрдэмтэн, профессор, багш нар нь юм.

Сая энэ хүндэт тайзан дээр энэ сургуулийн эрдэмтэн, профессор, багш нарыг урьж гаргаж ирэхэд үнэхээр сэтгэл хөдөлж суулаа. Үнэхээр Монголын өмнөө барьдаг шилдэг хуульчид, улс төрчид, судлаачид, эрдэмтэн, профессор мундаг том хүмүүс тайзан дээр гарлаа. Тэгэхээр энэ лут хүмүүсээр эрдэм оюуныг заалгаж байгаа шавь нар, оюутнууд, үе үеийн төгсөгчид мөн мундаг хүмүүс байх ёстой гэж үзэж байна.

Шихихутуг сургуулийн төгсөгчид Монголын олон салбарт маш үр бүтээлтэй ажиллаж байгааг би өөрөө бас мэддэг. Тийм учраас энэ сургуулийн төгсөгчид, эрдэмтэн, профессорууд нь Монголын хөгжлийг хурдасгагч нар нь байх болтугай. Монголын нийгмийг ариусгагчид нь энэ сургууль, энэ эрдэмийг өвлөсөн үе үеийн төгсөгчид байх болтугай гэсэн сайхан ерөөлийг өргөн дэвшүүлье.

Үүнээс гадна их сэтгэл хөдөлж байгаа зүйл байдаг юм. Энэ юу вэ гэвэл Шихихутуг ХЗДС-ийн төгсөгчид мэргэжилдээ их сайн, мундаг хуульчаас гадна үнэхээр хүн шиг хүн болгож төлөвшүүлдэг юм байна гэдэг ойлголт надад байдаг. Яагаад гэвэл энэ сургуулийн анхны төгсөгч нь манай их сургуулийн захирлын туслах, хуулийн зөвлөх Ж.Цэцэгүнж гэдэг бүсгүй байдаг. Үүнээс би бодохдоо Шихихутуг ХЗДС хүнийг ямар сайхан төлөвшүүлдэг юм бэ, ямар сайхан цайлган цагаан сэтгэлтэй хүмүүс байдаг юм бэ гэдгийг хамт ажиллаж байгаа арван хэдэн жилийн хугацаандаа мэдэрч үүгээр төлөөлүүлж Шихихутуг сургуулийн хүн шиг хүнийг төлөвшүүлдэг эрдэмтэн, профессор, багш нарт баярлаж явдагаа илэрхийлье.

*Баярлалаа.*

# ШИХИХУТУГ ХЗДС-ИЙН ТӨГСӨГЧИД, БАГШ, ОЮУТНЫ "ЧАНДМАНЬ ХОЛБОО" АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТАНД ТУС СУРГУУЛИЙН ТӨГСӨГЧДИЙН ХОЛБООНЫ ДАРГА Н.ОДОНГИЙН ХЭЛСЭН ҮГ

Эрхэм хүндэт эрдэмтэд, профессор, багш нараа, төгсөгчид, оюутнуудаа

Та бүхний энэ өдрийн амар амгаланг эрье

Урсан өнгөрөх цаг мөч бүртэй мөр зэрэгцэн суралцаж, ухаант хүмүүний амьдралын эргэлтэд хөл нийлүүлэн алхахдаа эрдэм ном, оюун билгийг шүтэн дээдлэгч багш нар, оюунтан ангийнхандаа учран золгохын ерөөл өргөж байсан нь саяхан билээ.

Цаг хугацаа хэмээгч нь өнгөрснийг дуурсгаж, одоог өрнүүлж, ирээдүйг сануулж байдаг нь үнэний хувьтай юм. Хэдхэн жилийн өмнө оюутан хэмээх хүндтэй, бас хариуцлагатай үүргийг хүлээж байсан үеэ өнөөдрийн энэ өдөр багш нар, төгсөгч та бүхэнтэйгээ уулзах юм гэж төсөөлж байсангүй.

Эрдэмт багшид насан ашид шүтвээс эрдэм аяндаа гарна.

Билгийн чанадад хүрэхэд ухаант багш хэмээх сайн газарчгүйгээр үл хүрнэ хэмээх мэргэн сургаалиар өнөөдрийн энэ хүндтэй индрээс төгсөгчдөө төлөөлөн хэлэх үгээ эхлэхийг хүссэн маань учиртай.

Шихихутугаар овоглосон бидний эрдмийн их өргөөг түшин тулагч тулгын гурван чулуу нь **багш- оюутан-төгсөгч** билээ. Энэ утгаар Шихихутуг хууль зүйн дээд сургуулийн удирдлага, хамт олон, төгсөгчдийн холбооны үе үеийн төлөөлөл хамтран энэхүү арга хэмжээг зохион байгуулж байгаа нь цаг үеэ олсон төдийгүй цаашид эрхэм холбоог бэхжүүлэн зузаатгах үйл хэргийн анхдагч эхлэл болж байна.

Одоогоос 9 жилийн өмнө буюу 1999 оны 5 дугаар сард бидний хэдэн төгсөгч нөхөд хамтран **сургууль-төгсөгчдийн** байнгын харилцаа холбоог бэхжүүлэн өргөтгөх, дэмжин туслах зорилгоор 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр төгсөгчдийн холбоог үүсгэн байгуулсан юм. Бидний туйлын зорилго урна төдий байгаагүй юмаа. Оюутны хувьд суралцана гэдэг ямар нэг эцэс төгсгөлгүй, хязгааргүй мэт санагддаг ч энэ л эрхэм үүргээ биелүүлэхийн тулд тэд хичээнгүйлэн зүтгэдэг, бас хийж чаддаг. Оюутнууд суралцаж чаддаг байхын тулд суралцах орчин, сэтгэхүйн зөв хандлага, түлхүүр хэрэгтэй байдаг. Эрх зүйч мэргэжлийн үнэт зүйлсээ ойлгон эрхэмлэж чадсан оюутан л сайн төгсөгч, сайн хуульч, төрийн сайн хүн байж чадна.

Бид үүнд бага ч гэсэн хувь нэмэр оруулах чин хүслээр төгсөгчдийн холбоог үүсгэн байгуулсан юм.

- 2005 оны 10 дугаар сарын 4-ний өдөр төгсөгчдийн холбооны санаачлагаар төрийн их заргач Шихихутугийн хөшөөг сургуулийнхаа байранд хүндэтгэн залсан нь эрхэм хүмүүний үйл хэргийг нэр төртэй залгамжлан үргэлжлүүлэгч байх үүргийг оюутан суралцагчдад уриалан сануулсан томоохон үйл явдал болсон билээ.
- Өрх гэрийн жаврыг үргээн, өөдлөх бүхний эхлэлийг хос хоёр чавхдсаараа эхлүүлдэг морин хуурыг хүндэтгэн залах ажиллагааг бид сургууль дээрээ зохион байгуулсан.
- Оюутны илтгэх чадвар, спорт, урлагийн авъяас чадварыг дэмжин хөгжүүлэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд нь туслах зорилгоор "Чөлөөт мэтгэлцээн", "Оюутны урлагийн наадам"-ыг уламжлал болгон зохион байгуулж хэвшээд байна.
- Суралцах орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор сургууль, төгсөгчдийн холбоо хамтран ажиллаж байна, цаашид ч хамтран ажиллана.

Энэ бүхэн төгсөгч бидний хамтын ажиллагаа, хамтын сэтгэл, хамтын үр дүн байх ёстой. Та бүхнийг энэ үйл хэрэгт уриалан дуудаж байна.

Багшаас сурсан мэдлэг, чадвараар эрх зүйч мэргэжлийнхээ хандлагыг тодорхойлж, өөрийгөө тасралтгүй хөгжүүлдэг байх, тэр чинээгээрээ бусдыгаа дэмжин хөгжих боломжийг нээдэг байх нь дов жалганы үзэл бус дорны соёл, сэтгэлгээний хэв маяг билээ. **Бид нэг ам бүлийн, нэг өрх гэрийн гишүүд. Бидний овог Шихихутуг.**

Оюутан ахуй цагт эрх зүйн шинжлэх ухааны охь дээжийг хүргэхийн зэрэгцээ, оюун билэгт хүмүүн байлгахын тулд сурган хүмүүжүүлсэн, төгсөгч байхын хувьд бахархан хүндэтгэж, хамтран бүтээхийг сануулж буй эрдмийн өргөө сургууль-багш нартаа нийт төгсөгчдийнхөө өмнөөс хүндэтгэл илэрхийлж байна. Хүлээн авна уу.

Чандмань эрдэнийн гурвалсан холбоо үеийн үед бэхжин, бадамлаж байхын өлзийт ерөөлийг өргөн дэвшүүлье.

*Ном дор мөргөмү !*
*Багш дор мөргөмү !*

## ШИХИХУТУГ ХЗДС-ИЙН ТӨГСӨГЧИД, БАГШ, ОЮУТНЫ "ЧАНДМАНЬ ХОЛБОО" АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТАНД ТУС СУРГУУЛИЙН 4 ДҮГЭЭР ДАМЖААНЫ ОЮУТАН Э.МӨНГӨНЗАЛААГИЙН ХЭЛСЭН ҮГ



Сайн байцгаана уу? Эрхэмсэг багш, үе үеийн төгсөгчид, оюутнуудаа.

Та бүхэндээ энэхүү сайхан өдрийн амар амгаланг айлтгахын ялдамд энэ арга хэмжээг зохион байгуулж анд нөхөд, багш хоёрыг уулзах боломжийг олгосон нийт зохион байгуулагчиддаа талархал илэрхийлье.

Та бүхнийг хараад 4 дүгээр дамжааны оюутан надад бахархах сэтгэл маш их төрж байна. Ийм залуус энэ сургуулиас төрж, ийм залуус эндээс боловсорч, ийм залуус эндээс амьдралынхаа гарааг эхэлсэн гэж бодохлоор аргагүй л энэ сургууль сайн сургууль юм аа.

Тун удахгүй сургуулиа төгсөх гэж байгаа нэг ангийнхан маань ч гэсэн удахгүй, хэдхэн жилийн дараа энэ урд эгнээгээр суучихсан алдар нэрээ дуурсгаж Монгол улсдаа ихийг санаачлан хийж бүтээсэн хүмүүс болно гэдэгт би итгэж байна.

Сая энэ индэр дээр гарч ирсэн багш нар бүгд л энэ сургуулийн төгсөгчид, багш нарийг нь ярьлаа. Харин би одоо сурч байгаа оюутнууд, оюутан цагийн хэзээ ч мартагдамгүй амьдралын талаар цөөн үг хэлмээр байна. Оюутан байна гэдэг хамгийн сайхан дурсамж байдаг. Саяхан л манай үеийнхэн "мах байвал гурил олоод сайхан хоол хийж идэх юмсан. Даанч давс байхгүй" гээд л өлсөж явсан. Саяхан л манай үеийнхэн 20 гаруйхан хуудастай бие даалт бичээд дунд нь "за за багшаа та яг уншина ш дээ" гэж бичээд баригдаж байсан гээд их олон олон хөгжилтэй дурсамжууд зөвхөн оюутан бидний оюутан байх энэ богинохон амьдралд тохиолдсон инээдэмтэй, бас ичгүүртэй ч гэмээр хөнгөн цагаан цайлган сэтгэл маань бодогдож байна.

Манай сургуулийг жижигхэн гэж олон хүн ярьдаг юм байна лээ. Манай сургуулийг цөөхөн оюутантай гэж олон хүн ярьдаг юм байна лээ. Шихихутуг жижигхэн байж болно. Шихихутугийн оюутнууд цөөхөн байж болно. Гэхдээ энэ сургуульд сурч байгаа оюутнуудын бэлчээр нь том юм шүү.

***Та бүхэндээ баярлалаа.***

## ШИХИХУТУГ ХУУЛЬ ЗҮЙН ДЭЭД СУРГУУЛИЙН ТӨГСӨГЧИД, БАГШ, ОЮУТНЫ "ЧАНДМАНЬ ХОЛБОО" АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТАНД ОРОЛЦОГЧДЫН САНАМЖ БИЧИГ

Эрдэм номын харгуйд хөтлөгч багш,

Мэдлэг, чадвар, дадалд шамдан суралцагч оюутан,

Мэдсэн, сурсан оюуны баялаг, хуримтлуулж базаасан дадал туршлагаараа амьдралын их далайд сэлэгч төгсөгчид, бид тасалдан салшгүй уяа зангилаагаар хэлхэгдсэн чандмань холбооныхоо анхдугаар чуулга уулзалтад Эх орныхоо дөрвөн зүг, найман зовхисоос хуран цугларав.

Чуулга уулзалтаа 2008 оны 3 дугаар сарын 21-ний өлзий учрал бүрдсэн энэ өдөр Монгол Улсын Нийслэл-Улаанбаатар хотод хийж, ажлаа өндөрлөж байна.



Хүсэл эрмэлзэл, бодол тэмүүлэл, зорилго зорилт, хүч тэнхээгээ нэгэн үзүүрт эв санааны нэгдлээр илэрхийлж, дараахи хэдэн зүйлд авъяас, чадвар, мэдлэг оюунаа төвлөрүүлж, улс орныхоо хөгжил дэвшил, эрх зүйт төр, иргэний нийгмийн төлөвшил, эрх зүйн боловсрол, хүний хөгжлийн эрхэм нандин, үнэт зүйлст хувь нэмрээ оруулж байхаар нийтээр зөвшилцөн тохиров.

**Нэг.** Оюутан бүр оюунлаг оюутан байхын төлөө цаг мөч бүрийг үр дүнтэй зориулж, мэдэх, сурах, бүтээхийн үлгэр дууриалалыг шингээн мэргэжлийн хийгээд гадаад хэлний мэдлэгээр хаана ч гэсэн хөрвөн ажиллах чадвар бүхий иргэний төлөвшлийг цогцлуулъя.

**Хоёр.** Төгсөгч бүхэн ажлын зохих байртай байж, ахисан түвшингийн сургалтад чармайн өөрийгөө хөгжүүлэхийн тулд үргэлж санаа тавин ажиллаж, мэдлэг мэргэжлийнхээ өсөлтөөр ололт, амжилт дүүрэн явцгаая.

Төгсөгч бүхэн багш-шавийн барилдлага, сургууль хоорондын хэлхээ холбоогоо улам улмаар бэхжүүлан өргөтгөж, хамтын ажиллагаа, харилцан туслалцааг батжуулан бэхжүүлцгээе.

**Гурав.** Багш бүр мэргэжил, чадвар, сурган хүмүүжүүлэх арга ухааны жинхэнэ эзэн нь байж, эрх зүйн боловсрол, гадаад хэл, компьютер, түүх, эдийн засгийн мэдлэг, мэдээллийг орчин цагийн шаардлагын түвшинд түгээн эзэмшүүлэгч, оюутан бүрийн хайр хүндэтгэлийг хүлээсэн, тэдний эрх ашиг сонирхолыг дээдлэгч эрдэм оюун, ахуй амьдралын үнэнч хөтөч байцгаая.

Багш бүхэн судалгаа шинжилгээний үйл хэрэгт хүчээ сорьж, шинжлэх ухааны үр шимд боловсорч, хууль зүйн шинжлэх ухааны олон талт хөгжлийг тэлэн өргөтгөж явцгаая.

**Дөрөв.** Чандмалсан холбооны гурван талын дээр дурдсан хүсэл зориг, хүчин чармайлтыг бодит ажил хэрэг болгоход сургуулийн зүгээс бололцоотой бүхнийг хийж, харилцан туслаж, хамтран ажиллахыг цаг ямагт хичээнгүйлэн зүтгэнэ.

Шихихутуг хэмээх Хууль зүйн дээд сургуулийн ширгэшгүй бахархал бол оюутан, төгсөгчид, багш, ажилтан, ажилчид Та нар мөн. Та бүхний хичээл зүтгэл, хөдөлмөрийн үр дүнгээр энэ сургууль Эх орныхоо хийгээд дэлхийн боловсролын орон зайд өөрийн гэсэн байр суурийг эзэлж байх болно. Тийм хэмжээнд ажилцгаая.

Сэтгэл, зүтгэл байсан газарт үйлс өөдрөг байдаг жам ёсыг эрхэмлэн дээдлэнэ.

Энэхүү санамж бичигт агуулгаар нь тодорхойлсон дөрвөн зүйл зорилтын биелэлт, үр дүнг нарийвчлан цэгнэн дүгнэх хоёр дахь чуулга уулзалтдаа 10 жилийн дараа баяр баясгалантайгаар хуран цуглацгаая.

***Сайн үйлс бүхэн дэлгэрэтүгэй.***
***Чуулга уулзалтад оролцогчид***

*2008 оны 3 дугаар сарын21-ний өдөр*
*Улаанбаатар хот*

# ШИНЭ НОМ

2008 онд хууль зүйн салбарын эрдэмтэд, судлаачид дарвах ном бүтээлийг та бүхний хэрэгцээнд зориулан гаргасныг товчлон мэдээлье




➢ Монгол Улсын гавъяат хуульч, ардын багш, хууль зүйн ухааны доктор, профессор Б.Чимидийн **"Сонгуульд суралцахуй"** ном хэвлэгдэн таны гарт очиж байна. Сонгуулийн талаар тайлбарлан бичсэн энэхүү ном нь сонгогч иргэдээс гадна энэ ажлыг зохион байгуулахад оролцох төрийн албан хаагчид, нам, эвслийнхэн, ажиглагчид, судлаачид, оюутан, сонгогчид уншиж мэдлэгээ дээшлүүлэхэд сонирхолтой бөгөөд нэн хэрэгцээтэй ном болжээ. Мөн төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан засгийн эрхийг барих сонгогч ард түмэн саналаа өгөхдөө биеэ хэрхэн бэлтгэх талаар тун сонирхолтой зөвлөгөө өгсөн нь талархууштай.




➢ Монгол Улсын гавъяат хуульч, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор О. Амархүү багшийн бичсэн **"Эрх зүйн онолын арван таван сэдэв"** ном та бүхний ширээний ном болон очиж байна. Хууль зүйн шинжлэх ухаанд хөл тавьж буй оюутан, судлаачид, ер нь эрх зүйт төрийн нөхцөлд амьдран байгаа иргэдэд эрх зүйн онолын суурь мэдлэг олж авахад нь зориулан гаргасан дагнасан бүтээл бол энэ ном юм. Уг ном эрх зүйн онолын суурь мэдлэг дээр тулгуурлаж салбар эрх зүйн мэдлэгт шилждэг зүй тогтол, арга зүйг эхлэн суралцагч оюутан, судлаач бүхэнд хялбаршуулсан аргаар хүргэж буй сонирхолтой бүтээл болсон байна. Номыг Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, Философийн ухааны доктор Н. Лүндэндорж хянан тохиолдуулжээ.




➢ Мөнхүү Б.Чимид багшийн туурвисан **"Үндсэн хуулийн мэдлэг"** ном та бүхний ширээн дээр очиж байна. Соён гэгээрүүлэх утга агуулгаар хялбарчлан бичсэн энэ ном энгийн ухамсрын түвшинд ерөнхий, суурь ойлголт авахыг хүссэн ард түмэн төдийгүй төрийн зүтгэлтэн, төрийн жинхэнэ албан хаагчид, оюутан, сурагчид, зөвхөн эрх зүйн салбарын гэлтгүй улс төр, философи, эдийн засаг зэрэг чиглэлийн олон судлаачдад зориулагджээ. Б. Чимид багшийн энэ номыг Монгол улсын гавъяат хуульч, Академич, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ж. Амарсанаа хянан тохиолдуулжээ.




➢ Философийн доктор /Ph/, Хууль зүйн шинжлэх ухааны доктор /Sc/, МУИС-ийн тэргүүлэх профессор, Н.Лүндэндоржийн **"Төрийн онол"** ном гуравдахь удаагийн нэмж засварлагдсанаар хэвлэгдэн худалдаанд гарлаа. Зохиогч энэхүү номондоо төрийг тодорхойлох хандлага, иргэний нийгэм, эрх зүйт төр, парламентын бүгд найрамдах улсын тухайд судалгааны шинэ мэдээлэл,"улс", "төр" гэсэн ойлголтыг заагдах тухай утга санааг тодотгон тайлбарласны гадна онол, арга зүйн олон олон шийн зүйлүүдийг нэмж оруулжээ. Монгол улсын Ерөнхийлөгчөөс жил бүр шалгаруулдаг шилдэг сурах бичгээр энэхүү номын хоёрдахь удаагийн хэвлэл нь 2005 онд шалгарч байв. Үүний дараа дахин нэмж засварласан болохоор бүр ч илүү хэрэгцээтэй нь тодорхой.